

Монголын хамниганы түүх, соёлын уламжлал

Түүхийн ухааны доктор(Ph.D) О.Баттуяа

Улаанбаатар- 2016

Гарчиг

Удиртгал

Нэгдүгээр бүлэг: Монголын хамниганы угсаа-түүх

- 1.1 Хамниганы түүхэн байдал
- 1.2 Хамниганы засаг захиргаа, нутагшилт, хүн ам
- 1.3 Хамниганы овог
- 1.4 Монголын хамниганы хэл аялгуу

Хоёрдугаар бүлэг: Монголын хамниганы аж ахуй, эд өлгийн соёл

- 2.1 Хамниганы мал маллагаа тариалах ажил
- 2.2 Ан агнуур
- 2.3 Хамниганы орон сууц
- 2.4 Хамниганы хувцас, гэр ахуйн эдлэл
- 2.5 Хамниганы уламжлалт хоол хүнс

Гуравдугаар бүлэг: Монголын хамниганы шашин шүтлэг

- 3.1 Хамниганы шашин мөргөлийн түүх
- 3.2 Хамниганы бөө мөргөл
- 3.3 Хамниганы онгод шүтээн

Ном зүй:

Хавсралт:

Монголын хамниганы угсаа-түүх

1. Монголын хамниганы түүхэн байдал

Аливаа ард түмний угсаатаны зүйг судлахад тухайн ард түмний өөрийн нэр, түүний гарал үүсэл, утга агуулга, хувьралын судалгаа зайлшгүй хөндөгддөг. Хамниганы судалгааны түүхээс үзэхэд нийт түнгүүсийн дотроос морьтон түнгүүсийг онцолж “хамниган” гэж нэрлэх санал цөөнгүй гарч байжээ. Энэ санал XIX зууныг хүртэл аялагч судлаачдын тэмдэглэлд дурьдагдаж байснаа аажмаар орхигдсоор, хамниганыг шууд түнгүүс гээд “хамниган” гэдэг нэр нь түрэг хэлтнүүд түнгүүсийг заасан нэршил гэж үзэх болсон байна. П.С.Паллас, Г.Ж.Рамстедт нарын тайлбарласнаар “хамниган” гэдэг нь харь газраас ирсэн өөр хэлтэн, харь хэлтнийг нэрлэсэн нэр болох юм гэсэн бол, Ф.В.Кливез, Б.Ренчин нар “кабканас” гэх эртний аймгийн нэр нэрийн дуудлага сунжирч өөрчлөгдсөөр “хамниган” болсон гээд, “кабканас” гэдгийг эртний “хавхчин” аймгийн нэртэй холбон тайлбарлажээ¹. Харин судлаач Д.Тангад, Монголын хамниганы дунд явуулсан хээрийн судалгаандаа үндэслэн хавхаар ан хийх уламжлал хамниганы дунд төдийлөн таарахгүй байна гээд тэдний суурьшиж байсан газар нутгийн байр байдалтай холбосон А.М.Решетовын дараахь саналыг дэмжжээ². А.М.Решетов кетүүдийн соёлд өмнөдийн ёс, заншилын элементүүд олон байгааг онцгүй анхаарч кетүүд эвенгүүдийг “хоемган” гэдэг бөгөөд энэ нь олон тоон дээр “тысдьен” буюу чулуун хүмүүс гэсэн утгаар нэрлэсэн нь юм. Хамниган гэдэг нь тэдний өөрийн нэршил бөгөөд Байгалийн өмнөдө талын хадархаг газарт нутагладаг байсан эвенгүүдмйн нэр буюу нутгийн байдлыг тусгасан нэр гэсэн үндэслэлэ гаргажээ. Ю.Д.Талько-Грынцевич, Ерөөгийн хамниганаас тэмдэглэгдсэн домогтой холбон, Алтайгаас ирэхдээ нэршсэн учир битүүлэг үг гэж үзсэн бол Г.М.Василевич “хамниган” нь монголжсон түнгүүсийг нэрлэсэн нь³ гээд нэрний гарал ба утгыг оноосонгүй. Ононы хамниганыг тусгайлан судласан Д.Г.Дамдинов “хамниган” гэдэг нь киданы нэгэн овгийн нэр юм гэж үзсэн байдаг⁴. “Хамниган” нэрний утгыг олон талаас нь тайлбарлахыг оролдсон байдаг ч эрдэмтэн судлаачид санал нэгдэж чадаагүй байна.

Сэцэн ханы хамниган. Түүхийн сурвалж, архивын баримтад Сэцэн хан аймгийн гол хошуу Сэцэн ханы хошуу⁵, гүн Гомбожав⁶, засаг Буяндэлгэр⁷нарын 3

¹ Хамниган, МУ-ын угсаатаны зүй, III боть, УБ-1996, 335т

² Д.Тангад, Хамниган, МУ-ын угсаатаны зүй, III боть, УБ-1996, 335т

³ Г.М. Василевич, Эвенки, историко-этнографические очерки, Ленинград-1969, 10стр

⁴ Д.Г.Дамдинов, Ононские хамниганы, Улан-Удэ-1993, 4стр

⁵ Энэ хошуу нь өнөөгийн Хэнтий аймгийн Баянхутаг, Мөрөн, Хэрлэн сумд, Чингис хотын нутаг дэвсгэрийг хамарч байсан байна.

⁶ Гүн Гомбожавын хошуу Богд хаанд МУ-ын үеийн Сэцэн хан аймгийн Жонон вангийн хошуу юм.

хошууны нутаг буюу өнөөгийн Хэнтийн Өмнөдэлгэр, Мөрөн, Цэнхэрмандал, Жаргалтхаан, Биндэр, Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутгаар суурьшиж байсан хамниганыг нийтэд нь “Сэцэн ханы хамниган”, “ханы хамниган” гэсэн байдаг. Ардын засгаас өмнөх үед эндхийн хамниган нь гурван хошуунд хуваагдан сууж явсан хэдий ч толгой мэдүүлдэг захиргаа нь Сэцэн хан аймгийн гол хошуу байсан учраас “Сэцэн ханы хамниган”, “ханы хамниган”, гэж нэрлэсэн хэрэг. Архивын баримтаас үзвэл хамнигад 1680-аад он гэхэд дээрх хошуудын нутагт суурьшсан байжээ.

Хэбэй Сэцэн хан, гүн Гомбожав(жонон ван), засаг Буяндэлгэр нарын 3 хошууны хамниган ардаас ямар зүйлийн алба гаргуулах явдлыг яахыг эрж, их журганаа мэдүүлсэн Төр гэрэлтийн⁸24-р оны (1844) баримтад⁹, ...Хэбэй Сэцэн хан А(Артасэд), туслагч түшмэдээс ,... *Сэцэн хан миний гэрийн боол хамниган хэмээн нэршсэн ард болвоос лоча(~луча – О.Б)хэмээгчийн үрс бөлгөө... Халх нарыг тулгар дагаар орохын урьд тэд нар захын газарт гөрөөчлөн явсаар газар газарт хүлэгдэн хөнөөж булаан хулууж явсан учраас Сэцэн хан Баво(1655- 1683) тэдний тэргүүлсэн Харахуй, Пүлж, Багнангийн зэргийн араг илүү ардыг бариулан цаазалж боол болгосон...* хэмээн хамниганы түүхэн байдлыг тэмдэглэн үлдээжээ. Сэцэн хан аймгийн гүн Гомбожав, засаг Буяндэлгэр нарын хошууны хамниганы талаар засаг Буяндэлгэрийн хошууны шийтгэх туслагч түшмэдийн Тэр гэрэлтийн 24-р оны (1844) бичигт¹⁰ мөн хошууны хамниган ард нь ... *язгуураас харьяат засгийн нэрийн дор захирагдсаар ирсэн...*, Түгээмэл элбэгтийн 3-р оны(1853)архивын баримтад¹¹... *лоча(луч) хэмээх хамниган ардыг анх шагнасан цагаас нааш харьяат хошуунаас ангид Буяндэлгэрийн хошууны нутагт суусаар ирсэн гэсэн байхаас гадна, мөн баримтад¹²Гомбожав нарын газраас, ... миний урьд тушаал тушаалын эцэг өвгөдийн нэрийн дор гэрийн ард гээгдэн зарагдаж явсаар ирсэн хамниган хэмээн нэршсэн ардын уг учрыг хуучин данс байцаая гэвч урьд Тэнгэрийг тэтгэсний онд(1736-1795)онд галд түлэгдсэн удаа буй бөгөөд байцаах тэмдэггүй ... болохыг мэдүүлжээ. Гэхдээ Энх-Амгалангийн 21-р онд¹³(1682)... *тэдний луча-ийн үлдсэн ард манай харьяат ардаас дагуулж Хар мөрний зэрэг захын газраар уулгалан булааж явахуйд их цэрэг дайлаар одож зарлигаар Сэцэн хан Норовт тушаасаныг хурааж Хэрлэн голын газар авчирч, харьяат ардыг салгаж захиран суулгасан* байна. Гэвч тэдгээр хамниган ард дахин хэрэг өдөөж ... *бас тэдний ард бүлэглэж оргосныг бариулаад, хэдэн анги салгаж мөнхүү боол болгосон ...ажээ.**

⁷Цэдэнгаравын Буяндэлгэр 1842-1853 онд Сэцэн хан аймгийн далай Дархан бэйлийн хошуу(өнөөгийн Төв аймгийн Мөнгөнморьт сум энэ хошуунд багтаж байв) ноёнг наймдугаар удаа залгамжилсан. Энэ хошуу нь Түшээт хан аймгийн Дархан чин вангийн хошуутай хиллэж байжээ.

⁸ Засаг Буяндэлгэрийн үед холбогдож байгаа тул түүний хошуу засгийн алба хааж байсан Төр гэрэлтийн 24-р (1844)онд холбогдоно.

⁹ ТТА, Ф-М31, Д-2, ХН-1125

¹⁰ ТТА, Ф-М31, Д-2, ХН-1125

¹¹ТТА, Ф-М34, Д-2, ХН-37

¹² ТТА, Ф-М31, Д-2, ХН-1125

¹³ТТА, Ф-М31,Д-2, ХН-1125

Дээрх баримтаас үзвэл:

-Халхын Сэцэн хан аймгийн мэдэлд орохоос өмнө хил зах газарт засаг захиргаа сул өөрийн дураар нутаглаж байжээ. Сэцэн ханы мэдэлд орсон дараа нутгийн ардуудаас дагуулж нэг бус удаа оргож босоон гэх шалтгаанаар Сэцэн хан, засаг Буяндэлгэрийн, гүн Гомбожавын гэсэн 3 хошуунд хувааж суулгасаныг нийтэд нь Сэцэн ханы хамниган гэх болсон байна.

Архивын баримтад дурьдаснаар тэднийг луча-ын хамниган гэж нэрлэдэг байж. Луча~(луота¹⁴~лучча~нучча~лоча~люоча)гэдэг нь оросуудыг нэрлэсэн түнгүүс үг. Иймээс луча хэмээгчийн үр сад гэсэн нь тэднийг Оросын харьяанд байсныг хэлжээ. Тэднийг XIX зууны сүүл хүртэл “луча хэмээх хамниган ард”, “луча хэмээгчийн үрс” гэхчлэн нэрлэж байв.

Хамнигад Орос ба Монголын улс төрийн хил албан ёсоор тогтоогдох хүртэл, Төв Азийн улс төрийн байдал тогтворгүй үед албан ёсны засаг захиргаа сул, тархай бутархай сул чөлөөтэй байснаас зарим нь Монголын умард хил дагуу элдэв хэрэг өдүүлж үймээн самуун дэгдээж явсан байна. Төвөг чирэгдэл болсон эдгээр хамнигадаас цөөнгүйг нь Сэцэн хан их цэрэг хөдөлгөн олзлон авчирч гэрийн боол болгосон ч, мөн Манжийн Энх-Амгалан хаан ба Оросын II Петр хааны үед (1727 онд)хоёр тал тохиролцон газар хувааж хилийн тэмдэг тавин Сэлэнгэ, Нерчүгийн зэрэг гурван тойргийн буриад, хамниган нарт хилийн заавар дүрмийг таниулсан¹⁵ч гэсэн хочр улсын хил орчимын нутгийн суугчдыг бүрэн дэгтэй болгож чадаагүйгээр барахгүй хамниганы үймээн самууны дээрх хэргүүд XVIII зууны сүүлийн хагас хүртэл үргэлжилсээр байжээ.

Тэнгэрийг тэтгэсний 21-р оны(1756) баримтад,... Оросын хамниган 200-аад цэрэг ирж, Хэрлэн голыг гатлаж Хашаат зэрэг газар суусан 50 хот улсыг 5 сарын 12-нд идэв. Аваачсан малын дотор хонь 5500 гаруй, үхэр 500 гаруй, адуу 15, гэр дотор байх мөнгө, эд бараа, цэргийн зэвсэг нэг ч юм үлдээлгүй аваад хуяг Цэрэнжав, Ванбил хоёрыг алж, 8 хүнийг шархдуулж, энэ авсан малыг хүргэж

¹⁴Луота (луча)-орос гэсэн үг. “Луча” –орос гэсэн утгатай (Н.Н.Поппе, Материалы для исследования тунгусского языка, 1927, 49 стр) оросуудыг түнгүүсүүд “лучча” (нучча, учча, лоча, лота, люоча, луча...) гэнэ (В.Л.Серошевский. Якуты. Опыт этнографического исследования В.Л.Серошевского. ТI. Спб-1896, 249 стр) Оросуудыг 1640-өөд оны үед Амар мөрөн(Хар мөрөн)-д ирэхэд тэндхийн түнгүүсүүд,үхлээс огтхон ч айхгүй, үс сахалдаа баригдсан галт зэвсэг атган, тэднийг анх хараад “лоча”(ойн савдаг, эзэн гэсэн утгатай) гэж нэрлэсэнээр энэ нэр нь Амар мөрний түнгүүсүүдээс дамжин цааш Даур (Дагуур), Манжуурт түгсэн юм (История река Амура. составленная из обнародованных источников. Санктпетрбург-1859, 35 стр). Штраленберг, “луце” нь оросын леший буюу савдаг, ойн эзэн гэх утгатай, самоедууд Енисейн остякуудаар дамжуулан ийн нэрлэх болж, улмаар Ленагийн якутуудад тархан, Сибирийн бус төрөлтнүүдийн дунд хэдэн янзаар дуудагдсаар энэ болсон гэж үзсэн бол, Паллас, “луце” нь самоедийн хэлний догшин, ширүүн, ууртай гэсэн утгатай. Европын хэлэнд буулгасан хятад сурвалжид оросуудыг “олосс”, “олоссу”, “ло-ша” (францаар lo-cha) гэж тэмдэглэсэн байдаг. Хятадууд “л” үсгийг хэрэглэдэггүйгээс манжуур, Амарын хязгаарын түнгүүсүүд “р”-г “л”-ээр дуудах нь тохиолддог тул мөн замаар “луча” нэр түнгүүсүүдийн дунд болон сибирийн бус төрөлтнүүдэд түгсэн (Л.Щренк, Об инородцах Амурского края, ТII, Спб-1889, 201т)гэнэ. Хамниган хэлнээ “сал”, “сэл”- нь хэсэг тооны ай үүсгэх “чуул”, “чүүл”, “ууд”, “үүд” дагавар болох тул луочасал гэвэл оросууд гэсэн утгатай (Б.Ренчин, МАУ-ын хамниган аялгуу, УБ-1969, 53,110т).

¹⁵ Буряадай түүхэ бэшэгүүд, Улан-Удэ- 1992, 63т

өгөөд дахин хойш ирж танай ноёд болон, албат бүгдийг хамт довтолж иднэ... гэж заналхийлээд явсан тухай дэлгэрэнгүй өгүүлжээ.

Тэнгэрийг тэтгэсний 16-р(1751) он намрын тэргүүн сарын 15-нд ... бэйс Жанчивдоржийн хошууны Ишийн 157 морийг 9 хамниган **Мэлхэй** нэрт газраас тууж аваачсанд, Ишийн зэргийн 5 хүмүүн нэхэж **Үхэрт** нэрт газарт гүйцээд алагдаж Ишийн бие алагдав, 2 хүмүүн шарх лдлв, 1 морь алав, 157 морийг оросын хамниган цөм аваачив. Мөн сарын битүүний шөнө манай хошууны Дамцог, Цэрэн, Заяатын 3 хүмүүний 173 морийг **Амтат** нэрт газраас оросын хамниган 100 шахуу хүн тууж аваачсанд 8 хүн нэхэж маргааш нь гүйцэн алагдаж 4 хүн, 2 морь алагдаж, 1 хүн, 2 морь шархдав. Алагдсан 4 хүн 4 нум сумтай саадаг, 2 олбог, 173 морийг хамтаар оросын хамниган бүрнээ аваачив гэсэн байна. Мөн үед холбогдох архивын баримтыг нягтлан үзэхэд найралт төвийн 6-р(1728) оноос нааш Тэнгэрийн тэтгэсний 15-р(1750) он хүртэл нийт 2556 морь, 25 тэмээ, 34 үхэр, 3 хүн алагдсан гэж тэмдэглэжээ¹⁶. Үүнээс хойш Тэнгэрийг тэтгэсний 21-р (1756)оны зуны дунд сарын 27-д пууцагадын¹⁷ дээрэмчид 500 цай, 50 лан мөнгө, 15 тэмээ, 140 адуу, үхэр, 1232 хонь, гэрийн доторхи аяга шанаганаас дээших эд зүйлийг цөмийг авч, гэрийг нь эвдсэн¹⁸, Тэнгэрийг тэтгэсний 23-р(1758)онд Оросын намиар хулгай нар Баргын нутагт нэвтэрч 2500 морь, 130 тэмээ, 80 үхэр авч одсон¹⁹... гэж хамниганы хэргийн тухай мэдүүлсэн баримтууд цөөнгүй байна. Энэ мэт Оросын хамниган, пууцагад ~пооцагад, намиарууд Монголын зүүн хойд хилээр, Сэцэн хан аймгийн нутгаар нэвтрэн зоргоор авирласан²⁰үймээн самуун он удаан жил үргэлжилсээр байсныг гэрчлэх эдгээр баримт мэдээнүүд нь тухайн үеийн хамниганы түүхэн байдлыг харуулахын хамт Сэцэн ханы хамниганы угсаа-газар нутгийн хамаадлыг давхар илтгэжээ.

Ерөөгийн хамниган. Судалгааны бүтээл, архивын баримтаас үзвэл, Ерөө голын сав нутаг, Ходоод, Тангуй, бугант, Бэрлэг, Шарлан, Ялбаг, Төмөртэй²¹ зэрэг газруудаар байсан хамниганыг газар усдаар баримжаалан Ерөөгийн хамниган гэж нэрлэж ирсэн байна. Ерөөгийн хамниганыг хэдий үеэс тус гаурт

¹⁶ ТТА, Ф-М9, Д-5, ХН-10

¹⁷ Хамниганы пууцагад~ почоган~ (олон тоон дээр почогат~ почогар) овог нь ХҮИ зууны үед Витим, Кидимит, Нерчү, Ингэдэй, Чита, Конда, Шилка, Албазин, Баунт, Ярууна, Иргень нуурын тойрон, ХҮИИ зууны үед Өвөр Байгалиар(дагуурын бүлэг), Тэлэмбэ, Ярууны районд(Паллас), Акшины тойргийн Магутын харуулд(Георги) сууж байсан байна. 1774 онд Нерчүгийн Нерчүхан, Алканаар, Торго, Торгокон, Чаракчин, Кия, Киякханы салаа салбараар бүртгэгдсэн байна. Майнов 1897 онд Читийн тойргоос энэ овгийн хоёрдогч нэр – Ханагин гэж тодруулжээ. Харин судлаач Г.М.Василевич, Ханагин гэдгийг Канагин- тай харьцуулаад пууцагадын хоёрдогч нэрийг Якутаас гаралтай байж магадгүй гэж таамагласан байна. (Эвенки, историко- этнографические очерки, Ленинград-1969, 275стр). Буриадын эрдэмтэн Д.Г.Дамдинов, Ононы хамниганаас пууцагад~(почегар) овгийг бүртгээд, уг овгийг монгол гаралтай гэж үзсэн байдаг(Д.Г.Дамдинов, Ононские хамниганы, Улан-Удэ- 1993).

¹⁸ ТТА, Ф-М9, Д-3, ХН-33

¹⁹ ТТА, Ф-М181, Д-1, ХН-20

²⁰ ТТА, Ф-М9, Д-3, ХН-33, ТТА, Ф-М181, Д-1, ХН-20

²¹ Ж.Цэвээн, Түүвэр зохиол, УБ-1997, 123т

нутаглах болсон, тэдний угсаа-түүхийн талаар тодорхой чиг баримжаа болгох бодит баримт үгүй тул дараахь аман түүх болон эрдэмтэн судлаачдын саналыг дурьдахаас хэтрэхгүй нь. Ерөөгийн хамниганыг судласан Ю.Д.Талько-Грынцевич хамниганы угсаа-түүхэнд холбогдох нэгэн дотог тэмдэглэснийг сийрүүлбэл, ... Урьд 3000 жилийн өмнө хамнигадыг Алтай зүшгт сууж байхад, айл зэргэлдээ Соён улсын Байба хан, Бүр хан хоёрын үед их самуурал болж өлсгөлөн тохиолдсон учир тэндхийн хамнигад уван цуван хөдлөж бүтэн зуун жилд цуван явсаар Хар мөрөн хүрчээ. Ийнхүү нүүхэд энд тэнд тасарч хоцорсон нь Байгаль орчим ба Арамаг, Ерөө голын хамниган бололтой. Хамнигад Алтайгаас Ерөө хүртэл 30 жил явсан²² гэжээ. Энэ түүхээс улбаалан судлаач Жамсрангийн Цэвээн, Алтайн цаад бие Ил гол, Балхаш нуур ба Төмөрт нуурын орчимд эрт цагт байсан Усун улсын ямар үндэстэй нь тодорхойгүй. Чингисийн тайлганы бичигт Усуны гурван Зүрчид хэмээн гардаг нь хуучин судрын Усун улс мөн бөгөөд энэ нь хамниган үндэсний Зүрчид аймаг болж болно гэжээ²³. Өөрөөр хэлбэл, Ерөөгийн хамниганыг Алтайн цаанаас гаралтай гэж таамаглаад Ерөө, Хараа, Балж, Балрхан, Минж, Хэрлэн, Онон, Хилагу, Жидэ, Цөх, Орхон, Сэлэнгэ хэмээх нэрнүүд нь цөм хамниган хэлний нэр болой. Эдгээр нэрнүүд бөгөөс Чингэсээс урьдах ба Чингисийн үеийн судруудад үзэгдэх тул Ерөөгийн хамниганы идээшин суурьшсан нь их эртний явдал болж мэдмүй. ХҮII зууны үеийн хятад бичигт, Хөх хотоос хамниган овгийн монголчууд урваж умар зүг говь туулан арилав гэсэн байдаг нь тэд “хамниган овгийн монголчууд” гэдэг нь Ерөөгийн хамниган байж болмуй гэсэн санал нэмжээ. Гэхдээ энэ мэдээг түүхэн цаг үетэй нь холбовол, тэрхүү говь туулан арилсан хамниган овгийн монголчууд гэдэг нь ХҮII зууны дунд хэрд Манжийн хааны ялаас зугтаж хаант Оросын мэдэлд орсон хамниган Намиар(намиад- О.Б)аймгийн холбооныхон, баеид овгийн Гантөмөр түүний хамсаатнууд мэт байгаа юм.

Эрдэмтэн С.Бадамхатан дараахь аман түүхээс улбаалж Ерөөгийн хамниган Хөвсгөлийн хар дархадтай холбоотой байж магадгүй гэсэн таамаглал дэвшүүлсэн байдаг.

- Урьд дархад нутаг хүн амьтангүй зэлүүд газар байжээ. Чингис гэдэг хүн анх Тэнгис голыг гатлаж энд нутаглаж ан гөрөө намнаж амьдрах болсон үед Хараа, Ерөөгөөс хэдэн хүн Чингистэй уулзаад нутагтаа буцаж, Тэнгис гэдэг газар ан гөрөө элбэгтэй баялаг сайхан газар байна хэмээн ард олноо дагуулж ирэн энэ нутагт засаг захиргаа байгуулан суурьшжээ. Ингэж байтал Манж Чин улсын үед тэднийг Хараа, Ерөөд хураан аваачсан байна. Гэтэл Хараа, Ерөөд очсон улс нь нутаг орноо санаж мөрөөдөн унагатай гүү унагаа хаяж, хүүхэдтэй хүүхэн хүүхдээ хаян идээшихгүй болохоор гурын арьсан дээл, гурын эвэртэй малгай өмсөж Богд эзэнд бараалхан үнэн учираа хэлэхэд Богд эзэн тэднийг нутагтаа буцахыг зөвшөөрч Дархад шавь болтугай хэмээн айлджээ. Ингээд тэд Шишгэд нутагтаа эргэж ирсэн гэдэг. Харин Шишгэддээ ирэх хүчин хүрэлцээгүй хүмүүс нь Хараа,

²² Ю.Д.Талько- Грынцевичъ, Иройскіе Хамнеганы, Труды., TVII. В.3. 1904, 70стр

²³ Ж.Цэвээн, Түүвэр зохиол, Ёботь, УБ-1997, 123-124т

Ерөөдөө үлдсэнийг нь “хэвтрэн дархад”гэдэг юм. Хараа, Ерөөд нутаглаж байсан улс бол Онон, Улзаас тасарч ирсэн буриад угсааны улс²⁴.

- Дархад улс өндөр Богдын шавь болоод Хараа, Ерөө рүү очоод байснаа нутаг ус нь тохиролгүй эргэн ирж дархан шавь болсон юм. Хараа, Ерөөд тэдний хагас үлдсэн гэдэг. Богдод мөргөхөөр очиход Хараа, Ерөөгийнхөн гэж цагаан дээлтэй, хар хирвээтэй²⁵(бас халиу манзтай байдаг)дэгтийрхүү үсэн гуталтай улс хамгийн түрүүнд Богдод мөргөдөг байсан. Бид(дархадууд)тэдний дараа мөргөдөг байж билээ. Дам хүнээс сонсоход тэд нарыг хамниган буриад улс, манай дархадын дээд өвөг гэлцдэг байсан. Тэр хамниган улсын дээл манай дархад дээлтэй яг адилхан байсан юм. Тэгээд би тэд нарыг нөгөө Хараа, Ерөөд үлдсэн хэвтрэн дархад гэдэг буриад улс(хамниган-С.Б)нь байхдаа гэж боддог байсан гэх хууч яриа тэмдэглэжээ²⁶. Эрдэмтэн С.Бадамхатан ХҮИ зууны дунд үед Өндөр гэгээнд шавиар өргөгдөж Хараа, Ерөө голоор нутаглаж байсан өөлд, хамниган, хэрүүд отгийхон бүгд хар шавь байсан нь маргаангүй юм. Хар дархад хэмээх нэр нь хар шавиас ангид Хараа орчим нутаглаж байсан шавь нарыг Хараа дархад гэж урианхай нутгийн шавь нар нэрлэдэг байснаас үүссэн байж магадгүй гэсэн байна. Тэрээр Хөвсгөлийн “Хар дархад”-ыг Ерөөгийн хамнигантай холбогдох биш байгаа гээд, бататгах тодорхой баримтгүйгээ дурьдсан ч хэд хэдэн аман түүхийг бүтээлдээ багтааж, дархад ба хамниганы зарим заншил, газар нутгийн нэрнүүд адил байгааг харьцуулан онцолсоныг нь үзвэл энэ саналдаа нилээд талтай байсан бололтой. Харамсалтай нь хар дархадын бүрэлдэхүүнд халх шавиас гадна, хамниган отгийнхоноос оролцсон эсэх асуудлыг дэвшүүлэн нээлттэй орхисон эрдэмтэний дээрх таамгийг бататгах тодорхой баримт одоохондоо олдоогүй байна. Харин Ерөөгийн хамниганы хожуу үеийн түүхэнд холбогдох хэдэн аман түүх тэмдэглэн үлдээснийг сийрүүлбэл:

- Галдан бошигтын үймээний үед Өндөр гэгээн ойрадуудаас дүрвээд Ерөөгийн рашаан хавьд ирээд байхад нь “намиад”(хамниган-О.Б)-ууд гөрөөсний мах болгож аваачиж өгчээ. Өндөр Богд энэ махны чинь шөлийг ууя гэвэл намиадууд, энд байдаг халуун усанд дүрээд болгож авчирсанаа хэлсэнд, тэр халуун усыг нь гэгээнтэн үзээд Ерөөгийн рашаан гэж нэрлэсэн тул Ерөөгийн халуун рашааныг анхдугаар Богд нээсэн гэж хэлцдэг байна²⁷.

²⁴ С.Бадамхатан, Эрдэм шинжилгээний бүтээлүүд, II боть, УБ- 2002, 83 т

²⁵ Хирвээс - Үст эдээр хийсэн хажлага, мөшгөөр. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь, IY боть, УБ- 2008, 2515 т

²⁶ С.Бадамхатан, Эрдэм шинжилгээний бүтээлүүд, I боть, УБ- 2000, 84т

²⁷ ХҮИИ зууны үед Ерөө, Онон голын эхэн хавиар сууж байсан хамнигад тэндхийн халуун рашааныг эмчилгээний журмаар сүсэглэн хэрэглэж байсан байна. Өвөл, зун ялгаагүй өвчнөөсөө салъя гэсэн хүн болгон(хүүхдээс бусад) ийшээ ирж уг рашаанд орж, ууж хүртэх бөгөөд ингэснээр тэдний дотрын болон нүд толгойн зэрэг элдэв өвчин илааршдаг гэнэ. Энэхүү эмчилгээний шидийг нь монгол лам нар нээсэн гэх ба рашаан эмчилгээ хийх үедээ залбирч уншлага хийж байх ёстой учир лам нар байнга дэргэд нь байдаг байна. Хамгийн гол нь өвчтөн өөрөө сүсэглэж залбирах хэрэгтэй гэнэ. Тэр рашааны ойролцоох моднуудад элдэв өнгийн бөс даавуу уясан байжээ. А.П.Окладников, С.П.Крашенинников в Сибири неопубликованные материалы, Москва-Ленинград-1966, 95 стр.

- Ойрад, Халхын самууны үеэр Галдан бошигт Өндөр гэгээнийг нэхэж ирэхэд хамниганы Цоолой(Цолой)гэдэг баатар өөлдийн хэдэн баатрыг алаад Богдыг газарчилж, Естий рашаанд авчирчээ. Энэ учираас Өндөр гэгээн хамниганыг шавиа болгож ивээлдээ багтаасан гэнэ. Өөр нэг хувилбарт нь, хамниганы Соолой(Цоолой) баатар Өндөр гэгээнийг өөлдөөс дүрвэж явахад нь туслаж Шарлангийн Шар тал гэдэгт бүгүүлж энэ үеэс хамнигад Өндөр гэгээний номтой болсон юм гэжээ.

-Намиадынхан Өндөр гэгээнд зориулж Естий рашааны ойролцоо Халзан нэхийтийн Сарьдагт дуган бартж өгөхөд тэнд нь анхдугаар Богд өөрийн биеэр заларчээ. Тэндхийн “намиад”-ууд түүнд мөргөхөөр бараалхахад, Богд гэгээнтэн тэднийг малгайгаа авч мөргө гэж л дээ. Намиадууд хариуд нь:

Эсгий туурга нэвт өршөөдөг Богд

Эсгий малгай нэвт өршөөнө биз²⁸гээд малгайтайгаа мөргөсөн гэдэг. Манай хувилбарт, намиадууд өндөр гэгээнд мөргөхдөө

Хөтөл нэвт өршөөсөн юм

Хөдөс нэвт өршөөнө биз гээд малгайтайгаа мөргөсөн гэж байв²⁹. Дурьдсан аман түүхнүүдэд өгүүлсэнээр бол, Ерөөгийн хамнигад өндөр гэгээн Занабазарыг Ойрадын мөшгөлтөөс бултуулж амийг нь аварч, 1690-ээд оны үед түүний ивээлд багтаж улмаар анхны шавиудын нэгд тооцогдох болсон байна. Үүгээр ч тогтохгүй тэндхийн хамнигад өндөр Богдод зориулж дуган барьж өгсөн ажээ. Өнөөгийн Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг Туул голын томоохон цутгалангийн нэг Хийдийн голын эхэнд ХҮИ зууны үеийн хийдийн (Сарьдагийн)туурь байдаг бөгөөд энэ хийдийг өндөр гэгээн Занабазар халх, өөлдийн дайны үеэр дүрвэж явахдаа бариулсан гэдэг³⁰. Энэ хийд нь Эрдэнэ сумын нутаг дахь Сарьдагийн хийдийн дуган юм.

Ю.Д.Талько-Грынцевич, Ерөөгийн халуун рашаан орчимд хамниганы 6 овог байсны 4 нь пинхинь~(пөөинкин)овог, 2 нь хамниган овог байсан гэж тэмдглэжээ. Энэ мэдээг ардын засаг мандах хүртэл Ерөө орчимоор Богд гэгээний шавь “намиад”, “пөөинкин” отгийнхон байсан, Шарлангийн отгийн хамниган нь намиад удамтай, Ходоодоны хамниган пөөинкин удамтай гэж эрдэмтэн С.Бадамхатаны тодруулсантай³¹ харьцуулж үзэх юм бол хамниган овог гээд байгаа нь намиадуудыг хэлсэн болох нь. Цаашилбал энэ баримт ... Жавзандамба хутагтын шавь хамниган Ерөөгөөр нутагтай байж зах нутаг нийлсэн хошууны хамниган(Сэцэн ханы хамниган, ханы хамниган)-тай төрөл саданы холбоотой байжээ³² гэсэн академич Б.Ренчиний дүгнэлттэй уялдаж, улмаар Сэцэн ханы хамниган ба Ерөөгийн хамниган нь түүхэн талаасаа ч тэр төрөл гарлаараа ч тэр холбогдоно гэдгийг давхар харуулж байж болох талтай.

Дорнод Монголын хамниган. Эдүгээ Монголын хамниганы ихэнх нь Хэнтий, Дорнод аймгийн нутагт суурьшиж байна. Дорнод Монголын хамниган

²⁸ С.Бадамхатан, Ерөөд хийсэн судалгааны гар бичмэл, 1963

²⁹ О.Баттуяа, Ерөө, Хүдэрт хийсэн судалгааны гар бичмэл, 2007

³⁰ Д.Батсүх, Эрдэнэ нутгийн түүх, 1994, 18, 67 т.

³¹ С.Бадамхатан, Сэлэнгэд хийсэн судалгааны гар бичмэл, 1963

³² Б.Ринчен, МАУ-ын хамниган аялгуу, УБ- 1969, 19 т

гэдэгт Хэнтий аймгийн Биндэр, Дадал, Дорнод аймгийн Баян-Уул, Цагаан-Овоо сумын нутагт голлон суурьшиж байгаа хамниганыг багтааж үзэв.

Дорнод Монголын хамнигадын угсаатаны түүх бол Сибирийг колоничилсон түүх, колонийн бодлогын үнэн бодит дүр төрх юм.

Урьд Хэнтийн хамниган настангууд монгол газрын хамниган 15 эцгийн хамниганаас гаралтай, тэдгээр 15 эцгийн хамниганы 10 нь Хянганы нурууны араар, 5 эцэг сартуул нь Хар мөрний адгаар нутаглаж байсан гэдэг. Арван таван эцэг хамниганы үүсэл нь ХҮИ зууны үед холбогдоно. Тэд анх Нерчүгийн хамниган, мөн буриад, солонгууд болон Ойрад, Халхын зөрчилдөөний хөлөөс дайжсан монголчууд Байгалийн өмнөд талаар очиж суурьшсан нь 15 эцэг хамниган болсон байна³³. Хаант Оросын мэдэлд орсон эдгээр иргэдийг тухайн үед “15 эцгийн хамниган”, “15 эцгийн 500 хасаг”³⁴, “15 отог хамниган” гэхээс гадна “буриад болсон хамниган”³⁵ гэж нэрлэж байжээ. Буриад болсон хамниганы тухайд Хаант Оросын зүгээс Сибирийг колоничлох үед тэднийг дагаж алба татвар төлөхийг зөвшөөрөгсдийг “брат” буюу ах дүүс гэсэн найрсаг утгаар нэрлэх болсон нь хожим дуудагдах нь хувирч өөрчлөгдөөд “буриад” гэх болсон гэж үздэг. Иймээс “буриад болсон хамниган” гэдэг нь дээрх үгийн үүнтэй адил буюу Оросуудыг дагаж ороод “брат” гэж явсанаа буриад болсон гэсэн утгатай гэж үзэж болох юм.

Иймээс буриад болсон хамниган гэдэг нь үүнтэй адил буюу Оросуудыг дагаж ороод брат юм уу буриад болсон гэсэн утгатай. Өөрөөр хэлбэл Оросыг дагаж орсон хамниганыг буриад(брат-О.Б)болсон хамниган буюу арван таван эцгийн хамниган гэж байсан нэрлэж байна. ХҮИИ зууны 70-аад оны үед Гантөмөрийн мэдлийн 15 эцгийн(род)түнгүүсүүд Нерчү, Ингэдэй, Онон, Шилке, Аргуниар тархан, Амар мөрөн хүртэл суурьшиж байсны дотор “дулегат”-ууд Амар мөрөнд хамгийн ойр нутаглаж байжээ³⁶. Оросын харьяанд орсон өвөр Байгалийн ардыг 1728 оны үеэс Түнхэнээс зүүн тийш Шилке, Аргунь, Сретенск хүртэл хаант Оросын өмнөд хилийн харуулд суулгаж³⁷ дарааханаар нь 1764 онд 600 цэрэгтэй 4 полк(хороо), 500 цэрэгтэй 1 полк нийт 5 полк байгуулахад 500 цэрэгтэй 1 полкийг нь 15 эцгийн болон 3 отог хамниганаас бүрдүүлсэн байна³⁸. Тэдгээр хил харуулын 15 эцгийнхэн Нерчүд төвлөн сууж, монголчууд хил дээр үймээн гаргавал морьтон түнгүүсүүд(хамниган намиадууд-О.Б)нь нум сумаа агсан морьтойгоо, бугатан түнгүүсүүд нь явган цуглахаар байнгын бэлэн байдалд, нэг дор 3000-4000 цэрэг гаргах чадалтай байсан байна. Хаант Оросын талд хил

³³ Буряадай түүхэ бэшэгүүд, Улаан-Үдэ-1992

³⁴ Буряадай түүхэ бэшэгүүд, Улаан-Үдэ- 1992, 26 т

³⁵ Буряадай түүхэ бэшэгүүд, Улаан-Үдэ- 1992, 26 т

³⁶ Дагуурын найм ба таван эцэг (род)-ийн түнгүүсүүд нь Тэлэмбэ, Яруунаар нутаглаж байсан ажээ. Г.И.Георги, Описание всех обитающих в Российском государстве, народов и их житевских обрядов, обыкновении, одеждь, жилищь, вероисповедании и прочих достопамятностей. Спб-1799, 36 стр

³⁷ Буряадай түүхэ бэшэгүүд”, Улаан-Үдэ- 1992, 156 т

³⁸ Буряадай түүхэ бэшэгүүд”, Улаан-Үдэ- 1992, 156 т

харуулын алба хааж байсан хамнигад нь ХҮИИ зууны үеийн монгол цэргийн зохион байгуулалтын ерөнхий зарчимтай адил нэгэн ам бүлийн ах дүү хоёроос нэгийг нь, ах дүү гурваас ядаж нэгийг нь цэрэгт татдаг мөн хоол хүнсний тусгай дүрэмтэй байжээ³⁹. Хаант Орос улс Сибирийн олон овог, аймгуудыг өөрийн мэдэлд бүрэн төвхнүүлэхийн тулд энэ мэтээр зохион байгуулалтад оруулахаас гадна хүн амын талаар тодорхой арга хэмжээ авч байсны нэг нь Сперанскийн шинэчлэлт юм.

Сибирт Оросын засаглал сул байсан тул эзэн хаан Александр Павлович 1819 онд гүн Сперанскийг 1. Сибирийн угсаатнуудын ажил төрөл, аж байдлыг бүх талаас нь судлаж үзэх, 2. Сибир цаашид яаж хөгжихийг нь тоймлох зорилготойгоор Сибир явуулжээ. Гүн Сперанский Сибирт хоёр жил ажиллаж дээрх 2 зорилгоо биелүүлжээ. Улмаар түүний судлаж цуглуулсан баримтад үндэслэн хаант засгийн шийдвэр гарч Сибирийг губерни, область, округт хувааж, 1822 оны 06-р сарын 22-нд тэндхийн олон угсаатнуудад зориулсан шинэ хууль батлаж, степны дүүм(хөдөөгийн захирах яам)гэдгийг байгуулав. Мөн буриад-монголчуудыг, хамнигадыг, бухар, татаруудыг, Сибирийн бусад ардуудыг: - суурин, нүүдэлчид, хэрмэл иргэд гэж ялгаж⁴⁰, нийтэд нь “бус төрөлтөн”(инородцы)гэж нэрлэх болсон байна⁴¹, XIX зуунаас эхлэн Сибирт үйлдвэрлэл эрчимжиж, төмөр зам тавигдан оросууд олноороо суурьшин, эзлэгдсэн угсаатаныхаа хувьд бус төрөлтөнүүд газар нутгаар ихээхэн хавчигдах болжээ. Сибирийн бус төрөлтөнд багтаж, арван таван эцгийн гэгдэж явсан хамнигадын цөөн хэсэг нь 1904-1905 оны Орос, Японы дайны хөлөөс дайжин Монгол тийш нүүж эхлэсэн байна. XX зууны эхээр Бооржоос зүүн тийш Үлирэнгэ, Хуандай орчим байсан буриад, хамнигад, орос нийлсэн хэсэг өрх Орос, Японы дайн эхлэнгүүт Шинэхээн, Хайлаар хүртэл нүүжээ. Тэдгээр 350 гаруй өрх айлын дотор хамниган болон орос өрх 20 шахам байсан байна. Тэнд очсон буриад-монгол, хамнигад Хайлаараас урагш Имэн гол хүрч улмаар 1920 оны зун Монголын зүүн өмнөд хязгаараар орж ирэн Сэцэн хан аймгийн Эрхэмсэг бэйсийн хошуу, Илдэн гүний хошуугаар суурьшсан байна. 1919 оны үед тэдэн дээр Ага, Сүүгэлээс шууд ирсэн 200-аад өрх айл бас нэмэгджээ⁴². Тэдгээр буриад-монголчууд болон хамнигадаас Егүзэр хутагтын ивээлд орохоор Хан Хэнтий уулын аймгийн Эрдэнэцагаан уулын хошуунд очин, Олноо өргөгдсөний 11-р онд ...Нанзад, Цэвэгдорж, Шагдарсүрэн, Санжай, Даш, Жамбалдорж, Цэвээндорж ... нарын 26 хүн ойрхи хэдэн жилд Орос улс самууран хаан эзнээ байлгаж, засгийн эрхийг шилжүүлэн хувьсгах тухайд тэдний харьяатад захирагдаж асан манай монгол овог, шарын шашинт буриад, хамнигадын зэрэг олон хүмүүс зөвлөлдөж, язгуур үндэсээ эрхэмлэн батлаж, тусгаар зогсохыг тууриван дагаж буй сацуу, Оросын самуун улмаар нэмэгдэж хэд хэдэн анги хуваагдаж, харьяат буриад, хамниган нар захиран хамгаалах эзэнгүй гал усны адил гашуун зовлонд унан,

³⁹ Эвенг үндэстний товч түүх, ӨМАХХ-1988, 73 т

⁴⁰ Буриадай түүхэ бэшэгүүд, Улаан-Үдэ- 1992, 139 т

⁴¹ Д.Е.Лаппо, Обычное право Сибирских туземных народностей. Первый Сибирский краевой Научно-Исследовательский съезд, Новосибирск- 1928, 79стр

⁴² Г.Батжаргал, Манай нутгийнханы алтан үргийнханы товч түүх, 1995, 19-20 т

хамга эд хогшлоо хаян зайлан дутахаас аргагүй болоод, газар тариалан ба хөрөнгө хогшил зэрэг зүйлийг орхиш, өөр өөрийн амь биесийг тэнхрүүлэн аврах газрыг эгээрэн гарч, ...Егүзэр хутагтын шанзудба зайсан нар танаа батлан мэдүүлээд гуйх нь зовлон гачигдлын туйлд тохиолдож, орших орон ба захиран хамгаалах захиралгүй болсон бид нарын үнэн учирьг байцаан толилж харьяат харьяат шавьд бүрэн багтаан захирч өршөөх ажаамуу⁴³ хэмээн мэдүүлж Халхын Егүзэр хутагтын шавьд багтжээ. Эдгээр буриад, хамнигадын заримууд нь 1923 оноос Халх Нөмрөгийн буриад хошуунд захирагдаж байжээ. Тэд хамнигад ба буриад нарын үр садын олонхи нь эдүгээ Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын нутаглаж байна.

Монголын зорьсон хамнигадын нүүдэл октябрын хувьсгал, түүнийг залган гарсан иргэний дайнаас шалтгаалж 1920-од он нилээд гартал үргэлжилжээ.

Дорнод Монголын хамниганы дийлэнх нь 1917 онд Орост өрнөсөн октябрын хувьсгал, түүнийг залгаж эхлэсэн иргэний дайны хөлөөс дүрвэж Монгол руу үнэнхээ тэмүүлэн ирэгсэд юм⁴⁴. Тэд Хан Хэнтий уулын аймгийн Халх Нөмрөг голын хошуу, Улз голын буриад хошуу, Онон голын буриад хошуунд захирагдаж явсаар Хэнтий аймгийн Биндэр, Дадал, Дорнод аймгийн Баян-Уул, Баяндун, Дашбалбар, Цагаан-Овоо сумдын нутагт голлон сууж байна. Архивын баримтаас үзэхэд, эдгээр хамнигад Буриад-Монголын Адгаалиг(Адаголик)хошууны Бэрц, Гүнэй, Дульдирга, Зүтгэл, Онгоцон, Үзөөн⁴⁵, Сартуул, Хорийн аймгийн Ярууна хошууны Хөшүүр суманд харьяалагдаж Онон голын сав болон Бэлр, Бэрц, Балжхан, Үлирэнгэ, Талаца, Цамхаг, Сүмэндээр нутаглаж байсан ажээ⁴⁶. Тэднийг Ардын Засгийн Газар, орон нутгийн захиргаа огтхон ч цааргалалгүй буриад-монгол, хамниган алиныг нь ч үл ялган айл өрх бүрээр “гар даах бичиг” үйлдүүлэн баталгаа гаргуулж газар нутаг оноон сууртшуулсан бөгөөд уул газраа одоог хүртэл зохислон нутагласаар байна. Гэвч шашин ясны барилдлагаа дагаж Монголд ирээд аж амьдралаа төвхнүүлж эхлэсэн буриад-монголчууд болон хамнигадыг хувьсгалын хөл үймээнээс ч дутуугүй хөнөөлтэй “их хэлмэгдүүлэлт”-ийн эмгэнэлт хувь тавилан хүлээж байжээ. ЗХУ-ын ДХАК-ын улс төрийн газрын заавраар 1930-аад онд Хэнтий, Дорнод аймгийн буриад-монгол голдуу олон зуун иргэдийг 1917 оны хувьсгалын үйл хэргийг эсэргүүцэж нүүр буруулсан гэж буруутган, Японы тагнуул гэх зохиомол хэрэг тохоож ялласны дотор цөөнгүй хамнигад багтсан байдаг. Хэнтий аймгийн Биндэр сумын нутаг баруун

⁴³ ТТА, Ф- А29, Д- 2, ХН- 298

⁴⁴ Ганц манай улс руу ч биш 1940- өөд он хүртэл улс төрийн янз бүрийн шалтгаанаар хэдэн арван мянган буриад-монголчууд Австрали, Хятад зэрэг улсууд руу цагаачлан гарсан гэдэг (Как исчезла единая Бурят- Монголия (1937 - 1958 годы), Улан-Удэ- 2004, 75стр). Түүхэн урт хугацааны турш хөрш зэргэлдээ сууж, хэл соёлын талаар амьд холбоонд оршиж байсан буриад-монголчууд ба хамниганы хувь заяаг салгаж үзэх аргагүй тул буриад-монголчуудын нэгэн адил хамнигад ч гэсэн мөн үед дээрх улсууд руу цагаачлан гарсан гэдэг нь эргэлзээгүй.

⁴⁵ 1925 оны Буриад-монголын автономитын нутаг дээрх алба төлөгчдийн бүртгэлд Үзөөн сумын харьяатуудыг нийтэд нь түнгүүс гэж бүртгэсэн байдаг. Список населенных пунктов Бурят-монгольской Автономной Социалистической Советской Республики, Верхнеудинск-1925

⁴⁶ Буриад-монголчуудын хүсэн дагах бичигт Буриад-Монголын Адгаалиг хошууг хамниган-буриад хошуу гэсэн байна. ТТА, Ф-92, Д-1, ХН-1, 7, 15

Манхаадайгаас бөгтөр Өлзий, Санжайжав, Сүхээлэй, Жамъяангийн Балжин(Балдан), Балдангийн Чой, жартгай Нанзад, Гүрийн Жанчив, Тал орчимоос Норовын Чойндон, Бадрах, Дамдин, Гомбо, Шинэн, Равдан, Жамъян, Жамъянгийн Түчин, Жамъяангийн Зундуй, Адуун Юндэн, Адуун Соён зэрэг хамниган эрчүүд, нэгэн халуун бүлийн эцэг, хөвгүүд, Амгалантын хийдийн Дамба, Буд(Бүд) гэлэн Бараади, Дугар, Цэдэн, шар Наваан зэрэг хамниган лам нар баригдсанаас ихэнх нь Цаазлагдаж, зарим нь 5-10 жил шоронд хоригдох ял эдлээд эргэж ирсэнийг нутгийн иргэд, тэдний үр хүүхэд, ах дүү нар одоо болтол гэрчлэн дурсаж байна. Тухайн үед 40-өөд толгой үхэр, хориод хонь, арав гаруй адуутай хамниган өрх эсэргүүний ар гэр гэгдэн мал, хөрөнгөө хураалгаж 1 морь, 1 гүү, 1 үнээ, 2 бяруутай үлдэж байжээ⁴⁷. Эрчүүдийг нь хомрогolon баривчилж хөрөнгө малыг нь хурааснаар эдийн засгаар төдийгүй сэтгэл санаагаар нэрмэж, тэдний аж амьдралд хүнд цохилт өгчээ. Эдүгээ дээрх үйл явдал түүх болон улирч хамнигад тусгаар Монгол улсын ард нийтийн жишгээр аж төрөн, эрх чөлөөгөөр бүрнээ хангагдан амьдарч байна. Монголын хамниганы дундаас хэл бичгийн ухааны доктор, зохиолч өвгөөдэй хэмээх Цэндийн Дамдинсүрэн⁴⁸, улсын гарамгай мэргэн Аюушийн Цэвээн, улсын мэргэн Цэвээний Хүдэрчулуун, Монголд уулын спортын үндсийг тавьсан ахмад уулчин н. Раднаа, улсын анчин Чойдогийн Лувсан зэрэг нэртэй цуутай хүмүүс төрөн гарчээ.

Монголын хамниганы угсаа- түүхээс үзэхэд:

- Сэцэн ханы хамниганы Монголд суурьшсан нь ХҮII- ХҮIII зууны үед холбогдоно.

- Сэцэн ханы нутагт авчирсан хамнигад нэг бус удаа бүлэглэн оргож байсан тул халхын Сэцэн хан тухай бүрт нь нэхэн авчирч, гэрийн боол болгон, Сэцэн ханы хошуу, засаг Буяндэлгэрийн хошуу, гүн Гомбожавын хошуунд хүч тарамдуулан гурван анги салган суулгасан байна. Засаг захиргааны хувьд Сэцэн ханы гол хошуунд захирагдаж байсан тул дээрх гурван хошууны хамниганыг нийтэд нь “Сэцэн ханы хамниган”, “ханы хамниган” гэж нэрлэж байжээ.

- Ерөөгийн сав газраар нутаглаж анхдугаар Богдын анхны шавийн нэг гэгдэж байсан хамнигад нь намиад ба пөинкин отгоос бүрдэж байсан байна. Тэднийг нутагшилаар нь сурвалж судалгааны бүтээлд Ерөөгийн хамниган гэж нэрлэжээ.

⁴⁷ О.Баттуяа, Хэнтий аймагт ажилласан судалгааны гар бичмэл, 2005

⁴⁸ Цэндийн буюу “өвгөөдэй” Дамдинсүрэн 1911 онд Тэнүүнд төрсөн. Ар найман хорины хамниган юм. 1924 оны зун Биндэрьяа хан уулын хошууны танхимын анхны сурагчаар төгсөөд 1926-1929 онуудад аймгийн төвийн бага сургуульд суралцжээ. Тэндээс Улаанбаатар хотноо шилжин уран зохиолчдын дугуйланд суралцахын хамт удирдах ажилтны курс дүүргэжээ. 1935-1937 онд Үнэн сонины хариуцлагатай эрхлэгчийн албыг хашиж байв. Мал Тариалангийн яамны орлогч сайд байхдаа улс төрийн хилс хэргээр баривчлагдаж, 10 жил хоригдоод суллагдсан байна.

- Дорнод Монголын хамниганы Монголд ирж суусан нь ХХ зууны эхэн үеийн улс төрийн үйл явцаас шууд шалтгаалсан бөгөөд ХҮИИ зууны үед хаант Оросын өмнөд хилд харуулаар суусан 15 эцэг хамниганы удам хойчис гэж болно.

2. Хамниганы засаг захиргааны харьяалал, нутагшил, хүн ам

Сэцэн ханы хамниганы нутагшил, захиргаа, хүн ам. Түгээмэл элбэгтийн 3-р(1854)оны баримтад өгүүлсэнээр ... “луча хамниган” буюу Сэцэн ханы хамниганыг 1680-аад оноос харьяа хошуунаас ангид хөвч хангай бүхий хан Хэнтий уулын өмнө этгээд Хэрлэн голын эхэн Гурван Хориуд, Тэнүүн зэрэг газраар⁴⁹ нутаглуулж байгаад 1850-иад оноос нутгийн гүн рүү татаж Зорголын өмнүүр Ногоон нурууны хойгуур Бууралын Хөх чулуу, Даянт, Шургуйт, Баян хан, Баян ханы ар Хар толгой, Таван толгой зэрэг газраар суулгасан байна. Босго Тэнгэрийн даваанаас баруун өмнө байх Гурван Хориуд(Хориудын дээд, дунд, доод ам) нь Хан Хэнтийн тусгай хамгаалалтын бүс нутагт багтана. Чингис хаан болон түүний хөвүүн Толуй, ач Мөнх, Хубилай нарыг оршуулсан Их Хоригийн нутгийн өмнөд хилийн дээс Гурван Хориуд нь ХҮИИ зууны зурвас үед ханы хамниганы түүхэн нутаг болж байв. Гурван Хориудыг эрдэмтэн С.Бадамхатангийн бүтээлд, ... Хэрлэн дагуу Элэгцэг, Босго, Хонин өндөр, Гурван сайханы үзүүр, гурван Хориуд гэх дээд, дунд, доод ам байдаг. Хэрлэнгийн зүүн эрэг дагуу нутаг нь Сэцэн хан аймгийн Навааншүхэртийн хошуунд харьяалагдаж дотроо захиргааны хуваарилалтаар урианхад, хамниган гэсэн 2 отог болж явсан ажээ. Энэ Навааншүхэртийн хошуу гэдэг нь хуучинаар засаг Буяндэлгэрийн(1842-1853) хошуу юм. Гурван Хориуд нь урианхад отгийн нутаг байсан. Нөгөө хамниган отог нь Тэнүүний амаар нутаглаж, хожим ХҮИИ зууны үед Өндөр гэгээнд шавиар өргөгдөн шавь отог болсон⁵⁰ гэсэн байдаг. Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутагт багтах Тэнүүнийг одоо ч гэсэн хамниганы нутаг гэж тодотгож байна.

Хамниган настаны хуучилсанаар, Тэнүүний цээжинд хамнигад нутаглаж ирсэн. Хамниганы гол нутаг Тэнүүн байсан одоо ч Тэнүүнийг хамниганы нутаг гэж хэлэгдсээр байна.

Архивын баримтад Сэцэн хан Артасэдийн хошууны хамниган ард 1821 оны үед ... “Хэнтий хан уулын тайх овоо”-нд маш ойрхон засаг Цэдэнгогийн хошууны нутаг Тэнүүн, Тэнүүний эх Бугут кэрэг газарт нутаглаж байсан гэжээ. Тэнүүн гэдэг нь 50 орчим км үргэлжилсэн олон амтай, Тэнүүн голын сав нутаг.

Хориуд нь Сэцэн ханы гэрийн боол хамниганы нутагт гарцаагүй тооцогдох бөгөөд 1825 оны үед тэдгээр хамнигадыг уг нутгаас нүүлгэхээр шийдсэн байдаг. Гэтэл хамнигадыг өөрсдийн цагдан суусан ав хомрогын газарт хулгайгаар ан

⁴⁹ ТТА, Ф-М34, Д-2, ХН-30, Ф-М34, Д-2, ХН-37

⁵⁰ С.Бадамхатан, Эрдэм шинжилгээний бүтээлүүд, III боть, УБ-2006, 156 т

гөрөө хийх, гал алдах, бусдад заалдагдах зэрэг хэрэг өдүүлэх болов хэмээн буруутгаж тэднээс заримыг нь Сайшаалт Ерөөлтийн 25-р(1820) онд Да Сэцэн хан, Дэд да вантаны газраас яллаж шийтгээд, үлдсэн ардыг нь уг нутгаас татаж харьяа хошуунд нь(Сэцэн ханы хошуу) ойрхон засаг Цэмбэлжавын хошууны⁵¹ нутаг Зорголоос өмнө тийш нүүлгэн шилжүүлэхээр⁵² болсон ч олон арван жил идээшиж суурьшсан нутгаа орхихыг тэмчээгүй хамнигад Хэрлэн голын эхэн, Тэнүүн голын Бугат, Гурван Хориуд зэрэг газар Хан Хэнтий уулын ойролцоо хоргодон суусаар байжээ. Тэд нэг бус удаа шаардуулсаны эцэст Тэр гэрэлтийн эхний онуудад Хэрлэн голын эхнээс урагш засаг Цэдэнгогийн⁵³хошууны нутаг Зорголын өмнүүр Ногоон нурууны хойгуур Бууралын Хөх чулуу, Даянт, Шургуйт, Баянхан, Баянханы ар Хар толгой, Таван толгой зэрэг газраар уван цуван нутагшсан байна.

1841 оны 7 сараас эхлэн засаг Цэдэнгогийн газраас хэдэн удаа хүн томилж, хамниган ардыг хошууны нутгаас хөөж эхлэжээ. Түгээмэл элбэгтийн 3-р оны(1853)архивын баримтад,... урьд Төр гэрэлтийн 21-р оны(1841) 9 сард Цэдэнгогийн хошууны гэлэн Цэдэн хамниганы дарга Буджав миний 20 илүү жил өвөлжиж малын хашаа аргал зэргийг бэлтгэсэн Баянханы ар Хар толгойн бууцад буугаад, учир хэлж нүүхийг гуйвч огт хэрэгсэхгүй тул цаг гачаал бөгөөд аргыг эрж язгуурын найрамдалтай ёсоор айл бууя гэтэл гэлэн Цэдэн мөн огт хэрэгсэхгүй харин ихэд авирлаж миний өмссөн дээл зэргийг урж басхүү гэрийн ачааг холибуулан унагаж, унь ханыг эвдсэн⁵⁴ гэсэн хэрэг тэмдэглэгдэн үлджээ. Энэ мэт газар бэлчээрийн хэргийг нэг тийш болголгүй сунжруулж, дээр нь хамниган ардын нутгийг тодорхой зааж өгөхгүй байсан тул эндхийн хамнигад цаашид хаана нутаглахыг зааж өгнө үү! Хэмээн Сэцэн ханы хошуу захиргаанд хандахад, Төр гэрэлтийн 23-р онд(1843) уул хошуу захиргаа тэднийг Зорголын өмнөх нутагт⁵⁵ хэвээр суулгахаар шийдсэн⁵⁶ хэдий ч засаг Буяндэлгэр⁵⁷ тогтсон энэ зүйлийг дагахгүй хамниган ардыг хөөсөөр байсан тул 10 гаруй жил сунжирсан хамниганы газар нутгийн маргаант хэргийг дахин шүүхээс аргагүй болжээ. Ингээд түгээмэл элбэгтийн 3-р оны(1853)4 сарын 20-д Хэрлэн Барс хотын чуулган даргын газраас жанжин Сэцэн хан, засаг буяндэлгэр нарын хошууны хооронд засаг Цэрэндашийн хошууны нутаг дунд Зүртэйн эхэнд⁵⁸ газар болзож, хамниганы нутгийн маргааныг таслахаар засаг Цэрэндашийн хошууны захирагч

⁵¹ Сэцэн хан аймгийн Далай Дархан бэйлийн хошууны засаг Цэмбэлжав- 1794-1820 онд засаг тэргүүн зэргийн тайж залгамжилсан.

⁵² ТТА, Ф-М34, Д-2, ХН-25

⁵³ Засаг Цэдэнго(Цэдэнгаваа)- засаг Цэмбэлжавыг үе залгасан(1821- 1842)

⁵⁴ ТТА, Ф-М34, Д-2, ХН-37

⁵⁵ Хамниганы нутагт багтаж байсан Таван толгойг Төр гэрэлтийн 25-р онд (1845) гүн Гончогцэрэнгийн хошууны нутаг болгосон байна.

⁵⁶ Ф-М34, Д-2, ХН-37

⁵⁷ Засаг Буяндэлгэр нь засаг Цэдэнгог залгамжилсан.

⁵⁸ Энэхүү дунд Зүртэй гэх газар нь Сэцэн хан аймгийн Мэргэн гүний хошууны нутгийн зүүн хойд талд байна. Мэргэн гүний хошуу нь хойгуураа Жонон вангийн хошуу, зүүн өмнө талаараа Сэцэн ханы хошуу, баруун өмнө талаараа Баатар бэйлийн хошуутай хиллэж байжээ. Одоогийн Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын нутагт багтана.

Чимиддоржийг томилж, түүнд, ... ухах сайн бичигч, жич хөтөл хүмүүн нижгээдийг дагуулан тус аймгийн улаа хэрэглэх тэмдэгт олгож мордуулаад, тогтоосон өдөр газрын болзоонд хүрч хэргийн доторхи түшмэд ардыг бүрнээ нүүр учруулан нарийвчлан шүүж, эрх биш нэг тийш нь болгохыг даалгаж, басхүү нийлэх түшмэл бичигч нарын эл хэрэглэлийг харьяат 2 хошуунаас хувь адил хуваан хэрэглүүлэх явдлыг хамтран гаргахаар... мөн оны 3 сарын 17 өдөр тохирсон⁵⁹ ажээ. Энэ мэт маргаан зөрчил дагуулсан Сэцэн ханы хамниганы газар нутаг төдийлөн өөрчлөгдөлгүй явсаар ХХ зууны эхэнтэй золгожээ.

Ардын засаг тогтоосны дараах засаг захиргааны шинэчлэлт өөрчлөлтийн үеэр хамниганы газар нутгийн асуудал дахин хөндөгдсөн байдаг. 1931 онд Хэнтий аймгийн Хэнтий хан сум байгуулагдахад⁶⁰ Сэцэн ханы хамнигадыг тус сумын харьяат болгожээ. 1932 онд хуучин Сэцэн ханы эдгээр хамнигад Төв аймгийн Мөнгөнморьт⁶¹ суманд харьяалагдах хүсэлт гарган тус сумын 6, 7-р баг гэгдэх болсон ч Мөнгөнморьтын нутагт ирэлгүй Хэнтий хан сумын Хэрлэн голын эх, Тэнүүн, Зоргол, Зэргэмжээд нутагласан хэвээр байв. Тэд тус газарт цаашид ч нутаглах хүсэлтэй байгаагаа иэлрхийлж Мөнгөнморьт сумын 5, 6-р багийн дарга нар болон Төв аймгийн Яамны даргаар дамжуулан 1934 оны 9 сарын 4-нд БНМАУ-ын Засгийн Газрын ерөнхий сайд Гэндэнд захидал илгээсэн байна. Уг захидалд, ... тэдний олон ардууд эртний цагаас эхлэн хуучин Сэцэн хан хэмээх эдүгээ Хэнтий аймгийн баруун хойдох ой мод, хад асга, ус намаг, уул бартаа эзлэсэн өнцөг буланда ташаалдсан Хэрлэн голын эхэн ба Тэнүүн, Зоргол, Зэргэмжээ нэгэн хэсэг газарт хүн мал нийтээр идээшил суурьшилыг гүнээ олсоны тул Хэнтий аймгийн Хэнтий сумын нутагт хэвээр нутаглан буй болой. Хэнтий аймгийн Хэнтий сумын захиргаанаас бэрх хэцүү нугалаатны үед “Ар найман хорин”⁶² хэмээн нэрлэж хамтрал коммунаар далимдуулан бэлчээрийн тачир, усны багад нутаглуулсан... болон .. мал сүргийн тарга хүч авахуулахгүй хадлан бордоо үл бэлтгүүлэн, албан улаа зэргийг нэн үлэмж ноогдуулан энгийн номхон шударга ардуудыг ялимгүй хэрэгт холбогдуулан барьж хорих, байцаах, нэгжих зэрэг хөрөнгө зоорийг ихэд үрэгдүүлэн сүйтгүүлж, элдэв гачигдал зовлон учруулсаныг тоочиж барахгүй. ... Тэдгээр олон ардуудыг харьяа сумын нутагт

⁵⁹ ТТА, Ф-М34, Д-2, ХН-37

⁶⁰ МУ-ын засаг захиргааг дахин шинэчлэхэд Монгол улсын Засгийн Газрын 1931 оны 2 сарын 6-ны өдрийн II хурал ба улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1931 оны 2 сарын 7-ны өдрийн Y тогтоолоор Хэнтий хан сумыг байгуулжээ. М.Пүрэвдорж, Хөвчийн жонон вангийн хошуу, ӨХ-1993, 98т

⁶¹ БНМАУ-ын бага хурлын тэргүүлэгчдийн 1931 оны 2 сарын 7-ны өдрийн Y тогтоолоор мөн аймгийн Богдхан уулын хошуунаас байгуулагдаж, нутгийн үзэсгэлэнт уулын нэрээр Мөнгөнморьт хэмээн нэрлэгдсэн гэнэ. О. Пүрэв, Төв аймгийн Мөнгөнморьт сумын түүх, УБ-2003, 45т

⁶² “МУ-ын нутгийн захиргааны дүрэм” болон “Засаг ба засаг бус ван гүнгүүдийн дүрэм” гарч аймаг, хошуудыг тухайн орон нутгийн газар усны нэрээр нэрлэх болсны дагуу Мөнгөнморьт сумын зүүн хэсэг нь Хан Хэнтий уулын аймгийн Хан Хэнтий уулын хошууны Хэнтий хан сумын нэг хэсэг нь болж “Ар найман хорин” нэртэйгээр зохион байгуулагдсан байна. 1928 онд хуралдсан улсын Y Их Хурлаар 150 өрхтэй сумыг 300 өрхтэй болгож, арваныг 20 өрхтэй болгож “хорин” гэж нэрлэх болсон тул “Ар найман хорин” гэдэг нь 160 орчим өрх айлтай гэсэн үг юм.

суулгахгүй хэмээх буюу Мөнгөнморьт сумын захиргаанд өөрийн харьяат ардуудыг татаж авсугай хэмээх утгатай бичиглэл ирүүлэх хийгээд түлээ түлш, хадлан бордоо авахуулахгүй, тус сумын нутагт малын шинэ хашаа саравч бариваас хурааж хумхин авна... гэх зэргээр дарамтлаж байсныг нэгд нэгэнгүй тоочжээ. Гэсэн хэдий ч тэд... дээр дурьдсан Хэрлэн голын эхэн ба Тэнүүн, Зоргол, Зэргэмжийн газрыг эзэмшин мал ажил, ан гөрөө бус дэлхийн баялагт шүтэж, амьдран хүмүүжсээр ирсэн эл нутгуудад өвгөд хөгшдийн хүүр сэлтийг оршуулсан газраар онгон сүлдээ болгон тахиулсан уул, овоо гэгээн ард олны мухар сүсэг бишрэлтэй гүнээ зууралдсан сүм хийд буй, ер ч олон жилд нутаглан идээшсэн дөрвөн цагийн эргэлтэнд тохируулсан хүн малын салж хагацаж болшгүй идээшлийг олцгоосон нутгууд үүнээс өөр үгүй... тул хавчилга дарамтыг тэсвэрлэн энэ газарт нутагласаар ирсэнээ өгүүлж, өөрсдийнхөө ... мод ан гөрөөлийг шүтэж амьдран хүмүүжсээр ирсэн байдал ба зан суртлыг ... толилон үзэхийг хүсэхийн хамт ... хэрвээ тус Хорин нэгэн оршин буй нутгаас бидний олон ард алслан гарч нүүн орхиж одоход хүрвээс оронд хэнээр ч хэрэглэхгүй тийм эзэнгүй нутаг болон үлдэнэ⁶³ гэдгийг онцолсон байна. Мөн захидалд,... манай 2 багийн ард бол эртнээс нааш тусгай тусгай хошуу нэрлэгдэн явсан гэх эдгээр хамнигад нь хуучинаар гүн Гомбожав, засаг Буяндэлгэр нарын хамниган юм.

Шавийн хамниганы тухайд эрдэмтэн С.Бадамхатан, өнөөгийн Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын төдийг уруудан нутаглаж байсан Бишрэлтийн отог дотор хамнигад багтаж явсан гэж тэмдэглэжээ. Энэхүү Бишрэлтийн отог гэдэг нь Сэцэн хан аймгийн Дархан бэйлийн хошууны нутаг Цэнхэрийн голын эхэн сав, Борхын⁶⁴ рашаанаар байсан бөгөөд Бишрэлтийн отог нь 1925 онд Дэлгэр их уулын аймаг байгуулагдахад хамт нутаглаж байсан Эх Дагинын отгийн хамт Цэнхэрнугаарын отог болсон байна⁶⁵. 1926 онд Дэлгэр их уулын аймаг татан буугдахад Цэнхэрнугаарын отог нь Жаргалант уул, Хэрлэн Бэрстэй отгийн хамт Хэн Хэнтий уулын аймгийн Баянзүрх уулын хошуу болж, мөн 1931 онд энэ хошуугаар

1926 онд Дэлгэр их уулын аймаг татан буугдахад Цэнхэрнугаарын отог нь Жаргалант уул, Хэрлэн Бэрстэй отгийн хамт Хан Хэнтий уулын аймгийн Баянзүрх уулын хошуу болж, мөн 1931 онд энэ хошуугаар өнөөгийн Цэнхэрмандал, Жаргалтхаан сумдыг байгуулжээ. Эрдэмтэн Л.Мишиг хуучин Хэнтий сумаас баруун тийш Хурхын голоор Солборын⁶⁶ хамниган гэж 30 шахам өрх айл байсныг дурьдсан байдаг⁶⁷. Одоо Төв аймгийн Мөнгөнморьт суманд өөрсдийгөө хамниган овогтой гэх цөөн тооны хүмүүс байна. Тэдний зарим нь гамингийн үймээний

⁶³ О.Пүрэв, Төв аймгийн Мөнгөнморьт сумын түүх, УБ-2003, 49- 50т

⁶⁴ Бор хургын рашааны нэр сүнжраад Борхын рашаан гэх болсон нь энэ. Н.Бүрэнтөгөлдөр нар, Цэцдийн шастирт мөнхөрсөн Цэнхэрмандал, Модот- 2005, 6т

⁶⁵ Ц.Сономдагва, БНМАУ-ын орон нутгийн засаг захиргааны хуваарьт гарсан өөрчлөлтүүд (1921-1965), УБ-1967, 74-77т

⁶⁶ Солбор- Хуучинаар Хэнтий сумын нутаг одоогийн Өмнөдэлгэр сумын нутагт байдаг уулын нэр. Заримдаа Салбар гэж дуудах болжээ.

⁶⁷ Л.Мишиг. МАУ-ын хамниган аялгууг сурвалжилсан нь. Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтдийн анхдугаар их хурал. УБ- 1961,184т

хөлөөс дайжиж Сэлэнгийн нутгаас Минжийн хангайг дамжин тус суманд ирж суусан, мөн эртнээс(хэдий үеэсийг сайн мэдэхгүй ч өөрсдийн үеэс 2-3 дээш үедээ) л Тэнүүн, Тэнүүний цээжинд нутагласаар ирсэн гэх ажээ. Социализмын үед сумын дарга нар өвөлжөө бууц зааж өгдөг болсоноос хойш Тэнүүн эзгүйрсэн гэнэ. Хэнтий аймгийн Цэнхэрмандал суманд хамниган овогтой 10 гаруй хүн байгаа нь Сэцэн ханы хамниганы хойчис юм. Цэнхэрийн цээж, Хөх нуур, Таван толгой хооронд хавчигдмал хэдэн өрх байсан. Тэднийг

Буяндайгаа(Даянтад байдаг уул) Хэнтий гэдэг

Даянтаа далай гэдэг

Бух Сандагаа бөх гэдэг

Булуу Жүгдэрээ (толгойн ардаа булдруутай хүн байж)уургач гэдэг... гэж шоолдог байсан гэнэ. Урьд Тэнүүн их тахал гарч⁶⁸ цөөн хэдэн өрхийг золигт гаргасан гэдэг. Тэгж золигт гаргасан хамниган өрхийн улс энэ болоод явж байгаа нь бололтой. Цэнхэрмандалынхан хойд чигийнхэн гэж ярьна. Хойд чигийхэн гэдэгтээ хамниган, урианхай нараа багтаадаг. Хойд чигийхэнийг галын тавтай, галын тав гэдэг нь замгүй гэдэгсэн. Галын тав гэдэг нь эмэгтэй талаа дагадаг болтой байдаг. Галд нь өөх тос өргөдөг юм гэнэ лээ. Урианхайд нь ч байдаг байж магадгүй, урианхадаар явахад улцан нүдийг урчих юм биш байгаа гэж улцан нүдтэй Наваан Дугар гэж хүн ярьж байсан гэцгээж байна. Сэцэн ханы хамнигадын үр сад Цэнхэрмандалын нутагт цөөн тоогоор нутаглаж байна.

Сэцэн ханы хамниганы хүн амын байдал. Манжийн төрийн захиргаанаас 3 жилд нэг удаа ар Монголын хүн ам, эд хөрөнгийг тоолж байсны дотор хамнигад бас хамрагджээ. Монголын хамниганы хүн амын тооллогын баримтын хамгийн эртнийх нь Тэр гэрэлтийн 21-р онд(1841) холбогдож байна.

Хүснэгт1. Тэр гэрэлтийн 21-р онд (1841) Сэцэн ханы хошууны хамниган ардын хүн, малыг байцаан тоолж өргөсөн дэвтэр данс⁶⁹. Хамниганы дарга Дэлгэр:

Өрх	Ам	Адуу	Тэмээ	Үхэр	Хонь
45	180	170	-	467	597

Хүснэгт 2. Бадаргуулт төрийн 5-р оны(1879) тооллогын баримт данс⁷⁰.

Дэд да Сэцэн хан Лхасүрэнгийн⁷¹хамниган:

өрх	Ам	Адуу	Тэмээ	Үхэр	Хонь

⁶⁸ Тэнүүний цээжинд гарсан тахалыг Нанзан(зарим нь Молон зоч гэж байв)зоч дарсан гэдэг. Нанзан зоч гэж их чадалтай зоч – дэр голдгоороо чи газар хэвт, дэвсгэр голдгоороо би наана чинь хэвтэе гээд үхсэн хүнийг цээрлэлгүй орноос нь буулгаж орхиод өөрөө оронд дээр нь унтаж амраад ном гүрмээ уншиж тахлыг дарж явсан юм гэдэг.

⁶⁹ ТТА, Ф-М34, Д-2, ХН-12

⁷⁰ ТТА, Ф-М34, Д-1, ХН-414

⁷¹ Сэцэн ханы хошууны засаг Жанасрайн Лхасүрэн (1873- 1889).

45	197	65	5	59	351
----	-----	----	---	----	-----

Хүснэгт 3. Гүн Гончигцэрэнгийн⁷²(Жонон ван) хошууны Түгээмэл элбэгтийн тэргүүн оны(1851)тооллогын данс⁷³. Дарга Дашийн хамниган:

Өрх	Ам	Адуу	Тэмээ	Үхэр, сарлаг	Хонь, ямаа
184	952	801	7	1866	4970

Хүснэгт 4. Гүн Гончигцэрэнгийн хошууны хамниган ард Түгээмэл элбэгтийн 11-р оны(1861)баримт⁷⁴.

Өрх	Ам	Адуу	Тэмээ	Үхэр, сарлаг	Хонь, ямаа
147	976	521	5	2263	4219

Баримтад өгүүлсэнээр(Хүснэгт-1)Сэцэн ханы гол хошууны хамниганы нэг өрх дунджаар 4 хүнтэй, тооллогын хоорондох 40 шахам жилийн дотор энэ хошууны өрхийн тоо хэвээр, хүн ам нь 20 хүрэхтэй үгүйтэй өсч, харин Гончогцэрэнгийн хошууны⁷⁵хошууны хамниган өрхийн тоо тооллогын хоорондох 10 жилд 37-оор цөөрч, хүн 24-өөр нэмэгджээ. Хамниганы нэг өрх айл 1851 онд 5 ам бүлтэй байсан бол 1861 оны байдлаар тус хошууны нэг хамниган өрх 6 хүнтэй байсан байна. Харин Сэцэн хан аймгийн засаг Буяндэлгэрийн хошуу хамнигантай байсан хэдий ч тус хошууны хамниганыг бүртгэсэн тооллогын баримт хараахан олдсонгүй. 1851 онд Ванчин эрдэнэд өргөх мөнгөний оноосон хэмжээнээс⁷⁶ харахад, засаг Буяндэлгэрийн хошууны хамниганд гүн Гончогцэрэнгийн хамниганыхаас 6 дахин бага мөнгө ноогдуулсан байх тул засаг Буяндэлгэрийн хамниган гүн Гончогцэрэнгийн хамниганыхаас 6 дахин бага мөнгө ноогдуулсан байх тул засаг Буяндэлгэрийн хамниган гүн Гончогцэрэнгийн хамниганаас 6 дахин цөөн буюу ойролцоогоор 160 гаруй хүнтэй, мал хөрөнгө нь ч тийм хэмжээгээр цөөн байсан биз. Манжийн төрийн үеийн энэ мэт бүрэн бус мэдээ баримтаар баримжаалан тооцвол, XIX зууны сүүлийн хагас 1850-иад он орчимд Сэцэн ханы дээрх гурван хошууны хамниганы нийт хүн ам 1400 орчим болоод байсан бололтой.

Хүснэгт 5. Дайчин жонон вангийн хошууны Хамниган отгийн хүн ам 1910-аад онд :

өрх	Эмэгтэй	Эр	Хар	Лам	Нийт хүн ам
-----	---------	----	-----	-----	-------------

⁷² Гомбожавын Гончогцэрэн засаг, улсад туслагч гүн

⁷³ ТТА, Ф-М40, Д-1, ХН-10

⁷⁴ ТТА, Ф-М31, Д-1, ХН- 995

⁷⁵ 1828 онд гүн Гомбожав хошууны засаг барьж байв. Мөн үед хошууны хүн ам 8862, өрх 1967 байжээ.Ш.Нацагдорж, Сум, хамжлага, шавь ард, УБ-1972, 128т

⁷⁶ ТТА, Ф-М31, Д-3, ХН-860

128	231	200	100	100	431
-----	-----	-----	-----	-----	-----

1926 онд Өндөрхаан уулын хошуунаас⁷⁷Дэлгэр их уулын аймгийн Баянзүрх уулын хошуунд захирагдсан хамниган өрх -26, ам-128, үүнээс эр- 58, эм-70 гэж бүртгэгдсэн байна. Энэ нь Сэцэн ханы шавийн хамниган буюу Цэнхэрийн гол, Бор хургын(Борхын) рашаанаар нутаглаж байсан Цэнхэрнугаарын отгийн хамниган шавь нар юм.

Хүснэгт 6. Сэцэн ханы хошууны хамниганы нэг өрхөд ноогдох мал хөрөнгийн байдал.

	1841 оны байдлаар ⁷⁸	1879 оны байдлаар ⁷⁹
Адуу	4 толгой	1,4 толгой
Үхэр	10,3 толгой	1,3 толгой
Хонь, ямаа	13,2 толгой	7,8 толгой

Хүснэгт 7. Гүн Гончогцэрэнгийн хамниганы нэг өрхөд ноогдох мал хөрөнгийн байдал.

	1851 оны байдлаар ⁸⁰	1861 оны байдлаар ⁸¹
Адуу	4,3 толгой	3,5 толгой
Үхэр	10 толгой	15 толгой
Хонь, ямаа	27 толгой	28,7 толгой

Хүснэгт 7⁸². 1910-аад оны Дайчин Жонон вангийн хошууны Хамниган отгийн мал хөрөнгө:

Отгийн нэр	Адуу	Тэмээ	Үхэр	Хонь	Бүгд
Хамниган өрхийн	841	7	869	1144	2861

Хүснэгт 8⁸³.

Отгийн нэр	Адуу	Тэмээ	Үхэр	Хонь	Бүгд
Хамниганы жасын	89	-	191	770	1050

Монголын нийгэмд гэрийн хөвүүд, гэрийн боолын нэг хэсгийг дайны олзны хүн хүн бүрдүүлж байсан гэх⁸⁴тул Сэцэн ханы хамниганыг “дайны олзны хүн” гэдэгт хамаатуулж, Манжийн түрэмгийлэлтэй холбогдон гарч ирсэн “шинэ боол”, “өөлд боол” гэдэгтэй адилтган ойлгож болох юм. Сэцэн ханы хошууны хамниган 1820-иод оныг хүртэл гэрийн боол шинжээ хадгалсан маягтай байж мөн үеийн албаны

⁷⁷ Сэцэн ханы хошуу гэж байгаад 1923, 1924 оны үед Өндөрхаан уулын хошуу гэгдэх болсон.

⁷⁸ ТТА, Ф-М34, Д-2, ХН-12

⁷⁹ ТТХ, Ф-М34, Д-1, ХН-414

⁸⁰ ТТА, Ф-М40, Д-1, ХН-10

⁸¹ ТТА, Ф-М31, Д-1, ХН- 995

⁸² Д.Гомбосүрэн, Хөвчийн Жонон ван Цогбадрах, УБ- 2002, 19т

⁸³ Д.Гомбосүрэн, Хөвчийн Жонон ван Цогбадрах, УБ- 2002, 20т

⁸⁴ Ш.Нацагдорж, Сүм, хамжлага, шавь ард, УБ-1972, 38-39т

баримтад⁸⁵ ч тэднийг “гэрийн боол” хэмээн нэрлэж байжээ. Нэгэнт боол гэгдэж байсан эдгээр хамнигад Монголд нийтлэг байсан “гэрийн боол”, “гэрийн хөвүүд”-тэй адил өөрийн гэх өмч бараг үгүй байсан нь ойлгомжтой.

Сэцэн ханы хошууны хамнигад 1840-өөд он гэхэд аж төрөл туйлын ядуу, мөн үеэс 40-өөд жилийн дараа 1879 он гэхэд аж төрөл нь бүр ч дордож ханы хамниганы зарим малаар амьжиргаагаа залгуулах үндэсгүй шахуу болсон байжээ. Архивын баримтад,... 1868 оны намрын сүүл сараас эхлэн Түшээт хан, Сэцэн хан аймгийн олон хошуудын нутагт асар их цас унаж 4 зүйлийн мал...⁸⁶ ихээхэн сүйдсэн гэх бөгөөд тэдэнд хөрөнгөжих бололцоо байгаагүйн дээр байгаль цаг уурын энэ мэт гамшиг хүнд тусч, аж амьдралыг нь улам нэрмэсэн бололтой.

... Энх-Амгалангийн 27-р онд(1688) Галданы самуун тохиолдож, хэри дор Өмөхэй⁸⁷, түүний эхийн хамт хамгийг авч Шанзав Богдын соёлыг хүсэн түгээж орсон дараа дараагаар засаг хошуу байгуулж сум эр зохиосноос инагш тэдгээр лоча-ын үрс боол болсон хамниган ард язгуураас тэдний хан, бэйл, гүн, засгуудын гэрийн хүмүүн болж, эгнэгт аймаг хошууны жинхэнэ албан ... гаргуулж байгаагүй ч ... харьяат гэрийн эзэн засгуудын дорд гувчуур ... хэрэм, үнэг, гөрөөсний арьс үсний алба өргөж ⁸⁸ ... явсаар Сайшаалт ерөөлтийн 15-р оныг(1810)хүргэсэн байна. Мөн онд Сэцэн хан аймгийн чуулган даргын газраас ... элдэв албаныг давдуг гаргуулах учир, аймгийн өрх ам малыг байцаан тоолуулаад ... хамниган ард гэрийн боол хэмээх ардаас огт албан гаргуулсангүй язгуурын ... хуучин хэвээр үлдээхээр шийдэж Сайшаалт ерөөлтийн 24-р он(1819)хүргэжээ. Энэ үед хамниган ардууд урьдын адил хошууны засаг ноёдын шууд мэдэлд байж, дорд гувчуурыг нь залгуулж амьжиргаагаа бага зэрэг дэмнүүлсэн хэвээр байв. Харин Сайшаалт ерөөлтийн 23-р оны(1818)архивын баримтаас үзвэл, ... ав хомрогын газарт ойр Хэрлэн голын Гурван Хориуд зэрэг нутгаар суугаа Сэцэн хан Артасэдийн хошууны хэр ядуу хамниган ардаас(“луча”-ын хамниган-О.Б) ... зарлигаар цэрэг боловсруулан авлах ав хомрогын газраа цагдан суулгасан⁸⁹...гэх тул Сэцэн ханы хамниганы зарим нь мөн үед харьяа хан, засгуудын дорд гувчуурыг залгуулахын хамт аймаг, хошуунд биеэр зүтгэх алба хаах болжээ. Үүнээс хойш 1850-иад он гэхэд хамнигад нь аймаг, хошууны мал гаргах чинээгүй мөхөс ардуудад ноогдсон албыг туслалцуулан гаргахад оролцож эхлэсэн байна. Энэ тухай Түгээмэл элбэгтийн тэргүүн оны(1851)баримтад, ... Ванчин эрдэнэ гэгээн танаа өргөх, бас ... хамбад туслах иөнгө зүйлийг олон ноёдын хувь ба жас нар, хутагт хувилгаан, лам нар, тэдний шавь нар, суврагачин, хамниган ардад ... ноолгосноос гүн Гончигцэрэнгийн хошууны хамниган ард 32 лан, 5 цэн, 5 пүн, ... засаг Буян(Буяндэлгэр)-гийн хамниган лан-5, цэн-2, пүн-5-ыг⁹⁰ гаргасан гэжээ. Мөн XIX зууны сүүлийн хагаст Орос улсаас

⁸⁵ ТТА, Ф-М31, Д-2, ХН-1125

⁸⁶ ТТА, Ф-М36, Д-3, ХН-322

⁸⁷ Өмөхэй Сономдорж- Сэцэн хан Норовын ач, Шолойн дөрөвдөхи үеийн хүн.

⁸⁸ ТТА, Ф-М31, Д-2, ХН-1125

⁸⁹ ТТА, Ф-М34, Д-2, ХН-25

⁹⁰ ТТА, Ф-М31, Д-3, ХН-860

цөөнгүй тоогоор хураан авчирч байсан солон ардын аж төрөхүйд нэмэрлэх гэсэн хэдэн жил дараалсан алба гарч, Сэцэн хан аймгаас мал хөрөнгө татварлахад ханы хамнигад ч мөн мал хөрөнгө нийлүүлж байв. Бүрэлт засагчийн 7-р оны(1868) архивын баримтад⁹¹, солон ардад⁹² хөл малаар туслахад ... шар үхэр 250-ийн нэг бүрийг 5 лан, 4 цэн, бух 25-ын нэг бүрийг 5 лан, 4 цэн, эр хонь 100-ийн нэг бүрийг 9 цэн, эм хонь 1000-ын нэг бүрийг 7 цэн даацуулж бүгд нийлж 3325 лан болсоныг суврагачин ард ба хамниган гэрийн ард нарт зохислон хуваасан нь ... хамниган гэрийн ардуудад шар үхэр 2, үнээ 2, эр хонь 1, эм хонь 57-г дүйцүүлэн ноогдуулсанаас ... Сэцэн ханы хамниган ард: шар үхэр – 1, эр хонь- 10, эм хонь-8-ыг; гүн Цанлигдоржийн⁹³ хамниган ард шар-5, үнээ-5, эр хонь-4, эм хонь- 46-г; хамниган ард үнээ-1, эм хонь-8-ыг гаргаж байсан⁹⁴ ... байна. Энэ мэт алба гувчуур нь ядуу хамниган ардад нэрмээс болохын хамт тэдний мал нь их төлөв сарлаг, үхэр, ямааны төдий тул үнэ хүргэхэд нэн бэрхийн дээр, эдгээр албанаа нийлүүлэх үхэр, хонийг нас гүйцсэн, хүч тарган, бие бүдүүн сайнаас нь шилж гаргахыг шаарддаг байсан нь тэднийг давхар дарамтанд оруулж байсан ажээ.

Ерөөгийн хамниганы нутагшил, захиргаа, хүн ам. XX зууны эхэн үеийн Ерөөгийн хамниганы нутагшлыг Ерөө голын эхэн болон Ходоодон булаг, Бэрлэг, Ялбаг, Тангуй, Бугант, Шарлан ба Хэрлэн голын эхэн, Галттай ба Төмөртэй горхийн хийгээд Минж голын Зэлтэй гэж тоймлосон байдаг⁹⁵. Ерөөгийн хамниганд Шарлангийн, Минжийн, Ходоодын гэсэн шавийн хамниган отог отог ордог бөгөөд Шарлангийн намиад удмын отог нь Ерөө голын нэгэн салаа Шарлангийн голоор нутаглаж байсан учраас уг голынхоо нэрээр “Шарлан” отог гэж нэрлэгдэх болсон байна. Минжийн голын хамниган нь Шарлангийн отогт багтаж байжээ. Шарлангийн “намиад” удамтай отогт 50, 60-аад өрх айл байгаад зарим нь гамингийн үймээнээр⁹⁶ уул нутгаасаа гарч Ялбаг, Шивэр(өнөөгийн Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутаг) хавиар, Минжээр байсан хамнигад нь мөн үймээний үеэр Хэрлэн гол руу, өнөөгийн Төв аймгийн Эрдэнэ, Мөнгөнморьт сумын нутаг руу дайжсан байна⁹⁷.

⁹¹ ТТА, Ф-М31, Д-3, ХН-322

⁹² Уг баримтаас үзвэл, энэ удаад Орос улсаас хураах солон ардын тоог 2000-3000 гэж тодруулсан байна.ТТА, Ф-М31, Д-2, ХН-2297

⁹³ Жонон засаг Гомбожавын Цанлигдорж 1855- 1898! онд засаг, бэйсийн зэрэг улсад туслагч гүн цолтой байсан.

⁹⁴ ТТА, Ф-М31, Д-2, ХН-2297

⁹⁵ Ж.Цэвээн, Түүвэр зохиол, УБ-1997, 123-124т

⁹⁶ Өнөөгийн Сэлэнгэ аймгийн Ерөө сумын төв Тавинг гамингийн үймээний хөлд үрэгдсэн газар гэж нутгийн хөгшид хуучилж байна. Хүдэр сумын настан Пүрэвжавын Чандал (69 н) эмгэн, миний хадмууд хамниган угсааны улс. Нөхөр Мижидийн Чагцал Ходоодон хамниган хүний хүүхэд. Хадам талын маань настай эмгэн өтөл болсоныхоо хойно гамин ирлээ гээд ширдэг гудсаа үг сүггүй хураагаад л сандаргадаг байсан. Гамингуудаас айж явсаар тийм өвчтэй болсон юм билээ гэж байв. О.Баттуяа, Ерөө, Хүдэрт хийсэн судалгааны гар бичмэл, 2007

⁹⁷ С.Бадамхатан, Ерөөгийн хамниганы дүнд хийсэн судалгааны гар бичмэл, 1963

Ерөөгийн хамниганы “пөөинкин” отгийнхон одоогийн Сэлэнгэ аймгийн Ерөө, Хүдэр сумын нутагт Ходоодын хөндий, Тангуй, Бүхлээ, Галттай, Төмөртэй зэрэг газраар нутаглаж байжээ.

Тэд Бэрлэг, Галттай, Төмөртэйг оруулан 5 өртөө орчим ходоодон хэлбэртэй газарт сууж байснаас Ходоодон хамниган гэгдэх болсон гэнэ. Ходоодын хамниган 100(300)орчим өрх байсны ихэнх нь гамингийн үймээнээр Шивэр, Ялбаг, Хараа, Дарвитай руу нүүж, үлдсэн нь хожим Ерөө сумын 1-р багийг бүрдүүлэх болжээ⁹⁸. XX зууны эхээр Богд гэгээний шавь хамнигад болох 200 өрх айл, 800 орчим хүн Ерөө голын эхэн(Ялбаг, Тангу. Ж.Ц) хавиар Сэцэн ханы хамнигантай холилдон суурьшиж байжээ⁹⁹. Хүн ам, газар нутгаар нь багцаалах юм бол эдгээр хамнигад нь “пөөинкин” удмын Ходоодон отгийн хамниган болж байна.

Ерөөгийн хамниган нь Богдын их шавьд тооцогдож, “хамниган” отог гэгдэж халхын бусад отгуудын нэгэн адил Эрдэнэшанзавын Яамны мэдэлд явснаа 1924, 1925 онд их шавийн отгуудаар Дэлгэр их уулын аймаг байгуулагдахад тус аймагт харьяалагдах болжээ.

Түшээт хан аймгийн Баатар вангийн хошууны Зүүн хараа, Их мандал уул зэрэг газраар байсан Хамниганы 3(дарга- Лодой, дарга-Пунцаг, шүүлэнгэ-Наваан), Ширхэнцэгийн 1 (дарга- Хажид), Далай ижийн 1(дарга Лувсандорж), Хүүхэн ноёны отгийн хагасын хамтаар Эрдэнэмандал уулын отог, Түшээт хан аймгийн Эрдэнэ вангийн хошууны нутаг Хүйтэн Шарын гол, Дархан, Ерөө голоор байсан Шарын 1(дарга Аюуш), Хамниганы 1(дарга Цэрэнжамц), Эрдэнийн 1(шүүлэнгэ Насан-Очир)отгуудын хамтаар Шарбуянтын отогт багтах болжээ¹⁰⁰. Ходоодон отгийн пөөинкинүүд Шарлангийн намиадаас 2-3 дахин илүү хүн амтай тул Түшээт хан аймгийн Баатар вангийн хошууны хамниганы 3 отог ард гэдэг нь “пөөинкин”, Эрдэнэ вангийн хошууны хамниганы 1 отог гэдэг нь “намиад”-ууд байсан бололтой.

Түшээт хан аймгийн их шавийн хамниганы дарга Рэгзэнгийн отгийн бүгд хүмүүсийн хөрөнгө малыг магадлан байцаасан дансанд¹⁰¹, ... Бадаргуулт төрийн 34-р оны(1908) байдлаар, тус отгийн адуу- 842, үхэр- 1512, хонь-2533, хүн нь-155 байгаагаас хуврага-18, увш-8, гэлэн-13, үлдсэн нь эр, эм хүмүүс болно. Мөн үеийн хамниганы шүүлэнгэ¹⁰² Лувсангомбын багийн адуу-64, үхэр-100, хонь-218,

⁹⁸ С.Бадамхатан, Ерөөгийн хамниганы дунд хийсэн судалгааны гар бичмэл, 1963

⁹⁹ Ю.Д.Талько- Грынцевичъ, Иройскіе Хамнеганы, Труды, TVII. В.3. Иройские хамнеганы, 1904, 76стр

¹⁰⁰ Ц.Сономдагва, БНМАУ-ын орон нутгийн засаг захиргааны хуваарьт гарсан өөрчлөлтүүд (1921-1965), УБ-1967, 74-77т

¹⁰¹ ТТА, Ф-М85, Д-1, ХН-1348

¹⁰² Шүүлэнгэ хэмээх нь алба гувчуур хураагч гэсэн утгатай манж үг ажээ. Манжийн ноёрхлын үед шүүлэнгэ хэмээн их шавь, тамгатай хутагтуудын Засаг Захиргааны нэгж болох отгийн даргын туслах, отгийн даргыг хэлэх болжээ. Дэмч, шүүлэнгэ нарыг отог, отгийн сайд түшмэл хэмээн нэрлэсэн нь тааралдах бөгөөд тэдний харьяалдаг дөчин, хорин нь отгийг бүрдүүлэгч гол цөм болж байсан учраас тийнхүү нэрлэсэн ажээ.

ямаа-87, шүүлэнгэ-2, мэдээч-1, хуврага-2, хар-2, мөн Санжмятав ... гэж бүртгүүлсэн байна.

Дэлгэр их уулын аймгийн Мандалбуянт хошууны Эрдэнэмандалын отгийн хамниганы дарга Галсангийн отгийн малын тоо зэргийг нарийвчлан тоолсон дансанд¹⁰³ (он тодорхойгүй): ... отгийн нийт хүн-117, адуу-254, үхэр-970, хонь-563, тэмээгүй гэх зэрэг Ерөөгийн шавийн хамниганы тухай тойм төдий баримт байна. Ерөөгийн их шавийн хамниган нь Богдын харьяат шавь нарын нэгэн адил Жавзандамбын хувьдаа авах татвар буюу тахилын цайны¹⁰⁴ алба өргөж байв. Тахилын цайны албыг ноогдуулахдаа шавь нарын малын тоо толгойг харгалзан 20-иос дээш бод малтай хүнд оноодог байсан бөгөөд энэ албыг зарим үед “малын хөл тахил” гэж нэрлэж байжээ. Богдын тахилын цайны албыг хэрхэн оноож байсныг жишээлж үзвэл, өмнө өгүүлсэн хамниганы дарга Галсангийн отгийн нийт хүн ам, мал хөрөнгийн байдлыг харгалзан, тус отогт 6 сэвэг¹⁰⁵, 670 сул¹⁰⁶, хуучин 9 сэвэг, 100 сул, үүнээс 10 цайд үл хүрэх адуу нэгийг хасч, ... хамниганы Галсангийн отогт 5080, 1815 энэ 3895 бүгд сул 5590 цай болсоныг тодорхойлжээ¹⁰⁷. Мөн их шавийн Хамниган отгийнхон Жавзандамба хутагтын хэрэгцээнд зориулж ангийн үс, махны алба барьж байв. Олноо өргөгдсөний 4-р онд(1914) Хамниганы(дарга Сэрээтэр)отгоос 2 гахай оногдуулан авч Богдод өргөсөнд тэдгээр бэлтгүүлсэн гахай нь эцэнхий гэж гологдон дахин бүдүүн сайн гахай ирүүлэхийг тушаагдаж байсан байна¹⁰⁸. Хамниган шавь нар их шавийн албаны элч нарыг улаагаар хангаж, хутагтын сангийн жасааны уяа агтыг гаргалцаж байсан бөгөөд Олноо өргөгдсөний 6-р (1916) онд их шавийн хамнигад албаны унаанд зориулж 83 морь өргөсөн байна¹⁰⁹. Богд гэгээний анхны шавь нарын нэг Ерөөгийн хамниган нь бусад шавь нарын адил хир чадлаасаа давсан хэдэн төрлийн алба татварь дарагдаж явжээ. Ерөөгийн шавийн хамнигад нь мал хөрөнгө чинээний байдлаар Сэцэн ханы хамниганаас арай дээр байсан байна. Энэ нь тэд ан гөрөө элбэг ой хөвч газар нутаглаж, их шавь гэгдэж элдэв хавчилга дарамтаас хол явсантай нь холбоотой.

Ерөөгийн хамниганы газар усны нэрнүүд дархадын газар усны нэртэй тохирч байгааг эрдэмтэн С.Бадамхатангийн тэмдэглэсэн дээр дэлгэрүүлж тодруулсан нь:

Yalbagä – Мандал сумын нутаг Ерөөгийн эхэнд байх уул. Бэрлэгийн ойролцоо байдаг. О.Б

¹⁰³ ТТА, Ф-А74, Д-1,ХН-348

¹⁰⁴ Шавь нарт алба ноогдуулахдаа цайгаар юмүү эсвэл цайд оруулан бодсон мал буюу мөнгөөр оноож, 50 цайгаас дээш хөрөнгөтэй хүнээр уг албыг гаргадаг байжээ. Шар цай нь малд буулгавал 10 шар цай – 1 тэмээ; 8 шар цай- нижгээд толгой үхэр, адуу; 2 цай- 1 толгой хоньтой тэнцэнэ. Албаны 100 шар цай энгийн 300 шар цайтай тэнцдэг.

¹⁰⁵ 800 шар цайг “сэвэг” гэнэ.

¹⁰⁶ 800 хүрэхгүй шар цайг “сул” гэнэ.

¹⁰⁷ ТТА, Ф-А74, Д-1,ХН-348

¹⁰⁸ Д.Цэдэв, Их шавь, УБ-1964, 43т

¹⁰⁹ Д.Цэдэв, Их шавь, УБ-1964, 45т

Berlege(Бэрлэг)- Хөвсгөлийн улаан-Уулд байна. Бэрлэг гэж уйгараар чонот гэдэг үгнээс үүдсэн газрын нэр. С.Б. Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт Ялбагийн ойролцоо байх уулын нэр- О.Б.

Тангуй-Хүдэр сумын нутаг Хэрцийн голын дээд эх-О.Б.

Зэлтэй- Тангуйн баруун талд байдаг гол- О.Б.

Ходоод(Ходоодон булаг-Ж.Ц)- Бугант суурийнгийн нутаг-О.Б.

Хонин нуга- Сэлэнгийн Мандал сумын нутагт Бэрлэг, Ялбагаас урд чигт байдаг ян хөвчит уулархаг нутаг- О.Б.

Бугант-Сэлэнгэ аймгийн Бугант суурингийн нутаг.

Шарлан- Ерөө голын томоохон салаа

Галттай- Сэлэнгэ аймгийн Ерөөгийн нутагт байх голын нэр. Галагтай гэж нэртэй байгаад дуудлага нь хувирсаар Галттай болжээ- О.Б.

Төмөртэй-Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт байх голын нэр- О.Б.

Zevgicaini bömbögsei-Минжээс зүүн урагш байдаг- С.Б.

Tógól- Шарлан талд- С.Б

Xodõn- Урагшаа харсан амны гол. Ренчинлхүмбэ суманд байх голын нэр. Ходон гэх нь хадан гэх уйгар үг, чандагыг уйгараар ингэж нэрлэдэг байна- О.Б.

Xotoγaŋi aršaŋ- хаана байдгийг тодруулсангүй байна-О.Б.

Хоŋgi- Естийн рашаанд бий- С.Б.

Xõk boγodžõ- Зүүнхараад байх усаар хавчигдсан хадан хавцал. Богож гэж Ренчинлхүмбэд байгаа нь нэг талаараа устай хавцал газар гэнэ-С.Б.

Õngõlõgõ- мөн Ялбагт бий- С.Б.

Širxeŋcõgõ- Зүүнхараагийн төвийн уул.

Šivër- Ерөөд байна. Мөн Улаан-Уулд байдаг намагтай газрын нэр. Эрдэмтэн С.Бадамхатан Шарлангийн хамниган ба дархадын tatāgai гэж уулгалдаг аман хэллэг, гэрийн унийг униа¹¹⁰ гэж хэлэх нь таарч байгааг тэмдэглээд, гэрийн нохой тогтохгүй бол төмрөөр нохойн дүрс хайчилж босгоны дунд хаддаг заншил хамниган, дархадад хоёуланд нь байгааг онцолжээ.

Дорнод Монголын хамниганы нутагшил, захиргаа, хүн ам.

Хамниганаас Онон орчим, Гилбэр, Хэрийн харуулд суулгаж байжээ. Егүзэр хутагт Хэр харуулын хамниган, буриадуудыг шавь болгон мод материал, ангийн үс ноос бэлдүүлэх ажилд дайчилж байсан төдийгүй тэдний заримаас өөрийн хошуу Эрдэнэцагаан руу нүүлгэнэ гэж тэвдүүлж байжээ¹¹¹.

XX зууны эхэн үед Монголд орж ирсэн хамниганы хойч үеийнхэн Хэнтий аймгийн Биндэр, Дадал, Норовлин, Бэрх хотхон, Дорнод аймгийн Чойбалсан, Баян-Уул, Цагаан-Овоо, Дашбалбар суманд суурьшиж байна. Тэдгээр хамнигад анх ирсэн даруйдаа хувь тавилан нэгт буриад-монголчуудын хамт Онон голын буриад хошууны Балж, Батсүмбэр, Баян-Уул, Баянхан уул, Цагааннуур сум, Улз голын буриад хошууны баруун Тарь, Далай, Онон Ага, Адуун чулуун, Алхан зэрэг

¹¹⁰ Хэнтийн хорь буриадууд ч гэсэн Хөвсгөлийн дархад, Ерөөгийн Шарлангийн хамнигантай адилаар “татагай” гэж цочиж уулга алдахаас гадна бас тэдний нэгэн адил гэрийн унийг “униа” гэдэг юм(О.Б).

¹¹¹ Дадал сумын түүхэн товчоон, УБ-2010, 21т

сумдад харьяалагдаж байжээ. Тэд Монгол ирсэний дараагаар хамт ирсэн буриад-монголчуудаас тусгаар маягтай нутаглаж байсан ажээ.

Өнөөгийн Хэнтий аймгийн Биндэр сумын хамнигад Онон голын зүүн этгээд Хэнтийн Биндэр сумын хамнигад Онон голын зүүн этгээдийн их Тал, Мянган модот, Гурван Манхаадай, Сэрүүн, ар, өвөр Тарвагатай, Дэв мод, Гуриныхын¹¹² даваагаар суурьшсан байна. Хэнтийн Дадалын хамнигад Дадал сумын хуучин төв¹¹³, Гурван нуур, Угалзарын гол, Цагаан чулуутын ойролцоо Сөөгтэй, Хёрхон, Бөххөн¹¹⁴, Тосон¹¹⁵, өнөөгийн Дадал сумын төвийн зүүн хойд хэсэг Бөөр булаг, тус сумын төвөөс хойш байдаг Балж, Хёрхон голын бэлчир дагуу Мараан, Баянхан уул, мөн сумын төвөөс зүүн хойш Агацаар¹¹⁶, Дорнодын Баян- Уулын хамниган Хайлантын өвөр, Далт, Өвөр Үнэрч, Өвөр Дархинт, Үйсэн тасархай, Улаалзаргана гэх газраар голлон нутаглаж иржээ¹¹⁷. 2003-2004 онд Баян-Уул суманд очиход сумын төвийн баруун жигүүрт 10 орчим үзээн хамниган айл бөөгнөрөн суусан байгааг тус сумын төвийнхөн “үзээн хотон(хот айл- О.Б)” гэж нэрлэж байлаа. Дорнодын Дашбалбар сумын Дөчийн голын буриад нарын дунд тугчин, гүнээкин, үзээн, хасаг хамнигад багтаж байжээ. Тэднийг Гацаагай(Гацаагийн-О.Б) арын хамнигад гэдэг байсан бөгөөд 1950-иад оны сүүлч хүртэл уул газраа бөөндүү нутаглаж байжээ¹¹⁸. Хамнигадын дорнод Монголын нутагт ирсэн даруйдаа нутаглаж ирсэн дээрх газруудыг хөрш буриадууд нь одоо ч гэсэн “хамниганых” гэж тодотгосоор байна. Шилжилт хөдөлгөөн чөлөөтэй болсон өнөө үед Дорнод Монголын хамниганы нутагшлыг ХХ зууны эхэн юмуу дунд үеийнхээр нь хязгаарлах аргагүй болжээ. Зах зээл, үйлдвэрлэлийн хөгжлийг бараадсан нийтийн жишгээр тэд Улаанбаатар, Багануур, Дархан, Эрдэнэт зэрэг хот сууринд хамнигад тархан суурьшсан нь ойлгомжтой билээ.

Манай улс 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалаас хойш 1929, 1933, 1944, 1947, 1956, 1962¹¹⁹, 2000, 2010 онуудад хүн амын нэгдсэн тооллого явуулсан байна. 1922 оны баримтад Сэцэн хан аймгийн Балжийн сум 30-аад түнгүүс өрх байсан(буриаджсан түнгүүс)¹²⁰ бол 1928 оны байдлаар Онон хорийн хошуу найман сумтай байсны дотор тусгайлсан Хамниган гэж сум байсан нь 50 өрхтэй гэж тэмдэглэгджээ. 1933 оны хүн амын тооллогын бүртгэлд Хэнтий аймгийн Балж¹²¹ сумын 2-р баг 53 хамниган өрхтэй, тэдгээр өрхүүдэд эрэгтэй -

¹¹² Мөн үед энэ давааны ойролцоо аж төрөл ядруу хамнигад сууж, уг даваагаар нааш цааш хөлхдөг байснаас тэр давааг “Гуриных”-ын гэж доромж утгаар нэрлэдэг болсон гэнэ. Хэнтий Биндэр сумын багш нар хамниган Х.Батмөнхөөс 2007 онд тэмдэглэв.

¹¹³ Тэнгилийн гол буюу өнөөгийн Дадал сумын төвөөс баруун хойно байна.

¹¹⁴ Бөххөн нь Бөх хүн гэдэг голын нэр юм.

¹¹⁵ Л.Мишиг, МАУ-ын хамниган аялгууг сурвалжилсан нь. Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтдийн анхдугаар их хурал. УБ- 1961,184т

¹¹⁶ О.Баттуяа,Хэнтий аймагт хийсэн судалгааны гар бичмэл, 2005

¹¹⁷ Т.Галсан, Дорнод аймгийн Баян-Уул сум, УБ-2004, 68т

¹¹⁸ Г.Гантогтох, Дашбалбар Дашбалбарайхан, УБ-2005, 145т

¹¹⁹ 1962 оны хүн амын тооллого ТТА-т хадгалагдаагүй байна.

¹²⁰ А.Оюунтунгалаг, Монгол улсын буриадууд, УБ-2004, 45т

¹²¹ Балж сум нь 1934 онд татан буугдаж хүн ам нь Биндэр, Дадал суманд хуваагдан захирагдсан

74, эмс, охид - 72, лам, хуврага - 8, нийтдээ - 154 хамниган хүн бүртгэгджээ. 1944, 1947, 1956 онд улсын хэмжээнд хийсэн хүн амын тооллогоор Хэнтий, Дорнод аймагт хамниган албан ёсоор бүртгэгдээгүй байдаг. Гэхдээ манай эрдэмтэн судлаачдын тоймлосноор, хамниган олонтой Хэнтий аймгийн Биндэр суманд 1961 оны байдлаар 60- 70 орчим хамниган өрх, Дадал сумын хуучин төв, Гурван нуур, Угалзарын голоор 100 шахам хамниган өрх¹²², 2005 оны баримтад, Биндэрийн төвөөс зүүн тийш баруун Манхаадайд 70 гаруй хамниган өрх айл, 400 орчим хүн, 1990 онд Монгол улсын хэмжээнд 565 хамниган байсны 294 эрэгтэй, 271 эмэгтэй¹²³ байсан ажээ.

2004 оны байдлаар Дорнодын Баян-Уул сумын нийт хүн амын 17,4 хувийг хамниган эзэлнэ гэснийг¹²⁴ тус сумын нийт хүн амтай харьцуулж үзвэл Баян-Уул суманд 800, 900 орчим хамниган хүн суурьшдагаар баримжаалагдаж байна. Дорнодын Цагаан-Овоо сумын 3, 5, 7, 9, 10-р (1935-1959 оныг хүртэл) багуудын ихэнх нь хамниган байсан боловч 1995 он хүртэлх тус сумын хүн амын тооллогын дансанд нэг ч хүн өөрийгөө хамниган гэж бүртгүүлээгүй байх юм¹²⁵. Харин 2001 – 2002 оны байдлаар тус сумын 1- 6-р багт нийтдээ 40 гаруй өрхийн 260 орчим хүн өөрийгөө хамниганы түүхэн овгийн нэрээр бүртгүүлсэн байна¹²⁶. Энэхүү бүртгэл судалгааг буриад ба хамниганы байдлыг тодруулах зорилгоор орон нутгийн засаг захиргаанаас зориуд зохион байгуулсан ажээ. 2000 онд явагдсан МУ-ын хүн амын дэлгэрэнгүй тооллогын үеэр Хэнтий аймагт нийт 321 хамниган бүртгэгдсэнээс эрэгтэй- 181, эмэгтэй- 140¹²⁷, Дорнод аймагт 226 хамниган хүн бүртгэгдсэнээс эрэгтэй- 81, эмэгтэй- 145 байсан байна. Хамгийн сүүлд буюу 2010 онд явагдсан хүн ам орон сууцны тооллогоор манай улсад нийт 537 хамниган тоологдсоноос эрэгтэй- 309, эмэгтэй- 228 гэж бүртгэгджээ. Тэд Монголын хамгийн насжилттай угсаатны тоонд орж байна. Энэ нь уг бүртгэлд багтсан хамниган хүмүүс харьцангуй өндөр настай болохыг өөрөөр хэлбэл хамниганы настайчууд л өөрийгөө хамниган гэж үзэж байгааг харуулж байна.

Хүн амын албан ёсны тооллогын баримтад хамниганы хүн ам тодорхой хугацаанд цөөрсөн байгаа шалтгааныг 2003-2004 онд Хэнтий, Дорнод аймагт хийсэн судалгааны үеэр хамниган, буриад улсаас тодруулахад, тооллогын бүртгэлд халх, буриад, бусад гэхээс өөр тодруулсан асуулт байхгүй байснаас тоо бүртгэгч хүн нарийвчлан шалгаалгүй хамниганыг буриадтай адилтгаж шууд буриад гэж бүртгэх эсвэл зарим тохиолдолд хамниган хүн өөрөө “буриад” гэж бүртгүүлж байжээ. Урьд хамниган намиадууд (зарим нь улиад ч гэдэг) буриадуудыг бөөнөөр нь хядсан тухай өгүүлдэг Бавж баатар, Балжин хатаны домгоос улбаалан буриадууд хамниган хүмүүст төдийлөн таатай ханддаггүй үе

¹²²Л.Мишиг, МАУ-ын хамниган аялгууг сурвалжилсан нь, Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтдийн анхдугаар их хурал. УБ- 1961

¹²³ “History and culture of the Mongols, УБ-2006, 135ps

¹²⁴ Т.Галсан, Дорнод аймгийн Баян-Уул сум. УБ-2004, 68т

¹²⁵ Г.Батжаргал, Манай нутгийнханы алтан ургийнханы товч түүх, УБ-1995, 13т

¹²⁶ О.Баттуяа, Хэнтий, Дорнод аймагт хийсэн судалгааны гар бичмэл, 2004

¹²⁷ МУУСГ, Хэнтий аймгийн хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогын дүн, Хүн ам, тооллого судалгааны товчоо- 2001, 40- 47т

дамжсан нэгэн үзэл хадгалагдаж ирсэн тухай буриад, хамнигад хуучилж байлаа. Үүнээс голлон шалтгаалж буриадууд хамниганд дургүйцэх хандлага байсан тул хамнигад өөрсдийгөө буриадад тооцох сонирхолтой явж ирсэн гэсэн тайлбар ч хэлж байв. Энэ мэт байдлаас болж зарим хамнигад охидоо буриад айлд бэрлүүлэх дуртай, харин буриадууд нь арай өөрөөр хамнигантай худ ураг барилдахыг таашаадаггүй байсан гэнэ. Манай судалгааны явцад хамниган хүн өөрийгөө буриад гэхэд буриад хүн түүнийг хамниган гэж төрөл садангаар нь жишээлж нотлож байх нь тохиолдож байлаа. Дадал сумын хангис овгийн Доржийн Зундуйдагвыг хамниган хүн гэдгийг нь түүний ойр төрлийн хамниган эмгэн Сэндэн бид эгч дүүсийн хүүхдүүд гэж байсан боловч уг хүн өөрийгөө буриад эсвэл халх ч гэхгүй би хангис овгийн хүн хэлж байв. Харин 2008 онд хангис овгийн анчин мөнөөх Д.Зундуйдагва “Буриад анчны буурал тэмдэглэл” гэсэн нэртэй дурдатгалын номоо хэвлүүлснийг үзвэл өөрийгөө буриадад тооцож байгаа ажээ. Иймд буриадын овгийн бүрэлдэхүүнд “хангис” гэдэг нэгэн овог багтах нь бололтой.

2002- 2005 онд Хэнтий, Дорнод аймагт хийсэн асуулга судалгааны үеэр дунд эргэм насны хамниганы зарим нь үр хүүхдээ болон өөрсдийгөө халх, эсвэл буриад гэх сонирхолтой нь ажиглагдаж байв. Үүнийгээ тэд өөрсдийн болон үр хүүхдийнх нь нийгмийн дунд эзлэх байр суурь, ажил алба амжилттай урагшлахтай холбон тайлбарлаж байлаа. Гэхдээ олонхи нь цөөнхдөө илт биш ч гэсэн ямар нэгэн байдлаар тааламжгүй ханддагаас үүдээд угсаагаа ухамсартайгаар нуух нь хамниган төдийгүй нийт монголчуудын дунд ч байдаг. Хамниганы залуучууд энэ мэт шалтгаанаар өөрийгөө хамниган гэх дургүй байдгийн эсрэг, хамниган настангууд түүхэн тодорхой үед алдагдаж байсан үндэс угсаагаа эрхэмлэн сэргээх гэсэн эрмэлзэлтэй байна. Нийгмийн нөхцөл байдлаас хамаарч хамнигад өөрсдийн сонирхлоор албаны баримтад хамниган гэдгээ илэрхийлэхгүй байх, эсвэл угсаа нийтлэгийн хамаадлаа таньж мэдэхгүйгээс болж тэдний хүн амын тоо хэлбэлзэж байжээ.

1990 оны ардчилсан хувьсгалаас хойш хамниган угсаатны ухамсар сэргэх хандлагатай болж байна. Хэнтийн Дадал сумын баахашил овогт Ц.Мөнбиш хамниганы соёлыг өвлүүлэх, хамниган залуусын угсаатны ухамсарыг сэргээх зорилгоор сумынхаа хамниган настангуудыг цуглуулж хууч яриулах ажил нэг биш удаа зохион байгуулсан байна. 2015 оны 7 сард Хэнтий аймгийн Дадал суманд “... Орчин цагт нийгмийн хурдацтай хөгжлийн явцад, хэл, соёл, ахуйн өөрчлөлт гарч, үндэсний язгуур хэл соёлоо мартан, түүх угсаа гарвал уламжлал устан мөхөж байгааг сэргээх, ах дүү ураг төрөл садан, хэл соёл, уламжлалаа сэргээх нь одоо амьдарч байгаа хамниган угсаатны өмнө хүлээгдэж байгаа үүрэг тул ах дүү ураг төрөл садан угсаа гарвалаа мэдэж танилцах...” зорилготой “Хамниганы ургийн уулзалт” нэртэй арга хэмжээ зохион байгуулагдав. Уг үйл ажиллагаанд Хэнтий, Дорнод болон бусад төв суурин газарт ажиллаж амьдарч байгаа 70 гаруй хамниган иргэд оролцжээ. 2015 оны намар “Хамниган судлалын төв” байгуулагдав. Энэ ТББ-ын санаачлагаар Монголын хамниганы ахуй соёлыг харуулсан бүрэн хэмжээний нэвтрүүлэг бэлтгэж 2016 оны 2 сард МҮОН-ийн ТВ-ийн “Монголын нэг өдөр” хөтөлбөрөөр орон даяар цацсан байна. Эдгээр үйл

явдлууд нь хэдэн арван жил үндэстний олонхид төдийгүй үндэстний цөөнхөд (буриад) ч цөөнх болж явсан хамнигадын угсаатны ухамсар нь гүн бат хадгалагдсаар ирсэний жишээ, бүлэг нийтлэгтэйгээ илүү төрөлсөх гэсэн хүсэл, мэдрэмжийн илрэл юм.

Хэнтий аймгийн Ардын дуу бүжгийн “Хан Хэнтий” чуулгын бүжгийн багш, урлагийн гавьяат зүтгэлтэн Д.Санжаасүрэн 1976 онд дорнод Монголын угсаатан ястнуудын бүжгээр бүрэн хэмжээний концерт бэлтгэсний дотор “Хамниган анчид” бүжиг багтаж байжээ. Аймгийн МАХН-ын Хороо хянаад тайзнаа тоглох зөвшөөрөл өгөөгүй боловч энэ концертыг тухайн үед Болгар зэрэг социалист орнуудад тоглож амжсан байна. Концертын хөтөлбөрт багтсан “Хамниган анчид” бүжгийн хөгжмийг тус чуулгын хөгжмийн багш, Соёлын гавьяат зүтгэлтэн, хамниганы багшид овогт Д.Гомбо зохиож, тоглолтын хувцсыг нь Б.Ринчен абугайн бүтээл¹²⁸ дэх “Анд яваа хамниган хүн” хуулбар зургаас сэдэвлэн урласан ажээ. Мөн хойно хавсаргасан Б.Сундуйн¹²⁹ үг, Ц.Чинзоригийн ая “Нютаг”(Нутаг) дуунд дурьдагддаг(*Хавсралт- 4*) Хэнтийн Дадал сумын нутаг дахь Баянхан уул¹³⁰, Балжийн гол, Агац, Марааныг тэндхийн хамнигад, хамниганы нутаглаж ирсэн газар усдууд гэж байлаа. Энэ мэтчилэн хамниганд холбоотой сэдвүүд урлагийн бүтээлд тусгалаа олж байсан нь тэдний угсаатны ухамсар тасралтгүй хадгалагдаж байсныг харуулна.

Монгол хамниганыг ХХ зууны эхнээс судласан эрдэмтэн судлаачид, тэдний зан ааль ер төлөв томоотой ба шударга үнэнч, номхон тул гэмт хэрэг будлиан гарах ч үгүй, мөн өнгөрсөн түүхийг үзвэл язгууртан ноёдын анги байхгүй тул зан суртал ба өөрийнхөө эрх чөлөөний мэдрэл нь бүрхэгдүүлэн дарагдаж алдагдаагүй бөгөөд зан ааль, үзэл бодол нь эвдрээгүй, ардчилсан үзэлтэй, эрх чөлөөгөө хамгаалах дуртай, бусад хүмүүст үнэ хөлсгүйгээр туслахыг хичээх, хэлсэн үгэндээ эзэн болох тэргүүтэн сайн суртлын ард болой. Хулгай худал байхгүй, архи согтлол уухгүй, гэрийн дотор эвтэй, эхнэрүүдийн байдал монголчуудаас дээр бөгөөд дарлагдлыг үздэггүй ба эрчүүд бүхүй цагт эхнэрүүддээ тус хийлцмүй. Өөр зуураа эв ая ихтэй, цагаан цайлган санаатай, шулуун шударга зантай гэхчлэн тэдний сайн сайхан талыг магтан дурьдсан байдаг. Хамниган улсуудын сэтгэлийн сайхан чанар манай судалгааны үед ч танигдаж байсан бөгөөд тэдэнтэй ярилцах үед, хөгшин, залуу ялгалгүй хамниганы талаарх манай судалгааг хөхүүн баяртайгаар хүлээн авч, түүхийн нугачаанд бүдгэрч орхигдсон уламжлалаа сэргээн санахыг хичээж, сонсож дуулснаа харамгүй хэлж өгөн, ярьж хөөрөхөд туйлын уриалагахан хандаж,

¹²⁸ Б.Ринчен, МАУ-ын хамниган аялгуу, УБ-1969

¹²⁹ Яруу найрагч Бат- Очирын Сундуй(1954-1991). Хэнтий аймгийн Дадал сумын харьяат.

¹³⁰ Дадал сумын нутаг Дэлүүн болдогоос баруун хойш 20 гаруй км газарт Баянхаан уул байдаг. Баянхаан уул Бурхант, Шургадай, Оргойт гэх салбар гурван уул буюу оргилтой. Бурхант нь эрт дээр цагт босгосон бурхантай байсан гэдэг. Зүүн талын Шургадайд нь Тэмүүжин дайснаас зугтан нуугдсан учираас ийн нэрлэсэн ажээ. Урд талд нь байх Оргойтод нь эрт цагийн нэгэн бөөгийн өмсгөл Оргойг нуусан тул ингэж нэрлэгдсэн домогтой. Мөн Бурхант уулыг жар, далаад жилийн өмнө Бурхан Халдун гэдэг байсан гэнэ. Дээхэн үед Угтамын хийдийн гэгээн энэ нутагт заларч бэлд нь овоо босгон гурван жил тутам тахидаг болгожээ. Тэгээд Баянхаан гэж нэрлүүлсэн байна.

мэдэхгүй эргэлзсэнээ бусдаас тодруулах зэргээр үнэн сэтгэлээсээ хандах нь өнөө үед дуриал болохуйц байж билээ.

- ХҮИ зууны сүүл хирд хамниганыг Хан Хэнтийн уул хөвчит газар, Хэрлэн голын эхэн, Гурван Хориуд, Тэнүүн голын эхээр суулгасан нь Сэцэн ханы хамниганы түүхэн нутгийн хэсэг болох юм. Түүнээс хойш зуу гаруй жилийн дараа тэднийг Хан Хэнтийн тахилгат овооноос урагш Хэрлэн голыг уруудуулан Тэнүүн, Зорголын өмнүүр Ногоон нурууны хойгуур Бууралын Хөх чулуу, мөн Даянт, Шороот, Баянхан, Баянханы арын Хар толгой, Таван толгой зэрэг газар руу шилжүүлснээр уг нутаг нь 1930-аад он хүртэл хамниганы идэвхтэй амьдардаг тархац нутаг болж байжээ. Одоо ч Тэнүүнийг хамниагны нутаг гэж дурсаж байна.

- Ерөөгийн хамниганы намиад, пөөинкин отгийнхоны зарим нь гамингийн үймээний үеэр одоогийн Төв аймгийн Мөнгөнморьт, Эрдэнэ сум руу нутагшиж, үлдсэн нь хожим Ерөө сумын 1-р багт харьяалагдаж байжээ. Дорнод Монголын хамниганы Монголд ирээд нутагшсан болон захирагдсан нутаг захиргаа нь бараг өөрчлөгдөөгүй байна.

- Монголын аль ч нутгийн хамниган хөрш халх(Мөнгөнморьтын хамниган настан, халх гэхгүй хиад боржигод гэж ярьж байна. Урьд нь ч ингэж хэлдэг байсан гэнэ) болон буриадуудаас тусгаар маягтай нутаглаж иржээ.

- Хамниганы хүн амыг Манжийн төрийн үеийн тооллогын бүртгэлд хамрагдсанаар нь тоймлон гаргавал ХХ зууны эхэн гэхэд мянга хол давсан байжээ. 1944 оноос хойших албан ёсны тооллогод хамнигад цөөрсөн байгаа нь өөрсдийнх нь тайлбарласнаар олонхи тэдэнд ил далдаар таагүй ханддаг байсан болон тухайн үеийн нийгмийн тогтолцоо угсаатан хоорондоо бүх талаар эвлэлдэн нэгдэх, улмаар угсаатаны бүлэг, нийтлэгүүдийн хоорондын ялгааг арилгах замаар угсаатныг дотооддоо нягтруулахыг эрхэмлэх бодлого барьж байсанаас хамаарч угсаатаны ухамсараа илэрхийлж өөрийгөө тодорхойлох сонирхол, боломж нөхцөл төдийлөн байгаагүйгээс болжээ.

- 1990- ээд оноос хойш хүний эрх, эрх чөлөөг дээдлэж, Үндсэн хууль болон бусад олон хуулиар үндэстний цөөнхийн эрх ашгийг баталгаажуулсан нь хамниганы угсаатаны ухамсар сэргэх таатай нөхцөлийг бүрдүүлжээ. Нөгөөтэйгүүр тэдний угсаатны тодорхойлох чанар ямагт хадгалагдаж ирсэн байна. Ургийн овгийг иргэний үнэмлэхэнд заавал тэмдэглэх болсон нь тэдний ухамсарыг өдөөж сэргээх гол хүчин зүйл болжээ.

3. Хамниганы овог

Хамниганы судалгааны бүтээлд тэдний овгийн тухай нилээдгүй өгүүлсэн байна. Академич Б.Ринчен “Монгол ард улсын хамниган аялгуу” бүтээлдээ хамниганы 70 гаруй овог бүртгэж, нэрийнх нь тайлбар, холбогдох аман түүхийг багтаасан байдаг. Мөн Х.Нямбуу нарын хамт хэвлүүлсэн “БНМАУ-ын угсаатан зүй хэлний шинжлэлийн атлас”-д Монгол улсын хамниганы овгийн тархацыг тодруулсан байна.

Судлаач Д.Тангад хамниганы талаар дэлгэрэнгүй судлаад тэдний овгийн хамаатлыг эртний сурвалжит монгол овог, хамниган овог, хамниганжсан харь овог гэж дараахь байдлаар төрөлжүүлжээ. Үүнд:

1. Эртний сурвалжит монгол овог- багш нар, баргужин, баягид, бодонгууд, горлууд, дагаахан, дагуур, залайр, хатагин, мэхэрчин, өрлүүд, тугчин, улиад, үзээн, хонкирад, цахар

2. Хамниган овог- гачинха, гавунаг, кендэ, кэпцэнүүд, тийвэргэ, увачан, улиангай, урианхан, хөшүүр, хуланга, хуургад, хуучид, цоохор, цэмцэгэд, асури, ортон, буяндхан, халзангууд, хангис, гүнээхэн

3. Хамниганжсан харь овог- баахашил, дулиасэл, дулигад, лүнээкир, лүнээкин, нэфтэн, сонгоол, сартуул, чипчинүд, шээнхэгэр зэргийг багтаажээ.

Ж.Цэвээн Ононы хамниган дунд 1911 онд судалгаа явуулж тэндхийн хамниганыг 5000 орчим гэж багцаалан тэдний доторх овог төрлүүдийг мөн:

1. Монгол төрөлтөн- сарадул, урианхайтан, хачиун, хатагин, горлут, үзөөн, тугчин, гүнэйхэн, мэкээрчин, дагахан, багш нар, үлдэгэн, бичикентен;

2. Түнгүүс төрөлтөн- модоргон, луникер, дулигад, чимчигит гэж ялган үзсэн байх бөгөөд түүний монгол гаралтай гэх овгуудаас сарадул, урианхайтан, хатагин, горлут, үзөөн, тугчин, гүнэйхэн, мэкээрчин, дагахан, багш нар болон түнгүүс гаралтай гэх бүх овгууд Монголд байна¹³¹. Эрдэмтэн Д.Г.Дамдинов, Ж.Цэвээний Ононоос бүртгэсэн хамниган овгууд дээр чимчигин, пуцагад(почегор), бахашил(вакасил) овгуудыг нэмж, бахашил, луникер, дулигатыг түнгүүс төрөлтөн байж болох юм гээд бусдыг нь монгол гаралтай гэж үзжээ. Академич Б.Ринчен, Ж.Цэвээн, Д.Тангад нар хамниганыг манж-түнгүүс угсаатан гэсэн ерөнхий ойлголтоор авч үзэж байсан бол Д.Г.Дамдинов түнгүүс ба хамниган хоёрыг ялгаж, хамниган нь дагууртай холбогдож улмаар уг гарлын хувьд хятан нартай хамааралтай байх гэсэн саналтай байдаг. Иймд тухайн судлаач түнгүүс ба хамниганы холбоо хамаарлыг хэрхэн үзсэнээс хамаарч эдгээр ангиллууд хоорондоо ялгагдаж байгаа нь энэ юм.

2000 онд Монгол улсын хэмжээнд паспортыг иргэний үнэмлэхээр солих үед дээр нь заавал ургийн овгоо тэмдэглүүлэх болоход мартагдах шахсан төрлийн хэлхээгээ мэдэж сэргээх нь ганцхан хамнигадад төдийгүй монголчуудад ч тулгамдаж байлаа. Ургийн овгоо хэрхэн тодруулсныг хамниган улсуудаас асуухад, - урьд бидний овгийг эцэг эх хэлж өгдөг байсан учир уулаас овгоо мэднэ, зарим нь овгийн лавлах номон¹³² дээр тэмдэглэгдсэн овгуудын тархалтыг уугуул нутагтайгаа харьцуулан баримжаалан овгоо авсан гэж байв. Үүнээс гадна уламжлагдсан авьяас чадвар, эрхлэх ажил үйл зэрэгт түшиглэж, маш цөөн хэсэг нь өвөг эцэг болон өөрийн эцгийн нэрээр овгоо тэмдэглүүлсэн ажээ. Тэдний дотор бөөгийн онгодоос асууж өөрсдийн удам гарлаа мэдсэн нь ч байна. Иргэний үнэмлэхэн дээр халх, овгоо боржигон гэж тэмдэглүүлээд байтал, бөөгийн онгодоос угсаа гарвалаа асуухад, хамниган гэдгийг нь хэлж өгсөн гэх жишээ ч

¹³¹ Б.Ринчен, МАУ-ын хамниган аялгуу, УБ- 1969, 23-32т

¹³² А.Очир, Ж.Сэржээ, Монголчуудын овгийн лавлах, УБ-1998

таарч байв. Бөө мөргөл эрчимтэй дэлгэрч байгаа өнөө үед онгод тэнгэрээс овог төрлөө тодруулах нь нилээд түгэх хандлагатай болжээ.

Хамниган улсууд айлд ороод- Мэндэгчи?(хамниган) гэж гэрийн эзэнтэй амар мэндээ мэдэлцсэнээр, харилцан биенээсээ – Алидавтэ?(алид вэ та-О.Б) гэж асуулцан овгоо тодруулдаг. Эдүгээ энэ ёс буриад, хамниган олонтой сумдад ажиглагдаж байна. Монголын угсаатны зүйн атласт дорнод Монголын хамниган, буриадын өнөөгийн “овог”-ыг “эцэг” гэж тэмдэглэжээ¹³³. Гэвч 2002- 2003 онд явуулсан манай асуулга судалгаагаар Хэнтий, Дорнодын хамнигад өөрсдийн төрлийн хамаатлыг “овог” гэгцгээж, хаа нэг “омог” гэхээс биш эцэг гэж хэлж байгаа жишээ таарсангүй. Харин “овог” гэдэг чинь эцгийн нэрийг хэлж байгаа юм биш үү гээд урьд бол “омог” гэж ярьдаг байсан тухай тайлбар л мэр сэр хэлж байв. Дээрх эцэг гэдгийг ХҮИ зууны үед хаант Оросын өмнөд хил харуулаар суусан арван таван эцэг хамниган халх-монгол, буриад-монгол, хамниганаас хэрхэн бүрэлдэн зохион байгуулагдсаныг үндэслэн хамниганы түүхээс улируулж үзвэл, ХҮИ зууны үед цэрэг улс төрийн зориулалтаар зохион байгуулагдсан нэгжийг илэрхийлж байсан нь харагдах тул энэхүү “эцэг” - *“этэг” нь овгийн цэргийн удирдагчийг илэрхийлнэ, буриадын “sulinga” –тэй дүйнэ*¹³⁴ гэсэн тайлбартай холбож ойлговол зүйтэй юм. Хятадын судалгааны бүтээлд өгүүлснээр, эвенгийн аймгууд нь “хал”-аас бүрэлдэх бөгөөд хал нь “мухон”~(мухан) гэх их гэр бүлүүдэд хуваагдана¹³⁵. Мухан-ы эцэг дээдэс нь нэг удмаас гарсан үр ач нар болно. Өөрөөр хэлбэл, нэг овог төрлөөс салж гарсан 10 үеийн доторх хүмүүсээр бүрэлдсэн гэр бүлийн бүлгүүд гэжээ¹³⁶. Энэхүү уламжлалт ойлголт эвенгүүдийн дунд хадгалагдан хэрэглэгдсээр байгаа юм байна¹³⁷. Хэнтийн хамниган, хорь буриадууд “мухон” юмуу “мухаан” гэдэгтэй адил, ойр төрлийн залуучууд, хүүхэд багачуудыг дотносон энхрийлсэн маягийн утгаар “мухаа” гэж дууддаг. Иймд “мухан”~”мухаа” гэх нэршил буриад, хамниганд ураг төрлийн хэлхээг илэрхийлэн хэрэглэгдэж байсны ул мөр өөрчлөгдөн уламжлагдаж ирсэнийг харуулж байж ч болох юм.

Манай судлаачид нүүдэлчдийн нийгмийн зохион байгуулалт түүний нэгэн нэгж болох дундад зууны үеийн овог-ийн талаарх тайлбаруудыг харьцуулан “овог” гэдэг нь үндсэндээ эзэн ба хараат этгээдүүдээс бүрдсэн, нийгмийн давхаргын ялгаа ихээхэн гүнзгийрсэн, нүүдлийн мал аж ахуйн эдийн засгийн ба нийгмийн харьцааны үр дүнд бий болсон байгууламж бөгөөд дан ганц нэг төрлийнхний хүмүүсээс бүрдээгүй бүлэг гэжээ¹³⁸. Түүхээс үзэхэд, дээрх байдал ХҮИ зууны үеийн хамниганы овгийн дотор харагдаж байдаг. Харин Хэнтий, Дорнодод хийсэн судалгааны дүнгээс үзэхэд, хамнигад “овог” гэдгийг ураг төрлийн хэлхээ гэж үзэн, үүндээ 5-7 дахь үеэ хамаатуулж байна. Эдүгээ

¹³³ Б.Ринчен, МАУ-ын хамниган аялгуу, УБ-1969, 45 т

¹³⁴ А.Ф.Анисимов, Родовое общество эвенков(тунгусов), Ленинград-1936, 136 стр

¹³⁵ Эвенг үндэстний товч түүх, ӨМАХХ-1988, 158т

¹³⁶ Эвенг үндэстний товч түүх, ӨМАХХ-1988, 165т

¹³⁷ Г.Энхжаргал, Өвөр Монгол ба Хятадын даяаршил дахь шинэ эвенк, НСАНтропологийн магистрын зэрэг горилсон бүтээл, УБ-2010

¹³⁸ Эрт, дундад үеийн монголчуудын аж ахуй, соёл, ШУА, Түүхийн хүрээлэн, УБ-2006

хамниганы дунд тэдний угсаатны гарал үүслийн талаарх домог түүх яригдахгүй байх бөгөөд харин овгийн үүсэл гаралтай холбоотой домогууд нэг биш таарч байна. *Жишээлбэл*, багш нар овгийн хүний бөөгийн онгодоос сонссон гэх түүхийг нь сийрүүлвэл, урьд энэ овгийнхон хүн ам олонтой болж өөр зуураа салж нүүгээд нэг хэсэг нь баахашил овогтой болсон гэж байв. Судлаачид энэхүү багш нар овгийг мэргэжлээр нэрийдсэн үржвэр овог юм. Монгол хэлэнд өргөн хэрэглэгддэг *багш* нь самгард хэлний *бхикшу* гэсэн үг бололтой. Самгард хэлний бхикшу нь анхандаа бурханы шашины лам хуврагуудыг хүндэтгэсэн нэр байжээ. Монгол хэлэнд ч тэр л утгаараа хэрэглэгдэж байгаад яваандаа нийгмийн хөгжлийн явцад иргэний сургуулийн сурган хүмүүжүүлэгчийн эрхэлсэн ажлыг заах мэргэжлийн нэр болжээ. Харин XIII-XIV зууны үед энэ үг монгол хэлнээс зүүн түрэг, перс хэлэнд орж, тухайн хэлнүүдэд “бахши” хэмээн дуудагддаг болсон¹³⁹ гэжээ.

Намиад овог(намиад~ намяр~ намасин~ намясин[олон тоон дээр¹⁴⁰ ~ намят~ нямят~ нямасин~ нямат). XVII-XVIII зууны үед Хар мөрөн, Нерчү, Аргунь орчимоор байсан хамниган ардыг “наймар” ~ (“намиад”), “наймар ард”¹⁴¹, “намясин”¹⁴², “намасины эвенгүүд”¹⁴³ гэж нэрлэж байжээ. Хятадын сурвалжид өгүүлснээр, 1480-аад оноос хойш 200 гаруй жилийн дотор Мин улс Байгаль нуураас зүүн тийш Хар мөрний дээд, дундад урсгалын дагуу маш олон харуулын газар байгуулсан бөгөөд тухайн үед тэндхийн Ар Хянганы нурууны ар, өврөөр нутаглаж буга өсгөж байсан эвенг аймгийг “буга унаж ой шугуйгаар явдаг”, “ар уулын зэрлэг хүмүүс” гэдэг байсан байна. Харин морь өсгөж хэрэглэдэг нөгөө нэг хэсэг эвенгийг нь “жүрчин зэрлэгүүд” гэдэг байсан аж. Байгаль нуураас зүүн тийш Чита голын орчимоор сууж байсан эвенг үндэстний намиар аймаг нь шинэ намиар, хуучин намиар, цөгчэр, баиар(~баяар) зэрэг найман их овогт хуваагдаж байжээ. Энд дурьдагдсан “цөгчэр”-ийг “Мин улсын үнэн тэмдэглэл”-д “зали” гэнэ, “цөг”-г нь “за”, “цэр”-г нь “ли” гэж орчуулжээ. Зали гэдэг нь энэхүү цөгчэр овгийн түрүү бөгөөд мөн сурвалжид тэмдэглэснээр бол, Чита голын жүрчин зэрлэгүүдийн түрүү Зали зэрэг хүмүүс Мингийн төрд ирж Чита голын хамгаалалтыг байгуулан улмаар Зали-г бүгдийн захирагчаар өргөмжилсөн байна. Иймээс цөгчэр нь зали юм, зали нь жүрчин зэрлэгүүдийн нэгэн овгийн ахлагч тул “Чита голын жүрчин зэрлэгүүд” гэдэг нь Чита голын орчимоор нутаглаж байсан эвенгүүдийн өвөг дээдэс юм гэж үзсэн байдаг¹⁴⁴. Энэхүү жүрчин зэрлэгүүдийн хойчис буюу Байгаль нуураас зүүнших Чита(Шилке) гол орчимын эвенгүүдийг мөн үеэс арай хожуу Мин улсын сүүлч Чин улсын эхэн үед(XVII зууны эхэн) намиар юмуу намида аймаг гэдэг байжээ.

¹³⁹ А.Очир, Халхчуудын угсаатны бүрэлдэхүүн гарал, УБ-2010

¹⁴⁰ Камчаткийн экспедицийн 1733-1737 оны тайланд тэмдэглэснээр Баргужины түнгүүс (эвенг)-ийн дотор “намясин” овог байсан ажээ. А.П.Окладников, “С.П.Крашенинников в Сибири”, Москва- 1966, 137 т

¹⁴¹ ТТА, Ф-М181,д-1, ХН-21

¹⁴² Г.М.Василевич, Эвенки, историко- этнографические очерки, Ленинград-1969, 277 стр

¹⁴³ С.В.Бахрушин, Научные труды, Москва- 1955, 57, 62 стр

¹⁴⁴ Эвенг үндэстний товч түүх, ОМАХХ-1986, 28-29т

Оросын эрдэмтэн Г.М.Василевич, ХҮИ зууны үед Баргужинаас Аргунь, Шилке, Нерчүд, Яруунын нуур орчимд ирж, 1727 онд Акшины районд, Чандагатай, Ключевийн харуулаар, XIX зуун гэхэд Аргунь мөрөн, Цурхайтад¹⁴⁵, 1897 онд Читийн тойрогт тархсан гэж хамниганы хамгийн том овог болох намиадын нутагшлыг тоймложээ¹⁴⁶. Гэхдээ ХҮИ зуунаас Халх монголын умард тал, Өвөр Байгалийн өргөн уудам нутгаар тархан сууж байсан намиад овгийнхон XX зууны эхэн үеийн Ононы хамниганы дотор дурьдагдаагүй байна. ХҮИ зуунаас эхлэн оргодол бутралын байдалд явж, халх Монголын умард хилийг түйвээж элдэв хэрэг өдүүлж байсан, мөн Манжийн төр хамниган намиад аймгийн холбооны иргэдийг эргүүлэн авах сонирхолтой байсан зэрэг шалтгаанаар хамниганы хамгийн дайчин, цэрэг дайны эрдэмд үнэнхүү гарамгай тэднийг 1779 онд Оросын хатан хаан II Екетаринагийн шийдвэрээр Шилкээс хойших бэхлэлт харуулаар шилжүүлэн суулгасны улмаас 15 эцэг хамниганы голыг бүрдүүлж байсан намиад овог нь монгол хамниганы дотор цөөн тоогоор таарч, Ононы хамниганаас огт бүртгэгдээгүй бололтой.

Судалгааны баримтуудыг харьцуулан үзэхэд Ю.Д.Талько-Грынцевичийн Ерөөгөөс тодруулсан “хамниган” отог гэдэг нь эрдэмтэн С.Бадамхатаны хожим тодруулсан “намиад” отог болж байна. Энэхүү хамниган намиадууд өндөр Богдтой холбоотой аман түүхийн эзэн болж “хамниган”, “намиад” гэгдэн манай улсын Ерөөгийн сав нутгаар суурьшиж¹⁴⁷ байсан тул ХҮИ зууны үед Баргужинаас зүүн тийш Шилке, Аргунь, Нерчү хүртэл нутаглаж байсан намиадын тархалтыг тухайн үеийн Монгол улсын умард хилийн дагуу Ерөө, Минж, Хараа, Онон, Хэрлэн гол, Сэцэн хан Түшээт хан аймгийн хил залгаа нутгаар тэлмээр байгаа юм. Эдүгээ намиад овогтнууд Төв аймгийн Мөнгөнморьт суманд¹⁴⁸, шар намиад, хар намиад¹⁴⁹ овогтон Дорнодын Баян-Уул, Цагаан-Овоо суманд¹⁵⁰ тус тус бүртгэгдсэн байна. XX зууны эхээр Ерөөгийн намиадын зарим нь гамингийн үймээн, нутгийн захиргааны зохион байгуулалт зэргээс болж, Төв аймгийн Эрдэнэ, Мөнгөнморьт сум руу ирж нутагшсан энэ ажээ. Дорнод Монголын намиад овгийнхон нь XX зууны эхээр ирэгсэд юм. Тус овгийн нэрний тухай ямар нэг түүхэн мэдээ, тайлбар олж амжсангүй. С.Бадамхатангийн Ерөөгийн хамниганаас сурвалжилсан материалд, урьд хамниган отогт хөтгөөд, салжиуд, намиад гэж овгууд байсан. Эд хэдий үед ч юм их дээр цагт хойшоо буриад-монгол руу нүүснээс (халх Монголоос гарч- О.Б) найман хүн үлдэж тэднээс

¹⁴⁵ Шинэ, хуучин Цурхайтын суурин Аргунь мөрөн дээр байжээ. Архивын баримтад тэмдэглэгдсэнээр Цурхайтад Орос, Монгол хоёр тал нийлж хилийн хулгай худлын хэргийн асуудлаар төгсгөө хийж хохирлоо харилцан барагдуулах шийдвэр гаргадаг байсан байна. ТТА, Ф-М181, Д-1, ХН-20; ФМ9, Д-5, ХН-10

¹⁴⁶ Г.М.Василевич, Эвенки, историко-этнографические очерки, Ленинград-1969, 275, 277 стр

¹⁴⁷ Б.Ринчен, МАУ-ын хамниган аялгуу, УБ-1969, 27 т

¹⁴⁸ О.Пүрэв, Р.Оюунбилэг, Төв аймгийн Мөнгөнморьт сумын түүх, УБ-2003, 13 т

¹⁴⁹ Балжин хатаны домогт өгүүлсэнээр бол, Нерчүгийн Эрээн Шар тал гэдэг газраар “хар намят” овгийнхон нутаглаж байсан бөгөөд Уудай, Шуудай, Хар Харгана гэдэг 3 баатартай байсан гэнэ. Ж.Цыбен. Путевые дневники 1903-1907гг. ред-Ванчикова.Ц.П. Улан-Удэ- 2001

¹⁵⁰ О.Баттуяа, Хэнтий, Дорнод аймагт хийсэн судалгааны гар бичмэл, 2003

үүссэн улсыг намиад гэж нэрлэсэн гэдэг. Намиад гэдэг нь наймхан улсаас үүссэн гэх аман яриа л тэмдэглэгдсэн байна. Хятад сурвалжийн мэдээ баримтыг үндэслэх юм бол намиад овог нь морьтон жүрчин зэрлэгүүдийн нэг, Чита голын эвенгүүдэд багтаж явсан морьтон түнгүүс бөгөөд энэ овог нь өсөн үржиж хала намиад, шар намиад болон салбарлажээ. Намиадууд нь тэмээ өсгөх бөгөөд морьтон түнгүүст тооцогдож¹⁵¹ явсан байна.

Алтан(ган) овог. Энэ овог нь Хэнтийн Биндэрт “алтан”, Дорнодын Цагаан-Овоод “алтанган” нэрээр бүртгэгджээ. Алтанганууд хусны үйсээр даллагын уутаа хийдэг, нэг үеийн ноёнтон улс, тэд богино насладаг, үр удам ховортой голомт нь амархан тасардаг гэнэ. Хамниганчуудын тахиж явах учиртай Галид гэж онгон байдаг. Энэ нь угтаа хамниган гаралтай онгон биш, урьд Галидыг “алтанган” хамнигад өөр нэг харь овгоос бэр болгож буулгасан байна. Түүнийг хамниганы “алтанган” овогт бэрлэж очсоных нь дараа ямар нэг учираас буруутгаж, алтанганууд модонд хүлээд толгойг нь тас харвасан гэнэ. Үүнд нь өширхсөн Галид нь тэнгэрт онгон болж “алтанган”-ы охидыг дуусгана гэж тангараг тавьжээ. Тэрнээс хойш эмс охид нь тогтохгүй үрэгдэж, “алтанган” овгийн охид, хүүхнүүд Галид онгонд хорлогдоно гээд төрлөө нууж нөхрийн овгоор явдаг болсон ¹⁵²учираас энэ овогтон цөөн байдаг гэнэ.

Хамниганы “алтанган(ган)” овгийн бэрээд урьд нь “алтан” гэдэг нэрийг цээрлэн бэрлэхдээ алтыг “humanэ мөгөн”¹⁵³ гэдэг байсан нь дээрх аман түүхээс улбаалсан байж болох юм.

Буянт заард. Энэ овгийнхоны тухай дээрхтэй тун төстэй домог хамнигадын дунд яригдаж ирсэн байна. Хамниганы буянт заард овгийнхон төдийлөн олон биш. Урьд энэ овгийн ах дүү гурав Онон голын урд биеэс эхнэр оргуулахад хүүхний талынхан мэдэж, тэдний хойноос нэхжээ. Бага дүү нь хоёр ахдаа, та нар амь биеэ аван зугтацгаа, би эднийг саатуулж байгаад араас чинь гүйцэж очоод харваж дохио өгнө шүү, сумаар минь таниарай гэж захиад хоцорсон байна. Бага дүү нь хэлсэн ёсоороо нэхэж ирсэн улсыг төөрүүлж орхиод ах нараа гүйцэж ирэн сумныхаа зэвээр таниулах санаатай нэгнийх нь эмээл рүү харвахад, нэг ах нь дүүгийнхээ харвасан сумны зэвийг нягтлалгүй хариу харваж дүүгээ шархдуулсан байна. Дүү нь, намайг зориудаар харвалаа хэмээн өширхөж, энэ хүүхнээс хүү гарвал 25 хүрэлгүй үхэж байг гэж харааснаас “буянт заард”-ын эрчүүд богино наслах болж, энэ овгийнхоны хүн цөөрсөн гэдэг ажээ¹⁵⁴.

Баягид ~ баеид. Тус овгийн нэрийг баягир~ баякү (Цинциус, 65т)~ баягир~ боя-гир~ буя-гир~ пуягир~ бояр гэж хэдэн янзаар тэмдэглэсэн байна¹⁵⁵. Б.Ринчен абугай Дорнодын Баян-Уул, Цагаан-Овоогоос бүртгэжээ. Одоо ч гэсэн Монголын хамниган дунд энэ овгийн улс цөөнгүй таарч байна. Баян (орочон,

¹⁵¹ Г.М.Василевич, Эвенки, историко-этнографические очерки, Ленинград-1969, 275стр

¹⁵² О.Баттуяа, Хэнтий, Дорнод аймагт хийсэн судалгааны гар бичмэл, 2004

¹⁵³ Мэнүмэ- мөнгөн алтан [эвенг], мэнун, мунун [мөнгө] алт, зоос; багдарин мэнун- цагаан төмөр мөнгө; сарсума мэнун- цаасан мөнгө; менгун- мэгу- мунгу- мөнгө [солон]; мөнгөн [монг]

¹⁵⁴ О.Баттуяа, Хэнтий, Дорнод аймгийн нутагт хийсэн судалгааны гар бичмэл, 2003

¹⁵⁵ Г.М.Василевич, Эвенки, историко-этнографические очерки, Ленинград- 1969, 263 стр

үдэ, үльч, орог; монгол бичгийн хэлээр)- баян, баялаг; баяжүт~ баян газар¹⁵⁶ гэсэн үг тул энэ овгийн нэр мөн баян, баялаг гэх утгатай болох юм.

Хятадын түүхэнд бичигдсэнээр баягир овгийнхон хамниган намиад аймгийн 8 болон 15 их овог төрөл гэгдэж байжээ. Чин улсын “Оросын төвшитгөсөн арга бодлого” түүхэн бичигт, ХҮИ зууны сүүл гэхэд Эргүнэ(Аргунь) мөрний зүүн талаар нутаглаж байсан “намиар” аймгийн дотор баяар зэрэг 8 овог байсан байна¹⁵⁷. ХҮИ зууны сүүлчээр адуутан, малчин баягирууд Өвөр байгаль болон Амар мөрний орчимоор нутаглаж байсан¹⁵⁸, мөн хятад сурвалжид энэхүү Гантөмөрийг баяар овгийн түрүү гэсэн байдаг¹⁵⁹. Үүнээс үзвэл баеидууд “намиад” аймгийн холбоо, “15 эцгийн хамниган”-д багтаж яваад ХХ зууны эхээр Хэнтий, Дорнод аймгийн нутагт ирж суурьшжээ. Тэд мал аж ахуй эрхэлж, тэмээг уналга ачилганд хэрэглэдэг, моринд гарамгай, нум сумыг гайхалтай эзэмшсэн, дайнд улсууд бөгөөд ХҮИ зууны сүүл хэрд Гантөмөрийн мэдэлд явж, Орос, Хятадын түрэмгийллийг эсэргүүцэн тэмцэж байсан эртний сурвалжит овог болох юм.

Пэенкэн ~ пөөинкин (С.Бадамхатан) ~ поинкир ~ фиенхин ~ (Г.М.Василевич) пийнхинь (Талько-Грынцевич) ~пэйенкен (Б.Ринчен)¹⁶⁰ овог. Ерөө, Цөх голоор нутаглаж байсан 6 овгийн 4 нь пийнхинь~(пөөинкин)овог, 2 нь хамниган овог гэж хамниганаас ялгаж нэрлэсэн байдаг. Пөөинкин овгийнхон намиадын хамт¹⁶¹ Ерөө орчимоор сууж байгаад Энх- Амгалангийн 27 онд (1688) өндөр Богдын анхны шавийн нэг болжээ¹⁶². Ерөөгийн их шавь “пөөинкин” овгийнхон одоогийн Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутаг, Бугант суурингаас зүүн тийш, Хүдэр сумаас урагш 40- 50 км газар байх Ходоодын хөндийгөөр нутаглаж байгаад ихэнх нь ардын хувьсгалын өмнөх гамингийн үймээнээр Хараа, Дарвитай руу нүүж, үлдсэн зарим нь Ерөө сумын 1-р багт багтжээ. Судалгааны бүтээлээс үзэхэд Монголын Ерөөгөөс өөр газарт энэ овог тэмдэглэгдэж байгаагүй байна. Хэнтий, Дорнод, Сэлэнгийн Ерөө, Хүдэр сумын нутагт хийсэн манай судалгааны үед пөөинкин овгийнхон таарсангүй.

Залтууд ~(джалтот ~дялтот¹⁶³). Дорнод аймгийн Баяндун, Дашбалбар, Цагаан-Овоо суманд хамниганы залтууд овог бүртгэгдсэн байдаг¹⁶⁴. Эдүгээ

¹⁵⁶ В.И Цинциус, Сравнительный словарь тунгусо- маньчжурских языков, Т-1, Ленинград-1975, 65 стр

¹⁵⁷ Эвенг үндэстний товч түүх, ӨМАХХ-1988, 56 т

¹⁵⁸ Г.М.Василевич,Эвенки, историко- этнографические очерки, Ленинград-1969, 275 стр

¹⁵⁹ Эвенг үндэстний товч түүх, ӨМАХХ-1988, 57 т

¹⁶⁰ Фэйенкин гэх овгийн нэрийг заримдаа фз- тэй дууддаг байна. Б.Ринчен, МАУ-ын хамниган аялгуу, УБ-1969, 44 т

¹⁶¹ ТТА, Ф-М31-Д2-ХН-1125

¹⁶² Энх-Амгалангийн 27 онд (1688) Галдан бошигт Халх аймгийг уулгалан явсан хирд Өмөхэй насан багын тул түүний эхийн хамт хамгийг авч дагаар ирвэй. Дагаар ирсэн хүн 10 түм илүү өрх, 30-р он Долоон нуурт хаан өөд болоор одоод чуулган нийлсэнд зарлиг буулгаад Өмөхэйд сэцэн ханы цолыг агуулж хишиг хурим хуримлаад бор үнэгэн дах, буу, шүр шигтгэсэн хазаар худрага, эмээлтэй морь зэргийг хүндээр шагнавай. Өмөхэй энэ үед 10 гаруй настай байжээ. Б.Өлзийсүрэн, Халхын Сэцэн хан аймгийн хураангуй түүх, Өндөрхаан-1993, 22-23т

¹⁶³ Г.М.Василевич, Эвенки, историко- этнографические очерки, Ленинград-1969, 266 стр

¹⁶⁴ Б.Ринчен, МАУ-ын хамниган аялгуу, УБ-1969, 24 т

хамниганы залтууд овгийнхон Дорнодын Цагаан-Овоо суманд суурьшиж байна¹⁶⁵. Тэд ХҮИ зууны үед Нерчүгийн тойрогт нутаглаж байжээ¹⁶⁶. Дорнод Монголын “залтод” хамниган Нерчүгийн хамниган гэгдэн, 15 эцгийн хамниганд багтан, морь тэмээ эдлэгч, малчид байснаа ХХ зууны эхээр манай улсад нүүдэллэн иржээ. Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын залтууд хамниган, гэрийн сахиус гэж хар хурган “заяагач”-ийг шүтэж байна. Тэнгэрийн дуунаар хөөг, хөөг! хэмээн өндөр дуугаар хашгирч ганга уугиулна. Залтод хамниган нагацаа эрхэмлэн, нагац зээ ясаа харалцахгүй гэдэг.

Сартуул~ Sarta’ul¹⁶⁷~ Сартон (Сартот ~ Сартол ~ Сортот) овог нь 1680 онд Нерчүд бүртгэгдсэн байна. ХҮИИ зуунд дагуурын (Өвөр байгаль) бүлэгт багтан, 1897 онд Читийн тойргийн Үрүлгэ, Онгоцон, Куржиктайн захиргаанд хамрагдаж явсан¹⁶⁸ ажээ. Судлаачид ХҮИ зууны үед Нерчүд байсан сартот (сартол) хамниганыг монгол гаралтай гэж үзсэн байдаг.

Энэ овгийн нэрний тухайд, XII-XIII зууны үед монголчууд Хорезмын улсын захиргаан дахь мусульман шүтлэгтэн нарыг *сартуул (sartayul)* хэмээн нэрийддэг байв. Сартуул нь самгард хэлний *sart-* худалдаачин гэх *ymgamay* үг бөгөөд *sart (сарт)* гэсэн үгэнд монгол ярианы хэлний олны *-ul (-уул)* нөхцөл залгаж, *sartayul (сартуул)* хэмээх нэр үүсгэсэн гэж тайлбарласан байна. Мөн тэдний гарал үүслийг Чингис хаан 1219-1225 онд Дундад Азиас хэсэг мусульман иргэдийг олзлон, монгол нутагт авчирсан аж. XIII зууны эхээр монгол нутагт ирсэн сартуулууд Чингис хааны удмын ноёдод захирагдан явсаар XVI зууны дундуур Гэрсэнзийн хүү Далдан хөндлөнгийн мэдэлд очин Хангай уулын баруунаар нутаглах болж, Манж нар Монголыг эзлэхэд тэд Засагтхан аймгийн нэгэн хошуунд нэгэн хошуу захирагдаж уг хошууг Цэцэн (сартуул) засгийн хошуу¹⁶⁹ болжээ.

Буриадын сурвалжид өгүүлснээр, сартуул нь, урьд Чингисийн албат байгаад, Чингисээс хойш Хятадын мэдэлд орсон байна. Тэгж байтал отгийн түрүү сайд Хүлэг гэгч Сэцэн ханы хошуунаас ах дүү долоон нөхдөө дагуулан гарч Орос оронд ирж, тэд 1630- аад оны орчим Зэдэ, Үнгэй голоор ирж суусан¹⁷⁰ гэнэ. 1660 онд олёод¹⁷¹- монголчуудын цэрэг Халх- Монголд довтолж монголчуудаас сонгоол ба 8 овогт улс тасарч Сэлэнгийн монгол- буриадуудтай хамтарч, Сэлэнгийн 2 тал, тэнд цутгадаг Зэдэ, Сүхэ голуудаар, Хёлгын зүүн талаар нутаглажээ. Урьдын 6 отог буриадтай хамтран суусан 8 овогтон нь сонгоол, ашабагад, атаган сартуул, хатагин, подгородно отог, үзөөн, табангууд, XIX зууны сүүлээр энэхүү 8 овог өнөржиж сонгоол, ашабагад, нэгдэх ба хоёрдахь сартуул,

¹⁶⁵ О.Баттуяа, Хэнтий, Дорнод аймагт хийсэн судалгааны гар бичмэл, 2004

¹⁶⁶ Г.М.Василевич, Эвенки, историко- этнографические очерки, Ленинград-1969, 267 стр

¹⁶⁷ Б.Сумъяабаатар, Монголын нууц товчоо, Үсгийн галиг. УБ- 1990, §263, 264, 265.

¹⁶⁸ Г.М.Василевич, Эвенки, историко- этнографические очерки, Ленинград-1969, 278 стр

¹⁶⁹ Энэ хошууны албан нэр нь Халхын өрнө замын Зүүнгарын зүүн этгээдийн хошуу. Уг хошууны нутаг одоогийн Завхан аймгийн Цэцэн-Уул, Завханмандал, Ургамал, Түдэвтэй, Сантмаргац, Сонгино, Эрдэнэхайрхан сум бүхэлдээ, Увс аймгийн Завхан сумын нутгийн зүүн хэсэг.

¹⁷⁰ Буряадай түүхэ бэшэг, Улаан-Удэ-1992, 184 т

¹⁷¹ Ойрад-монголчуудыг хэлж байна.

нэг ба хоёрдахь атаганууд, хатагин, подгородно, үзөөн, 1, 2, 3 дахь табангууд болсон¹⁷² байна. ХҮII зууны 20-иод оноос ХҮIII зууны дунд үед Монголоос очсон олон овгуудын дотор “сартуул” багтаж байжээ¹⁷³. Энэхүү овог нь хуучин удам гарлын нэрээ хадгалж явснаа, Халх, Ойрадын зөрчилдөөнт үед Байгаль тийш очиж барга, буриад, хамнигадын дотор багтан орсоноор хамниганы сартуул овгийнхон бий болсон бололтой. Хамниганд гачинха сартуул, баахшил сартуул, модоргон сартуул, бамбачин сартуул, хатагин сартуул гэх овгуудыг хамтад нь 5 эцгийн хамниган гэсэн байхаас гадна эднийг тодотгож нэрлэсэн гачинха, баахшил, модоргон, бамбачаан, хатакин овгууд хамниганы дотор мөн бие дааж байна. Иймд “сартуул” овог нь уугуул хамниганы овог биш гэдэг илэрхий байгаа юм. Энэхүү овог нь Хэнтий, Дорнод аймагт бүртгэгдсэн байх бөгөөд Октябрын хувьсгалын хөл үймээнээс дайжин 1920- иод оны үед Дорнод Монголын нутагт ирсэн хамнигад болно.

Гуринха сартуул. Аман түүхэнд өгүүлснээр, сартуулын нэг эцгийн 9 хүн, хоол хүнс ховор хүнд үед хэр чадал муутай хөгшний том сэркины (сэрх) гүрээг ханаж өл залгуулж байжээ. Хөгшин гүрээгээ хануулсан сэрхээ хараад нөгөө сартуулуудыг гуринхнууд гэж харааснаас үүдээд гуринх сартуул гэдэг болсон гэнэ¹⁷⁴. Тулгам бэрх үед гал түлж хоол, унд хийж идэлгүйгээр, морьдынхоо судсыг ханаж, цусаар нь ундаалан өл залгасаар, 10 хоног буулгүйгээр шавдан довтолгодог. Энэ бол жинхэнэ татарчуудын язгуурын аж төрөл, зан суртал болой¹⁷⁵ гэсэн байдаг. Мөн 1790-ээд оны үед өвөр Байгальд зуд болж хорийн буриадууд малаа барж үгүйрээд, зарим нь үлдсэн амьд малаа ханаж, цусыг нь идэж, тэжээл болгож маш их зовж байжээ¹⁷⁶. Энэ мэтээр мал ханах, цусаар нь хоол тэжээл болгосон гэх баримт цөөнгүй байх тул гуринх сартуулын үүслийн тухай дээрх аман түүх нь гоёж чимээгүй, үнэний агуулгатай байж болох юм.

Үзөөн~(өзөөн), орос хэлнээ-(удзун~узон). Монголын хамниганы үзөөн овог нь бас буриад, барга нарын дотор байдаг. Үзөөн овгийнхон Нэрчүгийн 15 эцэг хамниганд багтаж хаант Оросын өмнөд хилийн харуулд сууж байсан ажээ. ХҮIII зууны дунд хирд Оросын судлаачдыг Онон голын сав, Монголын умард хил дагуу аялах үед, тэнд хил харуулын морьтон түнгүүсийн (хамниган-О.Б.) Үзөөн, Баликагир, Гүнэйн салаа байрлаж байсан гэдэг¹⁷⁷. Тэднийг 15 эцэгт багтсан тухайд буриадын сурвалжид, Бошигт хааны бослогын үеэр(Галдан бошигт-О.Б) Монголоос дүрвэж гарсан олон иргэд Сэлэнгийн буриад, Нэрчүгийн хамниган, солонгуудтай хамтарч 15 эцэг болсоны дотор шарайд, атаган, абаганат, худугта зончин, батууд, хатагин, үзөөн зэрэг зүйл бүрийн ястан байсан нь бүгд

¹⁷² Буряадай түүхэ бэшэгүүд, Улаан-Удэ-1992, 155 т

¹⁷³Ю.Д.Талько-Грынцевич. Народности центральной Азии (Монголо-халхасцы, буряты и тунгусы). Труды- Троицкосавско-Кяхтинского Отделения Приамурскаю Отдела Императоскаго Русскаго Географического Общества. ТҮ. выпускъ 1. Москва-1902, 42 стр

¹⁷⁴О.Баттуяа, Хэнтий, Дорнод аймагт хийсэн судалгааны гар бичмэл, 2003

¹⁷⁵ Марко Поло, Орчлонгийн элдэв сонин, УБ- 1987

¹⁷⁶ Буряадай түүхэ бэшэгүүд,Улан-Удэ-1992, 17 т

¹⁷⁷А.П.Окладников, С.П.Крашенинников в Сибири неопубликованные материалы, Москва- Ленинград- 1966, 98 стр

бодит(жинхэнэ-О.Б)монгол язгууртан билээ¹⁷⁸ гэсэн байдаг. Мөн үзээнүүдийн тухай буриадын аман түүхэнд, тэд Халхын Түшээт хан аймгийн Виндай- ахайн хошуунд байснаа, хавчигдан зовсны учир хаант Оросын албат болохыг хүсч 1660 онд оргожээ. Тэднийг удирдаж байсан Арьяа багш гэгч нь баригдаж, шатаагдах ялд орсон байна. Хэдэн шар чаргаар түлээ овоолж Арьяа багшийг шатаасны дараа эрдэм төгс нэгэн лам биеийг нь илааршуулсан ажээ. Виндай ахай ч наснаас нөгчиж Арьяа багш урьдын зорьсон хүслээ биелүүлэхийн тулд Бээжин ороод буцаж явсан цагаан хааны төлөөлөгчдийн нэг Семен Грачевийг дагаж Орост очжээ. Оросын захиргаанд орсоны дараагаар үзээнүүд Сэлэнгэ мөрний Наанги гэх газарт нутагшсан байна. Арьяа багшийн бие нь түлэнхий, толгойдоо үсгүй байсан гэдэг¹⁷⁹. Үзээн хамниганы настангууд өөрсдийгөө анх Монголоос тасарч гарсан гэж одоо ч дурсаж байна. Бас өөрөөр, хамниган ба буриадын дундаас гарсан хүмүүсийг “үзээн” гэдэг байсан¹⁸⁰гэх ажээ. Б.Ринчен абугай, Эрээний үзээн биеэ үзээн жалайр гэж нэрлэнэ. Жалайр – эртний монгол овог, Ар Өвөр Монгол, жич Дундад Азийн зэрэг газар байгаа нь, монгол хамниган дунд бас тэр монгол овог хутгалдан оролцсон байна гэж үзжээ¹⁸¹. Хамниган хэл аялгууг судласан эрдэмтэн Л.Мишиг хамниганы дотор “үзөөний” гэх онцлог дуудлага бийг тэмдэглэсэн байдаг¹⁸². Энэ нь “үзээн” овогтнууд халх-монгол хэл аялгуутан байгаад хамниганы хэл соёлд уусан, өөрийн гэсэн өвөрмөц аман аялгууны ялгаа үүсгэснийг гэрчилж байж болох юм. Хэнтийн багш нар, дулят хамниган настангууд, улусдай (улуснай) хамниган гэж байсан нь энэ үзээнүүдийг хэлдэг байсан санагдана гэж өөрсдөөсөө ялгаж байлаа¹⁸³. Аман түүх, буриадын сурвалж, хамниган настангуудын дурсамжаас үзэхэд хамниганы үзээн овгийнхон Монгол нутгаас гаралтай монгол овог бөгөөд ХҮИ зууны сүүлээр Халхын Түшээт ханы нутгаас дайжин Оросын харьяанд очоод буриад- монголчууд болон хамнигантай холилдоод хамниганы овог болсон нь энэ юм. Монголын хамниганы “үзээн” овгийнхон бусдаасаа хэл аялгууны талаар онцлог байж, уг удмаараа ялгарч иржээ. Оросын нэрт түнгүүс судлаач Г.М.Василевич энэхүү овгийн нэрийг монгол гаралтай гэж үзсэн байна¹⁸⁴.

Хангис~(хангин~хангид- Б.Ринчен). “С” ба “д”- г сэлгэж хэрэглэх нь хамниганы аялгуунд тохиолдох бөгөөд жишээлбэл, хамнигад буриад гэхийг “буриасай”, “буриас” гэдэг. Энэ дуудлагаар хангид нь хангис болох нь эргэлзээгүй.

Тэдний аман түүхэнд өгүүлснээр, хангис гэдэг бол дархан, төмрийн дархцуулын удамтай ажээ. Дархан хангисууд хаанаас ч юм дөшөөрөө сал хийж далай гатлан ирж хаа нэгтээ нутагласанд уул газрын бөө ад үзэж нутгаасаа

¹⁷⁸ Буряадай түүхэ бэшэгүүд, Улан-Удэ-1992, 131 т

¹⁷⁹ Буряадай түүхэ бэшэгүүд, Улан-Удэ-1992, 17 т

¹⁸⁰ Ж.Жүгдэржав, “Зарим сүмдаас” гарчигтай тэмдэглэл, Хэнтий аймгийн музейн сан хөмрөг

¹⁸¹ Б.Ринчен, МАУ-ын хамниган аялгуу, УБ-1969, 30, 91 т.

¹⁸² Л.Мишиг, МАУ-ын хамниган аялгууг сурвалжилсан нь, Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтдийн анхдугаар их хурал, 1961, 193 т

¹⁸³ О.Баттуяа, Хэнтий, Дорнод аймагт хийсэн судалгааны гар бичмэл, 2003, 2004

¹⁸⁴ Г.М.Василевич, Эвенки, историко- этнографические очерки, Ленинград-1969, 281 стр

хөөжээ. Энд суухад юу нь болохгүй байгааг асуусан ч шалтгаангүй хөөсөөр муудалцаж бөө нь хангис дарханыг - үгүй хийнэ гэж зүхсэн байна. Хариуд нь хангис дархан, төмрөөр хүн хийж, хөөргөндөө гал оруулаад нөгөө төмөр хүнээ барихад гар, хөл нь хайлаад тасрах шахаж байна гэнэ. Энэ сацуу нэг хүн ааг амьсгаагүй ирж, - би энджээ, буруу юм хийсэн байна, амаа барья гэж нөгөө бөө хэлүүлснийг уламжилжээ. Учир нь тэр бөөгийн хөл гар нь хөөргөнд барьсан төмөр хүнийх шиг болж, сул унжиж санжиж байсан юм байх. Ийм хатуу домогтой дарханы удам учраас манайхан өргөмжлөгдөж ирсэн. Хангис удмынхан баатрын саадгийг даллагандаа шүтэж явдаг. Хангис хамниган даллагын уутаа цагаан эсгийгээр ширж хийгээд, улаан даавуугаар эмжин, эсгий таг зүүж, гурвалжин зэвтэй, үзүүр хэсэгт нь зэс эсвэл мөнгөн толь тогтоосон хүрэн модон сумыг даллагын уутныхаа амсарт хийж, бурхан тахилын ойролцоо байрлуулдаг ажээ.

Хангисууд хэт цахин домнож элдэв өвчин эмнэх аргатай бөгөөд яр түүхий гарсан хүнийг эмнэхдээ:

Далай гаталж ирсэн

Дархан хангис удамтай бид, эмч нь бол домч нь бол! гэж хэтээ цахиж домнодог гэнэ¹⁸⁵. Академич Б.Ринчен “хангид” овгийг хамниган бус. Өвөр Монголд хангин овог буй нь эртний Канглы гэдгийн өнцөг сунжирч, орчин үед Хангин болж ирсэн ажгуу. Байгалийн хойд биеийн буриад дунд эл эртний Хангин- Кангин овгийн хүн буй бөгөөд өдгөө монгол хамниган дунд эл овгийн нэр гарч ирсэн гэжээ¹⁸⁶. Манай судалгааны үеэр Хэнтийн Дадал сумаас өөр газарт хангис овог таарсангүй.

Улиад. Барга нарын дотор тохиолдох улиад овог нь хамнигадын дунд бас байна. Улиад хамниган Дорнодын Цагаан-Овоод бүртгэгджээ. Буриадын Бавж барс баатар¹⁸⁷, Балжин хатаны домогт энэ овгийнхон Шилке голын хойд талаар Нерчү голоор нутаглаж байсан гэсэн байдаг. Сурвалжийн мэдээгээр, 1613 оны орчим хожимын Нэрчүгийн нутаг Хөхөлбийн хөвчийн ар өвөр, Үлирэнгэ голд цутгадаг Хуандайт гэдэг газарт нутаглаж түүний ойролцоох Аргунь ба Онон голоор нүүдэл хийж амьдарч байсан хорийн ардуудыг Онон голд байсан улиад хамнигад элдвийн хэрэг өдөөж хавчиж байсан гэдэг. Бүүвэй бэйл хааны сударт гарч байгаагаар энэ овог арван таван эцгийн хамниганд багтаж байсан ажээ.

1997, 2007 онд МУ-ын Засгийн Газрын тогтоолоор батлагдсан “Ургийн бичиг хөтлөх журам” нь ургийн овогтой болох шаардлагатай болж, 1999-2000 онд албаны бичиг баримтад ургийн овгийг заавал тэмдэглэж эхлэв. Энэ үеэс ургийн овог шинээр үүсгэжээ. Ийм овгуудад өвгөөдэй хамниган(хамниган-өвгөөдэй), хамниган минж, олон голт овгууд орж байна. Өвгөөдэй хамниган гэдэг нь манай нэрт эрдэмтэн хэлний зүйч өвгөөдэй хэмээх Цэндийн Дамдинсүрэн гуайн төрөл садны улс нийтээр хэлцээд түүний авгайлсан нэр болох өвгөөдэйг, уг гаралтайгаа хамтатгаж энэ овгийг үүсгэсэн байна. Зарим нэг түүхэн овгийг

¹⁸⁵ О.Баттуяа, Хэнтий, Дорнод аймагт хийсэн судалгааны гар бичмэл, 2003, 2004

¹⁸⁶ Б.Ринчен, МАУ-ын хамниган аялгуу, УБ-1969, 30т

¹⁸⁷ Бүүвэй бэйл хааны судар оршивой, ҮНС-ийн гар бичмэлийн сан хөмрөг

таамгаар өөртөө хамаатуулж авсанаас үүн лугаа үлгэрлэвэл зүйтэй юм. Хамниган минж гэдэг нь урьдын түүхэн нутгаа хамаатуулсан нэршил ажээ.

Энэ мэтчилэн өнөөгийн хамнигад өөрсдийн уг гарал ургийн овгоо сэргээн танихыг эрмэлзэн, овгийн түүхээ ярьж хэлцэж ирсэн төдийгүй бөөгийн онгод тэнгэрийн тусламжаар овгийн тугийг бий болгосон тохиолдол ч байна.

Хэнтий аймгийн Биндэр сумын “багш нар” хамниган Л.Эрдэнэцогт өөрийн овгийн тугыг бөөгийн онгодоос асууж хийсэн байна (Зураг- 1, 4). Тугны голд бөөгийн хэнгэрэг дээр бөртэ чоно, гоо марал, нарыг буулгаж, хэнгэрэгний дээр чоно, үнэг, шилүүсний чих, хэнгэрэгний доод талд доргоны хөл, баавгай ба гөрөөсний зүүн хойд хөл, тугны доод хэсэгт газар, усыг дүрсэлжээ. Хэнгэрэг дээрх бөртэ чоно, гоо маралыг “Монголын нууц товчоо”- ноос санаа авч угсаа гарлаа бэлгэдэж өөрийн сэтгэмжээр буулгасан ажээ. Туган дээр зурсан ангийн чих болон хөл нь уг амьтны хийморьлог эрхтнүүд юм. Урьд хамниган айлууд чоно, шилүүс, үнэгний чих, баавгай, дорго, гөрөөсний хөлийг “зөмөгөө” дээрээ өлгөдөг байсан бөгөөд түүгээр нь хамниган айл гэж таньдаг байсан гэнэ. Гөрөөс чимээ авахаараа зүүн хойд хөлөө өргөдөг. Мөн чих өвдвөл гөрөөсний зүүн хойд хөлний чөмгөөр домнож эмчилдэг гэдэг шүү гэж тайлбарлаж байлаа.

Дорнод Монголын хамнигад нагацыгаа аав, ээжийн дараа орох хүндтэй хүнд тооцдог. Хамниган настны хуучилснаар, урьдын улс - нагац чинь хэн бэ? гэж хамгийн түрүүнд асууж нагацаар нь хүнийг шинждэг байсан гэнэ. Тэд нагацтай холбоотой дараахь үгсийг хэлцсээр иржээ.

Нагацын тэнгэр их

Нагац зээ ясаа харалцахгүй

Нагацаас авбал налайна

Зээгээс авбал зэвэрнэ.

Нагацынхаа дэргэд дал барихыг цээрлэдэг. Далыг далуулаа гэлцэж байна.

Хамниганы ураг төрлийн нэр:

Бидний тэмдэглэсэнээр ¹⁸⁸	Б.Ринчений тэмдэглэсэнээр	Утга нь
Өмбөө	сагди ¹⁸⁹ еньин(еньи)	эмэг эх
Хөгшээ(багш нар)	сагди амьин(ама)	өвөө
Ажээ(дулят. хамн)	сагди амьин(ама)	аавын аав
Ав-	амин,амьин,ама	аав
Эжий	еньин еньи	ээж
Авгай	абага	аавын эрэгтэй дүү,
Авгаа	абага	аавын эмэгтэй дүү, эгч
Авгалжин	-	авгайн эхнэр
Нагац	нагачу	ээжийн төрөл

¹⁸⁸ Хэнтийн Биндэр сумын багш нар хамниган Ч.Гунгаагаас 2006 онд тэмдэглэв.

¹⁸⁹ Сагди гэх нь орохоны агуу, их, том гэсэн утгатай.

- Хамниганы аман түүхээс харахад тэдний дотор эртний монгол овгууд багтаж байгаа нь ХҮИ зууны үеийн төв Азийн улс төрийн нөхцөлөөс шалтгаалан өрнөсөн угсаатны шилжилт хөдөлгөөнөөс голлон үүдэлтэй байна. Өөрөөр хэлбэл, өвөр Байгалиар буриад- монгол, халх- монгол, манж-түнгүүс төрөлтнүүд хамтран суусан үед хамаарах юм.

- Түнгүүс юмуу хамниганы нэгдмэл угсаатны үүсэл гаралтай холбоотой түүх домог хэлцэгдэхгүй харин овгийн үүсэлд холбогдох нэг биш аман түүх уламжлагдсан, мөн овгийн түвшинд ахуй соёлын зарим ялгаа тодорхой байгаа нь тэд нилээд хожуу болтол нийгмийн байгууллын талаар овгийн зохион байгуулалтад голлон суурилж, өөр хоорондоо харилцаа холбоо муутай явж ирсэнээс шалтгаалсан бололтой. Мөн тэдний угсаа гарлын талаарх олон янзын саналыг нэг мөр болгож чадахгүй байгаагийн нэг шалтгаан нь хамниган угсаатаны үүсэл гарлын талаарх дотог түүх дэлгэр байдаггүйтэй холбоотой.

- Өнөөгийн хамниган хүний овгийн талаарх ойлголт нь ихэнхдээ төрөл садны холбоо сүлбээгээр төсөөлөгдөж байна. Гэхдээ овог нь түүхэн тодорхой үед арай өөр байж, “мухаа”~(мухан) гэх үгээр хэлэгдэж байсан байж магадгүй ул мөр хадгалагджээ. Энэ хэллэг нь дорнод Монголын хамнигад болон буриад-монголчуудын дунд хадгалагдаж байна.

4. Монголын хамниганы хэл аялгуу

Хэл нь угсаатны соёлын илэрхийлэл болж байдгийн хувьд манай бүтээлд хамниганы хэл болон хэлний судалгааны талаар тоймлон өгүүлэх шаардлага урган гарч байна.

Эрдэмтэн судлаачид, хамниган гэдэг нь европын хэлээр бол түнгүүс гэж нэрлэгдэж байгаа тэр угсаатан юм. Тэдний хэл нь алтай язгуурын манж-түнгүүсийн бүлэг хэлд багтдаг бөгөөд мөн бүлэг хэлний дотор эвенгийн хэл нь ороchon(эвенгийг түнгүүс юмуу ороchon гэдэг байв), негидаль(ламут)-ийн хэлний хамтаар түнгүүсийн буюу умардын хэлний салбарт багтана гэж үзэж ирсэн байдаг. Энэ нь дараах маягаар төлөвшсөн аж. XIX зууны түнгүүс судлалд гол үүрэг гүйцэтгэсэн Финийн эрдэмтэн М.А.Кастрен (1813-1852) алтайн язгуур хэлнүүдийг үгийн бүтэц, хэл зүйн хэлбэр,бие даах онцлог зэрэг хэдэн гол шинжээр нь харьцуулан судлаж, манж-түнгүүс хэлийг финно-угор, самоед, түрэг, монгол хэлийг нэг төрөл хэл гэж үзэн хамтаар нь”алтайн хэл” гэж нэрлэн, түнгүүсийн хэлийг самоедийн хэлээр дамжин финийн төрөл хэлтэй холбогдоно гэжээ. Мөн Г.И.Рамстедт, Н.Н.Поппе нар алтайн хэл ба манж-түнгүүс хэлний төрөл хамаарлыг гүнзгийрүүлэн судлаж, манж-түнгүүс хэлийг түрэг, монгол хэлтэй харьцуулж үзээд эдгээр хэлнүүд нь хоорондоо авиа зүй болон үгийн бүтэц, хэл зүйн хэлбэр, үгсийн сангийн хувьд төстэй болохыг батлан, манж-түнгүүс хэлийг “өвөг алтай” хэлнээс салбарласан гэж дүгнэсэн байна. Энэ мэтчилэн түнгүүсийн хэлний хамаарлыг гүнзгийрүүлэн судласаар эдүгээ “манж-түнгүүс” хэлийг “түрэг”, “монгол” хэлнүүдийн хамтаар “алтайн язгуурын хэл” гэх

үзэл бий болжээ. Судлаачдын тодруулснаар, монгол ба түрэг хэлний үг зүйн 50% нь, үгсийн сангийн 25% нь, мөн манж-түнгүүс ба түрэг монгол хэлний үгсийн сангийн 10% нь, үг зүйн 5% нь таарч, манж-түнгүүс болон самоедийн хэлнүүдийн үгсийн сангийн 70% нь дүйдэг байна¹⁹⁰. Түрэг, монгол, манж- түнгүүсийн хэл нь алтай язгуурын хэлд хамтдаа багтана гэдэг нь дээрх хэлтэн угсаатнууд түүхэн тодорхой үед нийтлэг нэг хэв шинжит хэлтэй байснаа нийгэм, улс төр, эдийн засгийн нөхцлөөс шалтгаалж бие биеэсээ тусгаарлагдан улмаар хэл аялгууны хувьд ялгаатай болж ирсэн гэсэн үг юм. Ийнхүү манж- түнгүүсийн хэлийг алтайн язгуурын хэлэнд хамаатуулсан нь тэдний угсаа-гарлын холбогдолд зарим талаар баримжаа болж байдаг. Гэхдээ энэхүү бүтээлдээ хамниганы хэлийг дээрх схемчлэлээр бус, зөвхөн Монголын хамниганы хэлний судалгааны хүрээгээр хязгаарлаж байгаа билээ.

Монгол хамниганы хэл аялгууг судласан академич Б.Ринчен, (“Монгол ард улсын хамниган аялгуу”, УБ- 1969), Буриадын эрдэмтэн Д.Г.Дамдинов (“Ононские хамниганы”, Улан-Удэ- 1993) нар өөрсдийн бүтээлдээ хамниганы хэл аялгуу төдийгүй тэдний угсаа түүхийн асуудалд баримжаа болох санал, дүгнэлтүүдийг тусгасан байдаг. Академич Б.Ринчен дээрх бүтээлдээ ашигласан материал хэрэглэгдэхүүний талаар тодорхой өгүүлсэн зүйл үгүй боловч түүний судалгаанд Хэнтий, Дорнодын хамнигад болон хуучин Сэцэн ханы хамнигадын дундаас цуглуулсан хэрэглэгдэхүүнүүд зонхилсон байдал ажиглагддаг. Тэрээр Монголын хамниганы дунд хэл аялгууны ялгаа байгааг нарийвчлан тодруулж, *тэрхүү ялгааны нэгийг нь “жинхэнэ хамниган” буюу “эвенг” хэл, нөгөөг нь “дундад эртний монгол аялгууны үлдэцтэй хамниган аялгуу” гэж нэрлэжээ.* Монголын хамниганы ихэнх нь дундад эртний монгол хэлний нэгэн аялгуугаар хэлэлцдэг. Хамниганы энэхүү аялгуунаа эртний монгол хэлний шинж тэмдэг хадгалагдаж, монгол худам үсгээр бичсэнтэй яв цав нийлж байгаа нь монгол хамнигас энэ аялгууг худам монгол бичгээр дамжуулан сурсан хэрэг огт биш юм. Гэхдээ *энэ аман аялгуу нь “хамниган” аялгуу биш, хамнигацуулын аманд үлдсэн монгол аман аялгууны зүйл юм гээд, энэ аялгууг “дундад эртний монгол аялгууны үлдэцтэй хамниган аялгуу” гэж нэрлэж, энэ аман аялгуу нь тэднийг хамниган хэлнээс монгол хэлэнд хэдийд орсоныг гэрчилж байна гэжээ.* Өөрөөр хэлбэл хамнигадын монгол хэлэнд орж эхлэсэн үе нь дундад эртний үед холбогдоно гэсэн саналтай байжээ гэж ойлгогдож байна.

Академич Б.Ренчин, *хамниган хэлээ мэдэгчид нь эвенг хэл гэж хамниган хэлээ нэрлэдэг нь, монголын дундад эртний хэлний байдал бүхүй аялгуугаар хэлэлцэгсдээс түүгээрээ ялгаж, жинхэнэ хамниган хэлээ эвенк хэл гэдгээрээ монгол үгтэй “хамниган” гэж нэрлэдэг хэлээсээ салгаж нэрлэдэг*¹⁹¹ *гэж монгол хамниганы хэл аялгууны ялгаа ба заагыг тодорхойлсон байна.* Өөрөөр хэлбэл, “жинхэнэ хамниган хэл”-тэн болох Монголын хамниганы цөөн хэсэг нь өөрсдийн

¹⁹⁰ М.Г.Туров, К проблеме этногенеза и этнической истории эвенков, Этнографическое обозрение, №03, Москва-1998, 46стр

¹⁹¹ Б.Ринчен, МАУ-ын хамниган аялгуу, УБ-1969, 88 т

уугуул хэлээ “эвенг” гэж, тухайн үед ихэнх нь мэдэж хэлцэж байсан монгол үгтэй “хамниган” гэдэг бас нэг хэл аялгуунаас түүнийгээ ялгаж байжээ. Дундад эртний монгол хэлний үлдэцтэй аялгуугаар яригч *хамнигад нь монголчуудаас нилээд өөр татлагатай аман аялгуугаар хэлэлцдэг учираас нутгийн монголчууд тэр аман аялгуугий нь өөрсдийн хэл аялгуунаас ялгаж үзээд байсан тул, хамнигацуул түүнээ “хамниган хэл” маань гэж “боддог болсон” гэсэн байна.*

Ерөөгийн хамниган, Мөнгөнморьтын хамниган, Хэнтийн Цэнхэрмандал, Мөрөнгийн зэрэг хамниганыг хэлний талаас нь нарийвчлан судлаад Ерөөгийн шавийн хамниган зах нутаг нийлсэн хошууны хамнигантай төрөл садны холбоотой¹⁹² ... байжээ гэж дүгнэсэн байдаг. Энэ нь Ерөөгийн хамниган ба Сэцэн ханы хамниганы холбогдлын тухайд бөгөөд энэхүү холбогдол нь хэл аялгуугаараа төдийгүй түүхэн талаасаа ч ойрынх гэдгийг бүтээлийн өмнөх хэсэгт дурьдсан билээ. Тэрээр энэхүү бүтээлдээ хамниганы гол цөмийг бүрдүүлж явсан хамгийн том, түүхэн овог “намиад”-ын тухай болон Сэцэн ханы хамниганы угсаатүүхийн талаар өгүүлээгүй байна. Хамниганы хэл аялгуунд дундад эртний монгол бичгийн хэв байдал хадгалагдан үлдсэн байгаа нь угсаатан судлаач, хэлний шинжээчдэд сонирхолтой судлагдахуун болохыг онцолж өөрийн судалгааны дүнг нээлттэй үлдээснээрээ тэдний хэл соёл, угсаатны судлалын асуудлыг дэлгэрүүлж, өөр өнцгөөс харахыг сануулсан ч байж болох юм.

Хамниганы хэлний судалгаанд Ононы хамниганы хэл, соёлыг судласан Буриадын эрдэмтэн Д.Г.Дамдинов, зүүн хойд Монголын хамниганыг судласан эрдэмтэн Л.Мишиг, Унгарын эрдэмтэн У.К.Каталин нарын бүтээл тодорхой байр эзлэдэг. Эрдэмтэн Л.Мишиг зүүн хойд Монголын хамниганы хэлийг Баргужины хамниган, барга хамниган хэл, манж бичгийн хэлний язгуур нэгтэй ба дүйх үгстэй тус тус харьцуулж үзээд, Монголын зүүн хойд нутгийн хамниган нар манж хамниган хэлтний тасархай бөгөөд тэдэнтэй нэг хэлтэй байсны ул мөр бүрэн арилаагүйн баримт илрэн байхаас гадна, тэдний мартсан хэл аялгуу нь хамниган эвенг хэлний өмнөд¹⁹³ буюу баруун салаанд багтах аялгуу байсан болбуу. Тэд XIII- XIV зууны үеэс эхлэн монгол хэлээр ярих болсон бололтой, одоогийн хэл аялгуу нь “Монголын нууц товчоо”-ны хэл буюу дундад эртний монголчуудын хэлний онцлогийг хадгалсаар байх тул тэднийг дундад эртний монгол хэлээр яригчид гэхэд болно гэжээ. Хамниганы хэл аялгууг 1. Цамхаг, Балжхаан, Хярун, Агуцын; 2. Берц, Хэр, Сүмэндийн; 3. Үзөөний гэж ялгасан байна¹⁹⁴. Монголын хамниганы дотроос үзөөний хэл аялгуу арай өөр байдгийг манай судалгааны үеэр ч гэсэн хамниган настангууд дурьдаж байсан билээ.

Эрдэмтэн Л.Мишиг 1970-аад оны үед Ерөөгийн хамниганыг мөн хэлний талаас шинжилж, тэндхийн монгол хамниганд манж хэл соёлын нөлөөтэй солон эвенг хэлний нөлөө буйг тодруулжээ. Ерөөгийн хамниган дунд уугуул хамниган хэлээс үлдсэн үгсийг тусгайлан үзэж, XVIII зууны үед “намиад”, “пөөинкин” Ерөөд

¹⁹² Б.Ринчен, МАУ-ын хамниган аялгуу, УБ-1969, 19 т

¹⁹³ Хар мөрөн өгсөөд, Сунгари мөрөн дагуу суудаг на[най], орочи, самагир, үдэ-ийн хэлийг манж-түнгүүс хэлний өмнөдийн бүлэг хэл гэж ангилдаг.

¹⁹⁴ Л.Мишиг, ”МАУ-ын хамниган аялгууг сурвалжилсан нь”, Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтдийн анхдугаар их хурал, УБ-1961, 193т

байсныг нотлон, Өндөр гэгээн Занабазарын үед жинхэнэ хамниган үгээрээ хэлэлцэн, хамниганд байгаагүй шарын шашны лам хуврагийн тухайд ч хамниган-манж гаралтай нэр хэрэглэж, зүүн зүгийн хамнигантай харилцаа хэлэнд нь байсны сонин гэрч баримт олжээ гэж академич Б.Ренчин Л.Мишигийн хамниганы хэлний талаарх дээрх судалгаанд ихээхэн ач холбогдол өгсөн байдаг.

1960- аад оны үед Ононы хамниганы хэлийг судласан Буриадын эрдэмтэн Д.Г.Дамдинов, зүүн хойд Монголын хамниганы(Дадалын) хэл аялгууны талаар судласан эрдэмтэн Л.Мишиг, К. Каталин нарын зэрэг судлаачдын бүтээлийг ашиглаж, Ононы хамниганы хэлийг ойрад монгол, монгол, дагуурын зэрэг хэл аялгуутай харьцуулан судлаад Ононы хамниганы хэл нь эртний монгол хэлний олон шинжийг өөртөө агуулж байгааг тодруулжээ. Тэрээр Е.М.Залкинд, П.Пеллиот, Л.Лигети зэрэг эрдэмтдийн хятан нь монгол хэлтэй төрөл нэг хэлтэй байсан байж болох тухай саналуудад үндэслэн, Ононы хамниганыг дагууртай холбогдуулж тэднийг манж- түнгүүсийн угсаатнуудаас ялгаж үзэх саналыг мөн дэвшүүлсэн байна. Хамниган угсаатны голлох гишүүд нь монголчууд юм. Гэхдээ тэд халх (халх-монголчууд-О.Б) биш, харин тухайн үедээ Ононы сав газар болон Даур/Дагуур/-аар нутаглаж байсан хятан нарын хойчис бололтой. Ононы хамниган нь ХҮII зууны үед хаант Оросын харьяанд орж, улмаар Монголын умард хил харуулын нутгаар суурьшсан Гантөмөрийн мэдлийн дагууруудтай холбогдоно.

Хамниганы судалгааны түүхээс үзэхэд, хамниганыг түнгүүсээс ялгаж үзэх ойлголт XIX зуун хүртэл байсан бөгөөд хамниганыг түнгүүс гэж нэрлэсэн нь улс төрийн учир шалтгаантай юм. Хятадын тал дагууруудыг эргүүлж авахаар оролдож эхлэхэд оросууд тэднийг түнгүүс гэж нэрлэсэн бөгөөд энэхүү улс төрийн тоглоомын улмаас "дагуур" нь "түнгүүс"- ээр солигдсон гэж үзсэн байна. Дорнод Монголын хамнигантай төрөл нэг Ононы хамниганы хэл нь тухайн үедээ хятан нарын хэсэг дагуурын хэлтэй олон талаар авцалдсан, монгол хэлний эртний шинжийг хадгалсан тийм хэл байж болох юм гэсэн Дашинима Галдановичийн санал хамниганы угсаа гарлын асуудалд сонирхолтой баримтлал болж байна.

Монголын хамниганы хэл аялгууг судласан эрдэмтэд тэднийг дундад эртний монгол хэлний үлдэцтэй хэлээр, эсвэл Монголын нууц товчооны буюу дундад үеийн монгол хэлээр яригсад гэж үзжээ. Хэл шинжлэлийн талаас бол, XI- XII зууны үеэс XV- XVI зууны үеийг “дундад үеийн монгол хэл”-ний үед хамааруулдаг бөгөөд энэ үеийн монгол хэлний аялгуунууд нь авианы тогтолцоо, хэлзүйн хэлбэр, үгсийн сангаар харьцангуй нэгдмэл байжээ. XI- XII зууны мэдээгээр – Енисей мөрний эх Найман мөрний саваар нутагладаг ойрад овгууд, мөн язгуурын монгол буюу “монгол дарлегин”(хамаг монгол)нь монгол хэлтэй гэхээс гадна мөн үеийн татар ба уйгаруудыг монгол хэл мэддэг гэсэн байна¹⁹⁵. Эндээс үзэхэд хамниганы монгол хэлэнд орсон үе буюу дундад эртний монгол

¹⁹⁵ Эрт, дундад үеийн монголчуудын аж ахуй, соёл, ШУА, Түүхийн хүрээлэн, УБ-2006, 18т

хэлний гэх үечлэлийн үед ба түүнээс өмнө үеийн монгол хэлтнүүд нь дээрх овог аймгуудаар хязгаарлагдаж байгаа юм. Хэл нь угсаатны үйл явц хэрхэн болж өнгөрснийг харуулж чаддаг учираас хамниган нь монгол хэлтний дээрх бүлгүүдэд ойртон нэгдэж байсан, эсвэл угсаа гарлын талаар тэдэнтэй нэгдмэл байсан гэх саналд хөтлөж байна.

Судлаачид дагуурын өвөг дээдэс болох хятан нар ямар хэлтэй байсныг шинжлэх ухааны үндэстэй баттай тодруулаагүй боловч тэд монголчуудтай угсаа гарлын талаар холбоотой гэх ойлголт давамгайлж байгаа билээ. -дагуурын хэл нь “Монголын нууц товчоо”-ны хэлтэй адилхан ХИҮ-ХҮ зууны монгол хэлний онцлог шинжтэй монгол хэл, -Дагуур бол Хятаны үлдэгдэл, мөн -хятан нарын хэл нь монгол, -Хятан, Монголын гарал нэг¹⁹⁶ гэсэн эрдэмтэн судлаачдын саналыг үндэслэх юм бол, дагуур, хамниган хоёр холбоотой, цаашилбал хамниган(морьтон түнгүүс) нь угсаа- гарлын талаар дагуур буюу дахэ-р дамжаад хятан нарт холбогдоно гэсэн санал бас тоймлогдож байдаг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Монголын хамниганы аж ахуй, эд өлгийн соёл

1. Монголын хамниганы мал маллагаа, тариалах ажил

Хамниганы аж төрөл. Ерөөгийн болон Сэцэн ханы хамниганы аж байдлыг тусгайлан судлаж гаргасан бүтээл ховор юм.

ХҮIII зууны эхэн үеийн архивын баримтад ханы хамниганыг “*гөрөөчин(луча-ийн) ард*” гэхийн зэрэгцээ ... *өөрийн харьяа хан, засгуудад хэрэм, үнэг, гөрөөсний арьс үсний алба өргөж*¹⁹⁷ байсан гэх тул тэдгээр хамнигад нь эртнээс нааш ан агнуур эрхэлж иржээ. 1820, 30-аад онд ав хомрогын газарт ойр нутаглаж байсан Сэцэн ханы зарим хамниганыг Хан Хэнтийн уулнаас татаж Дархан бэйлийн хошууны нутгийн гүн рүү суулгах гэхэд тэд хамнигад ихэд цааргалж энэ ажлыг бараг арваад жил чирэгдүүлсэн байдаг. Энэ үйл явдал нь Сэцэн ханы хамниганы анхны нутаг нь ан гөрөөл эрхэлж амьдрах таатай орчин нөхцөл болж, тэд ч голлон ан хийдэг байсан гэдгийг харуулж байна.

Хан Хэнтийн овооноос урагш нүүснээс хойш хамнигад малын өвөлжөө бууц бэлтгэн тэр газрынхаа халхчуудын адил мал маллаж, Жонон гүн Гончогцэрэнгийн хошууны хамниган таван хошуу малаас сарлаг, ямаа илүү

¹⁹⁶ Д.Пэрлээ, Хятан нар тэдний монголчуудтай холбогдсон нь, УБ-1959, 17 т

¹⁹⁷ ТТА, Ф-М31, Д-2, ХН-1125

өсгөж, Сэцэн ханы болон Жонон гүний хамниган хоёул тэмээ хэрэглэж байсан байдаг. Тэндхийн хамнигад нутгийн ардуудтай малын хашаа бууцаа булаалдан зарга үүсгэж байсныг үзвэл, мөн үед тэд өвөлжөө бууц засч эзэмшин, ан агнахын зэрэгцээ мал маллаж амьжиргаагаа залгуулж байжээ.

Ерөөгийн хамниган голлон ан гөрөө хийж байсан бөгөөд ХХ зууны эхэн үе гэхэд зөвхөн хэрэмчлэх төдий болсон байна. Энэ нь тэд байгаль орчинтой зүй зохисгүй харьцаж ой модыг хядан огтолж ан гөрөөсийг гамгүй алах болсноос шалтгаалжээ. Хамниганы олонх нь 60 орчим үхэр, 20-30 адуу, 300 хүртэл хоньтой байсан ба баячууд нь 1000 хүртэл толгой адуутай байсан гэнэ. Тэд монгол эсгий гэрт суун, өвөлжөө зуслан хоёрыг ээлжлэн нүүж, малын тэжээл болгон өвс хадаж, өвөл хэрэглэхээр мойл, сараана, халиар, мангир, мэхээр, самар мэтийг түүж нөөцөлнө. Хамниганы оюун сэргэлэн, аливааг онох мэдэхүй дор түргэн тул ан агнахын оронд шинэ ажил эрж алтны уурхайн газраа түлээ юм зөөх буюу уурхайн ажил хөдөлмөр хийх зэргийн олбор байх болсон¹⁹⁸ байна. Судлаач Кондратьев, Минж голын салбар Залаатай горхинд байх их шавийн хамниганы тухайд, зуны цагт хар модны холтсоор барьсан гэртэй, өвлийн цагт мухар модон байшинтай, эсгий гэр байхгүй, үүний учир нь бол хонь цөөн тул эсгийгүйгээс болжээ. Голлон ан агнуур эрхэлж амьдрах ба адуу, сарлаг өсгөнө. Тэнд нийт 42 хүн, адуу 42, үхэр 60, сарлаг 70- 80, хайнаг- 5, ямаа – 40, хонь 100-200 орчим, 11 тооны гэр сууц байснаас 8 нь холтсон гэр, 3 нь дөрвөлжин мухар модон байшин байж, зарим гэрийн дэргэд юм агуулах модон амбаар, пин ба тугалын хороо барьсан байжээ. Ан агнахдаа зөвхөн идэхийн тулд агнах тул ан гөрөөс дэргэдүүр нь ажиггүй явна гэж тэмдэглэсэн байдаг. Ж.Цэвээн 1931 оны эхээр Ходоодоор нутаглах хамниганыг(пөөинкинүүд) нягтлаад, тэд их төв бөгөөд сэргэлэн шударга, чигч, ажил амьдрал нь мал маллахаас гадна, ан агнах ба юм бага сага ачих мэт болой, үлэмж баян ч үгүй, хоосон ч үгүй, нэгэн жигд дунд хэрийн амьдарлагатай ¹⁹⁹ гэхчлэн хамниганы аж төрлийн талаар тэмдэглэсэн байна.

Дорнод Монголын хамнигадын ахуй соёлын байдлаас үзэхэд, тэдний аж төрөх хэв маяг нь ХҮIII зуун гэхэд Сибирийг бүрмөсөн эзлэхсэн байсан оросуудын болон хөрш зэргэлдээ буриад-монголчуудын ахуй амьдралын зарим хэв маягаас шингээн хувирч хөгжиж ирсэн байдаг. Сибирийн бус төрөлтнүүдийн дунд 1749 оны үеэс модон тэрэг, чарга хэрэглэх, малын хашаа хороо барих, 1760-аад оноос хадуураар өвс цавчиж овоолж хадгалах, 1790-ээд оноос орос маягаар байшин барьж суух дадал тогтож эхлэсэн²⁰⁰ ажээ. Хамниган төдийгүй Сибирийн олон ард түмэн хаант Оросын колоничлолд өртсөнөөр тэдний аж ахуй соёлын хавчилга нөлөөнд орж хуучин уламжлалт хэрэглээ, аж ахуй эрхлэх хэв маягаа хувьсган өөрчилж багагүй хүндрэл амссан байдаг. Оросууд Сибирт олноор суурьшиж эхлэсэн нь бүс нутгийн уугуул хүн ам үржил шимгүй газар нутаг

¹⁹⁸Ж.Цэвээн, Түүвэр зохиол- I, УБ- 1997, 126, 127 т

¹⁹⁹Ж.Цэвээн, Түүвэр зохиол- I, УБ- 1997, 126- 127 т

²⁰⁰ Буряадай түүхэ бэшэгүүд, Улан-Удэ-1992, 100,104 т

руу шахагдаж, уламжлалт аж ахуйгаа санаан зоргоор эрхлэх боломжгүй болж аж төрөх нөхцөлөөр хумигдсан нь хүндрэлийн гол шалтгаан болсон ажээ.

XX зууны эхэн үед Байгалийн өмнө талаар суугч буриад, хамниган хамтдаа- 200000 (1896 оны байдлаар, Өвөр Байгалийн бус төрөлтөн хүн ам нийтдээ – 228376²⁰¹) гаруй, бүгд эрдэмгүй, буриад, хамниган хоёрын эхнэр бүр ч эрдэмгүй, 1000 эхнэрээс 5 нь бичиг гаргаж чаддаг байсан байна. Өвөр Байгалийн буриад, хамнигад үржил шимгүй нутаг руу шахагдсанаар ихэнхдээ мал маллаж, зохистой багахан газарт тариа тарьж, гол усны захаар суугчид нь загас агнуур, ой тайгад суугчид нь ан гөрөөгөөр амьдарч байжээ. Тэднээс Агын буриад-монголчууд нь үлэмж муу газартай, Сибирийн бус төрөлтний бараг тал хувь нь газар тарианы ажил огт мэддэггүй²⁰² байсан ажээ. Ийн аж төрж байсан буриад, хамнигадын цөөнгүй хэсэг нь хожим XX зууны эхээр дорнод Монголын нутагт ирж суусан байдаг. Тэндхийн хамниган настангуудын өгүүлэх нь, Оросын нутгаас ирсэн даруйд орох оронгүй, өмсөх зүүх, идэх уухаар ихээхэн хомс байсан тул, хамниган эрчүүд нутгийн уугуул хүмүүст ямаан тэрэг дархалж хонины цувдайгаар солих, эмэгтэйчүүд арьс шир элдэх, хувцас хунар оёх, баян айлд “хууһан” хийх зэргээр ойр зуурт зарагдан аж төрлөө залгуулж байжээ. Чинээлэг айлын малыг хардаг хүмүүсийг буриад, хамнигад “хууһан” гэж нэрлэдэг. Энэ нь зарцтай дүйх ойлголт юм. Цагаан- Овоогийн улиад хамниган Балжмаа (2003 онд 74 н) 18,19 орчим настайдаа Түмэндэлгэр сумаар нутаглаж байсан Шарагшаан гэх ганц бие хөгшнийд 6 сар гаруй хугацаанд “хууһан” хийж 1000 орчим хонийг нь хариулж сард 1 хониор хөлс авч байсан гэнэ. Малаа харуулж байгаа айл “хууһан”-д зуны цагт голдуу хоймог, өвөл нь гурилтай шөл эсвэл цус хуурч өгдөг байжээ¹. Хамнигад хууһан хийж амьжиргаагаа залгуулах нь 1940-1950-иад оныг хүртэл хадгалагдаж байсан байна.

Мал маллагаа. Сэцэн ханы хамнигад нэгдэлжих хөдөлгөөн өрнөх хүртэл голдуу сарлаг маллаж байжээ. Нэгдлийн үед үхэртэй болжээ. Тэнүүний хамнигад сарлаг маллаж, сарлагийн сүүгээр цагаа идээ бэлтгэж, хөөврийг нь тушааж амьдралдаа нэмэрлэж иржээ. Тэд Дамдинбишрэлт бурхан сарлагийг уулнаас дүүгүүрээр буулгаж ирсэн гэж ярьна. Сарлаг талд муу, талын шингэн өвсөнд идээшдэггүй, ууланд дуртай, хэвтэл бууц гэдэггүй амьтан. Сарлагийг тэргэнд хөллөнө. Урьдын цагт нуруу ачиж уулаар явдаг байсан гэнэ. Сүү нь өтгөн, сүүг нь боловсруулж хэд хэдэн төрлийн идээ умдаа бэлтгэнэ. Заримдаа цагаан идээг нь хятад пүүсэнд зардаг байжээ. Сарлагийн мах сэрүүн чанартай. Монгол бух авчирч сарлаг дагуулна. Монгол бух, сарлагаас гарсаныг усан хайнаг гэнэ. Бие томтой, чадалтай, тэсвэртэй, уналга ачилгад зүтгэлтэй, хээрийн нохойд төлөө өгдөггүй гээд усан хайнагийг эрхэмлэнэ. Сарлагийн бух монгол үнээнээс гарсаныг тосон хайнаг гэнэ. Социализмын үед суурь тусгаарласнаас болоод монгол бух сарлаг дагахаа больжээ. Сарлагийн хөөвөр, хонины ноосыг хольж гэрийн дээвэр туурга, оймс хийнэ. Сарлагийн савгийг засгийн ноосонд өгөхгүй хадгална. Сарлагийн тэргүүн гэж хүндэлнэ. Сэцэн ханы хамнигад ямааг

²⁰¹ В.В.Птыцин, Селенгинская Даурия, Спб- 1896, 2 стр

²⁰² Оросын албат буриад нарын орших ёсон амой, Наран-1908, 11-13 т

чөтгөрийн төрөл, бэлчээрт хортой, хот хөлдөөнө, хүйтэний үед хонь дарж хэвтдэг гээд чухалчилдаггүй байжээ. Хамниганы нутаг уул хад бартаа саад ихтэй тул сарлаг өсгөхөд нэн таатай. Архивын баримтаас ч гэсэн тэднийг сарлаг ямаа голдуу өсгөж ирсэнийг харж болно. Адуу, хонь, үхэр өсгөж байжээ. Сарлагийг социализмын үе хүртэл зөвхөн хамнигад л өсгөж ирсэн байна. Социализмд орж нэгдэл байгуулагдахад хамнигад нэгдэлээс оноосон малыг суурьлан маллаж, нэгдлээс заасан газарт нутаглах болжээ.

Өвөр Байгалиар ялангуяа Ага нутгаар суух хамниган, буриадын ихэнх нь нүүдэл ахуйгаар аж төрж иржээ. Агын талаар мал маллан амьдарч байгаад Орос, Японы дайны үеэр Хайлаар хүртэл нүүж, 1910-аад он гарган Халх Нөмрөгийн хошуунд ирсэн хамнигад²⁰³ нүүдэл ахуйгаа илүү хадгалж ирсэн нь 2004 оны судалгааны явцад ажиглагдаж байлаа. Хамнигадын нүүдэл, тухайн үед Агаас эхлээд дорнод Монголын нутгаар дамжин Имэн гол хүрдэг байсан байна.

Хамниганы мал аж ахуй эрхлэх, аж төрөхүйн зарим уламжлалыг Дорнодын хамниган настангуудын ярианаас тоймловол, тэд өвөлдөө нүүдэллэж мал малладаг байсан бөгөөд бууц засч хашаа хороо барьж суурин сууддаггүй, нэг газарт сайндаа л 7-10 хонодог байжээ. Намар эрт цас унавал заавал өвлийг хүлээхгүй нүүж эхлэнэ. Нүүдлийн үед түр маягаар малын “харш”, “хаамаг” босгож малаа нөмөрлөдөг. Хавтгай банз моднуудыг холбон босоо дай хадаж “харш” хийдэг бол хаамгийг бог мал, тугал хашихад хэрэглэх тул нарийн сургааг холбож хийдэг байна. Нүүдэл хийхдээ тэмээ юмуу үхэр тэргээр ачаалж, нэг айл 7- 8 тэмээн тэрэгт гэр, эд хөрөнгөө багтаачихдаг байсан гэнэ. Монголын хамниган тэмээний мах идэхийг цээрлэдэг.

Өнөөгийн хамнигад адуугаа дааган насанд тамгалах бөгөөд 5 сарын эхээр даагаа тамгалж хонь, бяруугаа имнэнэ. Мал хорогддог гэж үздэг учираас хамнигад малаа имнүүлснээс хойших гурав хоногт сүү цагаан идээ зэрэг зүйл айлд өгөхийг цээрлэдэг. Тусгай хүн залж хурга, ишгээ хөнгөлүүлж хариуд нь бэлэг сэлт өгдөг уламжлалтай ажээ. Хамнигад адууны тамгыг ихэд дээдэлдэг бөгөөд газарт тавихыг цээрлэж, нүүдлийн үеэр гэрээ бариут хамгийн түрүүнд тамгаа оруулж гэрийн баруун хананд өлгөдөг. Тамгандаа шар тос, цагаан идээ хүндэтгэн өргөхийгөө “тамга идээлүүлэх” гэж байна. Хэнтийн дулят(дулегат-О.Б) хамниган аймгийн алдарт уяач Д.Жигмэд гахай өдөр морь барих, морь уяж эхлэхэд сайн гэж байлаа. Хамниганы адуу өсгөж үржүүлдэг уламжлалд нь тулгуурлан нийт түнгүүсүүдийн дотроос онцолж морьтон түнгүүс гэж нэрлэж байсан байдаг. Монголын хамниганы ердийн хөсөг тэрэг хэдэн төрөл байдгийн дотор дөрвөн дугуйтай паар²⁰⁴ тэрэг, хоёр дугуйтай “однохол” юмуу “ямаан тэрэг” багтана. Дөрвөн дугуйтай пар тэргийг арлаар нь сунгаж хэрэглэдгээ “сунгаа”, “сунгаа тэрэг” гэж нэрлэж байна. Тэрэгнийхээ хэмжээнд нь тохируулж бөмбөгөрдүү хэлбэрээр яс мод зангидан бүхээг хийж, түүнийгээ эсгийгээр бүрсэнээ Цагаан- Овоогийн хамнигад “мухлиаг(мухлиа)” гэж нэрлэж хэрэглэдэг.

²⁰³ Б.Ууганбаяр энэхүү нүүдлийн тухай тодорхой өгүүлсэн байдаг. Б.Ууганбаяр, Буриадуудын нэгэн нүүдлийн түүхээс, Угсаатан судлал, ШУА, Түүхийн хүрээлэн, УБ-2006

²⁰⁴ Паар гэдэг нь орос хэлний пара- хос, хослосон гэдэг утгатай үгний хувирал юм.

Мухлиагийг тэмээнд хөллөж, дотор нь зуух байрлуулж гал түлж, нүүдлийн үед хөгшид хүүхдээ суулгаж явдаг байсан гэнэ. Тэргэн дотор гал түлэх арга нэгдэлжих хөдөлгөөний үед нилээд түгээмэл болжээ. Өнөө үед мухлиагийг эсгийгээр бүрэх нь багасч түүнийг төмөр модоор орлуулан хийж, мөн адил нэрлэн хэрэглэж байна.

Харин Хэнтийн хамнигад тэмээг тэргэнд хөллөдөггүй, морь юмуу үхэр хөллөдөг. Гахайн толгойг ихэд хүндэтгэж ирсэн Хэнтийн багш нар хамниган, бид урьд мухлиаг, чингэлэг хэрэглэж байгаагүй гэж байлаа. Энэ нь уулаас тэмээ өсгөж эдлэж байгаагүйтэй нь холбоотой юм. Эд бараа, хувцас хунараа хадгалах чингэлэгийг Цагаан-Овоогийн хамниган “хүлиеэр” гэж нэрлэдэг. Баргууд “мухлиаг”, “хүлиеэр”-ийг мөн ийн нэрлэж хамнигантай адил зориулалтаар хэрэглэдэг юм²⁰⁵. Цагаан- Овоогийн хамниган болон буриадууд ахуйн зарим нэг зүйлийг өөрөөр нэрлэдэг нь судалгааны явцад ажиглагдаж байв. Цагаан-Овоогийн буриад, хамнигад хоолны шүүгээ (тавиур)-г тоохоон, эгч, эгчмэд хүнийг- авжаа, хогийн утгуурыг - гоcho, хөлдүүр гэх зэргээр Хэнтий, Дорнодын бусад буриад, хамниганаас огт өөрөөр нэрлэж байна.

Тариалангийн ажил. Монголын хамниганы тариалан эрхлэж эхлэсэн нь тийм ч эртнийх биш бололтой. 1790 оны үед Өвөр Байгалийн нутагт зуд болж мал олноороо үхэж буриадууд үгүйрлийн туйлд хүрсэнд, II Екатерина хатан хааны сангаас үр тариа, анжис хадуур үнэгүй өгч тариалан тариулж буриадууд цатгалан болов гэсэн нь тариалан тарих явдлыг хөхүүлээд зогсохгүй буриад, хамнигадын аж ахуйд гарсан нэгэн том өөрчлөлтийн үндсийг тавьсан байна²⁰⁶. Сурвалжид тэмдэглэсэнээр, XIX- XX зууны үед Байгаль орчимын буриад, хамниганы нутгийн байдал адилгүй бөгөөд зоны ч ажил явдал тэгшгүй байжээ. Буриад, хамниган хоёр эдлүүрийн 6 сая 780677 десятин газартай, дүүргийн дотор 56152260 десятин газартай, бус төрөлтний эрийн тоогоор хувааваас нэгэнд нь 87 хагасаас илүүгүй десятин хүртэж, үүнээс эдлүүрт зохистой нь 57 десятин газар болно. Гэвч бус төрөлтний газар нь хужир ба чулуун хайр, элсэн харгана, боролж, ширэнги, бургас, бүдэргэнэ элбэгтэй, хэрэггүй газар ихтэй, газрын 100%-ийн 15%- 75% нь үржил шимгүй байжээ²⁰⁷. Ингэдэйн сав газар хөрс шороо муутай, элсэрхэг байдаг бол Ононых тийм биш харин эсрэгээр хар шороон хөрстэй учир хөх тариа, овъёс, буудай гаргуун сайн ургадаг²⁰⁸ байна. Онон голын сав нутгаас ирсэн дорнод Монголын хамниганы нилээд нь тариа тарих уламжлалаа хадгалж, 1940, 50- иад оныг хүртэл буудай тариалж алба болон хувийн хэрэглээндээ нэмэрлэж байжээ. Тэдний буудай тариалах аргыг тоймловол, нийтдээ 6- 8 тооны шарыг хоёр хоёроор нь ёрмоонд оруулж, анжисанд хөллөн тариалангийн газраа хагалж борнойдоод үрээ суулгана. Намар хураасны дараа тэвэр тэврээр багцалж бооно. Ингэж боосон тарианы нэг багц боолтыг “цөслөөн” гэнэ. Хүйтний эрч

²⁰⁵ Г.Цэрэнханд, Барга, МУ-ын угсаатны зүй, II боть, УБ-1996, 101 т

²⁰⁶ Буряадай түүхэ бэшэгүүд, Улан-Удэ-1992, 17 т

²⁰⁷ Оросын албат буриад нарын орших ёсон амой, Наран-1908, 6, 7 т

²⁰⁸ М.Г.Новлянская, Даниил Готлиб Мессершмидт и его исследованию Сибири, Наука – 1970, 80стр

чангарсан үед цэслөөнөө мөсөн дээр авчирч хус модон “мольти”²⁰⁹-оор(молькин ч гэнэ) цохиж эсвэл мориор гишгүүлж цайруулдаг ажээ. Улаан буудайгаа чанах юмуу эсвэл тээрэмдэж гурил болгон хүнсэндээ хэрэглэж байжээ²¹⁰.

2.2. Ан агнуур

Монгол хамнигад ан агнуур хийх онцлог уламжлалтай байна. Тэд ангийн олзыг байж болох бүх боломжоор нь ашиглаж иржээ. Гэр сууц, хоол хүнс, хувцас эдлэлийн зэрэг зүйл, зан дадалд нь ан амьтан ямар нэг талаар заавал холбогдсон байдаг. Хамниганы дунд ан гөрөөлөхүйд баримтлах тусгай дэг жаяг, цээрлэх хийгээд билэгшээх ёс хадгалагдаж байгаа нь Монголын зарим угсаатаны бүлгийн ан агнуурын мөн ёстой таарч байхаас гадна тэдний өөр зуурт бага сага ялгаатай тал ч ажиглагдана. Хамниган анчид покров(ус мөс хөлдөж эхлэх үе 10 сарын 14)-ыг баавгай ичиж, хэрэм, гахайд явах хамгийн тохиромжтой үе, ангийн улиралд тооцдог. Өнөөгийн монгол хамниган анчин анд мордох өдрийн өглөө шүтээн болсон уул овоондоо ангийн хишиг гуйж идээ цайныхаа дээжийг өргөдөг ажээ. Гахай өдөр анд гарвал олз ихтэй байна гэж билэгшээнэ. Хамниган анчид эхэлж агнасан ангийхаа цусаар ганзагаа мялааж, дараа нь ангийн хишиг хүртээсэн хангай дэлхийгээсээ дахин ан авын олз аргадан хүсч хишиг даллага авдаг. Ингэхдээ унагасан ангийнхаа арьсийг битүү өвчсөөр сарьсан хоншоорт нь хүргэж орхиод:

Баян хангайн аршаан

Баатар эрийн олз

Бас дахин боор боор²¹¹ (Бас өөрөөр, бару бару баян хангайн хишиг минь хурай хурай²¹²) гэж арьсаар нь гурвантаа даллаад, сарьсан хоншоороос нь атган, сэгсэрч салгаад ангийн хишиг даллана. Агнасан ангийнхаа толгой, шийр, цусыг тухайн анг унагасан газарт нь орхидог учиртай²¹³. Хамниганы ангийн даллага авахтай адил, монголчуудын ан агнуурын ёсонд агнасан үнэгний арьсаар ангийн хишиг даллах зан үйл байдаг нь агнасан үнэгээ туламлан өвчөөд, сарьсан хоншоорт нь тулгаж орхиод, арьснаас нь барьж эргүүлэн даллаж биенээс нь салгаад,

Алтай Хангай минь

Үнэгнийхээ улаан

Чонынхоо цагаан

²⁰⁹ Хоёр модыг сураар холбож хийх бөгөөд нэг нь бариул болно. Нөгөө мод нь арай бүдүүн жин ихтэй, түүгээр тариаг цохиж цайруулдаг байна. Мольти гэх нь орос хэлний “молоть”- тээрэмдэх, таллах гэсэн утгатай үг хамниганы дунд түгээд, хамниганы хэл аялгууны нэгэн хувирал өөрчлөлтийн жишээ болоод явж байгаа нь энэ. Тариа цохидог мольтийг хөшүүр хамниган хүн “компитен” гэж байв. Харин хорь буриадууд хумтий гэнэ.

²¹⁰ О.Баттуяа, Хэнтий, Дорнод аймагт хийсэн судалгааны гар бичмэл, 2004

²¹¹ Хорь буриадын анчид агнасан ангийн арьсаар мөн адил даллага авах бөгөөд – баян хангай баар баар! гэж даллага авдаг гэнэ.

²¹² Д.Зундуйдагва, Буриад анчины бүүрал тэмдэглэл, УБ-2006, 20т

²¹³ Хэнтийн Биндэр сумын багш нар хамниган Х.Батмөнхөөс 2006 онд тэмдэглэв.

Мануулын эрээнээс хайрла

Хурай, хурай ... хэмээн далладаг байна.

Хэнтийн хамниганы “хангис” овгийн анчин чандагыг ангийн түрүү “цагаан буга” гэж билэгшээдэг байна. Хангис хамнигадын адил туулай, чандагыг ангийн түрүү гэж эрхэмлэх нь монгол анчдын дунд түгээмэл байдаг. Харин Хэнтийн хамниганы дулят овгийн анчин буга, хандгай, гахай, баавгайг ангийн хаан гэдэг, халхчууд л чандагыг “цагаан буга” гэж билэгшээдэг гэж өөрсдөөсөө ялгаж байна. Хангис овгийн хүн анд явах үед ам цагаан туулай өвөр лүү орох чиглэлээр өнгөрөхөд ангийн үүд нээгдлээ гэнэ. Монголын тувачууд туулайг “ангийн хаан” хэмээн ихэд хүндэтгэн үздэг байсан ба анд явж байхад өмнүүр нь туулай өвөрлөж өнгөрвөл даруй зогсож:

Ангийн хаан хишиг хүртээх нь

Гар чинь уртсаг, гар чинь уртсаг гэж шившдэг бол, өврөөс гарах чигт харайн таарвал, зогсолгүйгээр:

Ангийн хаан зөнөж үхэх нь

Амны хишиг дундрах болоогүй хэмээн шившээд, араас нь нулимдаг байжээ²¹⁴. Хамниган анчид ан авын замд таарах араатан, амьтан нар зөв баруун гар тийш гарвал ангийн хишигтэй, чоно таарвал маш сайн, болж өгвөл намнахыг л боддог гэнэ. Мөн анчин хүн хүнээс их юм авч байна, хүн хороож байгаагаар зүүдэлбэл сайн, анд явж байхад морь баярлаж заадах, нохой хөрвөөх, бараан шувуу угтаж дуугарч дагах, агнасан ан хэлээ хөндлөн зууж үхэх, сум тоглож гарсан байх, хээр отгийн гал буудах мэт чимээ гаргах зэрэг нь ангийн олз нааштай байхыг зөгнөдөг ажээ. Тэд, агнасан чоно, үнэгээ өвчихдөө хурдыг нь сааруулж байна гэж билэгшээж шөрмөсийг нь заавал тасладаг. Хамт явсан анчид газар салж агнахаар болвол явж байгаадаа “аян зөөлөн, ачаа хүнд, ан олзтой яваарай” гэж ерөөдөг ажээ. Хоноглосон газраа маш сайн цэвэрлэнэ, галаа сайтар унтраасны тэмдэг болгож хуурай хагд мушгиад гал түлсэн газраа булж үлдээдэг ёстой. Энэ нь гал түймэр тавиагүйн баталгаа болж өгч байгаа юм.

Хамниганы ан авд цээрлэх ёс байдгийг сийрүүлбэл, анд мордохдоо хэрэглэх хүнсний саванд, мөн унаа морьныхоо тоног хэрэгслийн зүйлд тэмээний ноос хүргэхгүй, тэмээний ноосон эд авч явахыг цээрлэдэг²¹⁵. Тэмээ хүйтэн хошуутай мал учир ангийн зам мөрд хүйтэн хошуутай малын эд оруулахгүй гэж үздэгээс үүдэлтэй юм байна. Анд явах замд таарах ан амьтан нар буруу хөндөлсөж гарвал олз муутай, ангийн хишиг харьдаг, үнэг таарвал сайнгүй, ер нь ангийн гэлтгүй аян замд үнэг таарах нь харш саадтай, өнгө зүс содон үнэг таарвал бүр гайтуулна гэнэ²¹⁶. Аян замд таарсан үнэгийг уул овооны эзэн, лусын амьтан, бөөгийн онгод ямар нэг дохио зөн өгч биеэ хувилган харагдаж байгаа нь тэр гэж ойлгож ирсэн байна. Ангийн замд үнэгтэй таарахыг цээрлэдэг энэ ёс ч баруун монголчуудын дунд түгээмэл байдаг. Хамнигад бугыг эртнээс нааш хүндэтгэж шүтэж ирсэн бөгөөд хамниган анчин нэгэн насны туршид таваас

²¹⁴ Монгол ёс заншил, зан үйлийн товчоон. УБ-2009, 304 т

²¹⁵ Д.Тангад,Хамниган, МУ-ын угсаатны зүй, III боть, УБ- 1998, 349 т

²¹⁶ Хэнтийн Дадал сумын хангис хамниган Д.Зундуйдагваас 2004, 2005 онд тэмдэглэв.

дээшгүй тооны буга намнах ёстой гэдэг байжээ. Эдүгээ энэ уламжлал орхигдож, олз ашиг бодож бугыг зоргоороо агнах болсон байна. Тарвагыг нүхний амьтан гээд элбэг агнахгүй, ахуй соёлын уламжлалд нь ч тарвагатай холбоотой билэгшээсэн зүйл таарахгүй байна. Харин идээ бузартуулна гээд тарваганы махыг цагаан идээнд ойртуулахгүй цээрлэдэг нэгэн ёс уламжлагджээ. Үнээ тугалласны хойно удааж нь гарахгүй байвал сүүлэнд нь тарваганы арьс зүүж домнодог гэнэ.

Хамниганы ан агнуурын гол арга хэрэгсэл нь занга, битүү занга, задгай занга, оньсон сааль, суман сааль, урхи, яам (нүх) ухаж бэлтгэх. Зангыг голчлон чандага, хүдэр зэрэг сэргэг анд тавьдаг байна. Мөн гахайд тавих бөгөөд сүргээр явах зам дээр нь хажуу газар тааруулж тавьбал тохиромжтой. Адууны хялгасаар урхи хийж хур шувуу, чандага агнана. Урьдын хамниган анчид өөрсдөө бирдаан буу хийж ан авд хэрэглэдэг байсан гэнэ.

Хамниган анчид эр үхрийн эврээр хийсэн “шэбшүүр”²¹⁷ -ээр буга дуудна. Эврэн шэбшүүр нь залуу буга, хөгшин бүдүүн буга дуудахад зориулагдан хоёр янз байдаг гэнэ. Эврэн шэбшүүрийн хөндийд үйс юмуу өвс хийж дуугаралтынх нь бүдүүн нарийнийг тохируулна²¹⁸. Залуу буга дуудах шэбшүүрийг доторх хөндийг нь нарийн байхаар тохируулдаг бол, нас бие гүйцсэн хөгшин буга дуудахад сөөнгө баргил дуутай байхаар тохируулж голыг нь арай бүдүүн хийдэг байна. Мөн судлаач Д.Тангадын тэмдэглэснээр, тэд “оромоо”²¹⁹ хэмээх нэг дэлэм хэртэй урт хуш, нарсыг голоор нь нүхэлж хийсэн зэмсгээр амьсгалаа дотогш сорох маягаар авиа гарган буга дуудаж агнадаг²²⁰ ажээ. Харин Сэлэнгэ аймгийн Дулаанхаан сумын музейд ангийн энэ зэмсэг хадгалагдаж байгааг музейн ажилтан “урам” гэж нэрлэж байна²²¹(Зураг- 2). Урам гэдгийг монгол хэлнээ, эртний үлээвэр хөгжмийн зэмсгийн нэгэн зүйл, буга адил дуугарах бүрээ гээд дээр үед үхрийн эвэр үзүүрийг нь цоолон хийж байсан бол сүүлд хус модны дурс хуйлах, мөн хусны хонгиогоор хийж байсан гэж тайлбарлажээ²²². Иймд судлаачийн тэмдэглэсэн хамниган анчины зэмсэг “ором” гэдэг нь урам-ыг хамниган хэллэгээр дуудсаныг ийн тэмдэглэсэн нь энэ бололтой. Харин буриад анчид “урам”- тай адил зэмсгээр хандгай, буга дуудан агнах бөгөөд энэ зэмсгээ “үлээвэр шэбшүүр” гэж нэрлэдэг. Энэ “үлээвэр шэбшүүр” урт байх тусам улам уянгалаг дуутай болдог гэнэ. Анг тусгай зэмсгээр дуудан агнах иймэрхүү арга өвөр Байгаль хийгээд Хар мөрний сав дагуух угсаатнуудын дунд өргөн тархсан байдаг. Хар мөрний дунд бие, Шилке, Аргуниар нутаглагч манегр анчид “оревун” гэх дээрхтэй адил зэмсгээр эмэгчин анг дуурайн дуугарч эрэгчинг нь дуудаж

²¹⁷ Шившүүр- ан авлахад дуугарган үлээх хөгжмийн зэмсэг. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. Ү боть, УБ-2008, 3079 т

²¹⁸ Хэнтийн Биндэр сумын багш нар овгийн хамниган Х.Батмөнхөөс 2006 онд ирүүлсэн тэмдэглэл.

²¹⁹ Судлаач Д.Тангад ангийн энэхүү зэмсгийг “оромоо”, “ороомбо” ялгаатай тэмдэглэсэн байна.

²²⁰ Д.Тангад, Хамниган, МУ-ын угсаатны зүй, III боть, УБ-1996, 346-347, 362 т

²²¹ 2009 онд Дулаанхааны музейн тайлбарлагч Отгонбилэг хүүгээс тэмдэглэв.

²²² Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь, УБ- 2007, IY боть, 2225 т,

агнадаг²²³. Манегрийн “оревун” нь монгол хамниганы “урам”-тай хийц хийгээд зориулалтаараа адилхан байдаг. Энэ нэр нь манж- түнгүүс хэлний “өрө-көл”-ээрэх, эргүүлдэх, хоргоох²²⁴ гэсэн үг байгаад нэр үг үүсгэх “вун”²²⁵ бүтээврийн тусламжтайгаар “оре+вун”~ (“урам”) хэмээх ан амьтан ээрж хоргоох зэмсгийн нэр болжээ. Хамниган анчид зориулалтын зэмсгээс гадна гарын доорх өвс, үйс зэргээр араатан амьтныг тун авьяаслаг дуурайн дуудаж агнадаг аргатай. Хусны үйсний нэг талыг гурвалжлан хошуулдаж, давхарлан нугалаад хэлээрээ тагнай руугаа тулгаад үлээж дуудна²²⁶. Согоотой буга, тойруулга буга, тааваараа явж байгаа бугыг өөр өөрөөр дууддаг учиртай. Баавгайтай газарт янзага дуурайж болохгүй, баавгайд бариулж магадгүй гэнэ. Хар мөрний манегрууд хүдрийг монгол хамнигадын адил үйсэн шовшуур буюу “печавун”-аар дуудаж агнана²²⁷. Анчины авхаалж чадварыг төдийлөн шаардаагүй ийм идэвхгүй аргаар араатан амьтан дуудаж агнахыг хамниган анчид төдийлөн таашаадаггүй.

Ан агнуурын хамгийн осолтой зэвсэгт тооцогдох саалийг Монголын хамнигад өргөн хэрэглэж байжээ. Сааль зүүнэ гэдэг нь, ангийн цувдаг зэрэг дээр агнах ангийнхаа өндөрт тааруулж тохиромжтой газарт буугаа тогтоогоод гохонд оосор зүүж, оосрын нэг үзүүрийг гишгэдэл нь таарах газарт далдалж орхино. Нэг ёсондоо өнөөх далдалсан оосрыг агнах гэж байгаа амьтан нь гишгэхэд бууны гох дарагдан сум ойж тэр амьтан өөрийгөө хороож байгаа хэрэг юм. Онъсон саалийг ан олноор явах зэрэг зам дээр, суман саалийг буга, гахай, хандгай зэрэг том биетэй амьтанд тавьдаг. Хамниган анчид яамаар ан хийх бөгөөд ингэхдээ, гүн нүх ухан амсар дээр нь бүдүүн мод хөндөлсүүлэн тавьж хоёр талыг нь хөм, сураар даруулж тогтоочихоод, түүнийхээ дээгүүр сургааг зэрэгцүүлж өрөөд сургаагаа далдалж өвс ногоо, мөчир гишүү хаяна. Сургаагны нэг үзүүрт гишгэсэн ан доошоо гүн ухсан яам (нүх) руу унадаг байна. Яамыг гахай, буга зэрэг том анд хэрэглэх ба яамаар ан хийхдээ буу хэрэглэдэггүй. Монголчууд ч ийм аргаар тураг ан агнадаг уламжлалтай.

Эдгээрээс гадна Монголын хамниган анчид гахай, шилүүс, гөрөөс зэрэг зэрлэг анг нохойгоор мөрдөж намнадаг. Залуу нохойг шинээр анд сургахдаа хашир анч нохойнд дагуулах, ангийн цус амсуулах маягаар амархан зүгшрүүлдэг. Анд сураагүй нохой гахай руу шууд дайрч хадруулах, шилүүсэнд асч байгаад тасдуулах зэргээр гэмтэж, эсвэл үхдэг байна. Өөд харж хэвтсэн шилүүс асч ирсэн нохойг дөрвөн хөлөөрөө хумсалж тэлээд тас татчихдаг гэнэ. Анч нохой боргож хоргооход шилүүснүүд модонд авирч амь гарах бөгөөд үүнийг

²²³ Г.М.Василевич. Материальная культура среднеамурских эвенков. Материальная культура народов Сибири и Севера. Ленинград - 1976, 108 стр

²²⁴ Н.Н.Поппе, Материалы по солонскому языку, Изд.Ак Наук СССР. Ленинград- 1931, 52 стр

²²⁵ Н.Поппе, Материалы по солонскому языку, Изд.Ак Наук СССР. Ленинград - 1931, 7 стр

²²⁶ Хэнтийн Биндэр сумын багш нар овгийн Х.Батмөнхөөс 2006 онд тэмдэглэв.

²²⁷ Г.М.Василевич. Материальная культура среднеамурских эвенков. Материальная культура народов Сибири и Севера. Ленинград - 1976, 108 стр

хамниган анчид шилүүс модлуулах²²⁸ гэж нэрлэдэг. Модлосон шилүүсийг дороос нь буудаж агнана.

Ойн жижиг амьтад үен, солонго, чандага, булга зэрэг анд занга тавьж агнадаг. Зурмыг “гаранга”-аар, шилүүсийг “ходоодон” зангаар, булгыг “хираас”(оньсон занга) зангаар агнадаг. Занга тавихдаа унанги модыг дагуулан тавьж түүнд орсон амьтны хойд хөл газарт хүрэхээргүй хөндий байхаар тааруулдаг байна.

Монгол хамнигад баавгайг сургаагаар хөшиж агнадаг. Ичээг нь хөндөж баавгайг босгоод гарч ирэхэд нь ичээний аманд отож байсан улсууд хоёр ширхэг нойтон сургааг зөрүүлэн баавгайн толгойг хөшиж тогтоох үед буутай анчин баавгайн амин газар онилж хорооно. Энэ аргыг судлаачид хамниганы “хөшүүр”²²⁹ овгийн нэртэй холбон тайлбарласан байдаг²³⁰. Гахай агнасан тохиолдолд хамгийн түрүүнд давчийг²³¹(гахайн өвчүүг цоройтой нь авахыг хэлж байна)нь авч хуйхалж иддэг. Урьдын анчид агнасан зэрлэг гахайн гэдэс дотрыг нь хүртэл цэвэрлэж авдаг, ер нь ангийн хишгээс хаях юм байдаггүй байсан гэнэ. Олон хүн явж ан агнавал ангийн махыг нь эвдэж хувь хүртэцгээн, намнасан анчин нь толгойг нь авна²³². Хамниган анчид ой хөвчид хоноглох үедээ бүдүүн мод мөчир цуглуулж түүдэг асаан түүнийгээ тойрон унтацгаах бөгөөд даарч жиндэхгүйн тулд биеийн дор өвс, холтос, шоргоолжны бут болон тохомоо дэвсэнэ. Хоноглох газартаа модны унасан мөчир гишүү овоолж дэргэд нь том түүдэг гал түлэхийг “гулубун” гэдэг ажээ. “Гулубун” нь Сибирийн түнгүүсүүдийн дунд дараахь утгатай тархсан байх бөгөөд “ойд юмуу хээр гадаа хаа нэгтээ хоноглох газар”, “ойд хоноглох газар”-ыг “гуливн” (Енисейн эвенг) ~гуливэн (Эрхүүгийн эвенг) гэдэг бол Аян, Ербогачины эвенгүүд түүдэг галыг “гулувун”, Вилюйн эвенгүүд “гулувун” гэдгийг “бууж хоноглосон газар” гэж ойлгодог ажээ. Эдгээр үгийн үндэс “гул”- нь гал гялсхийх, цахилгаан цахих, гал ноцоох, түүдэг асаах, гал хутгах гэсэн утгатай юм²³³. Иймд Монголын хамниганы дунд уламжлагдаж ирсэн “гулубун” нь түүдэг галтай холбогдох өргөн утгыг агуулж, үндсэн утгаа алдалгүй хадгалагдсан нь энэ ажээ. Эрдэмтэн судлаач А.Е.Аникин, манж-түнгүүс хэлний “гул” гэх үгийг монгол бичгийн хэлний “yolumta” гэх үгтэй адилтгасан байна. Монголын хамнигад “гулубун” буюу түүдгийг өрдөж засч сэргээх болон тогоотой хоол ундыг түүдэг~(гулубун) дээрээс өргөж гаргадаг 2- 3 м хиртэй урт нарийвтар, нойтон модыг талайбун~(талибун), “шилээгүүр” гэж нэрлэж байна. Мөн л гулубунтай

²²⁸ Хэнтийн Биндэр сумын дулят хамниган Д.Жигмэд нэг удаад том жижиг нийлсэн 6 шилүүс модлуулж байжээ.

²²⁹Кучигир~ кучит~ кучигир~ кучугур(Г.М.Василевич) ~ хөшүүр болсон бололтой. Баргажины дээд талаар Кучигэр нэрт газар байдаг. 1897 онд Амар(Хар)-ын тойрогт энэ овгийн нэрний Кучугур(Хөшүүр-О.Б)~(Кучигир)гэх хувилбар бүртгэгджээ. Г.М.Василевич,Эвенки, Ленинград-272стр

²³⁰ Д.Тангад, Хамниган, Монгол Улсын угсаатны зүй, III боть, УБ-1996, 341 т

²³¹ Давсыг - тафчъ (гиляк)~дабсунъ (манж)~дабасу (монгол). Л.Шренк, Об инородцах Амурского края. ТII . Спб-1883, 134 стр

²³² Хэнтийн Биндэр сумын дулят хамниган Д.Жигмэдээс 2005 онд тэмдэглэв.

²³³ А.Е.Аникин, Развитие и взаимодействи Тунгусо-маньчжурские заимствования в русских говорах Сибири. Новосибирск - 1990, 95 стр

адил Сибирийн түнгүүсүүдийн дунд өргөн тархсан ойлголт юм. Манж-түнгүүс хэлний “таливун” ~ (талайбун-талибун) нь үйс, зомгол(загас гэрдэх), бамбар гэсэн утгатай бөгөөд үгийн үндэс талит~ (талич~талит), талитч нь “загас гэрдэх” гэсэн утга илэрхийлнэ. Энэхүү талит~ (талич~талит), талитч нь манж-түнгүүс хэлний нэр үг үүсгэх бүтээвэр “вун”²³⁴- ны тусламжаар хамнигадын хэлж өгсөн - талайбун~ талибун~ таливун гэсэн хэдэн янз дуудагдах ч ойролцоо утга агуулгатай нэр болсон нь тодорхой байна. Монголын хамниган анчин “талайбун”-аар түүдэг галаа ердөн засдаг болон энэ үгийн агуулга, дуудлага нь дээрх жишээнүүдтэй адил байгаа тул Сибирийн түнгүүсүүдийн “гулубун”, “талайбун” гэх үгнүүд язгуур утгаа алдалгүй уламжлагдан ирсэн нь энэ болох нь. Сургаагийн үзүүрийг түүдэгт барьж шатааж цогшуулахад маш хурц үзүүртэй талайбун~(талибун) бэлэн болдог. Өнөөгийн хамниган анчид ан авын үеэр хээр хонох болвол заавал талайбун бэлддэг бөгөөд талайбун нь дайдын элдэв зэтгэр хий юм, гайгаас хамгаалдаг гэж үздэг. Хамниган анчид гулубун, талайбун гэж ярьдаг гэж буриадууд өөрсдөөсөө ялгаж байлаа.

Тэдний дунд талайбун~(талибун), шилээгүүрийн тухай дараахь домог яригдаж байна.

*Урьд нэгэн цагт хамниган анчинг гөрөөлөхөөр явахад хорлох санаатай нэг муу хүн араас нь сэм дагажээ. Түүнийг нь мэдсэн мөнөөх хамниган анчин өөрийгөө аврахын тулд түүдгийнхээ дэргэд суугаад - за “талайбун”~(талибун) чи хэд хүрэв,- “шилээгүүр” чи хэд хүрэв гэж асуугаад, шилээгүүр, талайбуныхаа өмнөөс шилээгүүр би төд хүрлээ, талайбун би мөн төд наслалаа даа гэхчлэн хариулж өөрөө өөртэйгээ өндөр дуугаар ярьж байсан юм гэдэг. Тэгэхэд нь нөгөө муу санаатан, энэ чинь олуулаа яваа юм байна гээд хорлож зүрхлэлгүй буцсан домогтой ажээ*²³⁵.

- Монгол хамниганы аж ахуй эрхлэлтийн байдлаас үзэхэд, тэд мал маллагаа, тариалах ажил, ан гөрөөл аль алинаар нь амьжиргаа болгож ирсэн байна.

- Хамниганы дунд дээрх аж ахуй эрхлэлтийн хэв маяг хадгалагдаж ирсэнээс гадна, тэд энэ хэв маягаа дагаад дан ганц малчин эсвэл анчин байсан гэвэл учир дутагдалтай. Идэвхтэй амьдарч байсан байгаль газар зүйн орчиныхоо боломжит бүх нөхцлүүдийг ашиглаж анчин - түүвэрчин, анчин - малчин гэсэн байдлаар амьжиргаагаа залгуулж иржээ. Тэд одоо ч гэсэн ан гөрөө хийж аж амьдралдаа нэмэр болгож байна.

-Судалгааны дүнгээс үзэхэд, Дорнод аймгийн Цагаан- Овоогийн хамнигад нүүдэл ахуйгаар амьдарч иржээ. Мал маллах уламжлал нилээд эртнийх бөгөөд мал маллагааны арга ажиллагаа болон түүнтэй холбогдох зан үйл нь монголчуудынхтай адил байна.

²³⁴ Н.Н.Поппе, Материалы по солонскому языку, Изд.Ак Наук СССР. Ленинград - 1931, 7 стр

²³⁵Энэ домгийг багш нар овгийн Л.Эрдэнэцогт өөрийн эцэг улсын анчин Ч.Лувсангаас сонссоноо 2010 онд хуучилсан болно.

- Тэдний ан гөрөөлийн зан үйлэнд холбоотой зарим үгс, ёс заншил нь манж-түнгүүсийн шинжийг хадгалсаар байгаа нь уулаас ан агнуур голлон эрхэлж байсаных нь гэрч болоод зогсохгүй хамнигад өөрсдийн ахуй соёлын өвөрмөц онцлогоо эрхэмлэн хадгалсаар байгаагийн илрэл юм.

2.3. Хамниганы орон сууц

Угсаатны эдийн соёлын үндсэн хэсэг болох гэр сууцны хийц хэлбэр, эдэлгээ зориулалт нь тухайн угсаатны нутагшил, эрхлэх аж ахуйгаас хамаарч байдаг. 1940- өөд оныг хүртэл монгол хамнигад, балгаан, байшин, зөмөгөө, эсгий(хурамшич) гэр гэсэн нилээд хэдэн төрлийн гэр сууц хэрэглэж байсан байна. Өнөөгийн хамнигад зөмөгөө, байшин, эсгий гэрийг орон сууц болгон ашиглаж байна.

Балагаан (балаган-балауан- эвенг; балаган-якут; balγan-монг)²³⁶. Манай судалгааны үеэр “балагаан”- ыг буриад, хамниганы аль аль нь хамниганы сууц гэж тодруулж байлаа. Энэ сууцны нэрийн утгыг хөөж үзвэл “балаган” нь- балагāн-овоохой гэсэн утгатай²³⁷ ажээ. Түнгүүсүүд нүүдэл хооронд буудаллахдаа “балага” гэх түр сууц босгож толгой хоргоддог²³⁸ гэнэ. Харин Үдийн түнгүүсүүд алд хэрийн өндөртэй шон дээр тусгайлан барьсан “балаган”-д талийгаачийн шарилыг байрлуулдаг²³⁹ гэсэн бол, Ононы хамниганы үлгэрт, ...*Ой кубчииги эзэлсэн гөө ортоон, ороцооной орондо очиб би, гурбан хараама нохойтой гэлцэнэ... Тыгээд лэ ой кубчээр ороод ла тэнэсэн нэгэл уртоосо урту цагаан гол байджи, үүлэ тулма үндэр үйсэн балагаан байба... үбүсүн балагангаа лүпү гүйджэркиналтай*²⁴⁰ гэж ойн иргэдийн сууц, түүний хийцийг тодруулсан байдаг. Эрдэмтэн С.Бадамхатан, Ерөөгийн хамниганы дунд– “balγan” гэж тал саравч маягийн сууц байсан гээд хийц, маягийг нь нарийвчлан тодруулаагүй орхижээ²⁴¹. “Балаган”-ыг ан амьтны арьс шир, даавуу, үйс, холтос, өвсөөр хучина. Монгол хамниган “балгаан” барихдаа 3-4 ширхэг нарийн сургаагийн нэг талын үзүүрүүдийг нийлүүлэн боож, нөгөө талыг газарт тэлэн жийлгэж, өмнө зүг харах талдаа орох, гарах зай үлдээж үлдсэн зайг нь модны долоор хучиж, өвөлд бол дээрээс нь ангийн арьсаар бүтээдэг. Намар хадлангийн үеэр өвсөн балгаан барьж суух уламжлал буриад, хамниганы дунд одоо ч хадгалагдаж байна. Балгааныг нэг бухал өвсөөр хучихад хангалттай хүрдэг гэнэ.

Зөмөгөө- (О.Б), (зөмөгөө ~ земьяа ~ зэмьээ ~ дзэмэээ~ зимье); золиоге- (Д.Т). Монгол хамниганы “зөмөгөө” нь холтосыг хуулаагүй хар модоор зааж барьсан, дөрвөлжин хэлбэртэй, жижгэвтэр сууц юм. Хөвсгөлийн дархадууд дээрх маягийн модон сууц барьж хэрэглэдэг байсныгаа “земьяа” гэж нэрлэдэг байжээ.

²³⁶ А.Е.Аникин, Тунгусо-маньчжурские заимствования в русских говорах Сибири, 1990, 62 т

²³⁷ Н.Н.Поппе, Материалы по солонскому языку, Изд.Ак Наук СССР, Ленинград-1931, 52 стр

²³⁸ А.Ф. Анисимов, Родовое общество эвенков(тунгусов), Ленинград-1936, 67 стр

²³⁹ Семейная обрядность народов Сибири, 1980, 172 стр

²⁴⁰ Ж.Цыбен, Улигеры Ононских хамниган, Новосибирск- 1982, 119 стр

²⁴¹ С.Бадамхатан, Ерөөд хийсэн судалгааны гар бичмэл, 1963

Монгол хамниганы “зөмөгөө” дархадын “зэмъяа”-тай адил болох нь гарцаагүй. Хамниган ба дархадын дээрх гэр сууцны нэрнүүд орос хэлний “зимовье” гэдэг үгнээс гаралтай бөгөөд дуудлага хувирч зөмөгөө~ зэмъяа болжээ. Энэ сууцыг өмнөд буриад (өмнөд сэлэнгийн-хамниган)-д “дзэмээ”, баруун буриад (эхирид-булагад)-д “соол” юмуу “тура”, зүүн буриад (хорь-умард сэлэнгэ)-д “баэшан” гэж нэрлэдэг байна²⁴². Хэнтийн хорь буриадууд зүүн буриадад тооцогдон, хэл аялгууны хувьд “хорь-умард сэлэнгийн” бүлэгт багтадгаа харуулж зөмөгөөг мухар модон “байшин” гэнэ. “Зөмөгөө”- ний дээвэр нь шувуу орой буюу шовх оройгүй учраас ингэж нэрлэсэн байна. Иймд оросын хэл, соёлын улбаа болж монгол хамниган болон өмнөд буриадын (өмнөд сэлэнгэ-хамниганы) хэл аялгуугаар хэлцэгчдийн дунд зөмөгөө~ дзэмээ~ зэмъяа нэрээр түгжээ.

Зөмөгөөг хэрэглэж эхлэсэн түүхээс үзэхэд, ХҮIII зууны сүүл үеэс өвлийн цагт эсгий гэрээс өөр сууц ашигладаггүй байсан хорийн буриадууд Түгнэ, Хёлгын баян чадалтай оросуудыг дуурайж ганц нэг ахлагч тайшаа нар “зэмьээ” гэр барьж хэрэглэж эхлэсэн байна. Сэлэнгэ, Нерчүгийн тойргийн буриад, хамниган нар зөмөгөөг анх албаны зориулалтаар барьж байжээ. Энэ тухай буриадын сурвалжид өгүүлснээр, ...ахмад тайшаа Ш.Ренчиний шийдвэрээр Анаа голын адгаас дээхнүүр Хутаг гэх хадны өвөрт тэр ноёны (Ш.Ренчин) бичиг хэргийг хадгалахын тулд 1745 онд жижиг мухар “зимьээ” барьсан²⁴³... нь тэндхийн бус төрөлтнүүдийн дунд модон байшин хэрэглэх үндсийг нь тавьсан байна. Анхандаа зөмөгөө(зимьээ)-г яаж гэрэлтүүлэх, дулаан байлгах аргыг төдийлөн сайн мэддэггүй байсан гэнэ. Яваандаа “зимьээ” нь өвлийн хүйтний цагт нялхас хүүхэд, төл малыг хүйтнээс хямгадахад их хэрэгтэй юм гэж ойлгоод 1820-иод оны үеэс өргөн хэрэглэх болжээ. Мөн баримтад өгүүлснээр бол зимьээг орон сууц төдийгүй төл малыг хүйтнээс хамгаалах байр болгон ашиглаж байсан байна. XIX зууны дунд үеэс хойш Сэлэнгэ, Нерчүгийн айл бүр зимьээтэй болсон байжээ²⁴⁴. Монголын хамнигад “зөмөгөө”- г сургаагаар дээвэрлэж, хөвдөөр чигжих юмуу эсвэл үхрийн баасаар шавж, дээгүүр нь шороо хаян дулаалдаг байна. Сайн чигжсэн дээвэртэй “зөмөгөө” нар халахгүй, бороо гоожихгүй тухтай байдаг гэнэ. Зөмөгөөнд улиасаар шал хийх бөгөөд шал хийх улиасны нэг талын бөөрийг тэгшилж цавчаад шахаж өрдөг байна. Гэхдээ “зөмөгөө”-г ихэнхдээ шалгүй хийдэг. “Зөмөгөө” нь өмнө талдаа модон хаалгатай, хаалганы хоёр талд жижиг цонх гаргах тул дотроо гэрэл гэгээ муутай²⁴⁵. Зөмөгөө нь оросуудын хэрэглээг дуурайсан хамнигадын анхны модон сууц бөгөөд анхны хийц хэлбэр, хэв маягаараа монгол хамниганы дунд уламжлагдан иржээ.

Холтсон²⁴⁶ дээвэртэй байшин. Дорнод Монголын хамниган хар модны холтсоор байшингаа дээвэрлэдэг. Том хэмжээгээр хуулсан холтос морин

²⁴² Ц.Б.Будаев, Лексика бурятских диалектов в сравнительно-историческом освещении, Новосибирск- 1988, 33 стр

²⁴³ Буряадай түүхэ бэшэгүүд, Улан-Удэ- 1992, 63-64 т

²⁴⁴ Буряадай түүхэ бэшэгүүд, Улан-Удэ- 1992, 81 т

²⁴⁵ О.Баттуяа, Хэнтий, Дорнод аймагт хийсэн судалгааны гар бичмэл, 2003, 2005

²⁴⁶ Дээврийн холтосыг зарим хамнигад өөрөөр “дол” гэдэг.

тэрэгнээс илүү гарч газар шүргэх шахам байх бөгөөд жижгэвтэр байшинг ийм 5-6 ширхэг холтсоор дээвэрлэхэд элбэг хүрдэг. Бор шувуу л гэмтээчихгүй бол холтсон дээврийг 3 жил хэртэй болгоод усанд дэвтээж дахин ашиглаж болдог байна. Байшингийн шовх оройг холтсоор бөгрүүлж, эхний эгнээний холтсыг дараах эгнээний холтосны ирмэгээр даруулах маягаар дээвэрлэнэ. Дээврийн холтсыг гажихаас сэргийлэн урт нарийн модоор хөндлөн даруулж, түүнийхээ хоёр үзүүрийг дээврийн нуруу моднуудад нарийн зүссэн үйсэн үдээрээр холбож бэхлэдэг. Байшингийн дээврийн өмнөд хэсэгт өрх гаргах бөгөөд өрхний тагыг хар мод эсвэл нарсаар хийнэ. Байшингийн их биеийг голдуу хар модон дүнзээр цавчиж, их биеийг нь зангидахдаа дүнзнийхээ үзүүрийг гадагш нь нилээд урт гаргадаг байсан гэнэ. Ингэж цавчсан байшингийн хийцийг хараад буриядууд хамниганы гэж таньдаг гэж байв²⁴⁷. Холтсоор дээвэрлэсэн байшин бөгчим халуун үед сэрүүн байдаг тул зуны байшинг хар модны холтсоор хучихад тун тохиромжтой. Зуны байшинг холтсоор дээвэрлэх уламжлал буриад, хамнигадын байсаар байна.

Холтсон байшин. Холтсон байшингийн яс модноос бусдыг нь хар модны холтсоор хийдэг тул холтсон байшин гэжээ. Яс модыг нь хар модоор дөрвөлжилж зангидна. Дараа нь нэгэн ижил хэмжээгээр бэлтгэсэн хар модны холтсыг яс модонд нь хүлж тогтоогоод байшингийн ханыг босгодог байна. Холтсон байшинг дээвэрлэхдээ өнөөгийн дүнзэн байшингийн дээвэр шиг оройг нь гурвалжилж хийнэ. Хэнтий аймгийн Биндэр сумын баруун Манхаадайн хамнигад хар модны холтсоор дуган барьж түүндээ хэлмэгдүүлэлтийн үеэр нураагдсан Амгалантын хийдийн ном судрыг хадгалж байсан²⁴⁸гэдэг. Ерөөгийн буюу Минжийн голоор нутаглаж байсан хамнигад ХХ зууны эхэн хүртэл холтсоор барьсан сууцанд амьдарч байсныг гэрчлэх зураг²⁴⁹ дээр, хамниганы холтсон сууц нь “зөмөгөө”-тэй адил дээвэр нь хавтгай, дээвэр, хананы аль алийг нь холтсоор хийсэн байх ажээ. Ерөөгийн хамниган хийгээд, дорнод Монголын хамнигад аль аль нь ХХ зууны эхэн хүртэл холтсон байшин сууцыг өргөн хэрэглэж ирсэн байна.

Холтсон гэр. Хамнигад гэрийг “джог”²⁵⁰ гэж нэрлэдэг байсан байна²⁵¹. Ерөөгийн хамнигад хар модны холтсоор гэрээ хучдаг байжээ²⁵². Мөн судлаач Кондратьевийг 1928 онд Минж голын салбар Залаатай горхиор явах үед тэндхийн хамнигад холтсон гэрт сууж байсан байна. Түүний тодруулснаар, тэдгээр хамнигад зун нь холтсон гэрт суух бөгөөд тэд хонь цөөтэй тул

²⁴⁷ Байшингийн зүүн хэсэгт пийшин байрлана. Пийшинг бөх бат болгохын тулд пийшин шавардах шавраа адууны хялгастай хольдог байжээ. Шинэхэн барьсан пийшин хагарч ан цав гарахдаа амархан байдаг тул хамниган эмэгтэйчүүд шингэн зуурсан шавраар өглөө бүр зүлгэж бэхжүүлдэг байна. Тэдний энэ дадлаас нь үүдээд, хамнигад пийшингээ хүртэл арчиж зүлгэдэг, цэвэрч улсууд гэсэн үг буриядуудын дунд одоо ч яригдаж байдаг.

²⁴⁸ Хэнтийн Биндэр сумын багш нар овгийн хамниган Х.Батмөнхөөс тэмдэглэв.

²⁴⁹ History and culture of the Mongols, International Institute for the Study of Nomadic Civilizations, UB-2006, 150 ps

²⁵⁰ Солончууд гэрийг- “зо” (Эвенг ардын үлгэр, ӨМАХХ- 1988, 95т), манж-түнгүүс хэлнээ “дзү” гэнэ (Н.Поппе, 44 стр).

²⁵¹ Б.Ринчен, МАУ-ын хамниган аялгуу, УБ-1969, 105 т

²⁵² С.Бадамхатан, Сэлэнгэд хийсэн судалгааны гар бичмэл, 1963

эсгийгүйгээс гэрээ холтсоор бүрдэг байсан гэнэ²⁵³. Кондратьевийн хар модны холтсон гэрийг гэрэл зургийн хальснаа буулгасныг нягталбал²⁵⁴, эсгий бүрээс, туурганы оронд холтос нөмөргөсөн байхаас бусад нь цөм монгол гэртэй адил бүслүүр, даруулга, өрхтэй байна. Энэхүү холтсон гэр дотроосоо нээгддэг, 2 хавтастай модон хаалгатай ажээ. Урьд Хэнтийн зарим хамниганы гэр нь хоёр хөндлөн дай барьж хадсан банз модон хаалгатай байсан бөгөөд ийм хийцийн хаалгыг хамниган хаалга гэж нэрлэж байсан гэнэ²⁵⁵. Хамнигадын гэр бөгжин тоонотой байжээ²⁵⁶. Хамниган настны хуучилснаар урьд Хэнтийн Цэнхэрмандал, Өмнөдэлгэр сумын нутгаар сууж байсан хамнигадыг “хар модны” хамниган гэж нэрлэдэг байсан ажээ. Харин ХХ зууны эхэн үед Хөвсгөлийн дархадын ядуучууд урцанд амьдарч байсан бөгөөд тэднийг бас “хар модныхон” гэдэг байжээ²⁵⁷. Энэ нь хөвч хангайгаар нутаглаж мод, холтос зэргээр орон гэрээ босгодог байснаас нь үүдээд бусад нь өөрсдөөсөө ялгаж ийн нэрлэж байсан бололтой. Монголын хамниганы холтсон гэр нь зарим судлаачийн²⁵⁸ дүгнэснээр малын үс ноос хэмнэх, салхи шуурганд бөх бат суурьлаг байх, суурин аж төрөхөд тохиромжтой зэрэг амьдралын ач холбогдолтойг харгалзсан хэрэглээ биш юм. Харин хөвч хангай газар амьдарч байсан хамнигад хүрээлэн байгаа орчин болон аж ахуй эрхлэлтээс шалтгаалж орон гэрээ үйс, холтос, ан амьтны арьс ширээр хулдаж байсны илрэл, ойн иргэд ба нүүдэлчдийн гэр сууцны аль алиных нь хэрэглээний онцлогийг агуулсан орон сууцны өвөрмөц хэв маяг болох юм. Чухамдаа холтсон гэр нь орон сууцны хэв маяг, эдийн соёлын уламжлалд гарсан хувьслын жишээ болж байна. Хамнигад гэрийнхээ модыг өөрсдөө хийж, мөн үүний хамт хэрэглээгээ хангачих түвшиний малгүй заримууд нь хар модны холтсоор орон гэрээ хучиж байжээ.

Тэд Монголд тогтон сууж аж амьдрал нь дээшилснээр холтсоор гэр, байшин²⁵⁹ барихыг огт больжээ.

Хурамшич²⁶⁰ гэр. Ононы хамниганы “сира~шира хурамчи” -ийг бол баруун монголд “шар хурамш” гэж нэрлэдэг. Ийм гэр нь хийц хэлбэрээрээ монгол гэрээс ялгаагүй, хурамшич буюу шар эсгийгээр²⁶¹ бүрсэн гэдэг утгаар - утаа тортогт идэгдэж шарласан эсгий бүрээстэй гэр гэж нэрлэсэн нь энэ юм. Гэрийн ханыг

²⁵³ Ж.Цэвээн, Түүвэр зохиол, I боть, УБ-1997, 127 т

²⁵⁴ Б.Ринчен абугайн бүтээлд(Б.Ренчин, МАУ-ын хамниган аялгуу, УБ-1969, хавсралт зураг) 1928 онд судлаач Кондратьевийн гэрэл зургийн хальснаа “Ерөөгийн хамниганы гэр” хэмээн буулгасан зургийг ашигласан бөгөөд мөн зургийг судлаач Г.Батнасан халхын гэр сууцны тухай бүтээлдээ холбогдуулан нийтлүүлж, гэр бүрэх холтсыг намар бэлтгэнэ хэмээсэн байхаас гадна аж ахуй амьдралын хэд хэдэн ач холбогдолтой гэж дүгнэсэн нь андуу болсон мэт байна.

²⁵⁵ О.Баттуяа, Хэнтий, Дорнод аймагт хийсэн судалгааны гар бичмэл, 2004

²⁵⁶ С.Бадамхатан,Ерөөд хийсэн судалгааны гар бичмэл, 1963

²⁵⁷ С.Бадамхатан, Эрдэм шинжилгээний бүтээлүүд, I боть, УБ- 2000, 133, 156 т

²⁵⁸ БНМАУ-ын угсаатны зүй, I боть, УБ-1987,140 т

²⁵⁹ Буриад, хамнигадын байшингийн дээврийн холтсонд бор шувуу олноороо цуглах тул нутгийн халхчууд бор шувуу дагуулж ирсэн гэж тэдэнд дургүйлхдэг байсан гэнэ.

²⁶⁰ Д.Г.Дамдинов, Ононские хамниганы, Улан-Удэ-1993, 117 стр

²⁶¹ Дорнодын Баян-Уулын үзөөн хамниган Д.Цэрэнхандын хэлснээр тэмдэглэв.О.Баттуяа, Хэнтий, Дорнод аймагт хийсэн судалгааны гар бичмэл, 2004.

бургасаар хийж үхрийн нойтон ширээр үдэж, унийг нь нарийн нарс юмуу модон цуулмалаар хийнэ. Хар мод, нарсны цуулмал хэврэг, гацуурын цуулмал илүү бөх эдэлгээ сайтай байдаг гэнэ. Өнөөгийн хамнигад гэрийг худалдаж авдаг болсон тул хийц загвар хэв маяг нь монгол гэрээс ялгаагүй болжээ.

Монголын ихэнх хамнигад дээрх орон сууцуудыг 1940-өөд оныг хүртэл нийтлэг хэрэглэж байсан байна.

Орон байрандаа хар модны холтос хэрэглэдэг уламжлал нь тэдний амьдарч буй байгаль газар зүйн орчинтой нягт уялдсан хэрэглээ юм.

Ерөөгийн хамниганы гэрийн эд хэрэглэлийг нэрлэсэн байдлыг С.Бадамхатангийн тэмдэглэснээр тодруулбал:

Гэрийн унийг – *uniān*

Гэрийн хана- *khanāyā*

Тооно- тооно

Хаалга- хаалга

Унийн толгой- *ugluryā*

Ханын толгой- *ugluryā* гэж нэрлэдэг байсан байна²⁶².

Монголын хамниганы гэр сууцны хэд хэдэн төрлүүд нь хүрээлэн буй орчин, эрхлэх аж ахуйгаас нь хамаарсан онцлогтой байна. Тэдний зарим орон сууц нь талын малчин ардын болон ой хөвчийн иргэдийн аль алиных нь хэрэглээний онцлогийг агуулсан шинжтэй байжээ.

Тэдний суурин сууцны анхны хэлбэр нь зөмөгөө бөгөөд зөмөгөөг гэр сууц ба малын байрны зориулалтаар ашиглаж байсан байна.

2.4. Монголын хамниганы хувцас, гэр ахуйн эдлэл

Хамниганы хувцас хэрэглэл, түүнийг хийх арга технологи. Монголын хамниганы ахуйн хэрэглээний гол түүхий эд нь адуу мал, ан гөрөөний үс ноос, арьс, шир юм. Тэд гэр ахуйн сав суулга, хувцас эдлэлийнхээ ихэнхийг арьс, шир боловсруулж хийдэг ажээ. Мал, ан амьтны арьсыг “бэрээвэн”, “шудрага”, “эргүүлгэ”-ээр элддэг байна. Бэрээвэн нь хийц хэлбэрээрээ буриадын “нуури” ба “шударуул” гэсэн хэсгээс бүрддэг “үбдэг талхи”- тай²⁶³ адилхан юм. Хамнигад талхи гэхгүй “эргүүлгэ” (*Зураг- 5*) гэж нэрлэдэг. Буриадууд эргүүлгийг өөрсдийн хэрэглэдэг талхинаас хийц хэлбэрээр нь сайн ялгаж “хамниган талхи” гэж нэрлэж байна. Хамниганы “эргүүлгэ” ~ (өргүлгө - манж-түнгүүс. Н.Поппе; эрьюүлгэ - агын буриад. А.А.Бадмаев; *ergigulge*- бичгийн монгол хэл) нь овор хэмжээ бага намхан (ойролцоогоор 1-1,5 м өндөр), гол нь задгай байдгаараа буриадын “талхи”-наас ялгагдана. Эргүүлгэ нь гол, хабусо (*khabuso*-хавирга- хам)-аас бүрддэг. Эргүүлгэний хабусо хоорондоо зай ихтэй байдаг тул элдэж байгаа арьс амархан хатдаг муу талтай. Том эргүүлэгт нэг удаад 4-5 ширхэг үхрийн арьс эсвэл 10 шахам хонины арьс хийж 3-4 хоног эргүүлж элдүүрийг нь гүйцээнэ. Зах зээлийн

²⁶² С.Бадамхатан, Сэлэнгэд хийсэн судалгааны гар бичмэл, 1963

²⁶³ А.А.Бадмаев, Кожевненное ремесло агинских бурят, Этнографическое обозрение №2, Москва-1998, 98 стр

хөгжлийг дагаад монгол хамниганы эд материалын хэрэглээ орчин үеийн хэв загварт шилжсэн боловч хөдөө орон нутагт мал маллан амьдарч буй хамнигадын хувьд арьс элдэж боловсруулах арга, хэрэглээ нь одоо ч хадгалагдсаар байна.

Хамнигад мал, ан амьтны арьсны өөрийн өнгөөр нь хувцас, эдлэл хийхээс гадна нүргэсээр²⁶⁴ (нэрвэс) будаж өнгө оруулна. Нүргэсний хальсыг нь хуулж хатаагаад халуун бүлээн усанд хандалж, хусны түнжний үнстэй хольж буцалгахад хар хүрэн өнгийн будаг гардаг бөгөөд ингэж бэлдсэн будгаар дээл, гөлөм зэрэг хувцас эдлэлээ будаж өнгийг нь засдаг ажээ. Мөн арьсыг аргалын утаанд битүү утаж²⁶⁵ шар, шар улаан өнгөтэй болгож дээл хийдэг байжээ. Хамнигад арьсан хувцас эдлэлийг буга, хандгай, гөрөөс гэх том ангийн болон үхрийн шөрмөсөөр оёдог байсан байна. Мал амьтны хойд хөлний шөрмөсийг авч, угааж хатаасны дараа нүдэж ширхэглэж томон утас хийдэг юм. Шөрмөсийг гадаа томоход салхи авч хэврэг болдог тул гэрт, эсвэл нөмөр газарт сууж томдог гэнэ.

Мал, ангийн арьсаар малгай, өмд, дээл, ан гөрөө хийхдээ хэрэглэдэг өвдөвч буюу түнги, богц сумаа гэх мэтийн өдөр тутмын гэр ахуйн хувцас эдлэл хийдэг байжээ. Хувцас эдлэлийн зориулалт эдэлгээ зохимжоос нь хамаарч арьсны үсийг гадагш ба дотогш нь харуулах, эсвэл гуужуулж хэрэглэдэг. Тугал, унага, хүдрийн арьсыг битүү өвчиж элдээд түүгээрээ “тугалмаг”²⁶⁶ гэх нэг төрлийн арьсан уут хийж ахуйдаа өргөн хэрэглэдэг байжээ. Эр үхрийн арьсыг бүтнээр нь элдэж мөн дээрх маягаар битүүлж оёод дотор нь ааруул эзгийг хуурай хүнс нөөцөлж хадгална. Амьтны годны үс барагтайд халцрахгүй, арьс нь удаан элэгддэг тул хонь, гөрөөсний годыг сайн гэгч нь татаж элдээд, нямбайлан зүйж бөх гэгчийн бүтээлэг хийж ороо хучдаг байжээ. Хонины нэхийний үсийг нимгэлж хайчлаад гутлын дотор өмсөх оймс хийнэ. Өвөлдөө эрэгтэй, эмэгтэй ялгалгүй хонины нэхийгээр оёсон өнгө цагаан нэхий өмд өмсдөг байжээ. Дорнод Монголын хамнигад, дээр тоочиж буй арьс үст хувцас эдлэлийг 1960-аад он хүртэл нийтлэг хэрэглэж ирсэн байна.

Монголын хамнигад мал, ан амьтны арьсаар хэдэн янзын гутал оёно. Буга, хандгай, адуу, үхрийн годоор өнөөгийн бидний “буузан” гэж тодруулдаг загвартай төстэй “мооршиг” гэх нэг төрлийн гутал хийнэ. Мооршигийн хийц тун хялбар бөгөөд тухайн амьтны нойтон годыг эргэн тойрон нүхэлж, нүх бүрийг нь уяа дээсээр сүвэлж татахад буузан хэлбэрийн “мооршиг” бэлэн болж байгаа юм. Түрүүг нь зузаан даавуу давхарлаж хийдэг байжээ. Энэ нь гутал гэхээсээ илүү даавуун түрүүтэй арьсан оймс гэмээр харагддаг байна. Мооршигийг дулааны улиралд өглөөний чийг, бороонд өмсөхөд тохиромжтойгоос гадна хадлангийн үеэр өмсөж, түрүүнд үйсэн савтай билүүгээ зүүчихээд явдаг байсан гэнэ. Мөн ан гөрөөлийн үеэр өмсөхөд дуу чимээ гаргахгүй хөнгөн байдаг юм байна. Мооршиг нь өдөр тутмын хэрэглээ биш ойр зуурт хөнгөн зөөлөн, эвтэйг нь онцолж өмсдөг байсан байна.

²⁶⁴ Нүргэс гэж нэг зүйлийн улаан хальстай бургас юм байна. Монгол хамнигад нүргэс, нэрвэс гэж ялгаатай нэрлэж байв.

²⁶⁵ Үүнийгээ бас өөрөөр утааринд оруулах гэдэг байна.

²⁶⁶ Буриадууд ч ийм арьсан уут хэрэглэх бөгөөд түүнийгээ тугал түүлмаг, түүлмаг гэж нэрлэдэг.

Хамнигад хүйтэн, сэрүүний улиралд голдуу хонь, ямаа, гөрөөсний арьсан боетог гутал өмсдөг байжээ. Боетогны улыг эр үхрийн зооны арьс, бухын хүзүү, гурын хүзүүний арьсаар хийнэ. Гурын арьсан боетог хамгийн бөх, эдэлгээ сайтай байдаг гэнэ. Боетог нь түрүү, хамар, зулаг гэх гол хэсгүүдээс бүтэх бөгөөд их биеийг ултай нь холбохдоо татагдаж хэв алдахаас нь сэргийлж ямаа болон хонины арьсан сарьс завсарт нь хавчуулах тул хийц үзэмжийг нь ч бас нэмэгдүүлнэ. Боетогийн түрүү, хамрыг дотроос нь нэвт хатгаж давхарлан ширээд зөвхөн өсгийн хэсгийг задгай орхиж хамгийн сүүлд гаднаас нь битүүлж оёдог ажээ. Хамнигад боетогныхоо өсгийн хэсгийг гаднаас нь оёдог, үүгээрээ буриад “бойтог”-ны хийцээс ялгагдана. Үүнийгээ, бид боетогны өсгийг гаднаас нь оёж битүүлдэг бол буриадууд дотроос нь оёдог гэж ялгаж байлаа. Улыг нь монгол гутлынх шиг ирмэгийг нь дагуулан цагаан бөс даавууг 10 гаруйг давхарлан нааж ширэх, эсвэл дан арьсаар хийж хоншоор, ирмэгийг нь дагуулж арьс давхарлан оёж тоноглох гэсэн хоёр янзаар хийдэг. Дотор нь эсгий дэвсээд хуурай хагдаар зузаалж өмсөхөд дулаан сайхан байдаг ажээ. Хамнигадууд боетогийг ур сайтай, хөлд эвтэй, яг тааруулж хийдэг гэдгээр нь дайруулж “хамниган боетог хав яв!” гэсэн хэлц үг хөрш буриадуудын дунд өргөн тархсан байдаг. Тэд боетогийг 1960²⁶⁷-аад он хүртэл нийтлэг өмсөж байжээ. Эдүгээ хамниган боетогийг Хэнтийн хамниган настангууд хааяа оёдог боловч энэхүү уламжлалт хэрэглээ нь орчин үеийн хувцас эдлэлийн хэв маягийг дагаад бараг орхигдох төлөвтэй болсон байна.

Дорнод Монголын хамнигад буриад гутал гутал оёж өмсөх нь одоо ч элбэг байна. Хийцийн хувьд буриад гутал нь хорь ба агын гэсэн ялгаатай байдаг. Тодруулбал, хорь буриадын гутал илүү ээтгэр хоншоортой нарийвтар хийцтэй, харин агын буриадынх палигардуу, хоншоор нь намхан. Энэ ялгаа нь мөн газрын хамниганыхад хадгалагдаж байна.

Хамнигад араатан амьтны арьсаар дээл(сун-Б.Р), дах хийнэ. Уужийг дэкэл гэдэг байжээ. Худам монгол бичгийн дэгэл гэсэн нь хамниганд дэкэл болсон ажээ²⁶⁸. Чоно, чандага, гөрөөсний арьсаар хүйтэн сэрүүнд өмсөх дээл оёдог. Чандаган дээлэнд ойролцоогоор 50- 60 ширхэг чандаганы арьс ордог байна. Ийм дээл шинэ дээрээ хүйтэн, биед наалдац муутай илчгүй байснаа, хуучирч үс сор нь налаад ирэхээрээ илүү дулаан болдог ажээ. Тэд дулааны улиралд гөрөөс, ямааны арьсаар хийсэн “сармай”²⁶⁹ дээл өмсдөг байжээ. Сармай дээл хийх гөрөөс, ямааны арьсыг аарц, тарагны шар сүүнд арав шахам хонуулаад үсийг нь гуужуулж, сэврээнэ. Сэврээсний дараагаар шууд элдээд л биенд эвтэй, зөөлөн сармай дээлийн илгэ бэлэн болж байгаа юм. Сармай дээлийг нэрвэсээр будаж өнгө оруулах нь байдаг ч өдөр тутам өмсөх тул голдуу өөрийн өнгөөр нь хийнэ. Хэлбэр хийцийн хувьд монгол дээлтэй адилхан, гэхдээ нилээд оготор хормойтой,

²⁶⁷ МАХН-ын ТХ-ны дарга Ю.Цэдэнбал 1957 онд Хэнтийн Биндэр сумын 7 жилийн дунд сургууль дээр ирэхэд 5, 6-р ангийн хамниган хүүхдүүд хөдсөн боетогтойгоо жагсаж байсан гэнэ. О.Баттуяа, Хэнтий, Дорнод аймагт хийсэн судалгааны гар бичмэл, 2004.

²⁶⁸ Б.Ринчен, МАУ-ын хамниган аялгуу, УБ-1969, 25 т

²⁶⁹ Сармай гэдэг нь үсгүй, тачир үстэй арьс. Тачир үстэй, хөрс муутай арьсаар хийсэн дээлийг сармай дээл гэнэ. Монгол хэл бичгийн тайлбар толь. УБ-2009, III боть, 1715 т.

хар өнгийн бөс даавуугаар энгэр болон хормойг нь дагуулан 2-3 хуруу хиртэй өргөн эмжиж, энгэр, зах, суганд нь товч эсвэл суран бүч хаддаг. Хамнигад дээлийг “сун” гэдэг байсан байна²⁷⁰. Ороchonууд гөрөөсний арьсан эрэгтэй дээлийг - “нилүсун”, эмэгтэй дээлийг - “асисун” гэдэг. Ороchonы нилүсун, асисүний хийц маягийг дүрсэлбэл өргөн энгэртэй, аль алиных нь хөвөө ханцуйг нимгэн арьсаар эмждэг. Мөн “асисун” буюу эмэгтэйчүүдийн дээлийг илүү гоёмсог болгохын тулд хээ угалз гарган эмждэг²⁷¹ ажээ. Амар мөрөн дагуу нутагладаг манегр, бирарууд гөрөөсний арьсан дээлийг “шун”~”сун” гэж нэрлэдэг. Сунг монгол дээлтэй адил энгэрийг нь баруун, зүүн тийш нь хумиж өмсөнө, заримдаа морь унахад дөхөмтэйг бодож задгай энгэртэй хийнэ. Зуны ийм дээлийн хөвөө, хормойг нь цэмбэ юмуу арьсаар эмжээд, суганд нь товч хадна²⁷². Урьд гөрөөсний арьсаар дээл хийдэг байсан гэх өнөө цагийн хамнигад ийм дээлийг гөрөөсний арьсан дээл гэхээс өөрөөр нэрлэж мэдэхгүй болжээ. Сун гэдэг нь манж- түнгүүс угсаатны дунд голдуу арьсан дээл гэх утгыг илтгэх тул монгол хамнигад дээлийг ерөнхийд нь “сун” гэж нэрлэхээс гадна арьсан дээлийг ч гэсэн “сун” гэдэг байсан бололтой. Тэд “сун” буюу гөрөөс, хонины арьсан дээлийг хар өнгийн бөс даавуу, хар илгэ, хар хурганы арьсаар(үсийг нь гадагш нь харуулж-О.Б.) 2- 3 хуруу хэртэй өргөн эмжинэ. Ерөнхий загвар нь өнөөгийн монгол дээлтэй адил байсан гэнэ. Монгол хамниган хийгээд ороchon, манегр, бирарууд арьсан дээлийг “шун”~”сун” хэмээн нэрлэж тэдний сун нь хоорондоо хийц хэлбэр төстэй байгаа нь тэдний хэл аялгуу болон хэрэглээний ойрын холбоог илтгэж байгаа юм. Хамнигад дээлийн ташаанд гурвалжин оруулга оруулж, хормойг нь дэрвийлгэнэ. Дээлийн хормой дэрэвгэр байх нь моринд мордоход мөн морь унах үед өвдгөө ороогоод явахад хормой нь хийсэхгүй, дулаан тухтай байдаг гэнэ. Суганд нь ч дөрвөлжин ромбо хэлбэртэй оруулга хийж нилээд уужим болгодог. Дээлийн хормой ба суганд оруулга хийдэг эсгүүрийн энэ арга өвөр Байгалийн эвенг бөөгийн хувцасны эсгүүрийн загвартай адилхан байна²⁷³. Мөн модон хэв халааж өнгө цагаан хонины нэхий дээлэн дээрээ дугуй хээ тавьж гоёдог байжээ.

Харин өнөөгийн хамнигад хурим найр, цагаан сар, наадам зэрэг өргөн олноороо тэмдэглэх баярын үеэр буриадуудтай адил басган дээл, самган дээл өмсч байна (*Зураг- 9, 10*). Гэхдээ хөрш буриадууд нь, хамнигад самган дээлийнхээ татаасыг биднийхээс илүү олон өнгө алаглуулж хийдэг гэж өөрсдийнхөөсөө ялгаж байлаа.

Тэд бэлтрэгний арьсаар дээл хийх бөгөөд 60 орчим бэлтрэгний арьс эрэгтэй хүний нэг дээлэнд элбэг хүрдэг. Бэлтрэгэн, чонон дээл өглөө үүрээр хүйтэн байдаг, энэ нь чоно үүрээр гүйдэлтэй байдгаас шалтгаалдаг юм гэнэ. Хамниган анчдын хуучилснаар чонон дээл, дахыг нөмөрч унтаад үүрээр жиндээд ирэхийн үес хэд хэдэн удаа сэгсрээд өмсөхөд халуу төөнөөд эхлэдэг ажээ. Ангийн арьсаар дээл хийхээс гадна тэсгим хүйтэнд өмсөх дах хийнэ. Нэг эм

²⁷⁰ Б.Ринчен, МАУ-ын хамниган аялгуу, УБ-1969, 58 т

²⁷¹ Орцоны өөртөө засах хошууны тойм байдал, ӨМАХХ- 1989, 60 т

²⁷² Г.М.Василевич, Материальная культура народов Сибири и Севера, Ленинград – 1976, 112 стр

²⁷³ Е.Д.Прокофьев, Шаманские костюмы народов Сибири. Религиозные представления и обряды народов Сибири в XIX- начале XX века, Ленинград-1971, 81 стр

баавгай, нэг шүдлэн баавгай, гурван бамбаруушийн арьсаар нэг дах хийж хүрдэг байна. Дах хийх баавгайн арьсыг бод малын арьстай адил “эргүүлэг”-т хийж элдэнэ. Баавгайн арьс тос ихтэй тул элдэхийн өмнө хөрсөнд үнс шавар түрхэж, урсгал усанд нэг хоног байлгадаг ажээ. Уснаас гаргаж, сэгсэрч сэврээсний дараа хөрсөнд нь аарц, тараг цагаа түрхэж дахин хэд хонуулаад идээ шүү нь шингэлээ гэж үзэн “эргүүлэг”-т хийж элддэг байна. Ийм дахыг энгэр нь голоороо задгай, биеийн өндөртэй тэнцүү шахуу урттай байхаар эсгэж хийдэг. Баавгайн дах нь хамниган анчдын гол өмсгөлийн нэг юм. Эвхэж хадгалсан дахыг шууд нөмөрвөл хүйтэнд төдийлөн нэмэр нөмөр болдоггүй, харин сэгсэрч салхи авахуулаад нөмрөхөд сор нь сэргэж дулаахан байдаг ажээ. Ер нь ганц баавгайн гэлтгүй том ангийн арьсан дээл хувцасыг үс сорыг нь сэгсэрч сэргээж өмсвөл харьцангуй дулаан байдаг гэнэ. Мөн баавгайн үс ноос илч ихтэй тул гутлын дотор зулж дэвсэхэд дулаан байх боловч байнга хэрэглэвэл нүд улайж, хараа муутгадаг сөрөг талтай юм байна.

Хамнигад голдуу мал, ан амьтны арьсаар хийсэн хэдэн төрлийн малгай өмсдөг байжээ. Дулааны улиралд өмсөх малгайг “сөдөг” гэнэ. Өвөлдөө үнэг, туулай зэрэг ангийн арьсаар хийсэн “маахуур” өмсөнө. Ерөөгийн Ходоодон отгийн хамниган настаны хуучилснаар, урьд Ерөөгийн хамнигад янзаган малгай өмсдөг байсан гэнэ. Бүтээлийн тэргүүн бүлэгт, Оросын колоницилогчдоос зугтан Хар мөрнийг гатлах үед эвенгүүд хожим биесээ бор гөрөөсний толгойн арьсан малгайгаар таньж явахыг захиж үлдээсэн гэх түүхийг дурьдсан билээ. Ерөөгийн хамниганы гөрөөсний арьсан малгай нь домогт гарах малгайтай хийц загвар адил болох нь эргэлзээгүй.

Хэнтийн хамниганы зарим нь урьдын хамниган хүний малгай босоо ширээстэй байсан гэж байв. Гэхдээ энэ мэдээ төдийлөн олон таарахгүй байна. Мөн хамниганы малгайн хэлбэр хийц нь буриадын “тооровч” малгайтай адил байхаас гадна оройг нь тойруулж ширсэн ширээсний тоо 8, 11, 15 байдаг гэнэ. Урьд тооровчийг 15 ширээстэй хийдэг байсан нь хорь ба ага буриадын тооровчийн ширээс хорь 11 эцэг, ага 8 эцгийг билэгддэгийг адил хаант Оросын хилийн харуулд суусан хамниганы 15 эцгийн тоог илэрхийлж байсан ажээ. Өнөөгийн хамниган хүн тооровч малгайн ширээсийн билэгдлийг анхаарахаа больж, янз бүрийн тоотой хийдэг болжээ.

Академич Б.Ренчиний тэмдэглэсэн Монголын хамниганы зарим хувцасны нэрийг судлаачдын нэрлэж байснаар монголжсон түнгүүсүүд буюу Хар мөрний угсаатны хувцасны нэрийн зүйлтэй харьцуулвал:

Мон. Хам	манж-түнгүүс	орочон	манегр, бирар	утга нь
Абен [Б.Р]	āwун	авун	аун ²⁷⁴	
малгай				
herки[Б.Р]	herki	эрки		эрки
өмд				
дэкэл[Б.Р]				дэкэли
ууж				

²⁷⁴Г.М.Василевич, Материальная культура народов Сибири и Севера, Ленинград – 1976, 112 стр

	коколда	коколло		коколло
бээлэй				
	омал	буһө	-	умул
бүс				
	сун		нилусун	сун-шун
дээл				
			асисун	

Хамниган хүүхдийн нялхын сэвлэг үсийг 2, 3 настайд нь толгойн оройд эвэр үлдээж авдаг ёстой. Харин хамниган настаны хуучилснаар, 1940, 50-иад он хүртэл, хамниган охид 7, 8 юмуу 10-аад настайгаасаа эхэлж гээг тавьдаг байжээ. Толгойн оройд хэсэг үс үлдээж бусдыг нь тойруулж хусаад, тэр хуссан үс нь ургаж эхэлмэгц хэсэг хэсгээр нь багцалж сүлжих бөгөөд энэ нь ойролцоогоор 8- 12 салаа (гүрлөө-мон.хам) болдог гэнэ. Ингэж хусахыг хамнигад зүйлэх²⁷⁵ гэж нэрлэдэг. Олон салаа сүлжсэн богино гэзгээ нилээд урт ургуулаад тав гэзэгтэйгээ нийлүүлж сүлжсээр нэг салаа болгоно. Багачууд арваад настай болчихоод үсээ хусуулж гэзэг тавьна гэдэг хэцүү, ичгэвтэр байсан гэнэ. Хамниган эмэгтэйчүүд хадамд гартлаа нэг салаа гэзэгтэй байх бөгөөд бэрлэх үеэр үсийг нь хагалж хоёр салаална²⁷⁶. Охид гэзэгнийхээ үзүүрт алтан чагт, мөнгөн өлгүүр, шүр зүүж гоёх ба мөн олон өнгийн мяндсан утсаар гэзгээ уядаг байжээ. Баяцуулын охид халиу, булга хадсан чигэвчтэй, залаатай малгай өмсдөг байсан гэнэ. Хамниганы эхнэрүүд буриад эхнэрүүдийн адил гэзгэндээ туйв зүүдэг байсан бөгөөд тэдний туйвны үзүүр буриад эхнэрийн туйвныхаас урт байсан гэж ялгаж байна. Өнөөгийн хамниганы настангууд өдөр тутам цайвар эсвэл цагаан өнгийн алчуурыг толгойн ард эсвэл эрүүн дороо зангидна.

Монголын хамнигад мал, амьтны арьсаар хувцас хийхээс гадна ахуйн жижиг хэрэглэл хийдэг. Гөрөөсний хэд хэдэн год элдэж үсийг нь гадагш харуулж хийсэн уут хэрэглэдгээ монгол хамнигад “туйварцаг”, “түнгэрцэг” гэж нэрлэж байна. Ононы хамнигад хуурай цай хийдэг арьсан уутыг мөн “түнгэрцэг” гэнэ. Түнгэрцгийн ёроолыг гөрөөсний сарьсаар уллаж, их бие болоод улных нь завсарт сарьс хавчуулж оёдог ажээ.

Энэ савны хэрэглээний зориулалтыг харьцуулж гаргавал:

Халимаг	Дархад	Ононы хам	Мон хам
“түнгэрцэг” ²⁷⁷	түнгэрцэг	түнгэрцэг	
түнгэрцэг			
тамхины уут	Шир, булигаар сав	цайны арьсан уут	гөрөөсний
годон уут			

Хамнигад тамхины уут савыг “хавтрага”²⁷⁸ гэнэ. Хар мөрөн, Аргунь, Шилке, Ингэдэй, Ононоор суугч манегр, орононууд эрэгтэй, эмэгтэй, хүүхэд багачууд

²⁷⁵ Зүйлэх - юмны үсийг хусч арилгахыг зүйлэх гэнэ. Монгол хэл бичгийн тайлбар толь, II боть, УБ- 2009, 1054 т

²⁷⁶ О.Баттуяа, Хэнтийд хийсэн судалгааны гар бичмэл, 2006

²⁷⁷ Д.Г.Дамдинов, Ононские хамниганы, Улан-Удэ- 1993, 74 стр

ялгаагүй бүгд тамхи татна. Тэндхийн эрэгтэйчүүд гаанс, этүүр, хулхивч, хэт, чимхүүр, хэтэвчээ даавуу юмуу адууны хялгасан бүсэндээ байнга зүүж явдаг. Тэд зочиноо “малу”²⁷⁹- даа суулгаад гаансаар дайлдаг²⁸⁰ гэж тамхины өргөн хэрэглээг нь тодруулсан байна. Мөн Хар мөрний сав дагуу нүүдэллэн амьдарч байсан манегр, бирарууд²⁸¹ тамхины савыг каптурга (~хавтрага) гэж нэрлэдэг байжээ. Тэд “каптурга”-ыг арьс, шир болон хилэн даавуугаар хийдэг. Хар мөрний адгаар суудаг гольдууд бүсэнд зүүдэг “уул (хэтний)-ын хайрцаг, сав”-ыг “kapptaró” гэнэ²⁸². Манегр, бираруудын “каптурга” болон гольдийн “kapptaró” нь монгол хамниганы “хавтрага”~ (каптурга~kapptaró) болсон нь энэ ажээ.

Бирар, манегр.	Мон.хамн.	Гольд, ороchon.	Халх.монг.
“каптурга”	“хавтрага”	“kapptaró”	“хавтага” ²⁸³

Дорнод монголын хамниганы “хавтрага”- ын хийц хэлбэрийг тодруулж чадаагүй ч нэрний адил төстэй байдалд нь үндэслээд Хар мөрний манегр, бираруудын каптургатай адил байсан гэж болох юм.

Дээрх нэрнүүдийн адил төстэй байдал нь Монголын хамнигадыг Хар мөрний ороchon манегр, бираруудтай холбоотой гэдгийг хэрэглээний уламжлалаар батлаж өгч байна.

Хэрэглээг нь нягталбал монгол хамниганы арьс ширэн эдлэл нь нүүдэлч малчдынхаас дутахгүй олон төрөл бөгөөд хийц хэлбэр нь ч тэднийхтэй төстэй байх ажээ. Тэд мал, амьтны арьс ширийг толгой шийрийнх гэж ялгалгүй аль хэсэг ямар эд зүйлд тохиромжтой, эдэлгээ хэр зэрэг даах вэ гэдгийг нь таньж, гүйцэд болон хагас боловсруулан хэрэглэж ирсэн байна.

Монгол хамниганы аж ахуй соёлын уламжлал өөрийн онцлогоо алдаж бүдгэрсэн, буриаджисан хэдий ч ахуйн хэрэглээ, түүний нэршлийн зүйлд хамниганы гэх зарим онцлог зүйл хадгалагдаж байна. Тэдний хувцас, эдлэлийн зүйлд халх, буриадын мөн түнгүүсийн бусад бүлгүүдийн адил төстэй хэв маяг

²⁷⁸ Хавтрага намд бүхил²⁷⁸ гэдэг нь– Надад тамхины уут өг! гэсэн утгатай. Буриад настаны дуудлагаар тэмдэглэсэн нь.О.Баттуяа, Хэнтий, Дорнод аймагт хийсэн судалгааны гар бичмэл, 2004

²⁷⁹ Маллу (малу) гэдэг нь манж-түнгүүс угсаатнуудын урц гэрийн хамгийн хүндтэй тал нь юм. Тэнд эмэгтэйчүүд сууж болохгүй гэсэн хатуу жаягтай байжээ.

²⁸⁰ А.Мичи, Путешествие по Амуру и Восточной Сибири. Спб- 1868, 218- 219 стр

²⁸¹ Бира гэх нь эвенгээр гол мөрөн гэсэн утгатай тул “бирар” гэдэг нь гол мөрний эргээр амьдрагсад гэсэн утгатай гэж энэхүү нэршлийг тайлбарласан байдаг.

²⁸² В.Диосэги, Берестовая посуда у манджура - тунгусов и методы ее изготовления, Будапешт - 1950, 11 стр

²⁸³ Ахуйн хэрэглээний уут сав, тамхины уутыг монголчууд “хавтага” гэнэ. Хавтаганы үмрүүл гэдэг нь хавтаганы тасам юм. Аяганы хавтага- аяганы уут, тамхины хавтага- тамхины уут, хөмөн хавтага- хөмөөр хийсэн уутыг хэлж байгаа юм. Монголчуудын биедээ авч явдаг аяга, хөөрөг зэрэг зүйлийг хийдэг голдуу хуниас бүхий амтай, бүсэндээ зүүх хийц гоёмсог нэгэн зүйлийн уут даалин. Мөн аарц шүүдэг уутыг хавтага гэдэг байна (О.Баттуяа, Сэлэнгэ, Дорноговь, Дундговь аймагт ажилласан судалгааны гар бичмэл, 2007). Баргужины түнгүүсүүд “каптака” гэхий тавцан, талбай (тэгш), харин “капта” гэвэл тэгшлэх гэсэн утгатай ажээ. Нерчү, Илимгийн түнгүүсүүд банз, хавтгай зүсмэл модыг “каптауа” ~ (каптакā) гэж нэрлэдэг байна. А.Е.Аникин. Тунгусо-маньчжурские заимствования в русских говорах Сибири. Новосибирск- 1990, 23 стр

байгаа нь ХҮИ зууны үеэс заримтай нь ойртон нягтарсан хийгээд хэнтэй гарал нэгтэй вэ гэдгээ харуулж байгаагийн тодорхой жишээ болно.

Гэр ахуйн эдлэл. Хамнигад модыг ялангуяа хус, хар мод, бургасыг ахуйдаа өргөн хэрэглэж ирсэн байна. Хусаар ямаан тэрэгний дугуй, харвах нумны их бие, гичир²⁸⁴, сум зэргийг, үйсээр ахуйн сав суулга (матал, байлгана, саагч, күнүг, бортого, түүс, аяга (ага-Б.Р), бүрхөөр), ан амьтан дуудах бишгүүр, хар модоор орон сууц, малын хашаа хороо, холтсоор нь гэрийн хана, байшингийн дээвэр, ааруулын дэлгэц зэргийг хийнэ. Урьдын цагт төмөр утас ховор үед онхойгоор (нарийн хус) чарганы оглио²⁸⁵(арал), мөн улаан бургас халааж хашаа саравчаа хүлж бөхлөнө.

Хус, үйс болон хар модны холтсыг хэрэглээнд бэлтгэх. Цаг улирлын аяыг тааруулж үйс бэлтгэх нь Сибир, Амар мөрөн дагуух угсаатнуудын дунд тархсан нийтлэг уламжлал хамнигадын дунд хадгалагдсаар байна²⁸⁶. Монгол хамнигад долонгийн(долын)үе²⁸⁷ буюу багцаалбал 5 сарын 15–наас 6 сарын 15-ны хооронд²⁸⁸ хусны үйс, хар модны холтсыг хэрэгцээт хэмжээгээрээ бэлтгэнэ. Ойн гүнд ургасан юмуу эсвэл уулын нөмөр бэл газарт сүүдэрлэж ургасан хар мод цэх шулуун, салаа мөчир сийрэг, яр багатай тул ахуйн хэрэглээнд тохиромжтой байдаг ажээ. Ийм модыг манай орны баруун нутагт (Увсын Өндөрхангай, Зүүнхангай) “хайнаг” мод, төв хэсэгт “сарлагийн сүүл” гэж нэрлэдэг. Харин хорь буриадууд ойн захын салаа мөчир сахлаг нарс, шинэс зэрэг модыг “үхэр сүүл”²⁸⁹ гэдэг. Буриадууд ахуйдаа хар модны холтос хэрэглэдэг байсан бөгөөд холтосыг хамниганы нэгэн адил бэлтгэдэг уламжлалтай.

Үйсийг хэрэглээнд бэлтгэхдээ цэх шулуун яр гаргүй хус сонгон тайрч битүүгээр нь сугалах юмуу эсвэл ургаа чигт нь нарийн төмөр үзүүртэй хутгаар зүсч нарийн модоор түнхэн хөндийлөөд түнжийг²⁹⁰ нь үлдээж авдаг байна. Үйс хуулдаг хутгыг үльчууд “gesu”, гольдууд “giasu” гэж нэрлэдэг²⁹¹ ажээ. Хамниган

²⁸⁴Нумны их бие ба товх хоёрын хооронд байх үзүүрийн хэсэг.

²⁸⁵Оглобли –чарга, тэрэгний арал, бариулыг хэлж байгаа орос үг оглио~оглиов болоод хамниган, буриадуудын дунд тархсан нь юм. Энэ нь орос, буриад, хамниганы хэлний адилслын нэгэн жишээ болж мөн хамниганы дунд оросын соёлын нөлөө нэвтэрсэн байгааг харуулж байна.

²⁸⁶ В.Диосеги, Берестовая посуда у манджура – тунгусов и методы ее изготовления, Будапешт - 1950, 4стр

²⁸⁷Долонгийн үе гэдэг нь ургамал мод үндсээрээ чийг авч амилан, сэргэсэн үе. Өөрөөр хэлбэл долонгийн цагаар үйс, холтос ба гол модны хоорондуур чийг гүйж норсон байх тул хуулахад хялбар болно. Холтсыг нь хуулан авсан хар модыг монгол хамниганчууд “хуулмаг”, хорь буриадууд “хууламгай” гэдэг. Хуулмаг нь хэдэн жилийн дараа хатаж гүйцээд хуурай түлээ болно.

²⁸⁸ Энэ үед хусны шүүс ялгарч эхлэдэг ажээ.

²⁸⁹ Хорь буриадын цагаангууд овогт Д.Жанчивнямбуугаас 2007 онд тэмдэглэв.

²⁹⁰ Үйс ба гол мод хоёрын завсарт хар хүрэн өнгийн өнгөр маягийн дагтаршсан зүйл болох “дол” юмуу “долон”-г хангис овгийн хамниган “түнж” гэж нэрлэдэг ажээ. Энэхүү дол буюу түнжийг буцалгаж малын гэдэс дотрын өвчинд өгдөг байна. О.Баттуяа, Хэнтий аймагт хийсэн судалгааны гар битмэл, 2004

²⁹¹ В.Диосеги, Берестовая посуда у манджура – тунгусов и методы ее изготовления, Будапешт - 1950, 4,17-18 стр

настангууд үйс хуулдаг багажны тухайлсан нэрийг мартсан гэх боловч хийц хэлбэрийн хувьд ульч, гольдуудын “gesu”, “giasu”-тэй төстэй гэж байв.

Хар модны холтсыг хэрэглэхийн тулд гол модноос нь долон, золомыг²⁹² нь гэмтээлгүй хуулж авах ёстой. Золом гэмтвэл хорхой амархан идэж, бороо ус гоожин холтсон дээврийн эдэлгээ богиносдог байна. Холтсоо хуулуут чийгтэй үед нь хүнд зүйлээр дарж тэнийлгэснээр хана, дээврийн зориулалтаар голлон ашиглагдах холтос бэлэн болж байгаа юм.

Ахуйн хэрэглээний хусыг үйстэй адил долонгийн өмнө эсвэл түүнээс хойно бэлддэг уламжлалтай. Тэрэг хийх хусыг намар авбал хамгийн тохиромжтой байдаг²⁹³. Учир нь намар цагт ургамал мод байгалийн жамаар чийгээ гадагшлуулж, хуурайшиж эхлэх тул хатаахад дөхөмтэй байдагтай холбоотой. Хар модны нэгэн адил нар бага тусдаг сүүдэр газарт ургасан хус цэх шулуун, бат бөх байх тул ахуйн хэрэглээний хусыг ихэнхдээ уулын ар, бэлээс бэлтгэдэг ажээ. Хамнигадын дунд хэрэглээ зориулалтаас хамаарсан хус бэлтгэж хатаах хэдэн төрлийн арга байдаг. Гэр ахуйн жижиг эдлэл хийх хусыг усанд 7- 10 хоног байлгаж эсвэл усанд чанавал чийг давирхай нь амархан арилж, хурдан хатна. Нөгөөтэйгүүр усанд удаан байлгаж, чанасан хус эдэлгээ сайтай байдаг. Хусыг усанд чаналгүйгээр нөмөр сүүдэр газарт 1- 2 жил орчим хатаагаад дугуйны хигээс[пайс- О.Б],тэрэгний бул, харвах нумны их бие, гичир, сум зэрэг байнга эдлэгдэж байдаг зүйл хийнэ. Дархчуудын өгүүлснээр, ингэж хатаасан хус нь муухан төмрөөс ч илүү бат бөх байдаг ажээ²⁹⁴.

Хамнигад хусны үйсээр давирхай нэрж ахуйдаа өргөн хэрэглэнэ. Монгол хамниган(дулегад хамниган) хусны давирхайг “жооход”²⁹⁵ гэж нэрлэнэ. Хусны давирхай нэрэхдээ, газарт ташуу шуудуу ухаж, түүндээ модон цорго суулгадаг. Цоргоны нэг үзүүрт хувин тосоод, нөгөө үзүүрт хүйс нь цоорхой тогоонд жижиглэсэн хус(үйсээ)-аа өрж, дээрээс нь тогоо хөмрүүлэн хоёр тогооны амсарыг холбож маш зузаан шавардана. Хустай тогооны дор хүчтэй гал түлэхэд давирхай нь хайлж тогооны хүйсээр гоожин модон ховилоор урссаар хувинд хуримтлагддаг. Ингэж нэрсэн жооходыг тэрэгний гол, бул, цөнд түрхэж эдэлгээг нь уртасгана.

Үйсэн аяга, тогоо(чуман). ХХ зууны эхэн үед монгол хамнигад амсар нь хааш хаашаа 10 гаруй см, 8 см-ээс өндөргүй хэмжээтэй үйсэн аяга хэрэглэж байжээ. Энэхүү аягыг хийхдээ үйсээ дөрвөлжлөн зүсч, өнцгүүдийг гаднаас нь хавчиж булан гаргаж оёх юмуу эсвэл нарийн модоор нэвт сүлбэж тогтоодог байна. Хамнигад энэхүү үйсэн савыг хэдэн янзаар нэрлэж байна. Хэнтийн багш нар(багсод) овгийн хамниган үйсэн савыг “цуман”, “шуумаз”²⁹⁶ гэж байлаа. Монгол хамнигад талх барьдаг төмөр сав, чанасан мах гаргадаг үйсэн сав, ааруул хатаадаг дэлгэцийг бас “шуман” гэнэ. Эдгээрийг(талх жигнэдэг төмөр нь ч гэсэн) хийх арга нь цөм үйсэн аяга хийхтэй адил, зориулалтаасаа хамаарч

²⁹² Золом- холтос болон гол модны хооронд байх цагаан хальс.

²⁹³ Л.Тангад, Хамниган, МУ-ын угсаатны зүй, III боть, УБ- 1996, 358 т

²⁹⁴ О.Баттуяа, Хэнтий, Дорнод аймагт хийсэн судалгааны гар бичмэл, 2004

²⁹⁵ Ононы хамниган хусны давирхайг “джоохо” гэнэ.

²⁹⁶ Б.Баатархүү, Хэнтий, Дорнод аймагт хийсэн судалгааны тайлан, 2003, 54т

хэлбэр хэмжээ, материал нь өөр өөр байх ажээ. Хорь буриадууд нялх хүүхдийн үйсэн хуурайлгыг “шуман” гэх ба энэ “шуман”-ны доод ирмэгүүдийг гаднаас нь хавчиж өнцөг гарган тогтоогоод дээр нь хонины өтөг бууц дэвсэж, адууны хялгас зулж давхарлан мөнхүү зориулалтаар хэрэглэдэг байжээ. Норсон үед бууцыг нь сольж дэвсээд л хүүхдээ хуурайлчихна²⁹⁷. Монголын хамниганы чумантай адил үйсэн савыг Хар мөрний манегрууд(орочонууд) хага~(ага~аа), бирарууд ага~ачан гэж нэрлэж, өргөн хэрэглэдэг ажээ. Хар мөрний гилякууд хамнигадын чумантай төстэй хийц бүхий үйсэн аяга(тотангры)²⁹⁸, үльчүүд үйсэн таваг(раЅа), үйсэн шанага(sulfu), үйсэн сав(ugda sufuni)²⁹⁹, орочонууд мөн загварын үйсэн сав(куккэ, mulu)- ыг өргөн хэрэглэнэ³⁰⁰. Эдгээрийг бүгдийг нь оёж хийдэг. Монголын хамнигад 1940-өөд оныг хүртэл эд бараа олдоц ховор тарчиг байх үед хоол ундаа үйсэн аяганд хийж идэн өдөр тутмын хэрэглээ болгодог байжээ. Эдүгээ ан гөрөө болон жимс ногоонд явж хээр буудаллах үедээ хоол унд хийж идэх, мөн дотор нь ус, идээгээ цуг үйгээд дээрээс нь улайтгасан чулуу хийж хорхогийн цай чанах зэргээр түр зуурын л хэрэглээ болгож байна. Урьд Оросын нутагт байхдаа буриадууд хулгай дээрмээс сэргийлж үхрээ бэлчээрт нь дагаж хариулдаг байжээ. Хүйтний улиралд өдөржин үхэр малаа дагадаг буриад багачууд үйсэн саванд аарц, цай зэргийг хорхоглон чанаж³⁰¹ өдрийн өл хоолоо залгаж явдаг байсан гэнэ.

Байлгана(үйсэн хувин). Хамнигад үйсэн хувинд нь сүү хийж 1- 2 хоног сүүдэр газар байлган зөөхий тогтоож түүнийгээ хүнсэндээ зориулдаг. Тэд энд онцолсон үйсэн савыг дээрх хэрэглээний утгаар нь “байлгаа”, “байлгана”, “байлганца” мөн үйлдэгдсэн эдээр нь “үйсэн хувин” гэж нэрлэдэг байсан байна. Хамниганчууд байлганыг голдуу 5-6 литрийн багтаамжтай хийнэ. Байлганыг хоёр давхар үйсээр хийх бөгөөд доторлох үйс нь битүү буюу хусыг огтлон сугалж авсан, гадарлах үйс нь задгай буюу ургаа хуснаас зүсч хуулж авсан байдаг. Гадна талын задгай үйсийг доторт нь тааруулж хажуу ирмэгийг нь битүүлж оёно. Байлганы хажуугийн оёдлыг бат бөх байлгахын тулд хатгаасуудыг зэрэгцүүлж хийх тул гаднаасаа ташуу болж харагддаг байна. Үльчүүдийн “ugda sufuni” болон “mulu” –ийн амсарыг даруулсан оёдол нь монгол хамниганы “байлгаа”-ны хажуугийн ташуу гэгдэх энэхүү оёдолтой яг адилхан байдаг³⁰².

Хамнигад үйсэн хувингийн ёроолыг хоёр давхар үйсээр дугуйлж эсгэн, түүнийгээ их биед нь тогтоохдоо гаднаас нь хонины ноосон утсаар ширнэ.

²⁹⁷ Хэнтийн Биндэр сумын хорь буриадын цагаангууд овгийн Д. Лхамцоогоос (72 н) 2006 онд тэмдэглэв.

²⁹⁸ Л.Щренк, “Об инородцах Амурского края”, Спб-1883, Хавсралт XII-ын зураг-8

²⁹⁹ В.Диосэги, Берестовая посуда у манджура - тунгусов и методы ее изготовления, Будапешт - 1950, 4, 6,7 стр

³⁰⁰ В.Г.Ларькин, “Орочи”, Москва- 1964, 57 стр

³⁰¹ Монголчууд ийм аргаар цоргимог бэлддэг бөгөөд ингэхдээ түүдэг галд өндөгөн чинээ 6-7 ш бөөрөнхий чулуу хийж улайтгана. Модон хуланд хийсэн хонь малын сүүн дээрээсээ бөөрөнхий чулуугаа цувуулан хийх бөгөөд 3, 4 дэх чулууны дараа хултай сүү буцлаж ширгэн өтгөрсөөр цоргимог бэлэн болно.

³⁰² В.Диосеги, Берестовая посуда у манджуро-тунгусов и методы ее изготовления, Будапешт- 1950, хавсралт зураг 3д, 6 т

Тэдгээр оёдлыг сэтэрч задрахаас сэргийлж давирхай юмуу тосоор шавж бөхөлдөг байна. Үүний дараа их биений амсарыг гадагш нь эргүүлээд түүнийгээ даруулж нарийн матмал³⁰³ улиас, бургас барьж амсартай нь нэвт хатган оёдог. Хамгийн сүүлд савны хоёр талыг нүхэлж адууны хялгасан бариул зүүгээд л "байлгаа" бэлэн болно³⁰⁴. Байлганыг цэвэрлэхдээ хонин бургасны хальсаар угааж, хужиртай усаар сайтар зайлаад сүүдэр газарт хатаана. Наранд хатаавал амархан хагарч эдэлгээ мууддаг гэнэ. Байлганыг буриадууд ч өргөн хэрэглэх бөгөөд "байлганцаг", "байлгаа" гэж нэрлэдэг. Зарим хорь буриадууд байлгааг улиасаар уллаж түүнийгээ "оёорцог" гэх ба энэ нь оёор (буриад)- ёроол гэдэг үгнээс үүдсэн тусгайлан бэлдэж хийсэн ёроолтой сав гэсэн утга агуулж байгаа юм. XIX зууны үед Амар мөрний адаг орчимоор суурьшиж байсан гилякууд монгол хамниганы байлганатай адил үйсэн савыг ундны ус зөөхдөө хэрэглэдэг байжээ. Тэндхийн айл бүрийн үүдэнд том хэмжээний үйсэн хувин, үйсэн шанага заавал тавиастай харагдана. Гиляк эмэгтэйчүүд мөрөн дээрээ дамнуурга³⁰⁵ тэгнээд, түүнийхээ хоёр талд үйсэн хувин зүүчихээд усаа зөөдөг гэнэ. Үндэсний музейн сан хөмрөгт хийцийн хувьд хамниганы байлганатай адил цаа саадаг сав хэмээсэн тайлбартай нэгэн үйсэн суулга байгаа нь Хөвсгөлийн дархадуудын хэрэглээ ажээ. Дан ганц үйсээр үйлдэгддэг тус сав нь Сибирийн ойн иргэдийн амьдрах орчинтой нягт уялдсан хэрэглээний ул мөр болж, Монголын хамниганы дунд уламжлагдаж ирсэн нь энэ юм.

Түүс(Зураг- 11, 12). Энэхүү суулгыг ихэнхдээ "түйс" гээд байдаг, уг нь хамниган дуудлагаар "түүсэ" гэх ёстой. Хамниган хүн - Түүсээ аваачга? гэсэн нь - Түүсээ авсан уу? гэсэн утгатай юм³⁰⁶. Түүс бол хамниганы төдийгүй буриадуудын түгээмэл хэрэглэдэг ахуйн олон янзын үйсэн савны нэг нь бөгөөд одоо ч гэсэн тэд хүссэн хэмжээгээрээ хийж гэр зуураа өргөн хэрэглэсээр байна.

Монгол хамниганы түүсний хэмжээ нь зориулалтаасаа хамаарч янз бүр, том нь бараг 10- аад литрийн багтаамжтай болдог ажээ. Жижиг түүсэнд давс, сахар зэрэг ойр зуурын юм хийхээс гадна, муудахдаа амархан, удаан хадгалж хэрэглэдэг жимс, чанамал, мангир гоголь, цөцгий тос хийхэд тун тохиромжтой байдаг гэнэ. Хамниганы түүс хийх аргыг тоймловол, түүс хийх хэмжээндээ тааруулж үйсээ дөрвөлжилж зүсээд усанд дэвтээж цэвэрлэнэ. Ер нь үйсээр ямар нэг зүйл хийх гэвэл заавал усанд дэвтээж зөөллөөд, өө сэвийг нь авч цэвэрлэдэг. Гаднах үйсийг оёж битүүлэхгүй харин хоёр талд нь хөрөөний ир мэт давхар догол гаргаж түүгээр нь уулзуулж чагталж тогтооно. Бэлэн болсон их биеийг нь улиасаар уллаж (ёроол хийж) ёроолыг нь дагуулж хоёр давхар үйсэн бүслүүр

³⁰³ Улиасыг 2 хоног орчим усанд хийж зөөллөөд хүссэн загвараараа матдаг.

³⁰⁴ О.Баттуяа, Хэнтий, Дорнод аймагт хийсэн судалгааны гар бичмэл, 2004

³⁰⁵ Ийм дамнуургыг гилякууд- "кормульхь", "джамда" гэж нэрлэдэг байна. Л.Щренк, Об инородцах Амурского края, Спб-1883, хавсралт XII, зураг - 1, 2т. Хус мод матаж хийсэн дамнуургаар ус зөөх уламжлал дорнод Монголын буриад, хамниганы дунд элбэг ба түүнийгээ "үүргэвч" гэж нэрлэдэг юм. Үүргэвчийн хоёр үзүүрт торомжоо ховил гаргаж түүндээ устай суулгаа тогтоочихоод дүүрч явах нь биед тээргүй, хөгшид хүүхдэд ялгалгүй тохиромжтой байдаг.

³⁰⁶ Багш нар хамниган Х.Батмөнх энэхүү тайлбарыг хэлж тэмдэглүүлэв.

хийсний дараа халуун усанд хэсэг хугацаагаар байлгахад улласан улиас нь тэлж завсаргүй бөх бат ёроол болж өгдөг байна. Түүсний амсрыг эргүүлж тогтоогоод түүндээ ягштал таарсан модон таг хийнэ. Ингэсний дараа амсрыг нь тойруулж ижил зайд нүхлээд, тэдгээр нүхнүүдэд таарч байхаар таглааг мөн адил нүхлэж модоор нэвт чагтлаж түгжинэ. Ингээд бат бөх тагтай юу ч хийсэн асгарахгүй түүс бэлэн болж байгаа юм³⁰⁷. Ийм түүсэнд сүү, архи зэрэг шингэн зүйл хийж моринд ганзгалахад асгаж цалгидаггүй, нэвтэрч нэвчдэггүй ажээ. Зүүн Сибир, Амар мөрний дагуу суудаг манегрууд түүсийг “кунга” (конги) гэж нэрлэдэг. Хийх арга хэлбэр нь ч монгол хамниганыхтай адил юм. Буриадууд ч мөн дарааллаар хийж, түгээмэл хэрэглэж байна.

Хамнигад мөн өөр нэг аргаар түүс хийдэг бөгөөд түүс хийх хэмжээндээ тохируулж үйсээ дөрвөлжилж зүсээд, сайн цэвэрлэсний дараа чанаж зөөллөнө. Түүсний дээд доод ирмэгийг дагуулж үйс давхар барьж хялгас эсвэл хонины ноосон утсаар их биеийг битүүлж шидэж оёно. Улыг нь улиасаар хийдэг. Оёж хийсэн түүсэнд мангир, гогод даршилж хадгална. Ийм аргаар хийсэн түүс Хэнтийн Дадал сумын ОНСКабинетэд хадгалагдаж байна(Зураг-11). Мөн тус сумын иргэн Бат- Эрдэнийн өмбөөгөөс өвлөгдсөн түүс (Зураг-12). Энэ түүсийг түүний өмбөө хийсэн гэнэ. Түүнээс энэ түүсийг нь музейд үзмэр болгож авахаар маш их ятгасан боловч огтхон ч зөвшөөрөөгүй юм. Үйсийг оёх ийм уламжлал хамнигадад л хадгалагдаж байна. Буриадууд түүс хийх нь элбэг ч ингэж оёж хийдэггүйгээрээ хамнигадаас ялгардаг. Үйсийг оёж хийх арга нь Сибирийн түнгүүс угсаатнуудад түгээмэл байдаг.

Матаал(Зураг- 13). Матаал хийх үйсийг долонгийн үеэр бэлтгэх ба халуун усанд дэвтээж зөөлрүүлээд дөрвөлжилж, булангуудыг нь хонины ноосон юмуу хялгасан утсаар нэвт хатгаж оёно. 10-р зурагт байгаа матаалыг Хэнтийн Биндэр сумын дулегат хамниган Д.Дэчингомбо хийсэн бөгөөд хавар долонгийн үеэр үйс хуулж дахин хийчихнээ гээд чанасан мах тавьж хэрэглэж байсан матаалаа 2010 онд аймгийн музейд бэлэглэсэн билээ. Түүний тайлбарлаж байгаагаар, матаалын үйс нимгэн байх тусмаа хийхэд дөхөмтэй, уян хатан тул эдэлгээ сайтай байдаг ажээ. Ямааны өөхөөр нугалаа завсрыг нь тослож эдэлгээг нь уртасгадаг. Матаал гэж нэрлэсэн учир нь матаж хийсэн гэсэн утгаас үүдэлтэй гэнэ. Үйсэн матаалыг ааруул дэлгэж хатаах, чанасан мах гаргах зэргээр мэр сэр ашиглаж байна. Урьд Хэнтийн хамниган хар модны холтосоор ааруул хатаах дэлгэц хийдэг байжээ. Дэлгэц хийх холтосыг дээврийн холтостой адил цагаан хальстай нь хуулж, тэнийлгэн хоёр захаар нь хөндлөн мод хавчиж тогтоодог байна.

Дэлгэцийн ирмэгт тогтоосон мод нь дэлгэцийг зөв хэлбэрт оруулахаас гадна тогтвортой байлгах хүндрүүлэгч болж өгдөг байна. Үйсээр ааруулын дэлгэц хийх арга нь “чуман” хийхтэй адил боловч чуманыг бодвол илүү том, далбагар, гэхдээ гүйхэн байдаг. Энд дурьдаж буй Монголын хамниганы ааруулын дэлгэц нь үйсэн сав хийх нийтлэг аргын уламжлал, хамниганы эрхлэх аж ахуйг даган хэрэглээний зориулалт нь хувирч нэмэгдсэний нэгэн жишээ энэ болж байгаа юм.

³⁰⁷ Хэнтийн Биндэр сумын багш нар хамниган Ч.Гунгаагаас(73 н) 2006 онд тэмдэглэв.

- Тэд модыг байж болох бүх аргаар боловсруулж, хамгийн өргөн хүрээгээр ашиглаж иржээ. Аж ахуй нийгмийн хөгжлийг даган хамниганы модны хэрэглээ хумигдсан ч хөдөө мал ахуйгаар амьдрагч хамнигадын дунд модоор ялангуяа хус, үйс, хар модоор эд хийх нь түгээмэл байсаар байна.

- Хамниганы үйсний хэрэглээ нь тэдний тархац нутгийн байгаль орчины онцлогоос хамаарч дагасан хэрэглээ юм. Үйс нь Сибирийн угсаатнуудын ахуйн хамгийн өргөн хэрэглээний түүхий эд болж, гэр сууц буюу барилгын зориулалтаар, шүтлэг бишрэлийн буюу билэгдлийн зориулалтаар, тээврийн хэрэгсэл болон гэр ахуйн сав суулга хийхэд ашиглагдан, ахуй амьдралын бүх хүрээнд голлож байжээ. Өөрөөр хэлбэл хус буюу үйс нь тэдний суурьшиж буй газар нутагт элбэг байх тул хамнигадын аж амьдралын гол хэрэгцээг хангаж чадаж байсан учраас түүхэн тодорхой үед угсаатны шинжийг нь илэрхийлэхүйц хэмжээнд хүртэл ашиглагдаж иржээ.

2.5. Хоол хүнс

Аливаа ард түмний хоол хүнс, түүнийгээ тохируулан өөрт ашигтайгаар хэрэглэх, бэлтгэж боловсруулах арга зэрэг нь тэдний идэвхтэйгээр амьдран сууж буй газар зүйн орчин, эрхлэх аж ахуйтай нь нягт уялдсан байдаг. Өөрөөр хэлбэл ямар ч угсаа нийтлэгүүдийн хоол хүнсний төрөл, түүнийг таашаан хэрэглэж буй байдлаас нь тэднийг ямар аж ахуй эрхэлж байсан хийгээд суурьшиж байсан газар орны онцлогийг олж мэдэх боломжтой гэсэн үг. Иймээс хамниганы хоол хүнсний төрөл, нэршил, хэрэглээ нь тэдний ахуй соёлын холбогдлыг тодруулахад зохих ач холбогдолтой юм. Тэд ан гөрөө, байгалийн зэрлэг жимс ногоогоор элдэв төрлийн хоол хүнс бэлдэж иржээ. Мэхээр, цагаан төмс, мангир, хүнхээл, гогоул, гичгэнэ, шумбуруу, нохойн хошуу, мойл, улаагана, нэрс, үхрийн нүд зэргийг нөөцөлж хүнсэндээ хэрэглэнэ. Хамнигад ургамал жимсийг боловсруулж дангаар нь хэрэглэхээсээ идэш хоолны нэмэр хачир болгох нь давамгайл байдаг. Тэдний хоол хүнсний төрөлд мал аж ахуйн гаралтай, мах, сүү цагаан идээний төрөл багтаж байна. Буриадуудын нэгэн адил үхэр өсгөвөрлөж сүүг нь боловсруулан хэдэн төрлийн цагаан идээ бэлтгэнэ. Тэдний цагаан идээ бэлтгэх арга нь хөрш буриадынхаас ялгарах юмгүй, түүнийгээ нэрлэх аялга дуудлага, амт чанар төдийд “байлгаа” гэхийг “байлганцаг” гээд, хамнигадын архи буриадынхаас хатуу гардаг гэх зэрэг ялгааг онцлох ажээ. Хамнигад цагаан сар, хурим найр зэрэг баяр ёслолын үеэр сүү, цагаан идээгээрээ архи нэрж өргөн хэрэглэдэг. Айрагны эх бэлтгэхдээ бүлээн сүүнд улаан бургас, далан залгаас, дугуй булантай цай хийж тодорхой хугацаанд байлгаад гаргаж авдаг байна. Мөн хөхөө суусан хар модны холтсыг айрагныхаа дотор хийхэд исэлт сайтай байдаг гэнэ. Цагаан идээ, айраг бузартаж архи гарахаа боливол айрагны саваа хөмрүүлж дотор нь арц ганга уугиулж ариутгадаг байна.

Ангийн махыг хүнсэндээ хэрэглэх нь өнөө үед хэвээр байна. Хамнигад жигүүртнээс голдуу нугас, сойр, хурын махыг хүнсэндээ хэрэглэдэг. Мөн хүнс хоол ховор тарчиг байсан дэлхийн II дайны үед чандага, туулай, хэрэмний мах, тархийг хуурч, чанаж иддэг байжээ. Хэрэмний арьсыг тухайн үед 60 мөнгөөр хятад худалдаанд өгдөг байсан гэнэ. Ерөөгийн намиад хамниган халхчуудтай нийлж гөрөөлөх үед халх хүн илгэн тараг идэхсэн гэхэд нь хамниган хүн, илгэн тараг, илгэн тараг л гэнэ азарган хэрэмний тархинаас л илүү байв гэж байсан гэдэг үгтэй³⁰⁸. Үхэр адууны мах, гэдэс дотрыг хоол хүнсэндээ өргөн хэрэглэдэг. Хамнигад, адууны мах, дотор гэдсээр эрэгмин, тэгмин зэрэг хэд хэдэн төрлийн хүнс бэлтгэдэг байна. Хэнтийн дулят хамниган настаны өгүүлэх нь, 1950-иад оныг хүртэл хамниган, буриад ялгаагүй айл бүгд л адууны гэдсээр гурилтай шөл хийдэг байжээ. Урьдын цагт хамнигад хоол хүнснээс хордохыг мэдэхгүй, зуны цагт сүү цагаан идээ, өвөл нь махыг гол хүнсээ болгоно. Өвлийн идэшний махыг сайвлаж хадгална³⁰⁹. Энэхүү дөрвөлжин модон савны нэрнээс үүдэн өвлийн идэш хоолны махаа нөөцөлж хадгалснаа “сайвлах” гэдэг. Гахай, адууг өвчилгүйгээр зөвхөн мөчийг нь тайрч, гэдэс дотрыг нь аван түүнийхээ оронд цас чихэж, цас, мөс, өвсөөр сайн гэгч нь дарж орхидог ажээ³¹⁰.

Байлгана(байлгац). Үнээ саангуут сүүгээ шүүгээд үйсэн хувинд (байлгаа~байлгана - энэ савны тухай хойно дэлгэрүүлсэн байгаа) хийж сүүдэр газарт 2-3 хоног тавьж орхино. Ингэхэд сүүний дээд тал өтгөрч өрөмтөн зөөхэй тогтох бөгөөд түүнийг нь хамж аван хүнсэндээ өргөн хэрэглэдэг юм. Энэ нь буриад, хамниганы аль алинд нь байсан цагаан идээ бэлтгэх хамгийн түгээмэл арга бөгөөд ингэж авсан байлганаа цаашид цохиж боловсруулан тос гаргадаг байна. Байлгацны сүүг буцалгаж эззгий гаргах бөгөөд түүнийгээ байлгацны буцалгасан зөөхэйтэйгээ хольж, дээр нь цагаан төмс чанаж хийгээд, өвөл идэхээр хонины гүзээнд нөөцөлж хадгалдаг. Байлганы сүүг эдүүлж отовроо³¹¹ (творог-ээдэм) болгоно. Урьдны хамнигадын өдөр тутмын хоол нь зун цагт бол байлгац эдүүлэн гаргасан отовроо (творог), зөөхэй (цөцгий) байжээ. Сүүг хэд хоногоор байлгаж зөөхэй гаргаж авдгаас нь үүдээд “байлгаа”, “байлгац” гэж нэрлэсэн байна. Одоо ч гэсэн машиндаж гаргасан зөөхэйг отовроотой хольж идэх нь Хэнтий, Дорнодын буриад, хамниганд ялгаагүй дэлгэр байдаг.

Аарц талх (эбхээл тордон). Өвлийн цагт голдуу бүхэл мах чанаад шөлөнд нь аарц хутгаж, гурил самарч “аарц талх” хийж иднэ. Хэнтийн Дадалын хангис хамниган Сэндэн, бидний багад манай өмбөө ийм аарц талхыг – “эбхээл тордон” гэдэг байсан. Хуучны хамниган хүн ийм идээг “эбхэл тордон” гэдэг байж л дээ гэснийг үзэхэд хоол идээний нэрний зүйлд гарсан бас нэг хувирал ажээ. Нөгөөтэйгүүр уг хамниган хүн буриад нарын адил аарц гэхгүй аарц талх гэж нэрлэж байна. Үзөөн хамниган арай өөрөөр мах эсвэл хярамцаг жижиглэн

³⁰⁸ Сэлэнгийн Ерөө сумын настан Цэдэвийн Хүрэлээс 2007 онд тэмдэглэв.

³⁰⁹ Д.Тангад, Хамниган, МУ-ын угсаатны зүй, III боть, УБ-1996, 352 т

³¹⁰ Д.Тангад, Хамниган, МУ-ын угсаатны зүй, III боть, УБ-1996, 352 т

³¹¹ Отовроо~отовроог гэдэг нь творог-ээдэм, эззгий, аарц гэсэн үгтэй орос үг буриад, хамниганы аман аялгуунаа хувираад байгаа нь энэ болно.

хэрчиж аарцтай хамт шөлөнд үйж чанаад дээрээс нь гурил самарч болгодог. Ингэж хийсэн аарцыг буриадууд хамнигадын аарц гэж ялгаж байна.

Ячмень ~ Ичмень (арвай). Орос хэлний “ячмень” нь дуудлага хувираад “ичмень” болсон нь энэ ажээ. Бүхэл мах чанасны дараа шөлөнд нь арвай хаяж буцалгаад энэхүү ичмень бэлэн болно. Ичменийг нүдэж хуураад хүнсэндээ хэрэглэнэ, энэ нь хамниганы дээд хоолонд ордог байжээ.

Затуран (сатуран). Түнгүүсүүд бугын сүүнээс цохиж гаргаж авсан тосыг давс, гурилтай хольж чихэртэй халуун цайнд үйж амталж уудгыг судалгааны бүтээлд тэмдэглэсэн байдаг. Үүнтэй адил манай орны хамнигад гурилыг цөцгий тосоор амталж хуураад сүүнд чанаж хүнсэндээ хэрэглэдэг. Үүнийг Хэнтийн хамниган “затуран” гэнэ. Өвөр Байгалиас Камчатк, Енисейгээс Амар мөрөн хүртэлх нутгийн түнгүүсүүд цөцгий, өөхөн тос, гахайн өөхөнд улаан буудайн гурилыг давстай хуурч цайны хийц бэлтгэж хэрэглэдэг бөгөөд энэ идээгээ “затуран” (~ затурань ~ сатурн³¹²) гэж нэрлэдэг. Хамнигад затуранг амттаны дээдэд тооцож иржээ.

Эрэгмэн. Адууны дотор эрхтэн элэг, бөөр, мах, өөхийг нь хэрчээд мангир, гоголтай (хүнхээл) хольж амтлан гэдсэнд нь чихэж чанаж иддэг гэнэ. Хөдөө аянд явахад голдуу эрэгминээр хүнс хийнэ. Мөн хамнигад өвөл идэшний адуу гаргангуут элэг, арвинтий чанаж болголгүй даршилсан ногоотой хольж иддэг. Харин буриадууд адууны арвинтийг гэдсэнд нь чихэлгүй хөлдөөж түүхийгээр нь иддэг гэж хамнигад өөрсдийн хэрэглээнээс ялгаж байв.

Тэгмэн. Хамнигад адууны элгийг гол мах, өөх, давс мангираар амтлан нарийн гэдсэнд нь хийж “тэгмэн” гэдэг нэг төрлийн хоол бэлтгэдэг. Дулят хамнигад тэгмэн хийхдээ адууны дотор өөхийг ямар нэг хольц амтлагчгүйгээр гэдсэнд нь хийдэг гэнэ³¹³. Хамнигад “тэгмэн”-ийг эрэгмэний адил чанаж болгоод хүнсэндээ өргөн хэрэглэдэг байжээ. Энэ нь халхчуулын бэлтгэдэг адууны найртай адил хүнс юм.

Татамин(хонины шөл³¹⁴). Цагаан сарын үеэр хамниган айл бүр адуу, үхэр, ангийн махыг дөрвөлжилж хэрчин давсаар амталж өөх тос ихтэй шөлтэй хоол хийнэ. Үүнийг “татамин” гэж нэрлэх бөгөөд махыг нь заавал дөрвөлжилж хэрчдэг онцлогтой ажээ. Хэн нэг хүн, урьтаж танайд цагаан сараар тэдэн аяга “татамин” иднэ гэж бооцоо тавьдаг байна. Тэр бооцоо тавьсан хүнийг шинэлэхээр ирэхэд ам гарсан аяганых нь тоогоор татаминаасаа заавал ч үгүй идүүлж баалаад гаргадаг байсан гэнэ. Харин Ононы хамнигад амьтны уураг тархиар хийсэн хоолыг татамин гэж нэрлэдэг ажээ.

Гахайн толгой. Гахайн толгой нь хамниганы хүндэтгэлийн зоогт тооцогдоно. Гахайн толгойн эрүүг нь зааж, төмөр улайсгаж хуйхлаж, зулматал чанана. Чанаж болгосныхоо дараа гэрийн доторхи хамгийн хүндтэй хүн нь

³¹² А.Е.Аникин, Тунгусо-маньчжурские, бурятские заимствования в русских говорах Сибири, 1988, 101стр Э.К. Пекарский, В.П. Цветков. Очерки быта приаянских тунгусов, Спб – 1913, 74стр

³¹³ О.Баттуяа, Хэнтий аймагт хийсэн судалгааны гар бичмэл, 2005

³¹⁴ Г.М.Осокинъ, Материалы для сборника поместныхъ словъ и выражений обще-сибирскаго и въ частности забайкальскаго наречія, Москва-1901, 87стр

төөлэйг цохолж хоёр завьжнаас нь эхэлж хөнддөг байна³¹⁵. Тэр хөндөж цохлосон хуйхыг тооноороо өргөдөг. Гахайн толгой, дөрвөн өндөр, сүвээний гурван хавирга нь хамгийн сайн, өөх мах ихтэй хэсэг бөгөөд гахайн толгойг улаан бөс даавуугаар ногтолж дөрвөн өндөртэй нь барьвал, адуу мал тань өсөх болтугай! гээд адуу горилж байна, хамрыг нь шөрөглөж хамагчлаад өгвөл үхэр мал тань өсөх болтугай! гээд үхэр горилж байна гэсэн утгатай³¹⁶ гэнэ.

Хамнигадын дунд гахайн толгойг сайн санасан айлдаа хүндэтгэн барьдаг нэгэн ёс байна. Гахайн толгойг айлд барих нь олзны сайныг өгч байгаа хэрэг ажээ. Гахайн толгой нь монгол хамниган хүний хамгийн хүндтэй хоолонд тооцогдон, түүнийг хүнсэнд хэрэглэхдээ ихэд билэгшээж, хүндтэй хүнээр хөндүүлэх зэрэг хэрэглээний тодорхой дэг жаягтай байсан байна. Хамнигад бас гахайн шийрийг галд хийж хуйхалж иддэг. Гахай агнасан айл ганц гэрээрээ идэхгүй, саахалт айлууддаа хувааж хүртээнэ. Хэрвээ гахайн махнаас хүртээхгүй бол их л чамлаж ярьдаг байсан гэнэ. Сибирийн угсаатнуудын дунд түгээмэл байдаг ан амьтны толгойг хүндэтгэдэгтэй³¹⁷ адил гахайн толгойг мөлжөөд ясыг нь хамаагүй хаядаггүй, газарт хүргэлгүй, модны салаа мөчирт эсвэл малын хашаа хороонд өлгөдөг ажээ³¹⁸. Мөн гахай газрын эзэн, газрын муу юмыг байлгадаггүй гээд гахайн толгойг гэрийн баруун хатавчинд авч явна³¹⁹. Эдгээр нь нэг талаас гахайн толгойг хүндэтгэж байгаагийн хэлбэр, нөгөөтэйгүүр өрх гэр, хашаа хороогоо муу юмнаас хамгаалах бас нэг дом арга болох юм.

Адуун төөлэй. Урьдны чинээлэг хамниган, агын буриадууд адууг өрлөж нядлаад толгойг чанаж “адуун төөлэй” залж, төр хурим хийдэг байжээ³²⁰. Адуун төөлөйтэй төр нь хуримын ерөнхий дэгээр үргэлжлэх бөгөөд адуугаар хүндэтгэл болгосон нь тэр айлын хөрөнгө чинээг л илэрхийлсэн хэрэг ажээ. Найрын зочин

³¹⁵ Хэнтийн Биндэр сумын дулят хамниган Д.Жигмэдээс 2005 онд тэмдэглэв.

³¹⁶ Дулят хамниган Д.Жигмэдийн хүргэн Б.Түмэнбаяр 2005 оны цагаан сараар гахайн толгойгоор идээ зассан байна. Гэхдээ хамнигад урьд гахайн толгойг цагаан сараар тавьж байхыг мэдэхгүй гэх тул энэ нь залуу хүний сонирхлоос үүдсэн бололтой.

³¹⁷ Якудууд үхсэн бүргэд таарвал жижиг арангкась (лабаз-оромж бүхээг) барьж хийгээд, өөд өөд нь барьлаа, энэ газар оронд эргэж бүү ирээрэй! Зэсэн улаан ясыг чинь хадгалж, цалин мөнгөн ясыг чинь тавьлаа! гэх зэрэг дээдлэн хүндэтгэсэн утгатай үгсийг хэлдэг байна. Ганц бүргэдийнхийг ч биш адуу, үхэр, бугын толгой, сээр нуруу зэргийг гадас, модны мөчирт тавьж орхидог ёстой. Үүнийг тэд түнгүүсүүдээс уламжилсан бизээ. В.Л.Серошевский. Якуты. Опыт этнографического исследования В.Л.Серошевского. Т.1. Спб-1896 657 стр. Мөнхүү амьтны сүнснийг амрааж дээд ертөнцөд илгээж байгаа буюу сайн төрөл олохыг нь билэгдэж байгаа нь энэ юм.

³¹⁸ Хэнтийн Биндэр сумын багш нар хамниган Х.Батмөнхөөс 2006 онд тэмдэглэв.

³¹⁹ Гэрийн баруун хатавчинд малын аман хүзүүг өлгөх ёс дархадад байдаг ажээ. Мөн идшинд хэрэглэсэн үхэр, хонины аман хүзүүний ясыг гэрийн баруун урд хатавчинд өлгөх заншил халх, хотгойд ястангуудын дунд үзэгддэг. Энэ заншил маш эртнээс үүссэн бололтой. Ингэж өлгөдгийн учир гэвэл амьтан үхсэн ч гэсэн сүнс нь амьд үлддэг гэж бөө мөргөлд үздэг ёс уламжлагдсан нь энэ байж болох юм. Иймээс тэр малын сүнс аман хүзүүний ясанд үлдэж амьд байгаа юм гэсэн утгатай. С.Бадамхатан, эрдэм шинжилгээний бүтээлүүд, УБ-2000, 104,128т.

³²⁰ Чивчин хамниган Дорийн Мижидийн хуучилснаар, 1960-аад оны үед Цагаан-Овоод Дугарын Цэдваан гэдэг айл адуун төөлөйтэй хурим хийж байсан ажээ. О.Баттуяа, Хэнтий, Дорнод аймагт хийсэн судалгааны гар бичмэл, 2004

хүндтэй нэгэн настан, адуун толгойг өндийлгөхөд хоёр залуу эр чихдэж дүгэргийн³²¹ хоймрын ширээнд залахыг “төөлэй чихдэх” гэнэ. Төөлэйн хамт хавиргыг нь бүтнээр чанаж тавьна. Хамнигад хонь, адууг халуун хошуутай мал гэх тул адууны толгойг хүндтэй идээнд тооцно. Энэ уламжлал Дорнод аймгийн нүүдэлч малчин хамниган, буриадуудын дунд түгээмэл хадгалагдаж явсаар багцаагаар 1960 гаран оны үед хүрээд орхигдсон байна. Хэнтийн анчин хамнигад адуун төөлэйтэй хурим, төр хийхийг мэдэхгүй, сонсоогүй гэж байлаа.

Хүнсний ургамал. Тэдний хүнсний хэрэглээний нилээд хувийг ургамал, жимс эзэлнэ. Жимсийг мөчирлөж түүх, гишүүг нь гэмтээхийг цээрлэдэг. Нэрс, хад, үхрийн нүд, мойл, үрэл, улааганыг хүнсэндээ өргөн хэрэглэнэ. Хад халуун чанарын жимс тул хүний эрүүл мэндэд харшгүй сайн, нэрс хүйтэн чанарын жимс болохоор хууч өвчин хөдөлгөж магадгүй гэмтэй гэж байна. Дэлхийн II дайны жилүүдэд цай ховордож үлэрийн навчийг намар хатсан үед нь түүгээд, усанд хандалж цайны оронд хэрэглэдэг байжээ. Мойлыг намар түүж нүдээд, зөөхөйтэй хольж өвөл хүнслэхээр нөөцөлнө. Газрын ургамлуудаас хамгийн түгээмэл олон төрөл янзаар хэрэглэгддэг нь цагаан төмс юм³²². Цагаан төмсийг хамнигад халуун нурманд булж, сүүнд чанаж идэхээс гадна зөөхөйтэй хутгаж амт хачир нэмэрлэдэг байна. Мөн шөлтэй хоолонд үйж хачирладаг байсан гэнэ. Гэхдээ амт нь тийм ч сайхангүй байдаг ажээ.

Хамниганы хоол хүнсний зүйлд мал аж ахуйн гаралтай сүү цагаан идээ болон ан гөрөөгөөр хоол хүнс базаах уламжлал аль аль нь хадгалагдаж иржээ.

Бүтээлийн энэ хэсэгт хамниганы уламжлалт баяр цагаалган ба анагаах мэдлэг ухааны зарим нэг аргыг хавсруулав.

Хамнигадын хамгийн хүндэтгэлтэй баяр бол хаврын тэргүүн сарын шинийн нэгэн, шинэ жилийн угтлага цагаан сар буюу цагаалган юм. Тэдний цагаан сарын шинэлэх ёс нь битүүлэх, идээ таваг засах, мөр гаргах, золгож шинэлэх зэрэг ерөнхий дадал зан үйлийн талаар монголчуудаас төдийлөн ялгарах юмгүй байдаг. Хамнигад цагаан сарын үеэр хашаа хороо, гэр сууцаа цэмцийтэл цэвэрлэж, идээ цагаа элбэг дэлбэг байлгахыг эрхэмлэнэ. Тэд цагаан сарыг ямар өнгө байдлаар тэмдэглэнэ тэр жилийг мөн байдлаар өнгөрүүлэх нь гэж билэгшээдэг тул жилийн ганц сайн өдөр гэж цагаан сараар өнгөтэй сайнаа хэрэглэж, сайн сайхнаа билэгшээн хэлцдэг байна. Өнөөгийн хамнигад цагаан сарын шинийн нэгний өмнөх өдөр бууз жигнэж, элдэв амттан, чихэр, жигнэмэгээр таваг бэлдэж гэр бүл болон хөрш айлаараа цугларч цадтал идэж ууцгаан, битүүлгэ хийдэг болжээ.

³²¹ Дүгэрэг засна гэдэг нь төр найрын үед гэрийн гадна зочидод зориулж ширдэг, эсгий зэргийг тойруулан суудал бэлтгэснийг хэлж байгаа юм. 2004 онд Дорнодын Цагаан-Овоо суманд Цэцэнхүү, Идэрцэцэг нарын төр хуримын үеэр дүгэриг засч эрэгтэйчүүд дүгэргийн баруунд, эмэгтэйчүүд зүүнд гэхчлэн төр найрын дэг жаягаар зочидыг суулган, ширээ тавьж идээ умдаа өрсөн байв. Буриадын төр- хурим, видео кино, “Барга, хамниган, буриадын угсаа соёлын хамаадал” төслийн тайлан. УБ- 2004. МУИС-ийн Азийн Судалгааны Төв

³²² Буриадууд мөн адил хэрэглэх бөгөөд цагаан төмс түүдэг хатгуурыг “гахна” гэдэг. Хатгуурыг хийхдээ, салаатай модны үндсэнд хавтгай төмөр суулгаж хийнэ. Заавал салаатай үндэс байхын учир нь хөлөөрөө гишгэж сэндчихэд дөхөмтэй байдаг.

Урьд битүүний өдрийг дүйцэн өдөр гээд махаар идээ засдаггүй байсан гэнэ. Цагаан сарын тавгийн идээнд үхрийн өвчүү, шагайт, хабусо(хавирга) тавьна. Өвчүүг малд байдгаар нь өөд нь харуулж таваглаад хонхорыг нь идээгээр дүүргэнэ. Мөн гонзгой дөрвөлжилж хэрчсэн боорцог буюу хавсайг (бас өөрөөр самнаа гэнэ) үелж өрөн, мойлтой өрөм, ааруул, шар тос цагаан идээ, чихэр жимсээр хачир чимэг нэмж таваг засдаг ажээ. Шинэлж ирсэн зочидоо “татамин” -аар дайлдаг. Шинэлэх үеэр бурхан шүтээнээ дэлгэж өвчүүний бүдэрхий болон идээ цагааны дээжийг таваглаж бурханыхаа өмнө тавьна. Хэрвээ “даваэ”, “заяаш” зэрэг онгод шүтээнтэй бол идээ, цайны дээжээс амсуулж байна гэж онгодын аманд нь түрхэж хүндэлдэг ёстой.

Шинийн нэгний өглөө Лхам бурхан айл бүрийг эргэх гэдэг хуучны үгийг билэгдэн тотгоныхоо дээр Лхам бурхны унаа морийг ундлах гурван ширхэг мөс тавьдаг. Нар гаруут өнгөтэй өөдтэй дээл хувцсаа бүрэн өмсөж, лам багшийн хэлсэн чигт морь унаж эсвэл явган явж мөр зүгээ гаргана. Ингэснээр тэр жилийнхээ явдал мөрийн цээрийг гаргаж байгаа юм.

Шинэлж яваа улс айлд ороод хамгийн түрүүнд бурханд мөргөж, дараа нь насны эрэмбэ дагаж өтгөс настангуудын тохойг өргөж золгодог уламжлалтай. Золгохдоо алчуур, малгайгаа авдаггүй. Харин буриад эрчүүд малгайгаа авч золгоцгоодог. Хамниганы томцуул нь гөрөөс, хонь, ямаа, хүдэрийн арьсан тасам³²³ барьж өөр хоорондоо золгоно. Эрхэм хүндтэй хүндээ хүдэрийн арьсан тасамаар золгодог байна. Цагаан сарын бэлгэнд авсан тасамыг эрхиний хэлхээ, оосор дээс болгон хэрэглэдэг байсан ажээ. Мөн настангуудтай “сэрс” хадаг барьж золгодог байсан гэнэ³²⁴. Манай судалгааны үед гахайн толгой хүндэлдэг, чандага, туулайг биш харин бугыг ангийн хаан гэдэг дулят хамниган настан, тасам барьж золгодогийг мэдэхгүй, тэр чинь үзөөнүүдийн л ажил байх даа гэж байв. Энэ мэтчилэн мартагдаж орхигдсон гэхээсээ илүүтэй өв уламжлал, соёлын ялгаатай байсан гэж үзэж болохоор онцлогууд Монголын хамниганы овог төрлийн түвшинд ажиглагдаж байлаа.

1940, 50-иад оны үед хамнигад, дугуй булантай цайг нарийхан зүсч, хонины ноосоор 2-3 ороогоод³²⁵ настангуудад цагаан сарын бэлэг болгож барьдаг байжээ. Үүнийг “тэвкэ барих” гэдэг. Тэвкэ барих нь хамниганд ч ганц байдаг уламжлал биш, буриад монголчуудын худ ураг барилдах ёслолын үеэр хүүгийн талынхан худгуйд тэмээний ноосоор ороосон тэвхэ цай барьдаг ёстой. Энэ нь идээний дээж цай арвитахын бэлгэдэл, тэмээний ноос халуун сэтгэлийн хүндэтгэлийг илэрхийлж байгаагийн хэлбэр гэнэ³²⁶. Хүүхдэд хонины хуйхалсан

³²³ Тасам - Буга, гөрөөсний арьсны зоогоор хийсэн сур. Тасам ганзага- буга гөрөөсний сураар хийсэн ганзага. Тасам - эмжээр, хөвөөлж оёсон зүйл. Гөлөмний тасам- гөлөмний эмжээр, дээлийн тасам- дээлийн энгэр гэсэн үг юм. Мөн нарийн торгомсог бүчийг тасам гэнэ.

³²⁴ Д.Тангад, Хамниган, МУ-ын угсаатны зүй, III боть, УБ- 1996, 360 т

³²⁵Тэвх гэдэг нь бяцхан, дөрвөлжин гэсэн утгатай. Тэвхэн цай гэвэл шахмал том цайг жижиглэн дөрвөлжин болгосон нь. Ер нь 1940, 1950-иад оны үед малын үс ноосны төлөвлөгөө биелүүлсэн айлд, 1,5 ш цай, 1 дүнсэн тамхи, 1 боодол даалимбыг хонины ноосоор ороогоод тараадаг байсан байна. Хонины ноосоор ороодог нь хонь халуун хушуутай мал гэж бэлэгшээсэн нь ажээ.

³²⁶ Г.Гантогтох, Монгол зан үйлийн аман яруу найргийн уламжлал, УБ- 2006, 59 т

шийр, хавсай, боорцог, домбон сахар, торго, бөс даавууны өөдөс зэрэг бэлэг сэлт өгнө. Сартуул хамнигад шинийн 6-нд мөргөж шүтдэг их овоондоо гарч цай сэржим өргөдөг, их овоонд эмэгтэйчүүд гаргадаггүй³²⁷. Эдүгээ хамнигадын шинэлэх ёс нь идээ цагаа, зоог хүндэтгэлийн талаар монголчуудын нэгэн адил нийтлэг дэг жаягтай болжээ. Тэд шинэлж ирсэн улсуудад ойр төрлийн хэлхээ, дотно сайхан харилцаагаа харгалзан бэлэг сэлт өгнө. Ихэнхдээ хадаг, мөнгө барьж золгодог болжээ.

Анагаах мэдлэг ухааны уламжлал. Хамниганы анагаах мэдлэгийн уламжлал энгийн болхи мэт боловч урт удаан хугацааны туршид хуримтлагдсан, амьдралын туршлагад суурилсан бодит мэдлэгээс үүдэлтэй байх тул ач тус нь төдийлөн алдагдалгүй хадгалагдсаар иржээ. Хамнигад ихэнхдээ ургамал болон амьтны эд эрхтний анагаах чанарыг таньж хэрэглэж байна. Хамниганы анагаах мэдлэгийг нягтлавал, нууц увьдаст тарни домын арга, мал, ан амьтны эд эрхтэн, ургамал, жимсийг элдэв аргаар бэлтгэж боловсруулан өвчин хуучаа анагаах аргатай байна. Мал, амьтны эд эрхтнийг хатааж, буцалгаж, эсвэл амьдлаг шинжээ алдаагүй халуун сэргэг байхад нь хэрэглэхээс гадна ургамлын үндэс, навч мөчир, жимс жимсгэнийг ашиглахдаа хүч нөлөөг нь ууршиж үгүй болохоос сэргийлж сүүдэр газарт хатааж, хандлаж эсвэл буцалгаж хэрэглэдэг ажээ.

Хамниганы анагаах уламжлалд хусыг олон байдлаар хэрэглэж байхаас гадна ан амьтдаас чоно, баавгай, гөрөөсний эд эрхтнийг түлхүү ашиглаж байна. Хусны мөөг “чага”, “онгол”-ыг өвчин анагаахад тустай гэж өргөн хэрэглэдэг. Эвенгүүд хусны урыг чага гэхтэй төстэй “чара”, “чэрү”, харин якутууд чарі, чарі гэнэ. Хамгийн сонирхолтой нь якутуудтай хөрш суудаг эвенгүүд хар модны зулмыг³²⁸ мөн үүнтэй төстэйгээр “чара” хэмээн нэрлэдэг бөгөөд чара-ыг өлссөн үедээ иддэг байсан гэнэ. Якудууд чага-ыг цайтай адил чанаж хандалж хэрэглэдэг³²⁹. Хусны ур буюу мөөгийг шинжлэх ухааны үүднээс судлан элэг, дэлүү, уушиг, ходоод, улаан хоолой, 12 нугалаа гэдэс, савны хортой ба хоргүй хавдрыг анагаадаг болохыг тогтоожээ. Хэрэглээний түүх хийгээд хусны тархац байдалтай холбож үзвэл энэ уламжлал Сибирийн анчин ойн иргэдээс улбаатай гэдэг нь дамжиггүй байна. Хусны түнжийг хүн, малын гэдэс дотор эвгүйцэхэд буцалгаж өгдөг. Үе мөчний өвчинд хус, нарсны шингүүсийг хандалж дүрж шавшиж хэрэглэнэ. Хавар хус навчлаад том жижгээрээ хурган чихний хэмжээтэй болох үед нь буцалгаж уухад тамир тэнхээ оруулдаг гэнэ. Хусны шүүсийг долонгийн үед авч хэрэглэнэ. Тэдний анагаах аргад өргөн хэрэглэгддэг хусны шүүс “С” витаминаар баялаг тул дотрын өвчинд тустай болох нь өнөөгийн шинжлэх ухаанд хэдийн нотлогджээ. Цөсний өвчинд маш сайн гэж байна. Чих булагтахад тэргэл сар руу харуулж гарыг нь алдлаад чөтгөрийн бургасыг(улаан бургас) хэмжиж огтлоно. Тэр бургас хатахад чихний булаг ч хатдаг³³⁰. Судлаач Д.Тангадын тэмдэглэснээр хасаг хамнигад, хүүхдийн чих хатгаж өвдөөд байвал

³²⁷ Д.Тангад, Хамниган, МУ-ын угсаатны зүй, III боть, УБ- 1996, 360 т

³²⁸ Зулам- модны дурсны дотуурх нимгэн хальс.

³²⁹ А.Е.Аникин, Тунгусо-маньчжурские заимствования в русских говорах Сибири, Новосибирск-1990, 54стр

³³⁰ Дорнодын Баян-Уул сумын хөшүүр хамниган Инзаа Бямбын Нэргүйгээс 2004 онд тэмдэглэв.

ганцаар сондгойрч ургасан улаан бургас авч хүүхдийн толгойг тойруулж хэмжиж огтлоод уннд хавчуулж хэд хоноход тэр бургасны чийг хатах ба үүнтэй зэрэгцээд хүүхдийн чих эдгэчихдэг юм байна. Энэ нь тухайн өвчтөний сэтгэл зүйд тулгуурлаж өвчнийг нь анагаах нэгэн хэлбэр бөгөөд бид одоо ч гэсэн олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, сэтгэл зүйн холбогдолтой бүтээлээс хамниганы энэхүү эмчилгээний аргатай адилхан жишээг төвөггүйхэн олж чадна.

Дотор эрхтэн муудвал гөрөөс агнангуут аль нэг дотор эрхтэнийг халуунаар нь муудсан эрхтэний харалдаа(бөөр муу бол бөөрийг нь бөөрний харалдаа нь тавих г.м)тавьж арьсаар нь орооход үр дүнтэй эмчилгээ болдог. Гөрөөсний эд эрхтнээр эмчилгээ хийхэд салхи авна гэхгүй тул боломжтой бол хөдөө ан гөрөөлийн үеэр өвчтөнг эмнэсэн ч болдог гэнэ. Хамниганы ан амьтаны эрхтэнээр эмчлэх уламжлалаас хэдэн жишээ дэлгэрүүлвэл махан хоол шингээх нь муудвал чонын мах идэхэд сайн. Мөн гахайн эд эрхтэнийг эмчилгээнд өргөн хэрэглэнэ. Гахай агнангуут халуун ходоодыг өнгөртэй нь идвэл ходоодонд жинхэнэ эм болдог. Гахайн бөөрний өөхийг сүүнд буцалгаж унтах үедээ ууж байвал уушигны өвчин хүндэрсэн үед болон сүрьеэ өвчинг эмнэнэ. Гахайн хавдарыг гахайн соёогоор үрж домнодог, элгийг нь борцолж хатаагаад, нүдэж усанд чанаж идвэл элгэнд тустай ажээ. Шүдний өвчинг голдуу ангийн эд эрхтэнгээр анагаана. Үүнд:

- Баавгайн хатсан цөсөөр эрүүний гаднаас нь үрж арчих
- Онцгойрж ургасан далан түрүүний үндэс, зөгийн үүр зуух
- Үмхий хүрэнгийн чив шатааж зуух
- Тоншуулын хэлээр шүдээ чигчлэх
- Могойн гуужмагаар үрэх, могойг дутуу хазах зэрэг аргатай ажээ.

Хүн байгаль, ургамал амьтныг өөртэйгээ адилтган амьдчилж, зорьж хүлээсэн үр дүнгээ тухайн зүйлдээ(рашаан ус, ургамал амьтан ч юмуу) сүсэглэн мэдүүлж, өөрөө итгэж хүртвэл үр дүнгээ амархан өгдөг гэх хамниганы уламжлалт домын арга нь одоо ч хэрэглэгдсээр байгааг нь онцолвол сэтгэл зүйн талаас итгэл төрүүлэн тухайн өвчтөнд ач тусаа өгч байгааг үгүйсгэх аргагүй юм.

Монголын хамниганы хоол хүнсний хэрэглээнд мал, ан амьтан, газар тариалангийн гаралтай болон зэрлэг ургамал жимс ногооны төрөл зүйлийн аль аль нь багтаж байна.

Хэдийгээр харьцангуй цөөн хүн амтай ч гэсэн тэдний хооронд аж ахуй эрхлэлтийг дагасан хоол хүнсний ялгаа байх бөгөөд гахайн толгой эрхэмлэдэг Хэнтийн анчин хамниган Цагаан- Овоогийн хамниганы сайн мэддэг адуун төөлэйн талаар сонсоогүй байна. Хамнигад гахай агнах нь элбэг байгаа ч гэсэн толгойг нь хүндэтгэн барихаа больжээ. Гэхдээ гахайн толгой барих нь тэднийг хэрэглээний талаар буриадуудаас ялгах гол онцлогийг илэрхийлэхийн хамт энэ ёсыг ам дамжуулан уламжилж байна.

Тэдний хоол хүнс бэлтгэх арга хэлбэр нь бусад нийтлэгүүдээс ялгарах хамниганы гэх онцлог шинжээ хадгалсаар байх бөгөөд хамнигадтай хэдэн зуун жил холилдон сууж байгаа буриадууд тэдний хоол хүнсний зарим зүйлийг одоо хүртэл өөрсдийнхөөсөө илт ялгаж байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Хамниганы шашин шүтлэг

3.1. Шашин мөргөлийн түүх

1930- аад оны хэлмэгдүүлэлтийн үед сүм хийдийг олноор устгасан үйл явц хийгээд түүнээс хойш 1990 оны ардчилсан хувьсгал хүртэл үргэлжилсэн шашингүйн үзэл нь хамниганы уламжлалт шашин мөргөлийн ёсыг мартагдуулжээ. Гэсэн ч тэдний шашин шүтлэг нь 1990-ээд оноос хойш аажмаар сэргэж эдүгээ өөрийн гэсэн дүр төрхийг олж байна. Тэдний уламжлалт соёлын хөгжилд зөвхөн 1930-аад оны улс төрийн үйл явц саад тотгор учруулаагүй юм. Сибирийг бүх талаар эзлэн авах гэсэн хаант Оросын тал эхнээсээ л хамниганы болон Сибирийн бус төрөлтнүүдийн соёлыг үе шаттайгаар устгах бодлого баримталж ирсэн байдаг.

1730- аад оны үед Өвөр Байгалийн ойролцоох нутгуудад лам хуврагууд олширч, бурхны шашин дэлгэрч эхлэжээ. XIX зууны эхэн үеэс хаант Оросын Засгийн газар Байгалийн тойрон суух буриад, хамниган бөө нарыг гадуурхан, бөө мөргөлийг хүчгүйдүүлж устгах бодлого идэвхтэй явуулах болсон байна. Энэ тухайд буриадын сурвалжид, мөн үед сонгоол Брайбун хийдийн лам нар бөө мөргөлтэй тэмцэл хийн, 1820 оноос эхлэн Сэлэнгэ, Хори нутгуудад, 15 эцэгт, хасаг буриадуудад Баргажин, Цээж, Түнхэн, Алайрт онгоны дүр дүрс, бөө удганы зэмсэг хэрэгсэл цөмийг нь шатааж, тэрнээс хойш бөө удганы тухайд дуулдах үзэгдэх юмгүй болсон³³¹ гэсэн байдаг. Сибирийн уугуул угсаатнуудын оюуны соёлын үндэс болсон бөө мөргөлийг устгахтай зэрэгцээд бурханы шашин хүчтэй дэлгэрч эхлэсэн байна. 1814 оноос нэн хожуугүй хамнигад Хужирт, Тарвагатай, Барисаанайд, хасаг хамнигад³³² Олхоной, Зугаалайд шарын шашины дацантай болжээ. Монголын үзөөн харчин дооромбо лам Галсан Содов 1841 онд Нерчүгийн хамнигадын дунд шарын шашин дэлгэрүүлэх үйл ажиллагаа идэвхтэй явуулснаар XIX зууны сүүлч гэхэд Нерчүгийн тойрогт Агын, Сүүгэлийн хоёр том

³³¹ Буряадай түүхэ бэшэгүүд, Улан-Удэ-1992, 142 т

³³² 15 эцгийн хамниган.

сүм байгуулагдсан байжээ³³³. Хамнигадын Буриад-монголын автономийн харьяат байх үеийн гол шүтээний газар нь 1802 онд байгуулагдсан Гүнэй, Тугчинхийд байсан байна. Тугчин хийдэд 50 орчим хамниган лам уншлага хийдэг, нийтдээ хорь гаруй байшинтай суурин маягийн байжээ. Тус хийдэд чойжин буудаг, Лхам бурханы сахиустай байсан байна. Дүйнхор, Найданжүдүг бурханы эртний хөрөг Тугчин хийдэд хадгалагдаж байсан ажээ. Дацангийн хаалган дээр бишгүүр үлээсэн сахиусан тэнгэрүүд үүлэн дунд байгааг харуулсан зураг байсан гэнэ. Тугчин хийдээс холгүй Гүнэй дацан байрладаг байжээ³³⁴. Мөн Онон мөрний хөвөө, Сүүгэл горхины адагт 1834 онд байгуулагдсан Даш Чоймполлин хийд нь тухайн үедээ буриад, хамниганы шарын шашины томоохон төвийн нэг болж байв. Ийнхүү зуугаад жилийн дотор зарим талаар хаант Оросын дэмжилгээр гэж болох нөхцөлд, ...*Орос гүрний харьяат Зүүн Сибирийн буриад- монголчуудад, хамнигад 7 үеийн хамба нар ламын шашныг мандан бадруулсан*³³⁵ байна. XIX зууны эхний хагасыг хамнигадын дунд бурханы шашин эрчимтэй түгэн дэлгэрсэн үе гэж болох юм. 1846 он гэхэд буддын дацан 34, бага сүм 144, Анаагын Хорид - 759 лам, Агын Хорид - 162 лам, 15 эцэг(буриад болсон хамниган)-т – 365 лам, Баргажанд- 53 лам, Алайрт- 37 лам, арван найман отгуудад - 3173 лам нийт 4549 лам нар байжээ. Гэтэл I Николай хаан Дорно зүгийн Сибирийн буддын шажинтны талаар 1853 оны 3 сарын 18-ны өдөр 61 тоот зарлиг гарган бүх буддын шажинтанд нийт 320 лам нар байхаар тогтоож үлдсэн лам нарыг нь хар болгохоор шийдвэрлэсэн байна³³⁶. Үүнээс хойш оросууд Сибирийн шашин мөргөлийг хянаж эхлэн, хар болсон лам нарыг лам хувцас өмсөх, ном уншлага хийх мөн жирийн олныг ламын хувцсанд оролцдог улаан өнгөтэй хувцас өмсөхийг нь хорьж, шашины ном хэрэглэлийг устгаж эхлэжээ. 1871 онд Сибирийн генерал - губернатор Н.П.Синельников буддын шажинтны араас маш их мөрдлөг хийж, буриад- монголчууд ба хамниганы овоо тахилын газрыг оросын номлогчид(миссионер) болон загалмайтны шашинд орсон буриад ахмадуудтай нийлж шатааж байсан гэдэг³³⁷. Үүнийг тэсвэрлэхэд бэрх болсон учир Сэлэнгийн 18 отог, 15 эцгийн хамниганаас томилогдсон итгэмжит төлөөлөгчид Санкт-Петербург хотноо очиж 1872 оны 9 сарын 30- нд II Александр Николаевич хаанд бичиг захидал өргөсөн боловч ямар ч хариу шийд ирүүлээгүй байна. XX зууны эхэн гэхэд Өвөр Байгальд бөөгийн мөргөлтөн - 3539, буддын шашинтан - 161658, үнэн алдартан - 29165 байжээ. Бурханы ёс дагагсад Байгалийн өмнөдөд таван ухааны сургууль хийдэг 32 дацантай³³⁸ болсон байсан гэнэ. Дээрх хүнд бэрх хавчилгыг туулж явсан хамнигад Монгол улсад ирэхээс өмнө болон ирсэн хойноо ч гэсэн буриад-монголчуудаас тусдаа хурал номын газартай байжээ. Өнөөгийн Хэнтий аймгийн Биндэр сумын төвөөс зүүн тийш Балжийн голын баруун талын

³³³ Потанин, Из путешествии по восточной Сибири, Монголии, Тибети и Китаю, 1896, 16 т

³³⁴ Ж.Цыбен, Путевые дневники 1903-1907 гг. ред-Ванчикова.Ц.П. Улан-Удэ- 2001, 138,284-285,352 стр

³³⁵ Буряадай түүхэ бэшэгүүд, Улан-Удэ-1992, 150 т

³³⁶ Буряадай түүхэ бэшэгүүд, Улан-Удэ-1992, 149 т

³³⁷ Буряадай түүхэ бэшэгүүд, Улан-Удэ-1992, 50 т

³³⁸ Ж.Цэвээн, Оросын албат буриад нарын орших ёсон амой, Наран-1908, 9- 10 т

Амгалант горхинд хуучин Балжхаан харуулаар нутаглаж байсан хамниган лам нар цугларч хурал мөргөл хийж байсныг гучаад оноос Амгалантын дуган гэж нэрлэх болжээ. Энэ хийд 3, 4 том дугантай, хийдийн дэргэд майдар эргэдэг байжээ. Амгалантын хийдэд Дамба, Бүд, Анганай Дамдинсүрэн, Чойжил, Цагаан зэрэг томоохон хамниган лам нар уншлага ном хурдаг байснаа, 1930- аад оны хэлмэгдүүлэлтийн үед бүгд баригдаж үрэгдээд, тэднээс Цагаан гэлэн ганцаараа үлдэж 1950-иад онд 90 гаруй настайдаа өөд болсон байна. Хэлмэгдүүлэлтийн үеэр Биндэрийн хамниганы Амгалантын дуганг нураахад тэндхийн хурлын ном судрыг үлдсэн үр хүүхдүүд нь уламжлан авч баруун Манхаадайн Хөх үзүүр(Мянган модот) гэдэг газарт холтсон дуган барьж түүндээ хадгалж явсан байна³³⁹.

Дорнод аймгийн Цагаан- Овоогийн хамнигад Монголд ирсэний дараагаар 1937 оныг хүртэл Егүзэр хутагтын хийд болон Хэрлэнгийн урд хөвөөнд байх Тугийн хийд³⁴⁰ (Чингисийн хийд)-эд мөргөдөг байжээ. Энэ хийд нь дан ганц буриад, хамнигадын мөргөлийн газар биш бөгөөд халхчуул ч өргөн очдог тэр үеийн томоохон хийдийн нэг юм. Сэцэн ханы чуулган даргын газраас Тугийн хийдэд Чингис богдын тахилга хийдэг байсан, энэ аймгийн эргэл мөргөлийн томоохон төв байжээ. Энэ хийдийн дуганы барилгууд бүгд цагаан өнгөтэй. Чингис богдын баримлыг гол дуганы хойморт залж, түүний зүүн урд талын дуган дахь ханын тааз тулган хийсэн жаазтай тавиуруудад сайн цагийн мянган бурхан гэж олон бурхан залсан байжээ. Дуганы дэргэдэх хийдийн сууринд хятадын “алавхи” ~ “лавки” (худалдааны жижиг мухлагийг буриад, хамниганчууд ингэж нэрлэдэг) байна³⁴¹. Тугийн хийд буюу Чингисийн тахилын сүмийг 1937 оны үед нураажээ. Тугийн хийдийн оройд байрлуулж тахиж ирсэн Чингисийн туг гэж нилээд том хар сүлд одоо Үндэсний Түүхийн Музейд хадгалагдаж байна.

Хараа, Ерөөгийн хамнигад нь өндөр Богдын анхны шавь болж явсан учир тэдний дунд шарын шашин давамгайлж байсан нь ойлгомжтой. Ерөөгийн хамниганы эргэл мөргөл хийдэг Ходоодын дуган гэж байсан байна³⁴². Мөн Сэцэн ханы хамниган Цэнхэрийн голын эхээр Даянт³⁴³ гэдэг газарт хамниган лам нар хурал хурдаг дугантай, тэр дуган нь Шадублин гэдэг нэртэй байсан гэнэ. Хорь, гучин ламтай, бас нэг хэсэг нь Брайбун (Бэрээвэн) хийдэд сууж байжээ. Энэ дуганы сахиусанд нь хар гөрөөс(баавгай) чоно хоёрын чихмэл байсан нь, хамниган отгийн дарга Балбар галзуу чоно алаад чихмэл болгож өргөсөн нь энэ гэнэ. Даянтын хамниган хурал нь анх модон гэртэй байснаа сүүлдээ дөрвөлжин модон дугантай болсныг нь цөм хамниган дархцуул бүтээсэн³⁴⁴ажээ.

Монголын хамниганы дунд шашин мөргөлийн нэгэн ёс овоо тахилгын уламжлал хадгалагдаж байна. Шарлангийнхан(намиад) ар Минжийн голын савд

³³⁹Хэнтийн Биндэр сумын багш нар овгийн Х.Батмөнхөөс тэмдэглэв.

³⁴⁰ Энэ хийд нь Хэрлэн Бар хотын түүрх, шар тоосгон барилгын ойролцоо байжээ.

³⁴¹ О.Баттуяа, Хэнтий, Дорнод аймагт хийсэн судалгааны гар бичмэл, 2004

³⁴² О.Баттуяа, Сэлэнгийн Ерөө, Хүдэрт хийсэн судалгааны гар бичмэл, 2007

³⁴³ Энэ нь өмнө бүлэгт гарсан Сэцэн ханы хамнигадын нутаг Шургуйтын өмнөх Даянт гэх газар юм. Гүн Гончогцэрэнгийн хошууны нутаг ажээ.

³⁴⁴Б.Ринчен, МАУ-ын хамниган аялгуу, УБ- 1969, 58т

байдаг Минжийн буурал буюу сүрлэг өндөр тахилгат Богд- Очир гэдэг уулыг тахиж идээнийхээ дээжийг өргөдөг байсан гэнэ. Ерөөгийн хамнигад Дөрвөн овоо, Үзүүрийн овоо, Бэрлэгийн Арцын овоо, Ялбагын Хөшөөт, Цагаан чулуут, Баянтөгөл, Тахилго овоог тахидаг байжээ. Талын овоог их овоо гэж тахидаг байсан нь 1941-1942 оны үед түймэрт автахад хамниган нар бидний энэ овоо 216 жил болоод хайллаа гэлцэж байсан гэдэг³⁴⁵. Үүнээс үзвэл, уг овоог 1725 оны үед босгосон бололтой. Тэдний хуучилснаар, Ходоодод Хөөврийн овоо гэж хамнигадын яггүй хатуу овоо байдаг байсан ажээ. Халхын Сэцэн хан аймгийн дархан бэйл Сэрээтэрдоржийн хошуу, хожимын нэр нь Хан Хэнтий уулын аймгийн Хан Хэнтий уулын хошуу одоогийн Төв аймгийн Мөнгөнморьт сумын Тэнүүн-Зүлэгтийн голын сав нутагт Эрээн модны овоо гэдэг ноёлог, өндөр нэгэн уулыг уг хошууны Хамниган отгийнхон, эрт дээр үед Эрдэнэцогт гэдэг нэр өргөмжилж, зуны дунд сарын эхээр буюу идээ цагаа дэлгэрч цонхрын хонь чөмөглөсөн үес жилд нэгэн удаа лам нараар тахиулдаг заншилтай байжээ³⁴⁶. ХХ зууны эхээр нүүдэллэн ирсэн Хэнтийн хамнигад Биндэрийн нутаг Амгалантын Мөнх овоо, их Талын Цагаан овоо, Баян хан, зүүн Баянхан, Жараан овоог³⁴⁷ бөө болон лам нараар тахиулж байсан гэнэ. Монгол нийтээр шашин, мөргөл хориотой үед орхигдоод байсан хамниганы овоо тахилгын уламжлал одоо дахин сэргэж, Биндэрийн нутаг их Талын бага Могойтод байдаг Цагаан овоог [Талын овоо ч гэнэ - О.Б] тэндхийн хамнигад хэд гурваараа нийлээд, зуны эхэн сарын шинийн 15-ны дотор 3 хонины шүүс өргөж, 3 идээ засаж, бөө бөөлүүлж тахидаг болжээ³⁴⁸. Тахилгын дараа идээ цагаагаа хувааж, тахилгад тавьсан 3 хонины төөлэйг нэг нэгээр нь айлд оноох бөгөөд тэр гурван айл нь дараа жилийн тахилгын шүүс бэлддэг ёстой гэнэ. Овоо тахилгын үеэр морь уралдаж, бөх барилдана.

Дорнод аймгийн хамнигад Тугийн хийдээс зүүн урагш Булган сумын нутагт байх Тугийн овоог тахидаг байжээ. Дорнодын Цагаан-Овоогийн нутагт байх

³⁴⁵ С.Бадамхатан, Сэлэнгэд хийсэн судалгааны гар бичмэл, 1963

³⁴⁶ Ц.Дамдинсүрэн, Мандах нартай үлгэрлэе, УБ-1968, 106 т

³⁴⁷ Жараан овоог 60 хониор тахидаг байснаас ингэж нэрлэдэг болсон гэнэ. Овоог олон тооны мал егүүтгэн тахиж нь Байгалийн ойролцоох угсаатнуудын дунд бөөгийн мөргөлийг хорьж цагдан, шарын шашин дэлгэр болохын өмнөх үед ихээхэн түгээмэл байжээ. Энэ нь бөөгийн тахилгат уул овоог олон амьтны амиар өргөл өгч номхотгон дарж авах утгатай холбоотой бололтой. Буриадын түүхийн сурвалжид тэмдэглэснээр бурхны шашинд дагахыг дурлагчид нь маш олон амьтныг алж тайлга хийх ба хэдэн үе амьтныг алж хэзээ бүхнээ архиар сацул барьж өөбсэдээ их бага, эр эмгүй архид орсон иргэд амой. Үлгэрлэвээс, Байтаг хэмээх нэг хадат уулыг 250 орчим гүү, 400-500 хонийг нэгэн дор нэгэн цагт нэгэн дохиогоор өрлөж алж тахидаг. Мөн Хашиа хэмээх уулын эзнийг тахигдаа хэдэн зуун хонь, 40 гаруй адууг алдаг бөгөөд хоньдын заримыг халуун усаар зулмаж, зарим хонины хоолойг хялгасаар боож, 4 хөлийн шилбийн арьсыг хөндийлж тэр нүх рүү нь үлээн үлээсээр хонины арьсыг биеэс хууртал үлээхэд, хонин тэсгэшгүй зовлонг болж, бөмбөг мэт тэсхийж үхдэг байна. Ж.Цэвээн, Оросын албат буриад нарын орших ёсон амой, Наран-1908, 16-17 т. Санаанд багтамгүй энэ заншил Байгалиас баруун тийших барга, буриад нарын дунд байсан гэнэ.

³⁴⁸ О.Баттуяа, Хэнтийд хийсэн судалгааны гар бичмэл, 2005.

Мандал овоог 1930- аад оныг хүртэл тэндхийн хамниган Маджа, улиад хамниган Намхианууд³⁴⁹ голлон тахиж байсан гэнэ.

3.2. Хамниганы бөө мөргөл

Хамнигадын мартагдаж орхигдсон уламжлалт соёл тэр дундаа бөө мөргөлийн ёс 1990-ээд оноос хойш өөрийн гэсэн онцлог өнгө төрхийг агуулан сэргэж байна. Хамниган бөөгийн чанарын зан үйл, хувцас эдлэлийн зарим зүйлд Монголын бусад угсаа нийтлэгүүдээс ялгагдах хэд хэдэн онцлогууд хадгалагдаж байдаг.

Хамниган бөөгийн чанар³⁵⁰- ын зан үйл. Хамнигад, эрдэмтэн О.Пүрэвийн, “Харын, шарын ялгаагүй монгол орны бүх нутгийн бөө ерөнхийдөө бөө болдог нэг л замтай. Энэ зам нь юуны түрүүнд ямар ч эмчилгээ авдаггүй өвчнөөр өвчилдөг. Тэгээд бөөд үзүүлтэл биед нь онгод нөхцөж шүглэсэн байна гээд бөө болохыг зөвлөнө. Дараа нь зөвлөсөн ёсоор нь бөө болсоноос хойш урьдын бүх өвчин аяндаа илааршиж бие нь бүрэн сайжирдаг” гэж тодорхойлсон энэ л замаар бөө болцгоож байна. Өөрөөр хэлбэл, биед нөхцсөн онгод тухайн хүнийг бөө болохоос өөр замгүй болтол нь хорлох тул элдэв гай зовлонд хашигдсан нөгөө хүн “чанар” гэх нэгэн ёслолыг заавал гүйцэтгэх замаар, өөрийн хүсэл зоригоос үл хамааран бөө болдог ажээ. Заавал үйлдэх энэхүү заншилыг судлаачид, чанар хийх ёслол бол үндсэндээ шавиас жинхэнэ бөө болох хүртэлх үе шаттай удаан хугацааны туршид үйлдэх ёслол гэж тайлбарласан байна³⁵¹. Чанар хийснээр тухайн бөө болж байгаа хүн угийг нь барьсан онгод тэнгэрийнхээ увидаст чадлаас өөртөө шингээж чадал чансаагаа нэмүүлэх бөгөөд хамниган бөөгийн чанарыг холимог чанар, хамниган чанар гэж хоёр өөрөөр нэрлэж байна. Буриадын сурвалжид өгүүлсэнээр, урьд гурван есөн хорин долоон модыг үндэстэй нь сугалж авчраад, навч мөчирийг нь нар буруу мушгиж, зүүн зүгт хандуулан ес есөөр нь эгнүүлэн зоож, нүүрний есөн модонд хүрэн арьс, удаахь есөд нь хар гөрөөсний (баавгай) арьсны өөдөс, дараагийн есөд нь хар хөх бөс даавуу уяж бэлдсэнээ “хамниган гарвалын чанар” гэдэг байжээ³⁵². Хамниган бөө нарын чанар нь дээрх “хамниган гарвал”-ын чанараас төдийлөн өөрчлөгдөөгүй байна. Тэд энэхүү хамниган гарвалын чанартай адил дэрбүлгэ гэж 27 тооны хар мод, мөн дээр нь эх, эцэг, үүр мод гэж зоож чанараа хийдэг. Буриад бөөгийн ёсонд чанарын модыг хамнигад шиг “дэрбүлгэ” гэхгүй “дэрбэлгэ” гэж нэрлэж

³⁴⁹ Маджанууд, Намхианууд, Нямнууд гэж Цагаан-Овоогийн хамниган, буриаднууд ярьдаг. Энэ нь тэднийхэн, эднийхэн гэсэн төрөл садны сүлбээгээр нь хамаатуулж хэлсэн нь юм. Бусад нутгийн буриад, хамнигад нь – *тан (тэн, тон)* гэсэн дагавар залгаж хэлдэг онцлогтой. Жиш, Маджаатан, Намхиатан г.м.

³⁵⁰ Бөөгийн энэхүү зан үйлийн “чанар” гэдэг нь “танара”- (тэнгэр бурхан- якуд; бурхан, бурханы дүр[хөрөг]- эвенг), тэнгэри- (тэнгэр, бурхан- буриад-монгол) гэсэн утгатай холбогдож болох юм.

³⁵¹ Б.Бадма-Оюу, Буриад бөөгийн “чанар хийх” зан үйлийн тухайд, Угсаатан судлал, Томус XIII, Fasc.1-22. УБ-2001

³⁵² Буриадай түүхэ бэшэгүүд, Улан-Удэ-1992, 55т

байна. Чанарын дэрбэлгэ-ийн тухайд, - онгод буумал хийгээд уг язгуураа хүндэтгэн уулын хусан найлзуур модыг чимэг яндар зүүж тахил өргөн, бөө бөөлж, чанар үйлддэг ес, хорин долоо, жаран гурав, наян нэгэн тоот хус модыг “дэрбэлгэ” гэнэ. Дэрбэлгэ нь бөөгийн чанар хийх шат шатаас шалтгаалан янз бүрийн тоотой байна. Нэрний тухайд дэ-язгуурт дэ-р-бэ-лгэ гэсэн бүтэцтэй жинхэнэ нэр үг бөгөөд дэгдэх, дэгэх, дээш, дэгдлэг, дэврэх, дэвэх, дэгжих, дэлэх гэх мэт дэ-язгуурт үгстэй төрөл болно. Дэрбэлгэ нь сүнс, онгод, сахиус тэргүүтэн чанарын модонд цугларан бөөгийн чанарыг дэгдээж, тэнгэрт хүргэх учиртай модон шүтээн, угийн гарвал унгийн шүтээнээ шүтэж узуураа хүндэтгэж байгаа модны шүтлэг³⁵³ гэсэн байдаг.

Зарим хамниган бөө нар чанар хийхдээ дэрбүлгэ-ийг хар модоор, үүр модыг хар мод юмуу хусаар, эх, эцэг модыг нарс гэсэн гурван төрлийн модоор төлөөлүүлдэг бөгөөд үүнээс нь үүдээд “хολимог чанар” гэж нэрлэж байна. Асар сартуул овгийн бөө Ж.Дэмбэрэлсайхан чанар хийхдээ, дэрбүлгэ-ийг 5 нарс, 4 хусаар, зарим үед бүгдийг нь хусаар төлөөлүүлдэг гэж байв. Харин удган Г.Мөнхзул эх, эцэг, үүр, цэргэ, 9 ширхэг дэрбүлгэ гээд нийт 13 хус хэрэглэх бөгөөд хэдэн чанар хийсний дараа, онгодын хэлж зааснаар дэрбүлгэ-ийнхээ тоог нэмэгдүүлэх учиртай гэнэ. Хар мөрний ороchonууд, бөөгийн зан үйл гүйцэтгэхдээ хамнигадын адил 27 хар мод хэрэглэдэг. Тэд чалбон³⁵⁴ (үүрийн цолмон) одыг хүртэл 27 “тагу”-буудал зам туулна гэж үздэг бөгөөд энэхүү 27 “тагу”-г мөн тооны хар модоор төлөөлүүлсэн нь энэ ажээ. Чалбон хүртэлх хорин долоон тагу буудал зам нь бөөгийн туулдаг замаас хамгийн уртад тооцогдоно. Хар модоор төлөөлүүлдэг нь, ороchonууд, бөөгийн онгод хар модны хөндийд оршдог гэж үздэгээс үүдэлтэй ажээ³⁵⁵. Мөн Буриад, хамниган бөө нар чанар хийх үедээ үүр модноос эхлүүлэн эх, эцэг, дэрбүлгэ-ийг дараалуулж бүх модыг алтан мөнгөн дунгуй гэх улаан утсаар(зарим нь 5 өнгийн утас томж хийсэн байдаг)холбоод, тэр утсаа урт сайхан жолоо гэж нэрлэж байна. Манай судалгааны үед, нэгэн буриад бөөгийн онгод нь орохгүй байсан тул өөр бөөд онгодыг нь оруулаад – ямар учираас онгод тэнгэр нь буухгүй байгааг лавлахад, чанарын дэрбэлгэ модны нэгийг дунгуй утсаар холболгүй үлдээсэн учир онгод нь буухгүй саатсан гэж байв. Өөрөөр хэлбэл улаан дунгуй нь онгод тэнгэрүүдийн дамждаг зам гэж ойлгогдож, тэрхүү зам тасалдсанаас уг бөөгийн онгод нь буухгүй байсан ажээ. Баеид хамниганы Г.Байгальмаа удган, угийн толгой онгод Жавзандолгорыг:

Долоон мүшин дамжлагатай

Хүнэ үүлэн гишгүүрэтэй

Хөрст дэлхий буудалтай

Үргэн хүндэй нуудалтай

Сомолтын басган Жавзандолгор авжаа ... гэхчлэн дуудаж байлаа.

Удган Г.Байгальмаагийн онгод тэнгэрийн дуудлага дахь тэнгэр газрыг дамнасан

³⁵³ Г.Гантогтох, Монгол зан үйлийн аман яруу найргийн уламжлал, УБ- 2007, 210т

³⁵⁴ Чалбон- Венера буюу Үүрийн цолмон од.

³⁵⁵ А.М.Мазин, Традиционные верования и обряды эвенков-орочононов(конец XIX- начало XX в), 1984,10стр

орон зайн ойлголт болон хамниган, буриад бөө нар хэдэн чанар хийгээд онгодынхоо заавраар дэрбүлгэ, дэрбэлгийн тоогоо нэмдэг зэрэг баримтыг харьцуулж үзвэл, хамниган бөөгийн ёсонд чанар хийж дэрбүлгэ нь олшрох хэрээр тухайн бөөгийн туулах зам уртсаж, чадал чансаа дээшилж, далд юмсын чанадад хүрэх увьдаст чадвар нь нэмэгддэг болох нь харагдаж байна. Иймд хамниган бөөгийн чанарын дэрбүлгэ нь угийн гарвал унгийн шүтээнээ шүтэж узуураа хүндэтгэж байгаа модны шүтлэг болохоос гадна онгод тэнгэрийн буудал, дамжлагыг бас билэгдэх ажээ.

Чанар хийж байгаа бөөгийн онгод нь орохоор эцэг модонд, удган нь эх модонд дүүлэн гарна. Зарим үед тэр онгод биед нь буухгүй хэдэн өдрийг барах бөгөөд шалтгаан нь тухайн онгодын ааш авир, эрдэм чадал эсвэл чанарын зан үйлийн дэгийг алдаа мадаггүй баримталж чадсан эсэхээс үүддэг байна. Улаач буюу бөө болж буй хүн онгод тэнгэрүүдтэй холбогдсоноор тэр онгодууд нь хүндлэл болгон бэлдсэн идээ шүүсийг хийгээр хүртэн, угийг нь барьж, зовлон гэмээсээ салах гэсэн улаачийн хүсэлтийг хүлээн авч,

Чанар дээр нь чанар нэмж

Чадал дээр нь чадал нэмж

Хүч дээр нь хүч нэмж

Хүсэл дээр нь хүсэл нэмж чанарын хэргийг гүйцэлдүүлдэг ажээ.

Эдүгээ хамниган бөө нарын цөөнгүй хэсэг нь Дорнодын Баян- Уул сумын нутаг Хархираагийн бөөгийн сууринд чанараа хийж байна. Тэндхийн буриад, хамниган, халх зэрэг бөө нар чанар хийхдээ салаа намиа нь гэмтээгүй залуу шинэс, хусыг үндэстэй нь сугалж эцэг, эх, үүр, дэрбэлгэ(дэрбүлгэ) мод болгон хэрэглэж байсан тул уулын модыг олноор сүйтгэлээ гэж дээд тэнгэрээс зэмлэл хүртжээ. Иймээс 2003, 2004 оноос эхлэн Хархираад чанар хийдэг бөө нар модыг үндсээр нь сугалж авахыг больж, зөвхөн бага хэмжээгээр мөчирлөн бэлтгэж, сорогчинд³⁵⁶ зүүгээд чанарын цэргэ(хардуул), үүр, дэрбэлгэ(дэрбүлгэ) модыг төлөөлүүлүүлэх болжээ(Зураг- 18). Эдгээр нь байгаль дэлхийтэй харьцах хэрэглээний нэгэн дэвшил, нөгөөтэйгүүр хамниганы төдийгүй Монголын бөөгийн чанарын зан үйлд гарсан томоохон өөрчлөлт юм. Харин эцэг, эх модыг баруун, зүүн талдаа 13 гишгүүртэй эгц босоо шат бүхий индэрээр орлуулж, бөө нар нь тус индэрийн баруун талын 13 гишгүүрээр, удгадууд нь зүүн талын 13 гишгүүрээр дамжин индэр рүү дүүлдэг болжээ. Индэрийн шатыг 13 гишгүүртэй хийсэн нь бөө хүн 13 чанар хийж байж чадал чансаа ханадаг гэдгийг билэгдсэн байна(Зураг-19). Энэ өөрчлөлттэй холбогдоод:

... Арын модыг оромдсон

Агар зандан индэр

Хөвчийн модыг оромдсон

Хүрэн зандан индэр ... гэх магтаалын шад бөө нарын дуудлагад хэлэгдэх болжээ. Арван гурван гишгүүрт шатны дор харалдаа 1x4 м хайрцагласан талбайд жижиглэж хагалсан шил асгасан байдаг нь бөөгийн онгод

³⁵⁶ Энэхүү шонг буриад бөө нар сорогчин гэж нэрлэж байна.

орж шат өөд өгсөхөд шилэн дээр гишгэдэл таарах тул, улаачид онгод гүйцэд орсон эсэхийн шалгуур болгож байгаа нь тэр гэнэ.

Хамниган бөө нарын чанарын зан үйлд аав, ээж, есөнчин гэж хэдэн хүн заавал оролцдог. Чанарын аав, ээжийг амьдрал тогтсон, элэг бүтэн хүмүүсээс сонгохыг эрхэмлэнэ. Есөн бяцхан хүүхдийг “есөнчин” болгох бөгөөд есөнчиний тоо хүрэхгүй бол хусны үйсээр хүний дүрс хийж есөнчин багачуудын хувцасны ард зүүж тоог нь гүйцээдэг. Есөнчингүүд чанар хийж байгаа бөөг даган дэрбүлгэ модыг тойрон гүйж, хэц хэнгэргийн дууг хүчжүүлж уг барьж буй бөөгийн биед онгод ортол түүрээнэ. Түүхийн тодорхой үед буриад хамниганы дунд гарсан зөрчилдөөнтэй холбоотойгоор хамниган багачуудыг, буриад бөөгийн чанарын есөнчинд багтаахгүй, эсвэл есөнчинг ахлуулахгүй гэж онгодууд дургүйцсэн тохиолдол гарч байжээ.

Чанар болон бусдын засал хийсний дараа хэрэг бүтсэн эсэхийг нягтлахдаа нэгэн модон тагшинд сүү хийж, дээр нь ганга үйрүүлж нэмээд хэнгэрэг дээрээ тавин даллаж шиддэг. Шидсэн тагшны амсар дээш харж буувал зорьсон хэрэг бүтлээ гэх ба уг тагш хөмөрч буусан байвал санасан зорьсон нь гүйцэлдсэнгүй гэж үзэн шалтгааныг нь олж шаардлагатай гэсэн зан үйлийг давтан хийж чанарын хэргээ гүйцэлдүүлнэ.

Буриад, хамниган ялгалгүй чанараа хийж дуусаад “шунгалаг” хэмээх нэгэн ёслол үйлддэг. Энэ үеэр:

Зээлэ зээлэ зээлэхэн

Зэд улаан хацар шавхдалтай

Зэрэглээ цагаан шүдээр хазалтайхан

Зээлэ зээлэ зээлэхэн... гэж хонины хошноогоор улсуудын хацрыг зөөлөн гуядахад хэн тэрнээс хазаж ам хүрч чадна түүнд буян заяа тогтоно гэж билэгддэг. Амар хавийн болон Олекмийн эвенгүүд баавгай уг нь хүн байгаад “сэвэк”(онгод)-ийн хорлол хүрч бүх бие нь үс ноостой болсон юм. Баавгай хүн байсан учираас хүний үг хэлийг сайн ойлгоно, бас өөрийн гэсэн дуутай тэр нь “зэлэн, зээлэй” гэх мэт сонсогддог. Иймээс Олекмийн эвенгүүд баавгайтай таарах юм бол “зэлэн зээлэй, Хурукэл тала, хурукэл зулави!”³⁵⁷ (Зэлэн зээлэй, эндээс яв, гэртээ харь! гэсэн утгатай) гэж хашгирдаг ажээ. Хамниган бөөгийн түрлэг нь эвенгүүдийн баавгайн дуун түрлэгтэй холбоотой бололтой.

Хамниган бөө нар чанар ханасан удганыг “дуулин”, буриадууд “дуурисха”³⁵⁸, чанар ханасан бөөг хамниган, буриад ялгалгүй “зайран” гэж байна. Хамниган бөө нар хэц хэнгэрэгээ цохиж эхлэнгүүт дуудлага аяндаа орж ирэх ба онгод орох үед аажмаар ухаан балартан өөрийн үйлдэл, хэл яриаг хянаж чадахаа больдог гэнэ. Энэ үед сүсэгтэн олныг онгод тэнгэртэй холбон хэлмэрчилж байдаг тусгай хүн заавал хэрэгтэй болох бөгөөд хүмүүс түүгээр

³⁵⁷ Г.М.Василевич, О культе медведя у эвенков, Религиозные представления и обряды народов Сибири вXIX- начале XX века. Ленинград-1971, 159 стр

³⁵⁸ Бүх сахилуудад хүртээгдсэн, дээд зиндааны бөө. Буряадай түүхэ бэшэгүүд, Улаан-Үдэ-1992, 233т

дамжуулж онгодтой харьцах ёстой. Тэр хэлмэрчийг тулмааш³⁵⁹ гэнэ. Г.Мөнхзул удган өөрийн тулмаашийг онгодын хэлсэнээр, жил мэнгээр нь тодруулж олж авсан байна. Хамниган бөө нар бусад бөө мөргөлтний нийтлэг жишгээр 5 сарын 22- нд тэнгэрийн үүд нээгдэж, 9 сарын 22- нд тэнгэрийн үүд хаагдана гэж үздэг тул энэ хооронд амжиж чанараа хийдэг.

Хамниган, буриадын бөө, удгад хэдэн чанар хийсний дараа гаанс зуусан, нүд, ам, сахал, хөмсөг бүхий хүн дүртэй гуулин баг хийж амилуулаад Авгалдай гэх онгод оруулж эхэлнэ.

Энэхүү Авгалдайг өнө эрт нөхцсөн бөөгийн догшин сүнс³⁶⁰, хорь буриад түмний дунд сахалт баавай гэж алдаршсан онгон сахиус, хорь арван нэгэн эцгийн онгод шүтээн гэсэн байдаг. Гэхдээ Авгалдай нь буриадын бөө нарт ч биш хамниганы бөө нарт мөн хамаарах бөгөөд Авгалдайн талаарх домогт өгүүлснээр бол энэ онгод нь урьд хамниган хүн байсан гэдэг.

Авгалдай онгодын тухай буриад ба хамнигадын дунд хэд хэдэн хувилбартай аман түүх яригдаж байгааг тодруулбал, эрт цагт Авгалдайг маханбодот хүн байх үед, түүний эхнэр нь охиноо дагуулаад төрхөмдөө айлчилахаар явж, Авгалдай Алтан шаахай нэрт хүүгээ хараад, долоон хүйлэн хонио хариулаад үлдсэн гэнэ. Авгалдай тамхинд их дуртай хүн байж л дээ. Эхнэрийг нь төрхөмдөө явсан хойгуур Туралин³⁶¹ бөө Авгалдайг хорлох гээд навчин тамхи зуугаад шувуу болж өмнүүр нь нисчээ. Авгалдай харцага болж хувираад түүнийг хөөгөөд тамхийг нь булааж аваад эргэж иртэл Алтан шаахай хүү нь далайн усанд живж үхсэн, долоон хүйлэн хонийг нь чоно бариад идчихсэн байжээ. Авгай нь тэнгэрийн охин тул увьдис чадлаараа болсон явдлыг нэгд нэгэнгүй мэдээд ихэд уурлаж Авгалдайг далайн ольтирог дотуур хөөж гүйцээд тарианы шимээсэг(дугуй хадуур)-ээр толгойг нь тас цавчаад модонд өлгөчихсэн гэдэг³⁶² ажээ.

Хамниган, буриад бөө нарын Авгалдайн дуудлагад түүний амьд ахуйдаа хэрэглэж байсан эд зүйлийг нь багтаан,

....Морины годон алчууртай

Мольчио модон трубкэтэй ... гэж дурьдаж байдаг.

Энэ дуудлагад гарах “алчуур” нь тамхины уутыг хэлсэн хэрэг юм. Өөрөөр хэлбэл, морины хөлийн арьсаар хийсэн тамхины уут савыг Авгалдай онгод махан бодит хүн байх үедээ хэрэглэж байсныг дүрсэлсэн нь ажээ. Авгалдай: - Гүүр тавьсан гөлмийн эзэд хойт үеийн хонгор их сайдууд Мэнд амар! гэсээр орж

³⁵⁹ Энэ нь “толмач” буюу хэлмэрч гэсэн утгатай.

³⁶⁰ Г.Гантогтох, Бөө мөргөл, МУ-ын угсаатны зүй, III боть, УБ- 1997, 78-79 т

³⁶¹ XIII зууны үед татарууд Сибирийг эзлэн авч Урал орчимд эзлэсэн нутгаа баттай сахиулж байхаар суурин газар, хот тосгод байгуулж, улмаар нэг газарт төвлөрч төлөвшсөн хүмүүсийг, хот тосгоны иргэдийг нэрлэсэн “тура” юмуу “туралин” гэх ойлголт бий болсон байна. Иймд энд гарах туралин нь бодит хүний нэр гэхээсээ илүүтэй хот суурин газрын, эсвэл Тура голын тэндэх бөөд холбогдох бололтой. Мөн Их Хянганы нурууны орчимд Тура гэх нэгэн гол байна. Х.Пэрлээ, Гурван мөрний монголчуудын аман түүхийн мөрийг мөшгөсөн нь, 1969, 99-102т.

³⁶² Худир буриад бөө М.Жавхлангаас 2005 онд тэмдэглэв.

ирнэ. Тэгэхэд тулмааш түүнд хэрэг зоригоо айлтган мэдүүлсний дараа онгод тэнгэрийн нэгэн адил өөрийн дуртай зүйл болох тамхийг

... Улаан тамхи унд минь

Хавуучи тамхи хав минь гэж эсвэл арай өөрөөр:

... Мангад шар капустаар

Мантай тантай манаруулъя.... гэсээр орж ирээд тамхи асаалгаж татдаг.

Чүдэнз зурж тамхийг нь асааж өгөхөд онгод оруулсан бөө нь савж унадаг удаатай тул аль болох буруу харж зуруул үзүүлэлгүй асааж өгдөг. Хуучины улс чүдэнз зурж гал гаргаж мэдэхгүй байсанаас чүдэнзний галаас цочиж байгаа нь тэр юм гэнэ. Трубкаэ хэцнийхээ цаагуур нуугдаж татна. Ингэж байхдаа, - Атырхань үзэгдэнэ үү? гэж байн байн айсан дүртэй асуугаад, ирж байна гэх юм бол, огло харайн босч архи ууж, тамхи татаагүй шиг аашилдаг. Энэ нь өөрийн гэмээс болж эхнэртээ шийтгүүлж байсантай нь холбоотой гэнэ. Авгалдайд мөнгөн аягаар архи хийж өгөхөд модны үндэс олдохоо болио юу гээд аягыг нь чулуудаж байхыг харсан. Энэ нь модны ур, үндэс ухаж аяга хийх уламжлал хамнигадын дунд түгээмэл хэрэглэгдэж байсны илрэл, Авгалдай махан бодот хүн байхдаа үндсэн аяга³⁶³ хэрэглэж байснаас үүдсэн ажээ.

Авгалдай онгод орж ирүүт, Гутаарь тэнгэрийн алдагдсан хэдэн тэмээ хайж яваа хүн шиг:

- Чацарганатай цагаан бууртай, долоон цагаан тэмээ харав уу? гэж асуудаг гэнэ. Тэгэхэд нь, байхгүй ээ, манай энүүгээр л лав үзэгдээгүй гэхэд

Хариуд нь: - Дэрс ургасан дэлхий бүү үзэгд

Тэмээгээ тавьсан тэнгэр бүү үзэгд гэж байдаг. Гутаарь тэнгэрийн хэдэн тэмээ нь дэрсэнд ороод олдохоо больчихлоо гэж тэнгэрээ зүхэж байгаа нь энэ гэнэ.

Хамниган удган Г.Байгальмаагийн Авгалдайн дуудлага³⁶⁴:

... Долоон алтан болдогхоо дугуйцаж бууһан

Гуулин хаанай хүвүүн даа

Гутаарь тэнгэрийн хүргэн даа

Ерэн таван наһатай даа

Еэхэр еэхэр алхаатай

Енгүү хар авгалдай

Наанай найхан дуулаарай ...

Гаруу гаруу гэдэг

Бөө М.Жавхлан (худир буриад, их чонод омог)-ийн Авгалдайн дуудлага:

Аяар зүүн урд зүгээс

Замбативийн орны хязгаарын газраас

³⁶³ Хусны үндсээр хийсэн аягыг хорь буриадууд- “матаар”, “улха матаар” ч гэнэ. Бирарууд модоор хөвөөлсөн үйсэн хайрцгийг “матаар”- тай төстэй “метар” гэх бөгөөд энэ нь тэдний хэл соёлын адил төстэй талыг харуулах нэгэн жишээ юм.

³⁶⁴ Г.Байгальмаа, буриадын цагаангууд овогтой. Эхийн талаар хамниганы Дэлгэр, Дэмбэрэл зайрангийн удмын удган. Гэхдээ түүний ээж агын буриадын галзууд овогтой гэж явдаг ажээ.

Гадаад далайн наад талд
Дотор далайн цаад талд
Долоон алтан болдогийн
Эргэн тойрон буудалтай
Енхэн уулын өвөрт
Өнчин ганц хайлаасыг ширээлдэж буусан
Атырхань гэж авгайтай
Ханжаахан гэж басгантай
Алтан шаахай хөвүүнтэй
Доголон борогч гүүтэй
Долоон хүйлэн хоньтой
Езээр хар ерхүүмэй
Енгүү хар авгалдай...гэхчлэн буриад, хамниган бөө нар өөр
өөрсдийнхөөрөө шүлэглэн дуудаж байна.

Дээрх дуудлага болон домогт гардаг “атырхань”, “хэтэрхээн” гэх Авгалдай онгоны эхнэрийн нэр нь манж- түнгүүс хэлнээс гаралтай бөгөөд дараахь утгуудыг агуулдаг. Атырхань~ атилкан- эмгэн, (монг.хамниган)³⁶⁵; atikkaг~эмгэн(солон); atirkan~эмгэн(баргажины түнгүүс)³⁶⁶, дагуурууд- баавгайг шууд нэрлэхээс цээрлэж, эр баавгайг- “этүрхэн”, - эм баавгайг – “атурхан”³⁶⁷, эвенгүүд “атырканна”³⁶⁸ гэдэг ажээ. Иймд “атырхань” гэдэг нь Авгалдай онгоны эхнэрийн жинхэнэ нэр биш ерөнхийдөө эмгэн, түүний эхнэр, эмэгтэй гэсэн утгатай, авгайлан хүндэлсэн нэр болох нь. Мөн дуудлага, домогт дурьдагдаад байгаа “хүйлэн” гэх хонины зүсмийг заасан нэр нь манж-түнгүүс хэлний “kulin”- могой, Енисейн эвенгүүдийн “кулиган”- могой, хорт могой бас цоохор, хар тарлан хонийг заасан³⁶⁹ утгатай үгнүүдээс гаралтай юм. Хэнтийн хорь буриадууд хар тарлан зүсмийн хонийг хүйлин хонь гэж нэрлэдэг³⁷⁰. Буриад, хамниган бөөгийн ёсон дахь Авгалдай онгодын тухай ойлголт ба түүний доторхи нэршил зэрэг нь тэдний соёлын адилслын жишээ болж байна.

Хамниган бөөгийн онгодын дуудлага, нэхэл, түүрээлгэ(түрлэг түрэх). Онгодын дуудлага гэдгийг, бөө нэгэн онгодод хандан түүний нэр цол, нутаг усыг нь тоочин, дэвжид асраасаа заларч улаачийнхаа биед орших хүртэл нь урьж байгаа аялгуут шүлэглэл гэж тодорхойлжээ³⁷¹. Хамниганы бөө, удгадын онгодын дуудлага нь аман яруу найргийн төрөл болохоос гадна хамниганы түүхэн нутагшил, хоол хүнсний уламжлалт хэрэглээ зэргийг тусгаснаараа угсаатан

³⁶⁵ Б.Ринчен, МАУ-ын хамниган, УБ-1969, 54т

³⁶⁶ Н.Н.Поппе, Материалы по солонскому языку. Изд.АкНаук СССР. Ленинград- 1931, 42стр

³⁶⁷ Мориндаваа дагуур үндэстний товч түүх, ӨМАХХ- 1988, 228 т

³⁶⁸ Г.М.Василевич, Эвенки-историко- этнографические очерки, Ленинград-1969, 58 стр

³⁶⁹ А.Е.Аникин, Тунгусо-маньчжурские заимствования в русских говорах Сибири, Новосибирск-1990, бстр.

³⁷⁰ Хэнтийн Биндэр сумын хорь буриадын хургай халибан овогт С.Очир(68н)-оос 2004 онд тэмдэглэж авав.

³⁷¹ Д.Бум-Очир, Монгол бөөгийн зан үйл, УБ- 2002, 36 т

судлалын ерөнхий ангиллын хүрээний судалгааны хэрэглэгдэхүүн болж байна. Удган Г.Байгальмаа угийг нь барьсан Дэлгэр, Дэмбэрэл нарыг дуудахдаа,

Өргөн найхан Үлирэнгийг
Үдэлгэж бууһан
Нарийн найхан Үлирэнгийг
Наадан тойрон бариһан
Аралтын өндөр нуудалтай
Өнчин толгой эргилэгтэй
Ар булаг шунгалагатай
Дэлгэр, Дэмбэрэл зайран...

мөн өөр нэг онгодоо дуудахдаа,

Хар толгой нуудалтай
Бул нуур шунгалагатай
Хөөврийн нуур гүйдэлтэй
Сомолт Мархайн хөгшин Дэжид
Нарийн найхан Ингэдэйг
Наадан наадан барьһан
Мантан мандрин нуудалтай
Хавчрангын булаг шунгалагатай
Мархайн самган Дэжид авжаа... гэж байв.

Монголын хамниган бөө нар нутгийн уул овооны эзэн онгод сахиусаа дуудаад зогсохгүй, эрт дээр үеийн хүч чадал ихтэй онгодуудыг хуучин шүтлэгт уул овооноос нь (өнөөгийн Оросын нутаг дахь) дуудаж идээ тахил өргөж хүндлээд хэрэг зоригоо бүтээлцүүлдэг байна. Хамниганы хамгийн том удгадын нэг Наранзай удганыг Цастын Цагаан хайрханаас(Цагаан тэнгэр уул) дуудан,

Алтан хилийг алхуулж

Мөнгөн хилийг мөлхүүлж ... авчирдаг гэнэ.

Мөн асар сартуул хамниган Ж.Дэмбэрэлсайхан өөрийн дээд үеийн онгод Дондогийн Цэрмааг Хэр, Тарвалжид байх Гурван могойт гэдэг газраас дууддаг гэж байлаа. Г.Мөнхзул удган, Алхана, Цагаан тэнгэр, Онгосойн даваа, Үлирэнгээс онгод дуудаж хүндэлдэг бөгөөд ямар онгод дуудах нь хэц хэнгэргээ барьсан үед аяндаа хэлэгддэг. Хамниган бөө нар бөөлөхдөө өөрт буудаг бүх онгодоо дуудах бөгөөд тэд чадал чансаагаараа дараалан дуудагдаад байх шиг санагддаг гэж байв. Г.Мөнхзул удган сөрөг юм болж болзошгүй гээд онгодын нэрнүүдийг цээрлээд тэмдэглүүлсэнгүй.

Хамниган бөөгийн онгод орсоны дараа маханбодтой байхдаа идэж ууж байсан болон онгод болоод хэрэглэж умдалж байснаа шүлэглэж нэхдэг бөгөөд үүнийг бөө мөргөлийн аман яруу найргийн нэхэл үг хэмээн төрөлжүүлсэн байна³⁷². Сартуул хамниган бөө Ж.Дэмбэрэлсайханы онгод булсан төмс, хуурсан арвай, Г.Мөнхзул удганы онгодууд, үрэл, арвай буудай, цагаан төмс зэргийг, Г.Байгальмаа удганы онгод гутаарь загас, шарсан мах, сүү, тараг зэрэг хоол хүнсний бодит хэрэглээний уламжлалыг харуулсан зүйлсийг нэхдэг ажээ.

³⁷² Д.Бум-Очир, Монгол бөөгийн зан үйл, УБ-2002, 45- 51т

Хамниган бөө нар уг бариулсан багш нарын заасан болон онгод тэнгэрийн зааж хэлснээс хамаарсан хэдэн янзын түүрээлгэтэй. Г.Мөнхзул удган угаа барьсан даруйдаа жолоо атгуулсан багш нь болох буриад бөөгийн адил, - “аахай ёохой минь ээ гөө, аяа байдө минь ээ гөө” гэж түүрээдэг байсан гэнэ. Одоо сахиусынхаа(онгод) дуудлагаар “хэхэл хэхэл хэхэл хэхэл...” гэж түүрээдэг болсон ажээ. Харин Хэнтийн сартуул хамниган бөө Ж.Дэмбэрэлсайхан, “ахар ёохор хэхэрхэн, хэхэр ёохор хэхэрхэн...” хэмээн түүрээж байх бөгөөд энэ түүрээлгийг өөрийн онгодоос мэдэж авсан гэнэ. Ж.Дэмбэрэлсайхан бөө Авгалдай онгодоо оруулахдаа:

Хатуу хар хэрэг дээрэмни

Эргэн байж буудаг билээлт

Оёон оёон, оёон оёон

Хэцүү хар хэрэг дээрэмни

Эргэн байж буудаг билээлт

Оёон оёон, оёон оёон... гэж түүрээж байв.

Харин баеид хамниган Г.Байгальмаа удган Авгалдайн дуудлагын түүрээлгийг арай өөр, - “гаруу, гаруу гаруу гаруу дайны гаруу” гэж түүрээж байлаа. Өөрөөр хэлбэл бөө мөргөлийн ёс нэгэнт орхигдон мартагдсан байсан тул анх бөө болж байгаа улсууд багш нарынхаа зааж сургаснаар түүрээж явснаа өөрийн онгод тэнгэрээ буулгаж бие дааж бөөлөөд эхлүүт түүрээлгэ нь жинхэнэ хамниган онгодоос нь хэлэгдэж мэдэгдэж эхлэдэг байна. Тэр нь онгод сахиусаас хамааран өөр хоорондоо ялгагдана.

Хамниган бөөгийн хувцас эдлэл. Монголын хамниганы дунд эртнээс уламжлан хадгалагдсан бөөгийн хувцас, тэнд нэг тийм хийцийн өмсгөл байсан даа гэх төсөөллийн ул мөргүй болсон байжээ. Хамниганы ихэнх бөө, удгадын өгүүлэх нь, тэд бөөгийн эд хэрэглэл гэж бүрэн бүтэн өвлөсөн юмгүй, бөө гэдгийг төсөөлөх ч үгүй байгаад, уг барих болж онгодын нэхсэн хэлсэнээр нь хувцас, хэрэглэлээ үйлдэж хэрэглэж байгаа гэнэ. Нөгөө зарим нь эх, эцэг болон ойр дотнын хэн нэг нь бөө удган байгаад, тэднээсээ зарим толь, хуур гэх мэт эдийг нууцаар өвлөсөн байна.

Зураг- 20, 21, 22 - эдгээр зурагууд дээр ХҮIII зуун болон, өнөөгийн хамниган бөө нарын байдлыг харуулав. 18-р зураг дээрх бөөгийн хувцас нь буриад бөөгийн хувцасны завдар ба хамниган бөөгийн хувцасны могойн аль алиныг нь агуулж байна. Манж- түнгүүсийн хэлээр зава- гэдэг нь нөмрөг бөөгийн хувцас гэсэн утгатай. Үгийн утгыг үндэслэвэл буриад бөө нарын нөмрөг дээрх завдарыг хамниганаас үүдэлтэй гэж болмоор байна. Харин яагаад хамниган бөөгийн хувцасанд завдар байхгүй байгаа нь сонирхолтой юм. 21-р зураг нь Дорнодын Баян-Уул суманд чанараа хийж байгаа Оросын харьяат эвенк удганы зураг юм. Яагаад нутагтаа чанар хийхгүй байгааг нь сонирхвол, буриад бөө олонтой тэд чанарыг нь удирдах болдог тул Монголд хийж байгаа гэлээ. Хувцасны материал өөр боловч хийц, ерөнхий билэгдэл нь монгол хамниганыхтай адил байна.

Монголын хамниганы харын уг барьсан бөө, удган нар хар нөмрөгтэй(архаали), цагааны уг барьсан бөө, удган нар нь цагаан нөмрөгтэй

байх бөгөөд нөмрөгний эргэн тойрон, түүний урттай бараг тэнцүү 12 ширхэг, майхавчиндаа 3 ширхэг нийт 15 могойн дүрс зүүсэн байдаг. Могой тус бүр бас 15 салаа толгойтой. Нөмрөг болон майхавчийн могойг даавуугаар оёж дотор нь хонины ноос эсвэл хөвөн зөөлөн эд чихэж хэлбэржүүлнэ(Зураг-22). Онгод тэнгэрийн нэхлээр хийсэн орчин үеийн хамниган бөө, удгадын хувцасны дээрх хийц нь буриадынхаас нилээд онцлог маягтай ажээ. Буриад бөөгийн архаали нь хамниганыхтай адил могой биш харин огт ондоо завдар гэх бөс даавуун туузан зүүтгэлтэй байдаг. Үүгээрээ тэдний хувцас хоорондоо илт ялгардаг. Хамниган бөөгийн өмсгөл дэх могойн тоо нь ямар билэгдлийг агуулж байгааг өнөөгийн бөө нар нарийн сайн тайлбарлаж мэдэхгүй байна. Гэхдээ 15 гэсэн тоо нь хамниганы арван таван эцгийг билэгдэж байж болох юм. Судлаач Е.Д.Прокофьев³⁷³ Сибирийн бөөгийн хувцасыг тусгайлан судлаад бөө нарын хувцас, эдлэл дэх могойн дүрсүүдийг хийц загвараар нь төрөлжүүлжээ. Түүний ангилалд үндэслэвэл, монгол хамниганы бөөгийн нөмрөг дэх могой чихмэл нь өвөр Байгалийн эвенгийн хэв загварт хамаарах маяг хийцтэй байна. Хамниган бөө нар бусад нийтлэгийн бөө удгадын ерөнхий жишгээр дуудлагадаа хувцас эдлэлийн талаар дурьдана. Харын талын уг барьсан сартуул хамниган бөө Ж. Дэмбэрэлсайхан:

Галзуу чонон хөлөгтөнгүүд

Гал могой ташууртангууд

Хүрэл чулуун зүрхтэнгүүд

Хөө хар нөмрөгтөнгүүд ... гэж шүлэглэж байна. Хамниган болон буриад бөөгийн хуяг өмсгөлийн “архаали” гэх нэр нь архаали~аркалән (эвенг)- бөөгийн нөмрөг; ~аркан (эвенг)- нуруу~агу (монгол)- ар, ар тал, нуруу- гэсэн утгатай үгнээс гаралтай ажээ. Энэ нь элдэв хорлолоос бөөгийн ар нурууг хамгаалдаг харын бөөгийн өмсгөл юм.

Бөөгийн хувцас, онгод шүтээний зарим нэршилийн ялгаа, хийцийн онцлог нь хамниган бөө мөргөл буриад болон бусад угсаа нийтлэгээс өөрийн онцлог ялгаатай явж ирсэний илэрхийлэл болж байна.

3.3. Хамниганы онгод шүтээн

Авгалдай. Бөөгийн мөргөлд ямар нэг хий биет сүнслэг оршихуйн тухай ойлголт гол байр эзлэдэг. Энэхүү сүнслэг биет онгод тахилын шүтээн Монголын хамниган дунд уламжлагдаж иржээ. Эрдэмтэн Ч.Далай энэ шүтээний тухайд, бөөгийн мөргөлд гурван янзын сүнс байна. Түүний нэг нь амьдран орших сүнс буюу эзэн нь үхэвч сүнс нь үхэхгүй, амьд хүмүүстэй хамт амьдарч ар гэр орондоо

³⁷³Е.Д.Прокофьев. Шаманские костюмы народов Сибири. Религиозные представления и обряды народов Сибири вXIX- начале XX века. Ленинград-1971

ач тусаа үзүүлж явна. Түүнийг гомдоохгүйн тулд үргэлж тайж тахиж хоол унд өгч байх нь чухал. Бөө мөргөлийн онгон гэдгийг сүнсний ойлголттой холбож үзэх нь зүйтэй³⁷⁴ гэсэн байдаг. Хамнигад, энд тайлбарласанчлан талийгаачийнхаа сүнсийг тахиж шүтэн ивээл хайрыг хүртэж ирсэн байна. Тэд хий биет байдаг гэдэгт итгэн шүтэн хүндэтгэж ирсэний нэг нь авгалдай юм. Ойр зуурын элдэв хэрэгтээ тус нэмэр болгож, орон гэрийнхээ гай түйтгэрийг хааж байх үүднээс өвөг дээдсийнхээ хэн нэгний сүнсийг амьд махан бодот хүнтэй адил идээ шүүсээр хооллон тусгай гэр барьж түүндээ байлгадагаа авгалдай гэж байна. Буриад, хамнигадын аман түүхээр бол, энэ хий биет маш ажилсаг, даалгасан ажлыг хялбархан хийчихээд дахин ажил нэхэж амар заяа үзүүлдэггүй гэнэ. Тэрнээс нь залхаад тэрэгний хигээс юмуу гэрийн униа(унь-О.Б) тоолуулдаг. Хигээс, унь хоёр нэг хэмжээ загвартай тойрог замаар хийгдсэн эд тул тоолж дуусдаггүй түүндээ сатаарч байдаг гэнэ. Хэрвээ хигээс яртай эсвэл уннд юм хавчуулсан байвал алдалгүй мэдээд дор нь тоолоод дуусгачихдаг ажээ. Авгалдайтай айл түүнийг дарах болвол бурханы орноос ямар нэг зүйл олж ирэхийг даалгадаг гэнэ. Тэгэхэд авгалдай, би ч тэр юмыг чинь авчирах нь авчирна, намайг ирэх үед угтуулаад нохойн баас шатаагаарай гэдэг байна. Авгалдай ч бурханы оронд очиж нөгөө юмаа аваад бурхан багшид хөөгдсөөр ирэхэд нь нохойн баас биш арц уугуулахад, бурхан багш авгалдайг гүйцэж дарж авдаг³⁷⁵ ажээ. Харин буриадууд ийм хий биет шүтдэгээ боохолдой гэж нэрлэдэг. Хамнигадын адил боохолдойгоо илүү гэрт байлгаж гэрийн ажил төрөлд нэмэр тус болгодог байжээ. Октябрын хувьсгалын үеэр дураараа авирлаж байсан большевикуудын тухай, ... боохолдой байдаг гэртэмнэй большевик байрладаг болоо... гэлцэж байсан гэнэ.

Заяаша~(заягачи). Монголын хамниганы гол шүтээний нэг бол “заяаш”~“заягачи” юм. Энэ шүтээний тухайд, заяагч тэнгэрийн гол үүрэг гэвэл ертөнцийн амьд болгоныг үүсгэн бүтээж, хувь заяаг тогтоон шийтгэхэд оршино. Заягачи тэнгэр (мон. *Jayaγas`l tngri*, бур. Заяаша, Заяан Сагаан тэнгэри, хал. Заягч) нь нэрийн гарлын хувьд “заяа”, “заяах” гэсэн үгнээс гаралтай. Хүн, тэнгэр нэрийн хувь заяаг тогтоож, захиран залагч тэнгэр, эд жаргалан, мал ахуйг сахигч тэнгэр. Буриадад тэнгэр нэр болон хүнийг төрсөн цагаас нь хувь заяаг нь зурж зохиодог, амь насыг нь өмгөөлж, адуу малыг нь хамгаалдаг Заяан Сагаан³⁷⁶ тэнгэр гэхчлэн тайлбарласан байдаг.

Буриад-монголчууд заяашийг хоёроор нь хийж шүтэж байсан бөгөөд нэгийг нь хан заяач нөгөөг нь хатан заяачи гэдэг байсан ажээ³⁷⁷. Мөн дагуурууд уулаас “заяагач” бурханыг тахидаг уламжлалтай³⁷⁸. Ороchonууд заяагачийг дагууруудаас уламжилан шүтэх болсон гэнэ³⁷⁹. Бөөгийн мөргөлт эрчүүд эхнэр авч өрх тусгаарлахдаа заавал айл гэрийн гал голомтыг ивээгч “заяна”-ыг бүтээлгэдэг байна. Гэрийн эзэн жил бүр заяандаа мөргөж өрөм, тараг, хайлмаг,

³⁷⁴ Ч.Далай, Монголын бөөгийн мөргөлийн товч түүх, УБ-1959, 13т

³⁷⁵ О.Баттуяа, Хэнтий, Дорнод аймагт хийсэн судалгааны гар бичмэл, 2003

³⁷⁶ С.Дулам, Монгол домог зүйн дүр, УБ- 1989, 79,169 т

³⁷⁷ А.И.Термень, Среди буряты Иркутской губернии Забайкальской области, Спб-1912, хавсралт

³⁷⁸ Мориндаваа дагуур үндэстний товч түүх, ӨМАХХ-1988, 228 т

³⁷⁹ Орцоны өөртөө засах хошууны тойм байдал, ӨМАХХ-1986, 70 т

архи зэрэг идээ ундааны дээжээр хүндлэж тайлга бүрийн махнаас хүртээдэг бөгөөд гахайн мах заянда өргөхийг цээрлэнэ. Зарим буриадууд заяаны тайлган гэж тусгайлан хийдэг. Заяна-ыг, 3-4 эмэгтэй хүний дүрсээр төлөөлүүлэн, тусгай хайрцагт хийж хаалганы зүүн талд байх тавиур дээр байрлуулан шүтэж явдаг байна³⁸⁰.

Дорнодын Баян- Уул, Цагаан- Овоогийн хар намиад³⁸¹, залтууд³⁸² хамнигад хар хурган заяашийг шүтэж байна. Тэдний зарим нь дээд үеэс уламжилсанаа таслалгүй шүтэж ирсэн бол, зарим нь энэхүү шүтээнээ урьд шашин мөргөл хориотой байхад орхигдуулсан тул саад тотгор салахгүй болж засал хийж бөөлүүлэх үед энэ гэм нь мэдэгдэж заяашаа дахин амилуулж сэргээн шүтэж эхлэсэн байна.

Хамнигад хар хурган заяашийг дараахь байдлаар босгоно. Хавар гарсан хар хургыг намар муулж арьс(хагс хурганы арьс)-ийг нь элдэж бэлтгээд түүндээ улаан шүрээр нүд хийж, год болгоноос нь улаан, шар, хөх, ногоон, цагаан өнгийн бөс торго зүүдэг. Баруун урд мөчид нь буюу заяашийн баруун гарт нь модон ташуур өлгөх, эсвэл урд хоёр годыг нь ташуур гэх нь ч бий. Хамнигад заяашийг гэрийн хоймор бурхан шүтээн байрлах газарт өлгөдөг. Дорнодын Цагаан-Овоо сумын хар намиад хамниган Т.Дазынх өвөг дээдсээс уламжилж ирсэн “заяаш”- аа шашин хориотой байх үед(1990-ээд оноос өмнө) шилэн нүүртэй модон хайрцагт хийж, хүлиертээ нууж явснаа одоо ил гаргаж тахиж байна. Заяашийг хүйлэн эсвэл шар халзан эр хониор шүүс тавин, бөө бөөлүүлж амьлуулдаг. Хамнигад заяашийг гурван жил тутам хониор тахил өргөж бөөгөөр хүндлүүлнэ. Заяашийг тахиж хүндлэх үедээ бөө, удгад:

... Хар хурган дахтай
Хан буурал заяаш
Бор хурган дахтай
Богд их заяаш ...
Хадын цаанаас бултайдаг
Хан богд заяаш
Бутны цаанаас бултайдаг
Бурхан богд заяаш...гэхчлэн магтаал хэлэн урин дууддаг.

Заяашид хониор тайлга тахил өргөхдөө бөө мөргөлийн ёсонд хонины ямар ч эд эрхтнийг хаялгүй дээд тэнгэрт мэдүүлдэг тэр нийтлэг дэгээр хийдэг ажээ. Тахилын идээ, хонийг эд эрхтэнээр нь нэг бүрчлэн мэдүүлсэний хойно, идээ умдаанаас уул овоондоо өргөж, тахилын хонины баруун талыг гэрийн эзэд, зүүн талыг хүндлээний үед байсан гаднын хүмүүст хувааж хүртээх бөгөөд ясыг нь үлдээлгүй шатаагаад, баас цус, шөлийг нь газарт булдаг байна. Заримдаа тахилын идээний дунд савтай тараг тавих бөгөөд бөөлж дууссаны дараа заяашийг тахиулж буй өрхийн тэргүүн түүнээс амсах үед нүүрээр нь тараг руу

³⁸⁰ И.М.Манжигеев, Бурятские шаманистические и до шаманистические термины, Москва-1978

³⁸¹ Дорнодын Цагаан- Овоо сумын хар намиад овгийн хамниган Төмөрийн Даз (79н)

³⁸² Дорнодын Цагаан- Овоо сумын залтууд овгийн хамниган Сундуйн Мөнхдорж(54н)

гударч инээд наргиа болгож хүндлээнийг өндөрлөдөг. Зашачийг хүндэлснээс хойших 3 хоногт тухайн айл идээ унд, эд юмс гаргах хориотой байдаг гэнэ.

Дээрх хүндлэлээс гадна цагаан сараар заяашийн өмнө түрүү мах, үхрийн өвчүү таваглаж, идээ ундааны дээжээр амыг нь мялаадаг. Мөн хавар болж цагаан идээ дэлгэрэхэд архи, тараг цагаан идээний дээж мөн хамгийн эхэнд тугалласан үнээний уургийг заяашид амсуулна. Заяашид сэтэрлэсэн морийг гэрийн эзэн өрхийн тэргүүнээс өөр хүн эдлэх ёсгүй. Дорнодын Цагаан- Овоо сумын хар намиад хамниган Т.Дазынх өвөг дээдсээс уламжилж ирсэн “заяаш”- даа цагаан үнээ сэтэрлэжээ. Хамнигад хар хурган заяашийг айлын адуу мал, эд хөрөнгийг харж хамгаалагч хэмээн шүтэж, хүндэтгэж байна.

Даваэ. Монголын хамниганы өөр нэг онгод шүтээн бол давай~(даваэ)³⁸³ юм. Хамнигад даваэг үхүгийн, адиарын, тоохоогой давай гэж нэрлэж байна. Энэ нь Дорнодын ага буриадууд хоол цайны савыг агуулж тавьдаг тавиур(шүүгээ)-ыг “үхүг”, “адиар”, Дорнодын Цагаан- Овоогийн буриад, хамниган нар уг тавиурыг “тоохоон” гэж нэрлэж байгаагаас хамаарч хэдэн янзаар хэлэгдсэнээс биш “даваэ”-н олон төрлийг илэрхийлсэн нь биш юм. Хэнтийн Биндэр, Дадалын хамнигад ийм нэртэй шүтээнийг сайн мэдэхгүй, харин Дорнодын Баян-Уул, Цагаан- Овоогийн буриад, хамнигад мэдэж энэ шүтээнийг хэдэн янзаар тайлбарлаж байв. Домогт өгүүлснээр, даваэ нь Дайван хааны тугалчин эмэгтэй байгаад нас баржээ. Нас барсаныхаа дараа хорь буриадад цай дагаж ирсэн гэнэ. Хорь буриадын үхэр нь тахлаар өвдсөн тул энэ нь Даваэгаас шалтгаалжээ гэж үзэн шүтээн болгон Даваэгаар “Даваэ багш” –г бүтээсэн байна. Анх Даваэ цагаан ямаагаар тахидаг байснаа дараа нь хониор тахидаг болжээ³⁸⁴. Мөн худир буриад хүн, даваэ гэдэг нь цайны эзэн юм. Цайны идээний эзэн байгаад цайгаа харамлаж дагаж ирээд даваэ болсон гэж байв. Хамнигад даваэг тахивал идээ цай тасрахгүй гэж билэгшээж хошноого, бөөр, зүрх, нугалуураар 3 жилд нэг удаа хүндэлж иржээ. Мөн хар намиад хамниганы тайлбарласнаар, даваэ гэдэг нь идээ ундааны манаач, галын зүүн урд хоолны шүүгээний цаана байна. Эсгийгээр хайчилж хийсэн хоёр хүний дүрс бөгөөд хооронд нь холбож шүүгээнийхээ ард байрлуулдаг гэж байв.

Дорнодын Цагаан-Овоогийн хамнигад хүн дүрт ийм шүтээнийг авгалдай гэж байна. Тэндхийн агын буриадын цагаангууд овгийн настан Гарамжавын Оргодолынх “авгалдай” гэх эрэгтэй, эмэгтэй хүн дүрт шүтээн тахиж байв. Энэ шүтээнийг Оргодолын эхнэр Дульдаргаас гаралтай чигчин хамниган Цэрэний Долгор(2003 онд 70н) -ын ээж охиндоо(Ц.Долгор) өвлүүлсэн нь энэ гэнэ. Байдал төрхийг нь тоймловол, шар өнгөт төмрөөр(гууль) хүний толгой хийж, нүд, ам, хамрыг товойлгон цохиод, үснийх нь оронд хонины ноос нааж хөрөглөн бүтээгээд

³⁸³ Монголчуудын бөөгийн ёсноо Давай онгон гэж нэг онгон байсны нэр нь, орос хэлнээ өгөөч гэдгийг давай хэмээн бичдэгтэй үсэг адил боловч, тэр Давай гэдэг монгол нэр, өгөөч гэдэг давай гэсэн орос үгийн адгийн “ай” нь шал өмнөө байдаг байна (Б.Ринчен, МАУ-ын хамниган аялгуу, УБ-1969, 41-42т).

³⁸⁴ Цыбен Жамцарано, Путевой дневник, 1908, 37 стр

цайвар өнгөтэй даавуун уутанд хамтад нь хийсэн байжээ³⁸⁵. Эдгээр онгодууд Ц.Долгор эмгэний талаас өвлөгдсөн тул эмэгтэйн талыг дагаж, гэрийн эзэгтэйн амжуулах ажил сүү сааль, идээ цагааг арвижуулж явах хамниганы хүн дүрт онгод шүтээн болно. Энэ онгодыг 1-2 жилд бөөгөөр тахиулж сүү, цагаан идээгээр хүндэлнэ. Шашин мөргөл хориотой байсан түүхэн урт хугацаанд энэхүү хүн дүрт шүтээний зориулалт ба нэршил нь мартагдаж орхигдоход хүрч “авгалдай” гэж нэрлэгдэж ирсэнээс биш дээрх баримтуудаас үзвэл энэ шүтээн нь даваэ бололтой юм.

Даваэ онгодыг Таван сахиусанд сацах сацалын үгэнд багтаан дурьдсан нь:

Ойд явахдаа бархиръя
Онгон минь нааш ирээч
Дайдад явахдаа бархиръя
Даваэ минь нааш ирээч
Хээр явахдаа бархиръя
Хэцтэн минь нааш ирээч
Хол явахдаа бархиръя
Хошиянгин минь нааш ирээч хэмээн дуудмуй³⁸⁶.

Монгол хамниганы шүтэж байдаг даваэ нь идээ ундааны талыг харж хандаж, элдэв бузраас сэргийлж байдаг, хүн дүрт онгод ажээ. XIV зууны үед Монголын нутгаар аяласан Плано Карпини, монголчуудын гэрт хаа сайгүй байх хүн дүрт онгодын тухай дэлгэрэнгүй дүрслэсэн³⁸⁷байдаг. Эртний монголчуудын онгод шүтээний зарим нь өнөөгийн хамнигадын дунд уламжлагдан үлдсэн энэ байна.

- Хамниганы шашин мөргөлийн замналыг үзвэл, хаант Оросын засгийн газраас Сибирийн бус төрөлтнүүдийн тэр дундаа хамниганы уугуул соёл бөө мөргөлийг бурханы шашинаар түрүү барьж устгах бодлого хэрэгжүүлж эхлэснээр XIX зууны дунд үе гэхэд хамниганы бөө мөргөл бараг орхигдож тэр сацуу бурханы шашин цэцэглэн хөгжсөн байна. Гэвч дорнын энэхүү их соёлыг XIX зуун дунд үеэс мөн л гадуурхаж, бөөгийн мөргөлийг үгүй хийхийн тулд хэрэглэж байсан яг тийм аргаар хамниганы шашин шүтлэгийг устгах арга хэмжээ авч эхлэжээ. Монголын хамнигад Сибирийн бус төрөлтнүүдийн адил энэ мэт хавчилга дарамтад өртөж байсан ч шашин шүтлэг, эргэл мөргөлийн уламжлалаа тодорхой хэмжээгээр хадгалж ирсэн төдийгүй 1930-аад он буюу хэлмэгдүүлэлтийн үе хүртэл хөрш зэргэлдээ халх, буриад алинаас нь ч тусгаар овоо тахилга, мөргөлийн сүм дугантай байсан байна.

- Хэдийн мартагдах шахаад байсан бөөгийн хувцас хэрэглэл, дэг ёс дахин сэргэхэд онгод тэнгэрийн оролцоотойгоор улаач бөө, удгадууд гол үүрэг гүйцэтгэж байгаа ажээ. Тэд хамниганы соёлыг дахин бий болгож байна. Мөн

³⁸⁵ Г.Цэрэнханд, Б.Отгонбаатар, Б.Баатархүү - Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн нутагт явуулсан угсаатан судлалын хээрийн судалгааны тайлан, ШУА, Түүхийн Хүрээлэн, Угсаатан судлалын сектор, 2003

³⁸⁶ Б.Ринчен, Монгол бөөгийн дуудлага, УБ-2006, 132 т

³⁸⁷ Жиованни Дель Плано Карпини, Монголчуудын түүх, УБ-1988, 16т

бөөгийн хувцас эдлэл хийгээд чанарын зан үйлийн онцлогууд өөрийн унаган төрхийг аль болох хадгалан сэргэж байгаа нь хамниганы гэх соёлын ялгааг баяжуулахын хамт тэдний угсаа соёлын ялгарлыг улам тодотгож байгаа юм.

- Аливаа бүхнийг амьдчилж, цаанаа эзэнтэй гэж хүндэтгэн зохистой харьцаж байгаа эсэхээс хүний хувь төөрөг хамаарна гэх бөө мөргөлтний ерөнцийг үзэх нийтлэг үзлийг илэрхийлсэн эртний хүн дүрт онгодын нэгэн төрөл Монголын хамниганы дунд өнөөг хүртэл уламжлагджээ.

Ном зүй

Монгол бичгээрх ном, сурвалж:

1. Алтанбагана, Кидан нарын гарал үүсэл, ШУА, Түүхийн хүрээлэн, Ф-25, ХН-210
2. Буриадын түүх, УТНС, гар бичмэлийн сан хөмрөг
3. Бүүвэй бэйл хааны судар оршив, УТНС, гар бичмэлийн сан хөмрөг
4. Монголын нууц товчоо, Худам монгол бичгээр сийрүүлсэн Ш.Гаадамба, УБ-1990
5. Морин даваа дагуур үндэстний товч түүх, ӨМАХХ- 1986
6. Оросын албат буриад нарын орших ёсон амой, УТНС, Гар бичмэлийн сан хөмрөг
7. Орцоны өөртөө засах хошууны тойм байдал, ӨМАХХ-1989
8. Эвенг ардын үлгэр, ӨМАХХ- 1988
9. Эвенг үндэстний товч түүх, ӨМАХХ-1986
10. Түүхийн Төв Архив, Ф'М9- Д3- ХН16
11. Түүхийн Төв Архив, Ф'М9- Д3-ХН33
12. Түүхийн Төв Архив, Ф'М9- Д5-ХН10
13. Түүхийн Төв Архив, Ф'М31- Д2- ХН1125
14. Түүхийн Төв Архив, Ф'М31- Д3- ХН25
15. Түүхийн Төв Архив, Ф'М31- Д3- ХН754
16. Түүхийн Төв Архив, Ф'М31- Д3- ХН860
17. Түүхийн Төв Архив, Ф'М34- Д1- ХН414
18. Түүхийн Төв Архив, Ф'М34- Д2- ХН12
19. Түүхийн Төв Архив, Ф'М34- Д2- ХН25
20. Түүхийн Төв Архив, Ф'М34- Д2- ХН30
21. Түүхийн Төв Архив, Ф'М34- Д2- ХН37
22. Түүхийн Төв Архив, Ф'М36- Д3- ХН322
23. Түүхийн Төв Архив, Ф'М40- Д1- ХН10
24. Түүхийн Төв Архив, Ф'М85- Д1-ХН1348
25. Түүхийн Төв Архив, Ф'М181- Д1-ХН20

26. Түүхийн Төв Архив, Ф'102- Д1-ХН11
27. Түүхийн Төв Архив, Ф'102- Д1-ХН3
28. Түүхийн Төв Архив, Ф'92- Д1-ХН1
29. Түүхийн Төв Архив, Ф'92- Д1-ХН7
30. Түүхийн Төв Архив, Ф'92- Д1-ХН11
31. Түүхийн Төв Архив, Ф'92- Д1-ХН15
32. Түүхийн Төв Архив, Ф'А29- Д2-ХН298
33. Түүхийн Төв Архив, Ф'А74- Д1-ХН348

Тайлан хэрэглэгдэхүүн:

34. Баттуяа.О, “Монголчуудын угсаа-гарал, өв соёл” төслийн тайлан, МУИС-ийн Азийн Судалгааны Төв, 2003
35. Баттуяа.О “Барга, хамниган, буриадын угсаа соёлын хамаадал” төслийн тайлан, МУИС-ийн Азийн Судалгааны Төв, 2004
36. Цэрэнханд.Г, Отгонбаатар.Б, Баатархүү.Б - Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн нутагт явуулсан угсаатан судлалын хээрийн судалгааны тайлан, ШУА, Түүхийн Хүрээлэн, Угсаатан судлалын сектор, 2003
37. Цэрэнханд.Г, Баттуяа.О, Сэлэнгэ, Дорноговь, Дундговь аймгийн нутагт явуулсан угсаатан судлалын хээрийн судалгааны тайлан, ШУА Түүхийн хүрээлэн. Угсаатан судлалын сектор, 2007
38. О.Баттуяа, Ерөө, Хүдэрт хийсэн судалгааны гар бичмэл, 2007
39. О.Баттуяа, Хэнтий, Дорнодод хийсэн судалгааны гар бичмэл- 2003, 2004, 2005, 2007
40. О.Баттуяа, Хэнтий амйгийн Цэнхэрмандал, Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутагт хийсэн судалгааны гар бичмэл- 2015
41. Г.Энхжаргал, Өвөр Монгол ба Хятадын даяаршил дахь шинэ эвенк, НСАНтропологийн магистрын зэрэг горилсон бүтээл, УБ-2010

Кирилл бичгээр:

42. Амар.А, Монголын товч түүх. УБ-1989
43. Бадамням.Б, Буриад-монголчуудын угсаа-түүхийн зарим асуудал. Олон улсын эрдэм шинжилгээний бага хурал. УБ-2000
44. Бадамхатан.С, 1963 онд Ерөөд хийсэн хээрийн судалгааны гар бичмэл
45. Бадамхатан.С, 1984 онд Хэнтий аймагт хийсэн хээрийн судалгааны гар бичмэл
46. Бадамхатан.С, Эрдэм шинжилгээний бүтээлүүд, Iботь, УБ- 2000
47. Бадамхатан.С, Эрдэм шинжилгээний бүтээлүүд, IIботь, УБ- 2002
48. Бадамхатан.С, Эрдэм шинжилгээний бүтээлүүд, IIIботь, УБ- 2006
49. Б.Бадма-Оюу, Буриад бөөгийн “чанар хийх” зан үйлийн тухайд, Угсаатан судлал, Tomus XIII, Fasc.1-22. УБ-2001

50. Батжаргал.Г, Манай нутгийнханы алтан ургийн товч түүх, Чойбалсан-1995
51. Баттуяа.О, Сэцэн ханы хамнигадын тухай, Угсаатан судлал, Tomus XIII, Fasc.1-22. УБ-2001
52. Д.Батсүх, Эрдэнэ нутгийн түүх, УБ-1994.
53. Бум-Очир.Д, Монгол бөөгийн зан үйл, УБ-2002
54. Буряадай түүхэ бэшэгүүд, Улаан-Үдэ- 1992
55. БНМАУ-ын угсаатны зүй, I боть, УБ-1987
56. Бүрэнтөгөлдөр.Н, Цэцдийн шастирт мөнхөрсөн Цэнхэрмандал, Модот- 2005
57. Галсан.Т, Дорнод аймгийн Баян-Уул сум, УБ-2004
58. Гантогтох.Г, Монгол зан үйлийн аман яруу найргийн уламжлал, УБ-2007
59. Гантогтох.Г, Дашбалбар Дашбалбарайхан, УБ-2005
60. Гильом Де Рубрук, Дорно этгээдэд зорчсон минь, УБ-1988
61. Гомбосүрэн.Д, Хөвчийн Жонон ван Цогбадрах, УБ- 2002
62. Гонгоржав.Г, Монголчуудын чулуун өв соёл(эртний үеэс- XX зууны эхэн). ШУА. Археологийн хүрээлэн, УБ-2005
63. Дадал сумын түүхэн товчоон, УБ-2010
64. Далай.Ч, Монголын бөөгийн мөргөлийн товч түүх. Studia ethnografyfica. Tom- I. Fasciculus-5. УБ-1959
65. Дулам.С, Монгол домог зүйн дүр, УБ- 1989
66. Дондог.Ч, Улз голын цууриа. УБ- 1988
67. Марко Поло, Орчлонгийн элдэв сонин, УБ- 1987
68. Монгол ёс заншил, зан үйлийн товчоон, ШУА Түүхийн хүрээлэн, Угсаатан судлал, Нийгэм соёлын антропологийн салбар; УБ-2009
69. Мишиг.Л, МАУ-ын хамниган аялгууг сурвалжилсан нь, Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтдийн анхдугаар их хурал, УБ- 1961
70. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь, IY боть, УБ- 2008
71. Плано Карпини, Монголчуудын түүх, УБ-1988
72. Нацагдорж.Ш, Сум, хамжлага, шавь ард, УБ-1972
73. Пүрэв.О, Хар дархадын хураангуй түүхээс, УБ-2008
74. Пүрэв.О, Оюунбилэг.Р, Төв аймгийн Мөнгөнморьт сумын түүх, УБ-2003
75. Пүрэвдорж.М, Хөвчийн Жонон вангийн хошууны түүх(1688-1990), Өндөрхаан- 1993
76. Пүрэвдорж.М, Хөвчийн жонон вангийн хошууны түүх бүтээлийн гар бичмэл, Хэнтий аймгийн музейн сан хөмрөг
77. Пэрлээ.Х, Хятан нар тэдний монголчуудтай холбогдсон нь. УБ- 1959
78. Пэрлээ.Х, Гурван мөрний монголчуудын аман түүхийн мөрийг мөшгөсөн нь, УБ-1969
79. Өлзийсүрэн.Б, Халхын Сэцэн хан аймгийн хураангуй түүх, Өндөрхаан- 1993
80. Оюунтунгалаг.А, Монгол улсын буриадууд, УБ-2004

81. Очир.А, Сэржээ.Ж, Монголчуудын овгийн лавлах. УБ- 1996
82. Ринчен.Б, Монгол Ард Улсын хамниган аялгуу, УБ-1969
83. Ринчен.Б, Монгол Ард Улсын угсаатны судлал, хэлний шинжлэлийн атлас, УБ-1979
84. Ринчен.Б, Монгол бөөгийн дуудлага, УБ-2006
85. Сономдагва.Д, БНМАУ-ын орон нутгийн засаг захиргааны хуваарьт гарсан өөрчлөлтүүд(1921-1965), УБ-1967
86. Тангад.Д, Хамниган, МУ-ын угсаатны зүй, III боть, УБ-1996
87. Ууганбаяр.У, Буриадуудын нэгэн нүүдлийн түүхээс, Угсаатан судлал, ШУА Түүхийн хүрээлэн, УБ-2006
88. Хэнтий аймгийн хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогын дүн, МУҮСГ. Хүн ам, тооллого судалгааны товчоо- 2001
89. Цэвээн.Ж, Түүвэр зохиол, I боть, УБ-1997
90. Цэрэнханд.Г, Монголчууд: Угсаа – соёл, зан заншил, II боть, УБ-2005
91. Цэрэнханд.Г, Барга, МУ-ын угсаатны зүй, II боть, УБ-1996
92. Цэрэнханд.Г, Угсаатны онолын асуудлаар эрдэмтдийн үзэл баримтлалын тухайд, Tomus XIII, Fasc.1-22. УБ-2001

Орос хэл дээрх ном зохиол:

93. Алексеев. А.И, Амурская экспедиция 1849-1855г. Изд- “Мысль” Москва -1974
94. Алексеев.Н.А, Материалы о религиозных верованиях якутов как историко- этнографический источник, Советская этнография 12. 1966
95. Алексеенко.Е.А, Домашние покровители у кетов. Религиозные представления и обряды народов Сибири вXIX- начале XX века, Ленинград-1971
96. Аникин. А.Е, Тунгусо-маньчжурские заимствования в русских говорах Сибири, Новосибирск- 1990
97. Анисимов.А.И, Общее и особенное в развитии общества и религии народов Сибири. Ленинград- 1969
98. Анисимов. А.Ф, Родовое общество эвенков(тунгусов), Ленинград-1936
99. Бадмаев. А.А, Кожевенное ремесло агинских бурят, ЭО 12, 1998
100. Банзаров.Д, Чернач вера и шамнаство у монголов и другия статьи, Спб- 1891
101. Бахрушин.С.В, Исторические судьбы Якутии. Научные труды, Т-III, Москва- 1955
102. Бахрушин. С.В, Ясак в Сибири в XVII в, Научные труды. Т-III, Москва- 1955
103. Березницкий.С.В, Мифология и верования орочей, Спб-1999
104. Будаев.Ц.Б, Лексика бурятских диалектов в сравнительно-историческом освещении, Новосибирск- 1978

105. Василевич.Г.М, О культе медведя у эвенков, Религиозные представления и обряды народов Сибири вXIX- начале XX века, Ленинград-1971
106. Василевич.Г.М, Материальная культура среднеамурских эвенков. Материальная культура народов Сибири и Севера, Ленинград - 1976
107. Василевич.Г.М, Топонимы тунгусского происхождения
108. Василевич.Г.М, Этноним саман- самай у народов Сибири, Советская этнография. 103
109. Василевич.Г.М, Эвенки- историко- этнографические очерки, Ленинград-1969
110. Георги.И.Г, Описание всех обитающих в Российском государстве, народов и их житевских обрядов, обыкновении, одежду, жилищ, вероисповедании и прочих достопамятностей, Спб- 1799
111. Головачевъ.П, Сибирь- Природа.Люди. Жизнь, Москва-1905
112. Дамдинов.Д.Г, Ононские хамниганы, Улан-Удэ-1993
113. Диосэги.В, Берестовая посуда у манджура – тунгусов и методы ее изготовления, Будапешт -1950
114. Добромыслов.Н.М, Заметки по этнографии баргузинских орочен, Труды. Троицкосавско Кяхтинскаго Отделения Приамурскаго Отдела Императорскаго Русскаго Географическаго Общества. Т-5. вып 1. Москва - 1902
115. История реки Амура. составленная из обнародованных источников, Санктпетрбург-1859
116. Казанин.М.И., И.Идес, А. Бранд записки о русском посольстве в Китай (1692- 1695). Москва- 1967
117. Как исчезла единая Бурят- Монголия (1937 - 1958 годы), Улан-Удэ- 2004
118. Культура и быт народов Бурятии, Улан- Удэ- 1956
119. Ларькин.В.Г, Орочи, Москва- 1964
120. Лаппо.Д.Е, Обычное право Сибирских туземных народностей., Первый Сибирский краевой Научно-Исследовательский съезд, Новосибирск- 1928
121. Манжигеев.И.А, Бурятские шаманистические и до шаманистические термины, Москва-1978
122. Мазин.А.И, Традиционные верования и обряды эвенков-орочононов(конец XIX- начало XX в)
123. Миллер. Г.Ф, Описание Сибирскаго царство, 1750
124. Миллер. Г.М, История Сибири, Москва- Ленинград- 1937
125. Мичи. А, Путешествие по Амуру и Восточной Сибири, Спб- 1868
126. Новлянская.М.Г, Филипп Иоганн Страленберг, его работы по исследованию Сибири, Москва, Ленинград- 1966
127. Новлянская.М.Г, Даниил Готлиб Мессершмидт и его исследованию Сибири. Наука – 1970
128. Обручев.В.А, Мои путешествия по Сибири, Москва-1963

129. Окладников.А.П., С.П.Крашенинников в Сибири неопубликованные материалы, Москва-Ленинград- 1966
130. Осокинъ.Г.М, Материалы для сборника поместныхъ словъ и выраженийъ обще-сибирскаго и въ частности забайкальскаго наречія, Труды. Троицкосавско-Кяхтинскаго отделения Приамурскаго Отдела Императорскаго Русскаго Географическаго Общества, Томъ- IV, выпуск 2, Москва-1901
131. Очерки истории культуры бурятии. Т1. Улан- Удэ -1972
132. Очерки Сибири для народного чтения. Иркутская губерния. Иркутск-1897
133. Пекарский.Э.К, Цветков.В.П, Очерки быта приамурских тунгусов, Спб - 1913
134. Потанин.А.В, Из путешествии по вост Сибири, Монголии, Тибету и Китаю, 1896
135. Попов.Н.П, В поисках тунгусской столицы, Москва.Ленинград-1930
136. Поппе.Н.Н, Материалы по солонскому языку, Изд.АкНаук СССР, Ленинград- 1931
137. Приамурье- Факты, цифры, наблюдения, Москва-1909
138. Прокофьев.Е.Д, Шаманские костюмы народов Сибири. Религиозные представления и обряды народов Сибири вXIX- начале XX века, Ленинград-1971
139. Птыцин.В.В, Селенгинская Даурия. Очерки Забайкальского края, Спб-1896
140. Сафронов.Ф.Г, Русские на северо- востоке Азии в XVIII- середине XIX., Москва-1978
141. Серошевский.В.Л, Якуты. Опыт этнографического изследования В.Л.Серошевскаго. Т1. Спб-1896
142. Список населенных пунктов Бурят-монгольской Автономной Социалистической Советской Республики. Верхнеудинск- 1925
143. Стахьев.Д.И, За Байкалом и на Амуре путевые картины. Спб-1869
144. Таксами.Ч.М, Некоторые общие черты летних средств передвижения у народов Нижнего Амура и Сахалина. Материальная культура народов Сибири и Севера, Ленинград - 1976
145. Талько-Грынцевич.Ю.Д, Древние обитатели Центральной Азии. Труды- Троицкосавско-Кяхтинскаго Отделения Приамурскаю Отдела Императоскаго Русскаго Географическаго Общества, ТII. выпускъ. 1и2. Москва-1899.1900
146. Талько-Грынцевич.Ю.Д, Народности центральной Азии(Монголо-халхасцы, буряты и тунгусы). Труды- Троицкосавско-Кяхтинскаго Отделения Приамурскаю Отдела Императоскаго Русскаго Географическаго Общества, ТУ. выпускъ 1. Москва-1902
147. Талько-Грынцевич.Ю.Д, Иройские Хамнеганы. Труды- Троицкосавско-Кяхтинскаго Отделения Приамурскаю Отдела

Императорского Русского Географического Общества, ТУИ. выпуск. 3. Москва- 1904

148. Титов.Е.И, Очередные задачи тунгусоведения. Первый Сибирский краевой Научно-Исследовательский Съезд, Т-V. Новосибирск- 1928

149. Титов.З.Д, Обзор этнографических материалов XVIII-XIX вв. О народах Сибири отдела рукописей государственной публичной библиотеки им. М.Е. Салтыкова- Щедрина, Советская этнография '02, Москва-1972

150. Термень. А.И, Среди буряты Иркутской губернии и Забайкальской области, Спб-1912

151. Туголуков В.А, Тунгусы (эвенки и эвены). Средней и Западной Сибири, Москва- 1985.

152. Туголуков.В.А, Изменения в хозяйстве и быте эвенков Иркутской области за полтора века, Советская этнография, Москва- 1982

153. Туров. М.Г, К проблеме этногенеза и этнической истории эвенков. Этнографическое обозрение '03, Москва- 1998

154. Хомич.Л.В, О некоторых предметах культа надымских ненцев. Религиозные представления и обряды народов Сибири в XIX- начале XX века, Ленинград-1971

155. Хомосов.С.Р, Савельев.Р.Г, Этнографический музей- заповедник народов Забайкалья, Материальная культура и искусство, народов Забайкалья, Улан-Удэ- 1982

156. Цинциус.В.И, Сравнительный словарь тунгусо-маньчжурских языков, Т-1, Ленинград-1975

157. Цыбен.Ж, Улигеры Ононских хамниган, Новосибирск- 1982

158. Цыбен.Ж, Путевые дневники 1903-1907 гг. ред-Ванчикова.Ц.П, Улан-Удэ- 2001

159. Чимытов.Б.Р, Этнографические заметки о старом быте цонголов Бурят. Материальная культура и искусство, народов Забайкалья, Улан-Удэ- 1982

160. Щренк.Л, Об инородцах Амурского края, ТII . Спб-1883

161. Экспедиция Беринга сборник документов подготовил к печати Покровский.А, Москва- 1941

Герман хэлээр:

162. Kathe U- Kuhalmi, "Der mongolisch-kamniganische dialect von Dadal sum und die frage der mongolisierung der tungusen in der Nordmongolei und Transbajkalien", Acta orientalia, academiae scientiarum Hungarical, redigit L.Ligeti, Tomus IX, Fasciculus 2, Budapest- 1959

Хавсралт-1

Дорнод Монголын хамниган ба буриад-монголчуудын

Монгол улсыг дагаж орохдоо өргөн мэдүүлж байсан батлан даах бичиг:

Орос улсын харьяат Буриад республикийн мэдлийн Яруунын хошууны Хөшүүр сумын Ламжав хэмээх Цэрэнпилийн бичиг, Монгол ард улсын харьяат

Хан Хэнтий уулын аймгийн Онон голын хошууны тамгын газар өргөө. Өргөн мэдүүлэх учир миний бие уг яс шашны барилдлагаар тус монгол ах дүү лүгээ нийлэхийн зорилгоор уул нутгаас Монголын 16-р оны 3 сард буриад нийтийн нүүдлийн горимоор гарч тус газар мөн он 4 сарын 15-ны өдөр хүрч ирээд тус хошууны харьяат Цагаан булаг зэргийн газраа сууж бөгөөд, одоо болвоос тус улс дор дагаар орохыг эрмэлзэн тус хошуунд баримтлан захирагдахыг гуйн мэдүүлэхэд үүгээр батлах нь ийнхүү дагаар орсон өдрөөс эхлэн бие хөрөнгөний албан үүргийг монгол ардын нэгэн адил хүлээхээ уялга болгон батлахаас гадна тухай тухай нүүрээр гар даалгаад ийнхүү учирын үнэн магадыг хянуулан тус хошууны Баян-Уулын сумын эрх баригчдаар батлуулж энэхүү батлах бичиг гучаад хувийг гаргаж ам хөрөнгө зэргийг үүний хойно жагсаан бичиж олдвоос нь Онон голын хошууны тамгын газар өргөн мэдүүлээд байцаан толилж улмаар туйлын газар зуурчлан ёсоор болгон шийтгүүлэх ажааму хэмээн үүний тул өргөн мэдүүлэв. МУ-ын 16-р он 9 сарын 22 өдөр гарын үсэг тавигч Ламжав Цэрэнпилийн үнэнч шударга тул үүнд гар даасан Баян-Уулын сумын 3-р багийн 3-р арваны харьяат Донир Чойвоны.

Жагсаасан нь жинхэнэ лам Ламжав Цэрэнпилийн нас- 34.

Баян-Уулын сумны эрх баригчид энэхүү өргөдлийн үнэнийг батлав. МУ-ын 16-р он, 9 сарын 22 өдөр, дугаар – 192. Сумын дарга Самбуудорж. Нарийн бичгийн дарга Норов.

Хавсралт-2

ӨМӨЗО-ны эвенг үндэстний дуу:

Амур мөрнөөс гарултай сан

Ялу голоор нутаглаа сан

Эвенг Найман гэдэг чинь

Эрэлхэг баатар баатар түүхтэй

Амур мөрнөөс гарултай сан

Ялу голоор нутагладаг сан

Хайлаар Хөлөн буйрд идээшигсэн сэн

Хуй Имэнд нутагшсан билээ

Эвенг Найман аймаг гэдэг чинь

Эрэлхэг баатар баатар түүхтэй

Эвенг Найман гэдэг чинь

Эрэлхэг баатар түүхтэй

Энэхэн эринд дуулсан дууг

Үеэс үед уламжлах болтугай

Эвенг Найман аймаг гэдэг чинь

Эрэлхэг баатар баатар түүхтэй.... гэсэн үгтэй ажээ.

Хавсралт-3

Yalbagā - Мандал сумын нутаг Ерөөгийн эхэнд байх уул, Бэрлэгийн ойролцоо байдаг- О.Б.

Berlege (Бэрлэг)- Хөвсгөлийн Улаан-Уулд байна. Бөрлөг гэж уйгараар чонот гэдэг үгнээс үүдсэн газрын нэр гэнэ (С.Б). Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт Ялбагийн ойролцоо байх уулын нэр-О.Б.

Тангуй- Хүдэр сумын нутаг Хэрцийн голын дээд эх- О.Б.

Зэлтэй- Тангуйн баруун талд байдаг гол-О.Б.

Ходоод (Ходоодон булан-Ж.Ц)- Бугант суурингийн нутаг – О.Б.

Хонин нуга- Сэлэнгийн Мандал сумын нутагт, Бэрлэг, Ялбагаас урд чигт байдаг ян хөвчит уулархаг нутаг - О.Б.

Бугант- Сэлэнгэ аймгийн Бугант суурингийн нутаг

Шарлан-Ерөө голын томоохон салаа

Галттай- Сэлэнгэ аймгийн Ерөөгийн нутагт байх голын нэр. Галагтай гэж нэртэй байгаад дуудлага нь хувирсаар Галттай болсон гэх ажээ-О.Б.

Төмөртэй- Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт байх голын нэр- О.Б.

Zevgicaini bömbögsei - Минжээс зүүн урагш байдаг (С.Б)

Töggöl - Шарлан талд (С.Б)

Xodõj - урагшаа харсан амны гол, мөн Рэнчинлхүмбэ суманд байх голын нэр. Ходон гэх нь хадан гэх уйгар үг, чандагыг уйгараар ингэж нэрлэдэг байна (С.Б).

Xotoγaŋi aršaŋ - хаана байдгийг тодруулсангүй байна (С.Б)

Xoŋgi - Естийн рашаанд бий (С.Б).

Xõk boγodžõ – Зүүн хараад байх усаар хавчигдсан хадан хавцал. Богож гэж Рэнчинлхүмбэд байгаа нь нэг талаараа устай хавцал газар гэнэ (С.Б).

Õngõlõgõ - мөн Ялбагт бий (С.Б).

Зүүн хараад байх усаар хавчигдсан хадан хавцал, шилээр нь давдаг газар

Širxeŋcögõ- Зүүн хараагийн төвийн уул

Šivër- Ерөөд байна, мөн Улаан-Уулд байдаг намагтай газрын нэр

Хавсралт-4

Үг. Б.Сундуй (Хэнтийн Дадал сумын уугуул)

Ая.Ц.Чинзориг(төрийн соёрхолт, урлагийн гавьяат зүтгэлтэн)

“Нютаг”

Баянхаанай ууламнай

Бугын урамдаат нютаг

Анхнай саханаар яаранхай

Ахай авгын нютаг

Урсгал дольгион Балжамнай

Улаалзай мойхоной орон

Уургай сайгаа аягаланхай

Урьхан ижийм нютаг

Агацай дэлгэр таламнай

Адуу малай бэлиээртэй

Ардай дуугаа аяланхай

Аншан баавайн нютаг

*Мараанай сэнхэр хөндий
Мангир таанай орон
Хаанаш явахан намтайяа
Хамтдаа л байһан нютааг*

Хавсралт-5

Нэрьеэлгийн(ниргэлэг³⁸⁸) дуун³⁸⁹

Үндүрхүн агуулын оройгоор
Үүрэйн туяан мандарна
Үндүр хүлтэй ширээндэ
Зулын туяан мандарна
 Набтархан агуулын оройгоор
 Наранайл туяан мандарна
 Найман хүлтэй ширээнд
 Зулын туяан мандарна
Сэнгэлгэни наранийн
Сүмбэр агуулые тойроно
Алтанхан шара нараниин
Агуулые тойроно
 Нарийхан голой бургаасан
 Наран сүргөө найгана
 Найманхан эсэгын ламанарнууд
 Дасан сүргөө найгана
Үргэн голой бургаасан
Үргүлжөөрөө найгана
Үзөөхөн эсэгын ламанарнууд
Дасан сүргөө найгана
 Харалгуйн бургаасан
 Хажуул тээшээ найгана
 Хамниган эсэгын ламанарнууд
 Дасан сүргөө найгана
Тугшин голой бургаасан
Тушаа бүрээ найгана
Тугшин эсэгын ламанарнууд
Дасан сүргөө найгана

Хавсралт-6

Дараахь хамниган дууг Хэнтийн Дадал сумын өндөр настан хамниган н.Балбар хамниган дуудлагаар бичиж ирүүлсэн нь.

³⁸⁸ Ниргэлэг хэмээх дуут бүжиг нь наадамчин олныг хамарсан нийтийн дүү бүхий нийтээрээ бүжиглэдэг тойрон бүжиг. Г.Гантогтох, Монгол зан үйлийн аман яруу найргийн уламжлал, УБ-2007, 70т

³⁸⁹ Ж. Цэвээн 1905-1907 оны хооронд буриад-монголын нутгаар аялахдаа Агын тойргийн Сөдөнтөөс тэмдэглэж авсан байна.

Дөлдөнкэн чикитэй көөрөзкэн мөни дөө
Дөлсүтэй лэ ахудаа морихон доо
Дөмэйл даа үгэтэй төрэ нэгэ кёбүүн мөни
Дээлтэй лэ ахудаа күнкөн дөө
 Хулахан чикитэй көөрөзкэн мөни дөө
 Хурдутаи ла ахудаа морихон доо
 Хуудуу үгэтэйхэн төрэ нэгэ кёбүүн мөни
 Хубцасутаи ла ахудаа күнкөн дөө
Босоохан чикитэй дөө көөрөзкэн мөни
Боожитай ла ахудаа морихон доо
Болдаггүй үгэтэй төрэ нэгэ кёбүүн мөни
Бойтогтай ла ахудаа күнкөн дөө

Хавсралт-7

Нитуг абу хоёр мину

Үндүр көөрөө унухул асамби
Үргүн Көрүдэ очихул асамби
Үбүгүн абутайгаа золгокул асамби
Үнүдкүүлжи таалуулжи өркөлкү асамби
 Молцугтайкан көөрөө унукул асамби
 Моринойгоо гүйкөөр хуугиулку асамби
 Моносутаихан Көрүдөө очихул асамби
 Мойл үрилөө түүкүл асамби
Цүндүгүр көөрөө унухул асамби
Сөндөлүүлжэ Ононоо умбуулкул асамби
Сөдкил бакаа дүүргөжи
Цүцүгүйтэй отобороогоо идэкүл асамби
 Кирики дөө, кирики дөө, кирики дөө
 Көрү Агуца нитуг минь дөө
 Бара даа бара барасан минь
 Буянтай буурал абу минь дөө

Хуацай овогту Мижисэй Цөцөгмаа
2010.06.06

Зобоку минь агу даа

Үндүр бороёогоо үриндү үгээркеэд
Унуку моригүй зобоку минь агу даа
Учирасун өкөнөрөө түркүмдүни буцаазаркеэд
Үбүр минь сөндийгөөд зобоку минь агу даа
 Цүдүгүр көөрөөгөө чинонд үгээркеэд
 Чидэрэй моригүй зобоку минь агу даа
 Цолбонкон төрөөкөөкөнөө түркүмдүнь буцаазаркеэд
 Цөөжи минь хоосураад зобоку минь агу даа

Газаагаа ганца моригүй
Гахай ябуган зобоку минь аку даа
Гала, усу ч үгүй гөр минь күндийрөөд
Ганцаараканаа үлээд зобоку минь аку даа

Хуацай овогту Мижисэй Цэцөгмаа
2010.06.06

Хавсралт-8

Хамниганы Дэлгэр зайран солонгос бөөтэй идэлдсэн домог ³⁹⁰

Огт хүүхэдгүй Егорынх гэж уулын хар гөрөөчин айлынх Цагаан-Овоогоор нутаглаж байсан байна. Авгай нь архи сайхан нэрдэг, түүнээс нь Дэлгэр зайран ч өдөр бүр очиж хүртдэг байжээ. Эхнэр нөхөр хоёр Дэлгэр зайрангаас хүүхэдтэй болгохыг гуйж гэнэ. Дэлгэр зайран ч зөвшөөрч, Егорын эхнэр ч зайранд архи татдаггүй байж. Ингэсээр нилээд хугацаа өнгөрч, нэг өдөр зайранг очиход Егорын эхнэр архи аягалсангүй. Хүүхэдтэй болгосон цагт чинь өгнө гээд авдартаа хийчихэж. Дэлгэр зайран тэнгэрээс хүүхэд олгуулна гэж шалсаар байгаад архинаас нь уугаад яваад өгчээ. Егорын эхнэр нэг өдөр хонио хариулаад явж байтал учиргүй их нойрмоглосоор хэсэг зуурт унтчихсан байж. Дэлгэр зайран ирээд, хүүхэдтэй болсон биз дээ, би авч яваад холбогоны үзүүрт биеийг нь зүсчихсэн шүү, тэхдээ зүгээр сайн хүү гарна гээд архи ууж байгаад явжээ. Егорын авгай төрөхөд нилээд том биетэй, мөрнийхөө орчим юмаар адсан юм шиг сорвитой хүү гарсан байна.

Хэсэг хугацааны дараа Дэлгэр зайран нилээд уруу царайлж ирээд:

- Егор чи надад тусла, гөрөөчиний чинь хэрэг одоо л гарах нь. Би танай хүүг солонгос бөөгийн хатны хэвлийгээс хулгайлчихсан юм. Нөгөө бөө нь мөшгөсөөр яваад намайг олж мэдээд амар заяа үзүүлэхгүй болохоор нь, би идэлдээ зарлачихаад байна. Тэр бөө асар чадалтай, би дийлж барахгүй байх. Чи надтай буу шийдэмээ аваад хамт яв гэжээ. Хоёул идэлдээ хийх уулынх нь энгэрт ирээд, Дэлгэр зайран нэг модны ёроолд гортиг зурж Егорыг дотор нь хэвтүүлээд, гортигноос гарч болохгүй шүү, өглөө болгоорой гэж захижээ. Өглөө эрт зүүн урд зүгээс хар бух, баруун хойд зүгээс жижиг цагаан бух ирнэ, тэр цагаан бух чинь би юм шүү. Эхний удаад би дийлдэнэ, дараа нь ганц удаа цахалж тулахыг бодно, тэр үед хар бухыг цоройход цавинд нь байх цагаан үсийг онилж алдалгүй буудаарай, алдаж буудвал чи бид хоёул зүйл дуусна гэсэн гэнэ. Бүх юм хэлсэн ёсоор нь болж гөрөөчин хар бухыг унагажээ. Хар бух хөрвөөн тийчилж байгаад цагаан сахалтай өвгөн болон хувирч:

- Хүний нутаг хэцүү юм, яах гэж харийн нутагт идэлдээ зарлав даа гэж гашуудаж байснаа бүргэд болон хувирч Егорын дээгүүр элгээрээ шүргэн алдаж нисэн самардаж байснаа зүүн урд зүгт нисчээ. Дэлгэр зайран гортигоо задалж

³⁹⁰ Худирын их чонод омгийн бөө М.Жавхлангаас 2003 онд тэмдэглэж авлаа. Энэ түүхийг нэгэн бөөгийн онгод түүний багш Ч.Цэрэн зайранд буугаад хуучлах үед нь тогтоож авсан гэж байв.

Егорыг гаргаад бид хоёр бие биедээ өргүй боллоо гээд явсан гэдэг. Егор хүүдээ Данху гэж нэр өгсөн нь Данхугийн Дугар гэх тэднийхний үр сад харь ясны царайтай улс Цагаан-Овоогоор байдаг гэж сонссон гэлээ.

Дэлгэр зайран буга болсон нь

Гөрөөчин залуу гол дээр ан отоод хэвтэж байтал нэг гөрөөс хүрч ирж ус уув гэнэ. Залуу ч онилж онилж буудахад оносон хэр нь гөрөөс шилгээхээс биш яах ч үгүй байсаар уснаас гарахад нь анчин залуу гэнэт буруу юм хийлээ, хэрэг бишдэх нь гэж сэхээрээд гөрөөсийг зөнгөөр орхижээ. Гэртээ ирээд байтал нь хүн довтолгож ирээд Дэлгэр зайран дуудаж байгааг хэлжээ. Залууг очиход Дэлгэр зайран, - Хүн хол юманд явж ангаж ядраад ус ууж байхад яасан ч олон бууддаг юм бэ? Май энэ пүүлээ ав гээд – буудсан сумыг нь халуунаар нь өгч байсан гэдэг түүхтэй.

Хамниганы Мичишкин удганы домог

Хамниганы Мичишкин гэж их чадалтай удган байсан гэдэг. Нэг удаа долоон шогдоо (дээрэмчин) мангадтай (оросуудыг мангад гэдэг) таарч дээрэмдэх гэхээр нь тэр долоон оросыг өөрийн эрдмээр доодохоор нь холбоод орхичихсон гэдэг. Энэ учираас Мичишкийн удган онгод болон буухдаа:

Долоон шогдоо мангадыг

Доодохоор нь холбосон ... гэж орж ирдэг байна.

Мичишкин удган цагаан хааны комисст шалгуулсан нь

Цагаан хааны комисс буриад, хамнигадын нутгаар явж бөө, удгадын эрдэм чадлыг шалган тэнцсэн эрдэм чадал сайтайд нь бөөлөх зөвшөөрөл олгодог байжээ. Мичишкин удганы шалгуулах ээлж ирж, өөрийн эрдэм хүчээ үзүүлэх болж дээ. Удган комиссийнхонд, намайг цонх онгойлго гэхэд онгойлгоорой, их ус орж ирнэ. Дотор нь том том загас хөвж байгаа, тэрнээс шилээд бариарай, намайг хаалгаа онгойлго гэхэд мөн онгойлгоорой гэж захиад бөөлж гэнэ.

Бөөлж байгаад цонхоо онгойлго гэхэд нь комиссынхон хэлсэн ёсоор нь болгов. Салхивчаар их ус орж ирэн өрөөний талд хүрэхэд Мичишкин удган усан дээр зогсоод бөөлж байсан гэдэг. Оросууд усан дотор зогсож байтал хэлснээр нь олон загас хөвж байж, тэд загасанд дуртай юм хойно захаас нь зангалайдаж(загалмай-О.Б) барьж эхлэсэн байна. Тэгж байтал удган хаалгаа онгойлго гэж гэнэ, хэлснээр нь онгойлгож, ус ч урссаар шавхагдаж, өрөөнд юу ч үгүй болсоны хойно сэхээ авсан оросууд биенээ хартал дотуур хувцасгүй бүгд нүцгэн зогсч байж. Цагаан хааны комиссынхон ичсэндээ Мичишкин удганд бөөлөх эрхийг нь хамгийн түрүүнд өгсөн гэнэ.

Хамниганы тараг бүрэлдэхдээ муу болсоны учир

Буриад бөөгийн хэлэх нь хамниганы тараг олигтой бүрэлддэггүй гэнэ. Энэ нь дараахь учираас болсон байна. Буриадын Бавж барс баатар хамнигадыг дайлаар яваад нэгэн хамниган айлд орсон чинь тэр айлд бөө бөөлж байхтай

таарчээ. Бавж барс баатар тэр бөөг нь барьж аваад савтай айраг руу толгойгоор нь гударч алсан байна. Тэр үеэс хойш хамнигадын тараг бүрэлдэхдээ муу болсон домогтой ажээ³⁹¹.

³⁹¹ О.Баттуяа, Хэнтий, Дорнод аймагт хийсэн судалгааны гар бичмэл, 2003